

Хөрөнгийн бирж хөрсөө шинэчилж
байна

Монгол: Салаа замын уулзварт

Бид ажилгүйчүүдийн
эгнээнээс гарч чадсан!



Нийгмийн хариуцлагын тухай хариуцлагатай ярьъя



Naran Motors Co.,Ltd

www.bmw.mn



Sheer
Driving Pleasure



PRINCIPLES OF LEADERSHIP.

BMW 7 Series. Inspired by the core principles that take leaders from success to success.



ХАРИЛЦАХ ДАНСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Танд мөнгөн хөрөнгөө найдвартай, эрсдэлгүй, орон зайг үл харгалзан удирдах боломжийг олгоно.

Та харилцах дансаа дараахь

MNT USD EUR
JPY RUB CNY

валютаар нээх боломжтой.



Хамгийн өндөр хүү

Найдвартай, шуурхай

Орон зайгаар
хязгаарлагдахгүй

Хямд



MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч,
Эрхлэгч: Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч,
Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор:
Terrence Edwards

Сэтгүүлч:
Д.Мөнхчимэг
Х.Хулан
Э.Зоригт

Орчуулагч:
Э.Өлзийлхам

Дизайнер:
Б.Урангэрэл

Маркетингийн менежер:
Д.Бариянжав
8880 0825
Б.Энхцэцэг
9901 5476

Хаяг:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23
Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

“Улаанбаатар принт”
ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

"Интер ном"
"Majestic" их дэлгүүр
"Цэцэг төв"
"Зиг заг" автосервис
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza" дахь салбар
"Мир" номын дэлгүүрийн
"Metro mall" дахь салбар
"Минж плаза"
"Sky" супермаркет
"Алтантүлхүүр" номын дэлгүүр



Дэлхийд ганцхан монгол наадмаа сайхан тэмдэглэж, дэлгэр зуны улиралдаа амралтыг чухалчилсан уншигчдадаа “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон толгойгоо амрааж, авсан эрч хүчээрээ бизнесээ цэцэглүүлэхийг уриалж байна.

Зургаа дахь дугаараа уншигч таны гарт хүргээд буй “Mongolian Economy” сэтгүүл өмнөх дугаарууддаа “Ногоон хөгжил”, “Invest Mongolia”, “Аялал жуулчлал” зэрэг салбарын асуудлыг түлхүү хөндөж, онцлох сэдвээ болгож байсан бол энэ удаа эдийн засгийн гол зүтгүүр болох хувийн хэвшлийнхэндээ бизнесээ урагштай байлгахад нь дэмжлэг болохыг хичээв.

Улсын хурдацтай хөгжил, уул уурхай дагасан мөнгөний ширүүн урсгалтай холбоотой хувийн хэвшлийнхэнд бизнесээ цэцэглүүлэх боломж улам бүр нэмэгдэж байгааг хэн хүнгүй анзаарч ажиж байгаа нь дамжиггүй ээ. Харин улсын хөгжил урагшилж, эдийн засгийн орчин тааламжтай болохын хэрээр эрхэм бизнесмэн таны өмнө эх дэлхийгээ хайрлах, эрдэнэт хүмүүнийг хүндлэн дээдлэх, эрхэм ашгаа эх орны хөгжилтэйгээ хуваалцах нийгмийн хариуцлага тулгарч байгааг хараахан ухамсарлаагүй яваа бол “Mongolian Economy” сэтгүүлийн шинэ дугаар таныг энэ талын мэдлэг, мэдээллээр цэнэглэх болно. Түүнчлэн эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ огцом нэмэгдэж буйгаас Голланд өвчин, “халуун мөнгө” гээд олон асуудал хаалга тогшиж эхэллээ. Энэ нь бизнесээ улам илүү хариуцлагатай, соёлтой эрхлэх шаардлага Монголын бизнесмэнүүдийн өмнө тавигдлаа гэсэн үг. Тухайлбал, компанийн нийгмийн хариуцлага гэдэг үг монголчуудын чих, нүдэнд танил болоод багагүй хугацаа өнгөрсөн ч уудам Монголын хөрснөө ургаж идээшиж чадахгүй өнөөдрийг хүрэв. Манай хамт олон энэ чухал сэдвийг онцлон хүргэхийг зорилоо.

“Нийгмийн хариуцлагын тухай хариуцлагатай ярья” гэдэг нийтлэлээс уншигч Та Компанийн нийгмийн хариуцлагын тухай тодорхой зөв ойлголт авахаас гадна Компанийн нийгмийн хариуцлагын сонгодог хөгжилтэй ХБНГУ-ын туршлагыг ч Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг / ГОУХАН/-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн санаачлага хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч Стефан Ханзельманны ярилцлагаас сонирхоорой.

Монголын хөрөнгийн захын хөгжилтэй холбоотойгоор бизнесийн сайхан санаагаа бодит амьдрал болгох гэж зөвхөн арилжааны банкныг царайчлах биш, сайхан санааг, сайн төслийг санхүүжүүлдэг хөрөнгө оруулалтын банкууд ч Монголд мэндлэх цаг ойрхон байгааг дуулгая.

Хувийн хэвшилд төрийн оролцоо хэт их байх нь сайн үр дүн авчрахаасаа илүүтэй саар зүйл даллаж, жамаараа явах зах зээлийг хэрхэн эвддэгийг наадмын өмнө шатахуун тасалдах үеэр монголчууд бэлээхэн харлаа. Тэгвэл энэ тухай манай сэтгүүлчийн бичсэн “Laissez Faier” нийтлэлээс багагүй зүйлийг мэдэж авах болов уу. Үүнээс гадна “Wall Street Journal”-ын тусгай сурвалжлагч Маурэн Орд (Maureen Orth) Монголоор аялж, “The Luxury Frontier” хэмээх маш сонирхолтой нийтлэл бичсэнийг уншигчдадаа хөрвүүлэн хүргэж буй.

Мөн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” зарласантай холбоотойгоор “Mongolian Economy” сэтгүүл иргэдийг ажил хийж, сайхан амьдрахад уриалж, “Амьдрал” булан шинээр нээлээ. Манай шинэ булан нэгээр тогтохгүй, уншигчдынхаа эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, стресс ядаргаанаас өөрийгөө хамгаалах талаар ч эмч, мэргэжилтнүүдийн зөвлөгөөг хүргэж байгаагаа уламжлахад таатай байна.

Эцэст нь тэмдэглэхэд, Монголын эдийн засаг, улс төрийн хамгийн халуун сэдэв байсаар ирсэн Тавантолгойн асуудлаар шинэ мэдээлэл, шийдвэр гарах тусам улам л толгой эргэж байна. Монголчуудын ч, гадаадынхны ч. Энэ тухай ч мөн “Mongolian Economy” сэтгүүлээс та уншиж болно.

Орлогч эрхлэгч И.Отгонжаргал



...КНХ бол эдийн засгийн өрсөлдөх чадварын чухал хүчин зүйл, нэмүү өртгийн сүлжээний нэгэн хэсэг, компанийн амжилтын үндэс мөн... 9



...Жан-Батист Колбэрт хэсэг бизнесмэнээс ямар тусламж хэрэгтэй байгааг нь асуухад нэг нь "Laissez vous faire" буюу "Биднийг зүгээр л орхичих" хэмээн хариулсан гэдэг... 20



...2008 онд уг машин 12-оос илүү оронтой тоо багтааж чадаагүйгээсээ болж гацаад, хэсэг хугацаанд ажиллаагүй юм. Америк улсын өрийн хэмжээ гэрлийн хурдаар нэмэгдэж байгааг инээдтэй гэмээр энэхүү явдал харуулжээ... 34

Компанийн нийгмийн хариуцлага

- 6 Нийгмийн хариуцлагын тухай хариуцлагатай ярья
- 8 Нийгмийн хариуцлага хэрэгжүүлдэг бол Top-100-д өрсөлдөөрэй
- 9 Др.Штефан Хансельманн: Монголд компанийн нийгмийн хариуцлагын стандартыг зөв хэрэгжүүлэх боломж байна
- 12 Хөрөнгийн бирж хөрсөө шинэчилж байна
- 14 Өрсөлдөх чадвар өөрийгөө танин мэдэхээс эхэлнэ
- 15 "Өглөгийн тангараг"
- 18 Та компанийн нийгмийн хариуцлагын талаар юу хэлэх вэ?

Эдийн засаг

- 20 Laissez Faire
- 21 С.Мөнхсүх: "Хувийн агаарын тээвэрлэгч аюулгүй, тогтвортой, ашигтай ажиллаж болдгийг баталсан
- 24 Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтийн үндсийн үндэс нь монгол хүний хөгжил дэвшил
- 27 Монгол: Салаа замын уулзварт
- 32 Хоёр байгууллага-нэг систем

Хөрөнгийн зах зээл

- 34 Америкийн "А" ямар үнэтэй вэ?
- 36 Брокеруудыг битгий давраа

Уул уурхай

- 39 Тавантолгойг ойлгоход толгой хүрэхгүй нь ээ
- 41 Алтны үнийн өсөлт хүчээ авлаа
- 42 "Мянганы үйлдвэр" мянгуужингийн үлгэр болох уу?

Байгаль эх

- 45 Хүндлэм бишрэм Отгонтэнгэр уул
- 47 Нар дэлхий хоёр

Бизнес

- 49 "Манай банкууд эрсдэлээ зөв удирдах аргыг номноос бус, жинхэнэ амьдралаараа туулсан"
- 52 Бид ажилгүйчүүдийн эгнээнээс гарч чадсан!
- 55 Гадаадад гайхагдсан монгол чадвар
- 56 Хонгилын үзүүрт сүүмэлзэх бүдэг гэрэл
- 58 Та ямар ном уншиж байна вэ?
- 59 Бизнес эрхэлж буй хүний хувьд хамгийн чухал 20 асуулт
- 60 Стресс гэж юу вэ?



..Цанхийн баруун хэсгээс тэрбум ам.доллар, зүүн хэсгээс нь 250 сая ам.доллар урьдчилгаа болгон авлаа хэмээн ам уралдан баясахаас өөрийг засгийн эрх баригчид ярихгүй байна...39



...Монгол хүний хөдөлмөрийн зах зээл дэлхий байх ёстой...49

Компанийн нийгмийн хариуцлага



- 8 Нийгмийн хариуцлага хэрэгжүүлдэг бол Top-100-д өрсөлдөөрэй

- 9 Др.Штефан Хансельманн: Монголд компанийн нийгмийн хариуцлагын стандартыг зөв хэрэгжүүлэх боломж байна

- 12 Хөрөнгийн бирж хөрсөө шинэчилж байна

- 14 Өрсөлдөх чадвар өөрийгөө танин мэдэхээс эхэлнэ

- 15 “Өглөгийн тангараг”

- 18 Та компанийн нийгмийн хариуцлагын талаар юу хэлэх вэ?

Онцлох сэдэв

Нийгмийн хариуцлагын тухай хариуцлагатай ярья

Б.Санжааханд

Компанийн нийгмийн хариуцлага. Энэ Көгүүлбэр их учиртай. Монголын ДНБ-ий дийлэнх хэсгийг үйлдвэрлэдэг хувийн хэвшлийнхэнд илүү хамааралтай ч компанийн удирдлагууд болохоор нийгмийн хариуцлага гэдэгт яг ямар тодорхойлолтыг багтааж ойлгох вэ гэдэг талаар учраа мэдэхгүй багагүй хугацааг өнгөрөөсөн. Гэхдээ Монголын бизнесмэнүүд энэ чиглэлээр огт юу ч хийдэггүй гараа хумин суудаг уу гэвэл үгүй. Ялангуяа том компаниуд нийгмийн хариуцлагаа ухамсарлахыг хичээж, асрамжийн байгууллагад хүмүүжигч хүүхдүүд болон өндөр настнуудыг хооллох, эсвэл урлагийн тоглолт, ном хэвлэл ивээн тэтгэж санхүүжүүлэх, оюутнуудад тэтгэлэг өгөх, мод тарих зэрэг өглөг буяны шинжтэй, нэг удаагийн тусламж дэмжлэгийн арга хэмжээнд мөнгө хөрөнгө зарцуулах нь цөөнгүй. Өнөөдрийг хүртэл тэдний олонх нь үүгээрээ компанийн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна гэж ойлгож ирсэн. Түүнийгээ ч том зүйл хийлээ гэж сонин хэвлэл, зурагтаар

сурталчлах дуртай. Өөрөөр хэлбэл, компанийн нийгмийн хариуцлагыг PR сурталчилгаа тал руу нь хөгжүүлэхийг чухалчилдаг тал бий, манайханд. Түүнчлэн ядуу хүмүүс, урлагийнхан, эсвэл Бат, Дорж хүнд өвчин тусчихлаа, гадагшаа явж эмчлүүлэх гэсэн юм туслаач гэж компанийн захирлуудад хандах нь олонтаа. ХААН банк Сангийн менежер Ц.Оюунцэцэг “Манайд өдөрт дунджаар таван хүн янз бүрийн байдлаар хандив, тусламж гуйсан саналтай орж ирдэг. Бусад компанид мөн адил ийм тооны хүмүүс очиж байгаа байх гэж би боддог” гэв. Ийнхүү гуйх байдал нь аль аль талдаа хүндрэлтэй. Нэг талаас иймэрхүү байдлаар өглөг хандив өгөхөөс нийгмийн хариуцлага гэх ташаа ойлголттой явдаг компанийн захирлуудын хувьд татгалзах нь хэцүү. Татгалзахгүй байя гэхээр Оюунцэцэгийн хэлснээр өдөр бүр таван хүний гуйлтыг биелүүлээд байвал юу болох билээ. Тийм болохоор компанийн нийгмийн хариуцлага гэдэг асуудал манай захирлуудын толгойг өвтгөдөг гэсэн үг.

Тэдний ингэж өглөг хандив, тусламжийн байдлаар нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байгаа нь иргэдийн бизнесийн байгууллагынхнаас тусламж, дэмжлэг авах хүслийг улам дэврээж, давраах талтай. Нэг жишээ хэлэхэд, өнгөрөгч тавдугаар сард Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/-аас “Компанийн нийгмийн хариуцлага” сэдэвтэй хурал хийсэн. Тэр үеэр МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл “Компанийн нийгмийн хариуцлагыг зарим хүн компанийн захирлыг загнадаг хэрэгсэл болгож байна. Хандив тусламж гуйчихаад, түүнийг нь зөвшөөрөхгүй болохоор “Танайх яасан нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлдэггүй компани вэ” гээд загнаж байх жишээтэй. Гэтэл энэ ойлголтыг орчин үеийн компаниудын түвшинд аваад үзэх юм бол нэгнээ загнадаг хэрэгсэл ч биш, өглөг буяны үйл, хандив тусламжийн аль нь ч биш юм. Компани ч бай, аж ахуйн нэгж байгууллага ч бай, хувь хүн ч бай нийгмийн нэг хэсэг гэдгээ мэдрэх учиртай. Нийгэм надад падлий байхгүй. Би л болж байвал болоо гэсэн ойлголтоосоо салах ёстой. Тийм ч учраас манай Танхим гурван PPP буюу хүмүүсийг бод, гариг дэлхийгээ хайрла, ашгаа бод гэж хэлээд байгаа юм. Нийгмийн хариуцлагад ядуурал, өнчин хүүхдүүд, боловсролгүй эмэгтэйчүүдийн асуудал бүгд хамаатай. Тэгэхээр бид зөв ойлголтыг нийгэмд түгээж, зөв хэрэгжүүлэх ёстой. Өнөөдрийг хүртэл бидэнд энэ талаар ухуулга сурталчилгаа хийж, таниулах хамгийн наад захын

▸ зурагт хуудас ч алга. Ойлголтоо нэгтгэж цэгцлэхийн тулд юуг компанийн нийгмийн хариуцлага гэж хэлэх вэ, юуг хэлэхгүй вэ гэх байдлаар ялгаж салгаж авах хэрэгтэй байна” гэв.

Компанийн нийгмийн хариуцлага гэдэг нэр томъёог хэрэглээд бараг арваад жил болж байгаа байх. Энэ хугацаанд өглөг буяны үйл, маркетингийн хэрэгсэл төдийхнөөр ойлгож ирсэн нь бидний хувьд учир дутагдалтай. Гэхдээ одооноос компанийн нийгмийн хариуцлагын талаар аж ахуйн нэгжүүд том, жижиг гэлтгүй нэгдсэн зөв ойлголттой болохоор хичээн зүтгэж байгааг онцлон тэмдэглэхэд таатай.

Дэлхий нийтэд 1970, 1980-аад оноос үүсэл хөгжилтэй ч эл нэр томъёо өдгөө улам бүр “моодонд” орж байгаа учраас монголчууд одооноос бодол ойлголтоо цэгцлээд, зөв хэрэгжүүлэх юм бол оройтохгүй болов уу. Хөгжингүй улс орнуудад нийгэм, эдийн засгийн хөгжлийн нэг чухал механизм хөдөлгүүр болсон энэ ойлголт шилжилтийн эдийн засагтай Монгол Улсад цагаасаа өмнө айлчилсан учраас манай хөрсөн дээр идээшихгүй удсан ч байхыг үгүйсгэхгүй. Тэгвэл өдгөө манай улс шилжилтийн эдийн засагт хэдийнэ цэг тавьж, уул уурхайн их мөнгө далласан үсрэнгүй хөгжлийн босгон дээр ирсэн учраас нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч болсон компанийн нийгмийн хариуцлагын тухай хариуцлагатай ярихаас аргагүй болов.

Өнгөрөгч зургадугаар сард МҮХАҮТ-аас “Компанийн нийгмийн хариуцлагын IV форум” зохион байгуулсан. Тэр үеэр туршлагаасаа хуваалцсан компаниудын төлөөлөгчдийн танилцуулгаас харахад, энэ тал дээр манай томоохон компаниуд ахиц дэвшил гарахаар зүйлүүд багагүй хийж буйг мэдсэн. Тухайлбал, компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр улсдаа тэргүүлээд зогсохгүй олон улсын холбогдох байгууллагуудад үнэлэгдэж буй нэгэн компанийн тухай дурдахгүй өнгөрч болохгүй. Энэ компаниас олон байгууллага аж ахуйн нэгж үлгэр дуурим авч учиртай. Тэр бол “Хас” банк юм.

Аж ахуйн нэгж байгууллага компани бүр нийгэм эдийн засгийн харилцааны нэг субъект, нийгмийн хөгжилд оролцож байгаа салшгүй нэг этгээд юм. Хувь хүн ч ялгаагүй. Тийм ч учраас нийгмийн хөгжилдөө тодорхой хувь нэмэр оруулах учиртай. Хамгийн энгийнээр хэлбэл, зөвхөн ашгийн төлөө явах ёсгүй. Нийгмийн хөгжилд оруулж байгаа хувь нэмэр нь 1000 төгрөг олчихоод нэг төгрөгийг нь нийгэмдээ өгнө гэсэн үг биш. Юуг ойлгож байна гэвэл тухайн аж ахуйн нэгж байгууллагын бүхий л үйл ажиллагаа нь нийгэмдээ чиглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл,

нийгмийн хариуцлага бизнесийн үйл ажиллагааных нь үндсэн нэг хэсэг байх ёстой” гэж “Хас” банкны гүйцэтгэх дэд захирал Л.Төр-Од тайлбарлалаа. Тус банк ард иргэдийнхээ санхүүгийн боловсролыг сайжруулах, хуримтлал хадгаламжтай болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор БСШУЯ-тай хамтраад ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Тэмүүлэл” хөтөлбөр хэрэгжүүлдэг нь нэлээд үр дүн харагдахаар байгаа аж. “Түүнчлэн манайх Даяар тайлагнах санаачилга байгууллагын гишүүн учраас сүүлийн дөрвөн жил олон улсын стандарт шалгуурын дагуу тайлагнаад явж байгаа. Зөвхөн санаачилга, зарчмуудад санал нэгдэж, гарын үсэг зурахдаа гол нь биш, түүнийг хэрэгжүүлэх нь бидний өмнө илүү том сорилт болчихоод байна” хэмээн Төр-Од захирал тэмдэглэсэн.

Мэргэжлийн хүмүүсийн дунд ХААН банкныг компанийн нийгмийн хариуцлагаар бодлого стратегиа нэлээд цэгцэлчихсэн газар гэж онцолдог. Тийм болохоор ХААН банк Сангийн менежер Ц.Оюунцэцэгийн үгийг хүргэе. “Тухайн компани бизнесээ явуулахдаа хариуцлагатай, зөв үйл ажиллагаатай, байгальд ээлтэй, засаглал нь нээлттэй ил тод байх, тогтвортой өсөлтийг бий болгох, ажилтнуудаа сургадаг, хөгжүүлдэг, олсон ашгаасаа нийгмийн хөгжилдөө зориулах ёстой. Товчоор үүнийг л компанийн нийгмийн хариуцлага гээд байгаа юм л даа. Харамсалтай нь Монголд өглөг буяны үйл, маркетинг гэж үзэж, дутуу дулимаг ойлголттой байгаа учраас компанийн нийгмийн хариуцлагын дараагийн түвшин рүү ороход тодорхой цаг хугацаа хэрэгтэй байна. Гэхдээ сүүлийн үед цөөнгүй компанид ололттой зүйл ажиглагдаж байгаа нь сайшаалтай. Манай ХААН банкны хувьд компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх бодлого журам стратегитай. Бүх зүйл тодорхой ойлгомжтой байдаг. Тийм болохоор өдөрт хандив тусламж гуйж орж ирж байгаа хүмүүсийн асуудлыг шийдэхэд амар байдаг. Бид 2-3 жилийн өмнөөс өглөг, хандиваа ялгаж салгаад, өглөг огт өгөхгүй гэж бодлогоо тодорхойлж, стратегиа боловсруулсан. Мөн хувь хүнд чиглэсэн ивээн тэтгэлэг үзүүлэхгүй. Нэг удаагийн арга хэмжээнд бас No гэж хариулна. Гагцхүү тогтвортой хөгжлийг бий болгоход хувь нэмэр оруулах, тогтвортой өөрчлөлтийг бий болгох бодит үндэслэлтэй арга хэмжээг хэрэгжүүлэх тодорхой стратеги мөрдөж ажилладаг” гэв.

Монголд компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр гайгүй ажил хийдэг ямар компани байгаа талаар зарим хүнтэй санал солилцоход “Мобиком”-ын “Моби тэмүүлэл”

хөтөлбөрийг багш, сурагчдад үлдэх юмтай гэж магтах юм билээ. Энэ талаар тус компанийн гүйцэтгэх захирал Д.Болорт хандлаа. “Бид 2009 оноос олон салбарт бус тодорхой нэг салбарт илүү бодитой, үр дүнтэй хөрөнгө оруулах зорилт тавьсан. Тэгээд орон даяар санал асуулга явуулж 280-аад мянган хүнээс санал авахад, Монголын ирээдүй боловсролтой монгол хүнээс хамаарна. “Мобиком” боловсролын салбарт томоохон төсөл хэрэгжүүлж хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй гэж олон нийт онцолсон учраас уг төслийг хэрэгжүүлж байгаа” хэмээн ярилаа.

Ер нь хүссэн хүсээгүй нийгмийн хандлага нийгмийн хариуцлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэжээ. НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд 30-40 монгол компани нэгдсэн байсан бол өдгөө 300-400 болтлоо нэмэгдсэн байх жишээтэй. Түүнчлэн МҮХАҮТ-аас Нийгмийн хариуцлагын кодексийг гаргахаар зэхэж байгаа гэнэ.

Манайд өмнө нь компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр сүүлийн үед дотоод, гадаадад урт, богино хугацааны сургалт ч нэлээд явагддаг болж. Тухайлбал, МҮХАҮТ өнгөрсөн тавдугаар сард НҮБ-аас багш нар авчирч, компанийн менежер 25 хүнд дээрх сэдвээр анхан шатны сургалт зохион байгуулсан. Түүнчлэн “Хас” банкны Л.Төр-Од, ХААН банк Сангийн Ц.Оюунцэцэг нар нь Тайландад мастер сургагч багшийн сургалтад хамрагдаж байжээ. Ц.Оюунцэцэг хэлэхдээ “Гаднын бизнесийн том сургуулиудад компанийн нийгмийн хариуцлагын тусгайлсан хичээл сургалтын программд нь туссан байдаг юм билээ. Манайд болохоор Санхүү, эдийн засгийн дээд сургууль энэ чиглэлийн нэг хичээлийн хөтөлбөртэй байна. Гэхдээ тэр нь оюутнууд өөрсдөө сонгож үздэг хичээл. Мөн миний мэдэж байгаагаар компанийн нийгмийн хариуцлагын сэдвээр 2-3 магистрийн ажил бичигдсэн байдаг. Бусдаар нэг их үзэж харах юм одоогоор дотоодод бага байна. Би жишээ нь гадагшаа сургалтад явж сурч мэдсэн зүйлээ интернэт ухаж мэдээ мэдээллээр баяжуулж байгаа” хэмээн сонирхууллаа.

Эцэст нь хэлэхэд, компанийн нийгмийн хариуцлага хэмээх үгийг өнөөдрөөс эхлээд зөвхөн компаниудын хэрэгжүүлэх ажил биш, нийгмийн харилцаанд оролцож байгаа хувь хүн танд ч гэсэн хамаатай гэдгийг хэлэх байна. Багагүй хугацаанд сонсох, ярихаас хэтрэхгүй сэтгэлдээ хоосон оршоосон энэ нэр томъёог зүрх сэтгэлдээ ойртуулж, Монголын хөрснөө ургуулах цаг болжээ. Хариуцлагаа амжилттай хэрэгжүүлж, нийгмээ хөгжүүлцгээе, монголчууд аа. ■

Топ-100

Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлдэг бол Топ-100-д өрсөлдөөрэй



Мобиком” компанийн гүйцэтгэх захирал Д.Болор МҮХҮТ-аас өнгөрсөн тавдугаар сард зохион байгуулсан “Компанийн нийгмийн хариуцлага” сэдэвт хурлын үеэр “Нийгмийн хариуцлагыг зөвхөн топ том компаниудаас харж, шаардах биш, жижиг компаниудыг гаргаж ирэх хэрэгтэй. Үүнтэй холбоотой хэлэхэд, манайх энэ жилийн Топ-100 компанийн шагналаас өөрийн хүсэлтээр татгалзахад бэлэн байна. Аливаа юмыг хийхэд урам зориг чухал байдаг. Манайх компанийн нийгмийн хариуцлагаа муу хэрэгжүүлдэгтээ энэ нэр хүндтэй шагналаас татгалзаж байгаа юм биш. Нийгмийн хариуцлага гэхээр манай монголчууд том компаниуд л хийж хэвшүүлэх ёстой гэсэн буруу бодолтой байх шиг санагддаг. Гэтэл нийгмийн хариуцлагыг сайн хэрэгжүүлдэг, 4-5 хүнтэй халуун дулаан орчинтой жижиг компани олон бий. Тэднээс гаргаж ирэх ёстой. Компанийн нийгмийн хариуцлага гэдэгт нэг их том зүйл ойлгох шаардлагагүй. Заавал том байх албагүй, жижигхэн байгууллага хэрнээ ажилтнууд нь усаа хэмнэдэг, цахилгаанаа зөв зарцуулдаг, зөв дадалтай, ажилтнуудынхаа нийгмийн асуудалд анхаарч, сургадаг боловсруулдаг, байгальд ээлтэй үйл ажиллагаа эрхэлдэг компани байхад л тэр нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна гэсэн үг шүү дээ. Тийм жижиг компаниуд манайх нийгмийн хариуцлагаа ингэж хэрэгжүүлдэг гэж өөрсдөө санаачилгаараа гарч ирэх нь ховор. Тийм болохоор МҮХАҮТ-ын Топ-100-гийн шалгаруулалтаар гаргаж ирэх нь чухал юм” гэв. Топ-100-гийн шалгаруулалтад байнга дээгүүр байрт жагсдаг “Мобиком” компанийн гүйцэтгэх захирлын дээрх санал хуралд оролцогчдын талархлыг хүлээсэн. Хурал дуусах үеэр нийгмийн хариуцлагаа сайтар ухамсарладаг компаниудын төлөөлд МҮХҮТ-аас “Нийгмийн хариуцлагын эрхэмсэг оршихуй” нэртэй шагнал гардуулсан. Энэ үеэр МҮХҮТ-ын дарга С.Дэмбэрэл “Шагналд дургүй “Мобиком”-ын Болор захирал гарч ирж, надтай шагнал гардуул” хэмээн хошигнон хэлсэн юм.

Бизнес эрхлэгчдийн шинэ жил буюу МҮХАҮТ-аас жил бүр зохион байгуулдаг “Entrepreneur”-ын үеэр Топ-100 компанийг шалгаруулдаг. Энэ шалгаруулалтыг явуулахдаа тус байгууллагаас үндсэн зургаан шалгуур үзүүлэлтийг тавьдаг гэсэн. Түүнд нь компанийн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх байдал гэдэг шалгуур үзүүлэлт ордог ч тийм

ч тод томруун хамгийн чухал нь болж чаддаггүй. Улсын төсөвт төвлөрүүлсэн татварын хэмжээгээр нь голчилж байр эзлүүлдэг гэж болно. Тэгсэн хэрнээ Топ-100-гийн шагналыг гардуулахдаа компанийн нийгмийн хариуцлагаар тэргүүлэгч гэдэг үгийг ёс юм шиг хэлдэг билээ. Энэ байдалд дээрх хуралд “Эрдэнэт” үйлдвэрийг төлөөлж оролцсон Ө.Золбаяр бас шүүмжлэлтэй хандсан. Тэрбээр “Манай уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр Топ-100-гийн шалгаруулалтад байнга нэгдүгээр байрт жагсдаг л даа. Гэхдээ компанийн нийгмийн хариуцлагаар танайх яг юу хийсэн бэ гэдэг ч юм уу бусад байдлаар Топ-100-гийн мэдээллийг бүрэн гүйцэд авч, шалгуур үзүүлэлтэд нь өөрчлөлт оруулах хэрэгтэй санагддаг” хэмээн ярьсан.

Өнгөрсөн жилийг хүртэл дээрх байдлаар шалгаруулж ирсэн Топ-100 компанийн шалгаруулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай талаар тус хурлын үеэр нэг бус хүн санал хэлсэн. Үүнийг гардан зохион байгуулдаг МҮХҮТ-ын холбогдох хүмүүс ч тэдэнтэй санал нэгдэж байсныг тэмдэглэе.

Нийгмийн хариуцлагын тухай нэгдсэн ойлголттой болж, бодитой зүйл хийж эхлэх чин хүсэл эрмэлзлэлтэй байгаа учраас Монголын компаниудын төлөөлөл ийн зарим асуудалд шүүмжлэлтэй хандаж байгаа хэрэг. Аливаа аж ахуйн нэгж байгууллага бүтэн жилийн хугацаанд хийсэн ажлынхаа үр дүнг харж, үнэлэлт дүгнэлт авах нь Шинэ жилийн үеэр байдаг. Тийм болохоор Монголын бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмждэг гол байгууллага нь МҮХАҮТ. Тиймээс тус байгууллагаас Монголын идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй мянган компани аж ахуйн нэгж дотроос жил бүр Топ-100-г шалгаруулна гэдэг том ажил. Тэрхүү шагналыг авна гэдэг нэр хүндийн хэрэг. Тэгвэл компанийн үйл ажиллагаа эрхэлдэггүй энгийн уншигч ч гэсэн оны эцэст Топ-100 компанийн жагсаалтад ямар өөрчлөлт орж вэ? гэдгийг сонирхдог. Харамсалтай нь тийм ч сонирхол татахаар өөрчлөлт тэр бүр ордоггүй. Уншигчид маань мэргэжлийн байгууллагын шинэчилсэн жагсаалтыг бараг л харалгүй Топ-100-д багтсан компанийг нэрлэж чадахаар болсон. Учир нь, сүүлийн хэдэн жил хүмүүсийн сонирхол татахаар өөрчлөлт ороогүй буюу байнга л шалгардаг компаниуд уламжлал юм шиг цувсан байдаг болохоор тэр. Мөн хамгийн гол шалгуур үзүүлэлт нь улсад хэр их татвар төлсөн нь байдаг болохоор мэдэж ядах юмгүй. Компанийн нийгмийн хариуцлага, засаглал гэх мэт тухайн компанийн хөгжилд тустай сонирхолтой үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт нь Монголд өнөөдрийг хүртэл тодорхой биш байсан тул шалгуур үзүүлэлтэд нэр төдий туссан байсан гэж хэлж болох юм. Тийм болохоор Монголын Топ компаниудын нийгмийн хариуцлагын асуудал ч өнөөдрийг хүртэл өндөр амжилтынхаа хэмжээнд байж чаддаггүй байсан гэсэн үг. Тиймээс ирэх Шинэ жилээс Топ-100 жагсаалтад сонирхолтой өөрчлөлт орох магадлалтай. Харин нийгмийн хариуцлагаа ухамсарладаг, хэрэгжүүлдэг л бол танайх жижиг компани гэлтгүй хүч үзээрэй. Монгол Улсад компанийн нийгмийн хариуцлагын асуудал чухлаар тавигдаж буй учраас таны ажлыг бодитоор бас бодлогоор үнэлэх боломж бий, амжилт. ■

Үзэл бодол

Др.Штефан Хансельманн: Монголд компанийн нийгмийн хариуцлагын стандартыг зөв хэрэгжүүлэх боломж байна

Компанийн нийгмийн хариуцлагын стандартууд эдийн засгийн чадавхи, өрсөлдөх чадварт чухал үүрэгтэй” гэж Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн санаачилга хөтөлбөрийн захирал Др.Штефан Хансельманн ярилаа.

Эдийн засгийн ухааны доктор Штефан Хансельманн нь Малайзын Пенанг дахь Жоржтауны Их сургуульд хоёр жил судалгааны ажил хийсний дараа Германы Констанц хотын Их сургуулиас эрдмийн зэргээ 1988 онд авсан байна. Тэрбээр ажлын гараагаа Германы эм зүйн Шеринг компанид стратеги төлөвлөлт, компанийн хөгжил чиглэлээр хашиж эхэлсэн байна. Улмаар 1991-1993 оны хооронд Шерингийн Ази-Номхон далайн Токио дахь төвд төслийн менежерээр ажиллажээ. 1993 онд Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн (цаашид ГОУХАН) Шинэ Делид хэрэгжүүлсэн Худалдаа, хөрөнгө оруулалтын төсөлд дэд захирлаар томилогдсон байна. 1996 онд Др.Хансельманн Латви улсын Riga хот руу нүүж, 1999 он хүртэл ГОУХАН-т, 1999 оны сүүлчээс Германы автомашины аж үйлдвэрт зориулсан цахилгаан эд анги болон хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг компанид захирлын албан тушаалыг гүйцэтгэсэн байна. 2008 оны долдугаар сард Монголд ирж, 2009 оны арванхоёрдугаар сараас эхлэн ГОУХАН-ийн Хөрөнгө оруулалтын бодлогын стратегийн зөвлөгөө төслийн (2011 оны 8-р сарын 1-ээс “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөрийн) захиралаар ажиллаж байна.

-Монгол, Германы эдийн засгийн хөгжлийн түүхээс ярилцлагаа эхлэх үү. Таны бодлоор, өнөөдөр хоёр орны бизнесийн хөгжил ямар түвшинд явж байна?

-Германы эдийн засаг хөгжлийн урт удаан түүхийг туулсан замналтай. Европт аж үйлдвэржилт XIX зууны дунд үеэс, одоогоос бараг 150-иад жилийн өмнө эхэлсэн билээ. Тиймээс Герман улс аж үйлдвэржилтийн мөчлөгийн дэвшилт шат руу аль хэдийн шилжин орсон. Социологи судлаачид материаллаг бус, өөрөөр хэлбэл мөнгө хамгийн гол хөдөлгөгч хүчин зүйл биш, харин амьдралын чанар, эдийн засаг, байгаль орчны тогтвортой байдлыг эрхэмлэдэг нийгмийн талаар ярих болсон. Энэ нь нүүдэлчний соёл иргэншилтэй Монгол орноос ялгагдах гол онцлог юм. Уул уурхай ирэх арваад жилийн турш эдийн засагт давамгайлах салбар болно. Герман, Монгол Улс нь эдийн засгийн хөгжлийн хоёр тэс ондоо тавцан дээр байгаа бөгөөд аж үйлдвэржилтийн төрөл ч гэсэн ондоо байх төлөвтэй. Миний бодлоор Монголын эдийн засгийн хөгжил гол төлөв байгалийн нөөц олборлолт, уул уурхайн салбар луу чиглэгдэх байх. Дэлхийн хамгийн анхны уул уурхайн Их сургууль XVIII зууны эхэн үед Саксон мужийн Фрайберг хотод байгуулагдсан хэдий ч уул уурхай нь Германд Монголд голлох



салбар болж байгаа шиг үүргийг хэзээ ч гүйцэтгэж байгаагүй. Германы уул уурхайн хөгжил тоног төхөөрөмж, химийн болон автомашины үйлдвэр хөгжих эх суурийг тавьж өгсөн юм. Уул уурхайн салбар 2018 он гэхэд албан ёсоор бүрмөсөн хаагдана.

-Герман, Монголын бизнесийн салбарын ялгааны талаар Та тодруулж ярина уу?

-Эрхэлж байгаа бизнесийн төрлүүд маш ялгаатай. Германы хувьд эрт үеэс машин зохион бүтээх ба тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх салбар илүүтэй хөгжсөн байдаг. Автомашины үйлдвэр “Фольксваген”, “Ауди”, “Даймлер” (Ноён Даймлер, ноён Бенц нар орчин үеийн машиныг бүтээгчид), “Порше” компанийг гаргаж ирсэн. Эм зүй, химийн үйлдвэрийн хувьд “Байер”, “Би Эй Эс Эф” (BASF), “Мерк”, цахилгаан барааны “Сийменс”, “Браун”, “Инфиненон,” “Сингулус” гэхчлэн дэлхийд алдартай олон компани бий. Саяхнаас эрчим хүчинд хэмнэлттэй, ногоон технологи нэвтрүүлсэн компаниуд Германы эдийн засгийн хөгжлийг тэргүүлэх болов. Харин Монгол орны хувьд мэдээж уул уурхай, байгалийн баялгийг олборлох салбар нэн чухал. Энэ нь уул уурхайтай хамааралтай аж үйлдвэр болон энэ салбарт бүх төрлийн үйлчилгээ үзүүлэгчид, тоног төхөөрөмж нийлүүлэгчид болон олборлох компани үүсэн бий болоход хүргэнэ. Монгол Улс коксжих нүүрс, төмрийн хүдэр, зэс боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж амжилтад хүрэх эсэхийг харах үлдэж байна. Үүнээс гадна мах ба сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэл боломжийн санагдаж байна. Эдгээр үйлдвэрлэл нь хөрөнгө оруулалт бага шаардахаас гадна ажлын байр бий ▶

► болгох сайн талтай.

-Германчуудын хувьд Монголд бизнес эрхлэхэд ямар хүндрэл бэрхшээл байдаг бол?

-Герман улс нь дэлхий дээр Хятадын дараа орох хоёр дахь томоохон экспортлогч. Энэ баримтыг харгалзаж үзвэл, Монгол оронтой хийж байгаа хэдэн зуун сая еврогийн худалдаа нь Германы нийт өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөөлөл болохгүй. Германд дэлхийн тавцанд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компани байхгүй. Тиймээс энэ чиглэл дээр Австрали, Канад, Хятад гэх мэт томоохон уул уурхайн компанитай орон илүү хамтарч ажиллана. Тэд шинэ төсөлд хэрхэн хөрөнгө оруулж хэрэгжүүлэхийг илүү сайн мэднэ. Харин Германы хувьд газрын тос ба хийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, Оростой хамтран ажиллаж байна. Хоёр дахь нөлөөлөх хүчин зүйл гэвэл Германы компаниуд нь бизнесээ өөрсдийн ширээнийхээ араас, бараа бүтээгдэхүүнээ дэлхийн өнцөг бүрт экспортолсоор ирсэн уламжлалтай. Германд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэлхий даяар усаар тээвэрлэдэг арга сүүлийн 100-гаад жилийн турш маш сайн үйлчилсэн. Гэвч өнөөдөр дэлхийн чиг хандлага өөрчлөгдөж байна. Эцэст нь сэтгэлгээний асуудал гарч байна. Германы компаниуд тухайн улсын зах зээлд нэвтрэхэд “бизнесийн орчин” буюу найдвартай бүтэц, журмыг шаарддаг бөгөөд урт хугацааны бизнесийн хөгжлийг чухалчилдаг. Хэрвээ эдгээр нөхцөл байдал нь ил тод бус, найдваргүй байвал Германы компаниуд шинэ зах зээлд хөрөнгө оруулахаас татгалзах нь элбэг. ГОУХАН-ийн зүгээс энэхүү бэрхшээлийг олж харсан бөгөөд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилготой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа. Хоёр жишээ нэрлэхэд, манай хуулийн төсөл Хууль зүйн яамтай хуулийн кодексийг шинэчлэх тал дээр, эрчим хүчний төслөөр ЭБЭХЯ-тай тус тус хамтран ажиллаж байна. Ингэж эрх зүйн нөхцөл байдлыг сайжруулснаар, бизнесийн орчинг хөгжүүлж, улмаар Германы зүгээс орж ирэх хөрөнгө оруулалт нэмэгдэх ач холбогдолтой юм.

-Монголд бизнес эрхлэхэд давуу талтай юу?

-Маш олон сонирхолтой боломж байгаа гэж би бодож байна. Мөн сүүлийн 12-18 сарын дотор өөрчлөлтүүд асар хурдтай гарч байна. Монголын уул уурхайн компаниуд Германаас тоног төхөөрөмж авах сонирхол нэмэгдэж байгаа. Нэг бус нэлээд хэдэн герман компани төлөөлөгчийн газраа нээсэн. Хоёр орны компаниудын хамтарч ажиллах сонирхол улам бүр нэмэгдэж байгааг онцлон тэмдэглэхэд таатай байна.

-Германы хөрөнгө оруулалтын чухал үе шатны талаар ярьж өгнө үү. Германы хөрөнгө оруулалт ямар бодлого, загварыг баримталдаг вэ?

-Дэлхийн II дайны дараах үеийг үндсэн гурван хэсэгт хувааж болно. 1960-аад онд Германы “Эдийн засгийн гайхамшиг” хэмээгдэх үе эхэлж, дэлхийн тэргүүлэгч экспортлогч болсон юм. “Германд үйлдвэрлэв” нэртэй алдарт брэнд энэ үед гарч ирсэн. Дээд зэргийн чанар, нарийн технологи, үйлдвэрлэлийн өндөр бүтээмжтэй аргыг ашиглан гаргасан энэхүү брэнд нь үнийн хувьд маш үнэтэйд тоцогддог. Удаах үе 1980-аад оны эцэст эхэлсэн бөгөөд “Сийменс”, “Фольксваген”, “Ауди”, “Би Эй Эс Эф” (BASF) нар үйл ажиллагаагаа олон улсын тавцанд явуулах болжээ. Учир нь Хятад Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогын дагуу олон улсын компаниуд бараа бүтээгдэхүүнээ Хятад руу экспортлох биш, харин тус улсад хөрөнгө оруулах шаардлагыг дагах хэрэгтэй болсон. Энэ үйл явц “Бош”, “Грамммер”, “Хелла”, “Дракслмайер” компанийн Энэтхэг, Хятадын хөрөнгө оруулагчид болгосон. Фольксваген компани гэхэд Хятадын зах зээлийн 20 хувийг эзэмшиж байна. Энэхүү чиглэлийг 1990-ээд оны үед баримталсаар

ирсэн. Мөн энэ үед Зүүн Европын орнуудын хил хязгаар нээгдэж, Германы компаниуд алс холын Хятад, Энэтхэг орнуудтай хамтрахаас илүү хилийн дээс даваад л орчих Польш, Словак, Чех улстай эдийн засгийн харилцаа холбоо тогтоосон. Ингэснээр үйлдвэрлэлийн зардлыг маш их хэмнэж, Герман улсын өрсөлдөх чадвар огцом сайжирсан. Энэхүү хөгжлийн үр шимийг хүртэгчид нь томоохон компаниуд биш, харин Германы жижиг, дунд үйлдвэрүүд болсон нь онцлог юм. Германы эдийн засгийн тулгуур хүч, хөгжлийн түлхүүр нь жижиг, дунд үйлдвэрүүд юм. Өнөө үед ч гэсэн Германы компаниудын дийлэнх хувийг Жижиг дунд компаниуд эзэлдэг (тус орны жижиг, дунд үйлдвэрүүд нь хэдэн зуун ажилтан, 200-300 сая еврогийн эргэлтийн хөрөнгөтэй байдгийг дурдъя). Ихэнх тохиолдолд гэр бүлийн бизнесийн хүрээнд явуулдаг эдгээр жижиг, дунд үйлдвэрүүдийг өнөөгийн эзэмшигчдийн аав, өвөө нь 1950-1960 оны хооронд үүсгэн байгуулж байв. Германы эдийн засгийн гурав дахь үе одоогоос 5-7 жилийн өмнө эхэлсэн гэж хэлж болно. Урьд өмнө нь жинхэнэ утгаараа олон улсын хэмжээнд нэрээ гаргаж байгаагүй жижиг, дунд үйлдвэрүүд одоо дэлхий дахинд үйл ажиллагаа явуулж байна. Үүний нэг шинж тэмдэг нь Европ дотор худалдааны хэмжээ буурч байгаа үзэгдэл юм. Одоогоос 15 жилийн өмнө Германы нийт экспортын бүтээгдэхүүний 75 хувийг Европын бусад орны хооронд гаргадаг байсан бол энэ тоо өнөөдөр 60 хувь хүрч буурсан байна, цаашид ч багасах хандлагатай. Энэ нь бүтээгдэхүүнээ Азид экспортлох болсонтой холбоотой бөгөөд эдгээр жижиг, дунд үйлдвэрүүд бизнесийн стратегия үндсээр нь өөрчлөхөд хүрч байна. Жишээ нь, Өндөр технологийн “Аикстрон” (Aixtron) компани үйлдвэрлэдэг тоног төхөөрөмжийнхөө 94 хувийг Ази руу экспортолж байгаа.

-Монголд нийгмийн хариуцлагын (КНХ) талаар тийм ч тодорхой ойлголтгүй. Сүүлийн жилүүдэд хөгжүүлэхэд ихээхэн анхаардаг болж байна. Компанийн засаглал, компанийн нийгмийн хариуцлага нь улс орны хөгжилд хэр нөлөө үзүүлдэг вэ?

-КНХ маш чухал. Монгол Улсад компанийн засаглал, КНХ-ын стандартыг эдийн засгийн хөгжлийн эхэн үеэсээ зөв хэрэгжүүлэх боломж байна. “Оюу толгой” компани л гэхэд энэ чиглэлээр 800 сая ам.долларыг дотоодын зах зээлд 2011 онд зарцуулна гэж хэлсэн. Энэ нь Монголын хувийн эвшилд өргөжин хөгжих томоохон аз шавшаан тохиож байна. Гэхдээ үүнийг дэлхийн хэмжээний хамгийн сайн туршлагад тулгуурлан хийх хэрэгтэй. “Манчестерийн капитализмийн” зарчмууд урт хугацааны үр дүнд хүргэхгүй гэдгийг компаниуд ойлгох шаардлагатай. Хүний нөөц, байгалийн баялгийн ашиглалтад анхаарал тавих зайлшгүй хэрэгтэй. Стандарт дэг журмыг үл харгалзан үйл ажиллагаагаа явуулах уул уурхайн салбар юунд хүргэдгийг харуулсан олон баримт, жишээ байдаг. Уурхайн хуучин орд газрууд, ухаж орхигдсон талбай, химийн бодисоор бохирдсон усны нөөц, сүйтгэгдсэн газар үлддэг. Эдгээр жишээ КНХ-ын стандартыг хэрэгжүүлж, Монголын компаниудад энэ талын сургалт мэдээлэл явуулах нэн чухал буйг харуулж байна. Гэвч стандартыг хэрэгжүүлж эхлэхэд хэзээ ч оройтохгүй. Монголын компаниуд энэ сэдвийг сонирхож эхэлсэн нь дуулгах сайн мэдээ. Гэсэн хэдий ч мэдээлэл, сургалт, тайлбарын ажил учир дутагдалтай байна. Компаниудын хувьд КНХ-ыг зөвхөн нэмэлт зарлага мэтээр ойлгож байна. Гэтэл бизнесээ тогтвортой хөгжүүлэх зорилготой бүх компанид энэ асуудал хамааралтай. КНХ-ыг тухай өнөөдрөөс бодож эхлээч ээ гэж би зөвлөмөөр байна. Эхэн үедээ мөнгө зарцуулагдах ч энэхүү хөрөнгө оруулалтын үр дүнд бизнесээ хэрхэн тогтвортой хөгжүүлэх тухай үнэ цэнэтэй мэдлэгийг олж авна.

-ГОУХАН-ээс зохион байгуулах КНХ-ийн чиглэлийн ►►

олон улсын бага хурлын зорилго юу вэ?

-ГОУХАН-ээс ирэх есдүгээр сарын 6-7-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор Компанийн нийгмийн хариуцлагын бага хурлыг Монголын компанийн засаглалыг хөгжүүлэх төв, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын төв болон Германы компанийн засаглалын төвтэй хамтран Их тэнгэр цогцолборт зохион байгуулна. Хурлын зорилго нь КНХ бол эдийн засгийн өрсөлдөх чадварын чухал хүчин зүйл, нэмүү өртгийн сүлжээний нэгэн хэсэг, компанийн амжилтын үндэс мөн гэдгийг ойлгуулахад оршино. Энэ чиглэлд олон жил ажилласан Германы компани, туршлагатай байгууллагуудыг оролцуулахаар урьсан байгаа. “Адидас”, “Би Эй Эс Эф” гэхчлэн компаниудын жишээн дээр КНХ-ын бодлого, стандарт хэрхэн хэрэгждэг талаар танилцуулах болно.

-Танай хөтөлбөр КНХ, компанийн засаглалын чиглэлээр зөвлөгөө өгдөг үү?

-КНХ-ын чиглэлээр зөвлөгөө өгдөг. ГОУХАН дээр дурдсан байгууллагуудтай хамтарч, нэу-хауг Монгол компанид дамжуулах тал дээр ажиллаж байна. Илүү ойлголттой болохыг хүссэн компаниудыг бид хэрэгцээтэй мэдээллээр хангаж өгдөг.

-Та ГОУХАН-ийн хөтөлбөрийнхөө талаар танилцуулна уу?

-Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг нь Монголд үйл ажиллагаа явуулахад бараг 20-иод жилийн нүүр үзэх гэж байна. Одоогийн байдлаар нийт долоон төсөл хөтөлбөртэй. Манай “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөр 2014 оныг дуустал хэрэгжинэ. Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга (IMRI) хөтөлбөрийн гол зорилго нь Монгол Улсыг түүхий эдийн салбар голлох эдийн засгийн цогц бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт ба эрдэс баялгийн түүхий эдийн салбараас орж буй орлогыг өргөн цар хүрээтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтөд ашиглахад хэрэгцээт институцийн болон эдийн засгийн нөхцөлүүдийг сайжруулахад, уг процесст гадаадын болон Монголын хувийн хэвшлийг зохистой харилцаагаар татан оролцуулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах юм.

Бид Монгол түнш байгууллагуудаа эдийн засгийн сайн засаглал (үүнд КНХ болон эдийн засгийн ил тод байдлын аспект орно), хувийн болон санхүүгийн секторыг хөгжүүлэх, уул уурхайн салбартай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх гэсэн гурван гол салбарт дэмжин ажилладаг. Мөн Монголын Хөрөнгийн бирж, Төрийн өмчийн хороо (ТӨХ), Стандартчилал хэмжил зүйн төвтэй хамтардаг. Манай гурван ажилтан ТӨХ дээр шинээр үүсгэн байгуулах гэж байгаа IPO хэлтэс дээр төвлөрөн ажиллаж байна.

-Та Герман -Монголын бизнес эрхлэгчдийн холбооны (ГМБЭХ) тэргүүн. Энэ ямар зорилготой холбоо вэ?

-ГМБЭХ нь нийт 40-өөд идэвхитэй гишүүнтэй. Холбоогоороо дамжуулж, Германы компаниуд болон бизнес эрхлэгчдэд зориулж мэдээлэл зуучилдаг. Бид Монголд ирж байгаа Германы бизнес төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулж, Германы байгууллагуудад Монголын өнөөгийн хөгжлийн талаар мэдээлдэг. Мөн Германы компаниудтай бизнес эрхлэх сонирхолтой, эсхүл Германаас тоног төхөөрөмж худалдаж авахыг хүссэн монгол компаниудыг мэдээллээр хангадаг.

-Монголын компаниуд Германы жижиг дунд үйлдвэрүүдтэй хамтарч ажиллах боломжийн талаар Та юу гэж бодож байна?

-Германы Жижиг дунд үйлдвэрүүд нь дэлхийн зах зээлийг эзэлсэн томоохон компаниуд биш учир Монголын компаниудтай хамтарч ажиллахад маш тохиромжтой гэж

бодож байна. Учир нь, Монголын зах зээл төдийлэн том биш тул хэмжээний хувьд сайн дүйцнэ. “Нууц Аваргууд” нэртэй эдгээр компаниуд холбогдох салбартаа технологи туршлагаараа тэргүүлдэг. Ихэнх тохиолдолд гэр бүлийн бизнес байдаг тул, менежментийн хүчин чадал хязгаарлагдмал. Тэдгээр компаниудын хувьд бизнесийн орчин тогтвортой, найдвартай байх нэн чухал. Хэрэглэгч төвтэй дотоодын түншийн санал шаардлагыг уян хатан хүлээж авдаг, ажлын байр бий болгох тал дээр илүү анхаардаг ийм компаниуд юм. Эдгээр жижиг, дунд үйлдвэрүүдийн сонирхлыг татахуйц тусгайвчлан бэлдсэн стратегийн төлөвлөгөө гаргавал маш сонирхолтой гэж үзэж байна.

-Уул уурхайн салбар Монголын эдийн засгийг тогтвортой өсөлтөд хүргэж чадна гэдэгт Та итгэж байна уу?

-Уул уурхайн салбар мэдэгдэхүйц хэмжээний өсөлтийг хэдийнэ бий болгосон. Гэвч энэ нь тэнцвэртэй, тогтвортой хөгжилд хүргэж чадах уу? Энэ асуултын үнэ зургаан сая долларын өртөгтэй. Тэрхүү өсөлтийг зохицуулах зөв стратеги болон бодлогоос ихэд шалтгаална. Асуулт үүнийг хэрхэн бүх талуудад ашигтай зохицуулах вэ гэдэгт байна. Засгийн газрын зүгээс тохиромжтой арга замыг хайж байгаа ч одоогоор дүгнэн хэлэхэд арай эрт байна. Ашиг орлогын давалгаа 2013 ба түүнээс хожуу үед бий болно. Тооцоолоход бэрх олон асуудал гарч ирнэ. Монгол Улс гаднаас орж ирэх ажлын хүчийг яаж зохицуулах вэ? Төлөвлөж байгаа бүх төслийг хэрэгжүүлбэл Монгол ойрын 20-иод жилийн турш хүний нөөц ба хөрөнгийг импортлогч болно. Энэ асуудлыг улс төр, нийгмийн хувьд хэрхэн шийдэх вэ? Оросоос дарамт үзүүлэх эрсдэлтэй. Саяхан гэхэд түлшний асуудалтай бид тулгарсан. Одоогийн байдлаар Монгол орон салаа зам дээр зогсож байна.

-Манайд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом өсч байгаа. Энэ талаар Та юу гэж боддог вэ?

-Зөв эх сурвалжаас гаралтай, зөв төрөл зүйлийг тусгаж, ухаалаг зохицуулалттай байвал гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нь мэдээж сайн зүйл мөн. Улс орноо хөгжүүлэх замд Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт шаардлагатай. ГШХО-ын хэмжээ ганцхан салбарт, ганцхан төсөлд төвлөрч байна. Нэг том төсөл эдийн засгийн өсөлтийг үүсгэхгүй. Эдийн засаг, нийгмийн зохистой хөгжил гэж олон төрлийн сурвалжаас гаралтай, олон оролцогч талын хэрэгцээнд тохирсон, тэнцвэртэй өсөлтийг хэлнэ. Иймээс эдгээр том үүрэг даалгаварт анхаарлаа хандуулахын тулд ГШХО-ын удаах урсгал хэрэгцээтэй болж байна.

-Герман Монголын түүхэн харилцаа Монгол орны хөгжилд ямар хувь нэмэр оруулж байгаа вэ?

-Герман улс шиг Монгол оронтой ийм удаан, дотно, найрсаг харилцаа тогтоосон орон бараг байхгүй болов уу гэж би бодож байна. Хоёр орны харилцаа холбоо XIII зуунд анх эхэлсэн. 1920-иод оны үед Монгол улсаас анхны оюутнууд Герман луу суралцахаар явсан. Хуучин Зүүн Германд олон Монгол оюутан суралцаж, амьдарч байх үед хоёр орны хоорондын харилцаа улам ойр дотно болсон. Харамсалтай нь 1990-ээд оны үед энэхүү онцгой харилцаа цаашид нэмэж өргөжөөгүй. Гэсэн хэдий ч Герман, Монголын харилцаа ер бусын шинж чанартай. Хүн амын 1.5- 2 хувь нь герман хэлээр ярьдаг өөр орон Ази тивд хаана ч байхгүй. Одоогийн байдлаар нэг мянга гаруй Монгол оюутнууд Герман улсад амьдарч, суралцаж байна. Герман улс Монголын хувьд яагаад сонирхолтой түнш нь болж байгаа вэ гэвэл, бид нарт уул уурхайн салбар дээр шууд сонирхол байхгүй тал. Хоёрт гэвэл, Германы компаниуд нь урт удаан хугацааны бизнесийг хөгжүүлэхийг чухалчилдаг. Ойрын хугацаанд хоёр орны харилцаанд хүчтэй ахиц гарна гэдэгт би итгэлтэй байна. ■

Компанийн засаглал

Хөрөнгийн бирж хөрсөө шинэчилж байна

Цахим шуудангаа нээхэд дахиад л баахан мэдээлэл иржээ. “Хүннү коал”-ын томоохон хувьцаа эзэмшигчийн багцад өөрчлөлт орсон тухай мэдэгдэл гарсан бол “Петро матад” хайгуулын ажлын явцынхаа талаар мэдээлсэн байх жишээтэй. Гадаадын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгосон компаниуд ийнхүү үйл ажиллагааныхаа тухай тогтмол, тодруулбал сардаа хэд хэдэн удаа хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулдаг.

“Компаниуд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байж л хөрөнгө татаж чадна. Харин энэ нөхцөлийг компанийн засаглал бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалдаг. Хөрөнгө оруулагчид мэдээллээр л тэжээгдэж байдаг учраас энэ нь засаглалын амин судас юм” хэмээн Компанийн засаглалын хөгжлийн төвийн захирал Ж.Үнэнбат тайлбарласан билээ. Гэтэл Монголын хувьцаат компаниуд санхүүгийн тайлангаа гаргахгүй, хувь нийлүүлэгчдийн хурлаа товлохгүй, ногдол ашгаа тараахгүй байх нь энүүхэнд. Бүр хаана байршиж байгаа нь тодорхойгүй, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь эргэлзээтэй том толгойтнууд Монголын хөрөнгийн биржээр дүүрэн хөглөрнө. Энэ бүхэнд

цэг тавьж, их цэвэрлэгээ хийж байж л компанийн засаглалыг сайжруулах нөхцөл бүрдэхийг Монголын эдийн засгийн форумын оролцогчид тэмдэглэж байсан.

Өнгөрсөн онд бүртгэлтэй байсан 336 хувьцаат компанийн 86 хувь буюу 288 нь сүүлийн хоёр жил дараалан үнэт цаасны бүртгэлийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангалгүй ирснийг Монголын хөрөнгийн биржийн шинэхэн удирдлага “илрүүлсэн”. Хувьцаат компаниудын ихэнх нь төрийн өмчит болон “гэр бүлийнх” (цөөн хүний эзэмшилд байдаг) учраас мэдээллийн ил тод байдал гэдгийг огт мэддэггүй, жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг зөрчиж, хууль журмыг уландаа гишгэдэг тухай Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвийнхөн аль эртнээс мэддэг байсан. Энэ чиглэлээр хийсэн судалгаа ч олон бий боловч дорвитой арга хэмжээ авалгүй өдий хүрсэн билээ. “Зах зээл анхнаасаа зөв голдирлоороо хөгжиж эхлээгүй болохоор компанийн удирдлагууд мэдээллийн ил тод байдлыг авч хэрэгсдэггүй байсан” хэмээн Монголын хөрөнгийн биржийн Бүртгэлийн албаны захирлын үүрэг

гүйцэтгэгч М.Энхтуяа тайлбарлаж байна.

1991 оноос төрийн өмч хувьчлах бодлогын хүрээнд 520 үйлдвэр, аж ахуйн нэгжийг ямар ч шалгуургүйгээр бүртгэх замаар Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүссэн билээ. Гэтэл эдүгээ 20 насыг зооглож буй Монголын хөрөнгийн биржийн түүхэнд 20 гаруйхан компани л шинээр бүртгүүлж, нэмж үнэт цаас гаргасан байдаг шүү дээ. Хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох хүсэл, эрмэлзлэлийг бий болгохын тулд олон жил бугшсан заваан байдлыг арилгахаар СЗХ, Монголын хөрөнгийн биржийн мэргэжилтнүүд ханцуйгаа шамлан ажилдаа оржээ. Өнөөгийн 334 хувьцаат компанийн 145 нь бүртгэлээс хасагдах нөхцөлтэй байгаа юм. Үлдсэн 189 компанийг “A board”, “B board” гэж хоёр ангилсан бөгөөд үүнээс ч 52-ыг нь “Баяртай” гээд явуулах төлөвтэйг хүснэгтээс харна уу.

Хувьцаат компаниудын удирдлагыг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэг болтол нь “сургахын” тулд мэдээж олон ажил хийх хэрэгтэй. Энэ хүрээнд Монголын хөрөнгийн биржийнхэн эхний ээлжинд үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээгээ шинэчилжээ. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөө хэрхэн зарцуулж байгаагаа хагас жил тутамд тайлагнах, Компанийн засаглалын кодекст заасан журмуудыг мөрдлөг болгон ажиллах зэрэг үүргийг гэрээндээ нэмж зааж өгсөн байна. Үүний зэрэгцээ мэдээллээ товлосон хугацаанд өгөхгүй бол 50 мянган төгрөгийн торгууль ногдуулна гэсэн шинэ заалт багтаажээ.

М.Энхтуяагийн хэлснээр хариуцлага тодорхой хэмжээгээр өндөрсөн нь компаниуд мэдээллээ өгөхөд нөлөөлж эхэлсэн байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 135 компани хувь нийлүүлэгчдийн хурлаа зарлан хуралдуулж, 101 аж ахуйн нэгж санхүүгийн тайлангаа ирүүлсэн байгааг доорх хүснэгтээс харна уу. Он дуустал зай байгаа тул мэдээллээ өгч буй компанийн тоо нэмэгдэх хандлагатай. “Өмнө нь монголчууд хөрөнгийн зах зээлийн ач холбогдлыг ухамсарлаж байгаагүй. Харин одоо хөрөнгийн биржийг хөгжүүлэх тухай, компанийн ▶

Нийт бүртгэлтэй компани	334	100%
Бүртгэлтэй компани /LISTED/	189	56.4%
A board	32	
B board	157	
<i>Үүнээс: 52 ХК-ийн арилжааг зогсоож, бүртгэлээс хасуулахаар СЗХ-нд санал хүргүүлсэн, 73 ХК-д албан бичгээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, МХБ-тэй гэрээ шинээр байгуулж цаашид идэвхитэй ажиллахыг шаардсан</i>		
Бүртгэлээс хасагдах нөхцөлтэй /DELIST/	145	43.3%
СЗХ-ноос арилжааг нь зогсоосон	122	
<i>Анх 2008 оны 2-р сард 166 ХК-ийн арилжаа зогсоосон ба түүнээс 27 ХК нь бүртгэлээс бүр мөсөн хасагдаж, 13 ХК-ийн арилжааг сэргээсэн юм.</i>		
100% төрийн өмчит /огт хамрагдаагүй/		23

Эх сурвалж: МХБ

Он	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011.06.30
Нийт ХК-ийн тоо	395	392	387	384	376	358	336	334
Өмчлөлөөр:								
Төрийн өмчит	67	66	59	56	55	53	51	52
Хувийн өмчит	328	326	328	328	321	305	285	282
Бүртгэлтэй ҮЦ-ны тоо ширхэг	2,014,738,601	2,161,306,945	2,270,794,712	2,491,116,030	3,025,214,094	3,097,025,384	2,685,572,454	2,732,430,869
Төрийн өмчит	1,752,809,647	1,876,501,779	1,866,939,156	1,855,073,030	1,854,695,370	1,854,619,939	1,854,363,339	1,854,589,339
Хувийн өмчит	261,928,954	284,805,166	403,855,556	636,043,697	1,170,518,724	1,242,405,445	831,209,115	877,841,530
Шинээр бүртгэгдсэн ХК	4	3	3	5	6	1	0	1
Бүртгэлээс хасагдсан ХК	11	6	8	8	14	19	22	3
ХНХ зарлан хуралдуулсан	117	136	138	153	159	166	159	135
Санхүүгийн тайлан ирүүлэлт	174	158	145	114	115	105	151	101
Ногдол ашиг тараасан	12	17	23	30	38	27	16	27
Төндөр зарласан	19	26	8	8	2	2	2	2

Эх сурвалж: МоХБ

засаглалыг сайжруулах хэрэгтэйг дээр доргүй л ярьж байна. Энэ нь аж ахуйн нэгжүүд мэдээллээ өгөхөд мөн нөлөөлж байгаа болов уу” хэмээн М.Энхтуяа яриу.

Гэвч компанийн удирдлага, ТУЗ болон Хянан шалгах зөвлөл, хувьцааны таван хувиас дээш багц эзэмшигч зэргийн мэдээлэл өнөөдөр ч хангалттай биш байгааг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас харахад ойлгомжтой. 2007 оны сүүлчээр Санхүүгийн зохицуулах хорооны хурлаар Компанийн засаглалын кодексыг баталсан боловч энэхүү ойлголтын тулгын гурван чулуу болох шударга, хариуцлагатай, ил тод байдлыг эрхэмлэдэг хувьцаат компани Монголд алга гэвэл буруудахгүй ээ. Лондоны хөрөнгийн биржид хувьцаагаа арилждаг “Петро матад” (тус компанийн 19.93 хувийг “Петровис”, 3.58 хувийг Ж.Оюунгэрэл эзэмшдэг) л гэхэд өнгөрсөн жилийн тайлан хэмээн 56 хуудас материал бэлтгэсэн байгааг дурын хүн интернэтээр татаж аваад уншиж болно. Үүний хажуугаар санхүүгийн тайлангаа олон улсын стандартын дагуу гаргаж, хөндлөнгийн аудитаар хянуулан олон нийтэд мэдээлнэ. “Петро матад”-аас гадна “Аспайр майнинг”, “Хүннү коал”, “Харанга ресорсез” зэрэг монгол эзэмшигчидтэй, монгол менежменттэй олон компани гадаадаас мөнгө босгоод, компанийн засаглалыг хэрэгжүүлээд явж чадаж байна. “Энержи ресурс” л гэхэд Хонконгийн хөрөнгийн биржийн өндөр босгыг давж, их хэмжээний хөрөнгө төвлөрүүлснийг сануулах юун. Товчхондоо, компанийн засаглал гэдэг

монголчуудаас хол ойлголт огтхон ч биш бөгөөд түүнийг хэрэгжүүлэх нь ямар сайн талтайг мэдэрсэн, бусдадаа үлгэр дуурайл болчихоор үндэсний компани цөөнгүй байна шүү дээ.

Тэгвэл Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад үүнийг ойлгуулах, мэдрүүлэх тал дээр хэрхэн анхаарч байгааг нь лавлахад Г.Саруул одоогоор энэ чиглэлээр тулж ажиллах цаг хараахан ирээгүйг тайлбарлав. “Компанийн засаглалыг монголчууд 20 жил хайхралгүй ирсэн. Одоо хууль эрх зүйн орчин бүртгэл хэдхэн сар хүлээх л үлдлээ” гэж тэрбээр тэмдэглэсэн юм. Гэхдээ нэмж үнэт цаас гаргахдаа нэлээд амжилт үзүүлсэн “Силикат” компани мэдээллээ ил тод байлгах, засаглалыг хэрэгжүүлэх тал дээр бусдыгаа уриалан дуудаж чадсаныг Г.Саруул мөн онцолсон юм. Тус компанид хөрөнгө оруулах сонирхолтой аж ахуйн нэгж, иргэд ч олон байсан учраас хувьцаа нэмж гаргах сонирхолтой компани мөн олширч байгаа гэнэ.

Үүний зэрэгцээ Монголд үйл ажиллагаа явуулдаг “Айвенхоу майнз”, “Саусгоби ресорсез”, “Професи коал” зэрэг компани Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа гаргах хүсэлтэйгээ илэрхийлж байсан. Гэвч манай хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин олон улсын стандартаас зөрдөг учраас гадаадын хөрөнгө оруулагчид болгоомжилсон тал бийг МІСС хөрөнгө оруулалтын банкны ерөнхийлөгч Д.Ачит-Эрдэнэ тайлбарлажээ. Олон улсын зах зээлд нэр хүнд нь өссөн компаниуд Монголын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх нь засаглал,

мэдээллийн ил тод байдлаараа үлгэр жишээ болохоос эхлээд олон сайн талтайг Г.Саруул ч мөн онцлоод, үүний тулд хөрөнгийн зах зээл “хөрсөө шинэчлэх” хэрэгтэйг хүлээн зөвшөөрөв. Компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ намрын чуулганаараа батлах төлөвтэй бөгөөд тэр хооронд Монголын хөрөнгийн бирж бүртгэлийн стандартаа олон улсын түвшинд хүргэж, “Millenium IT” программаа суулгах зорилготой ажиллаж байгаа юм билээ. Ирэх оны эхний улиралд хөрсөө шинэчилж үндсэндээ дуусахыг мэргэжилтнүүд ярьж байна.

Компанийн засаглалаар тэргүүлэгч АНУ арга хэмжээ авсан зөрчлүүд болон торгуулийн хэмжээгээрээ дэлхийд толгой цохидог. Тэгвэл Монголд ч гэсэн хууль эрх зүйн орчин нь бүрдээд ирэхээр засаглалыг уландаа гишгэдэг том толгойтнуудад өндөр хариуцлага хүлээлгэхээ албаны хүмүүс амлаж байгаа юм. “Хөрөнгийн захад орж ирнэ гэдэг зүгээр л мөнгө аваад гарах биш, тэр хэмжээгээр өндөрүүрэг, хариуцлага хүлээхийн нэр” хэмээн Г.Саруул онцлов. Шударга, хариуцлагатай, ил тод компанийг хөрөнгийн зах зээл ч, хөрөнгө оруулагчид ч хүсэж байна. Өмч хувьчлалын бодлогын дагуу ямар ч шалгуургүйгээр бүртгэгдэж, тэр хэрээрээ дураараа дургиж байсан компаниудад одоо ингэж болохгүй гэх сануулгыг өгч эхэллээ. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд засаглалаа сайжруулж чадахгүй бол “Баяртай” болох цаг ойртсоор. ■



Ч.Отгочулуугийн булан

Өрсөлдөх чадвар өөрийгөө танин мэдэхээс эхэлнэ

Пүүс компаниуд аливаа нэг зах зээлд хэрэглэгчдийг өөртөө татахын төлөө хоорондоо өрсөлддөгийг бүгд сайн мэднэ. Улс төрийн нам, хүчнүүд ч мөн адил сонгогчдын санал, итгэлийг олох замаар Засгийн эрхийн төлөө өрсөлддөг. Хувь хүмүүс ч тэр нийгэмд эзлэх байр суурийн төлөө зүтгэдэг. Бид өөрсдөө хэн нэгэнтэй өрсөлдөхөөс гадна бусдыг хооронд нь өрсөлдүүлж чадна. Жишээ нь, манай нүүрс, зэс, алт зэрэг баялгийг олборлох эрхийн төлөө дэлхийн томоохон компаниуд өрсөлдөж байна.

Эрчтэй даяарчлагдаж буй энэ цаг үед хүн бүр өөрсдөө мэдсэн, мэдээгүй тодорхой хэмжээгээр өрсөлдөөний нэг хэсэг болон амьдарч байгаа юм. Балар эртний үед хүний хурд, хүч хангалттай биш бол араатны хоол болох тавилан хүлээж байлаа. Өнөө цагт махчин амьтдын идэш болох аюулын магадлал ялангуяа том хотын иргэдийн хувьд бараг тэтгэй тэнцэнэ. Харин ажилгүй, орлогогүй, нийгэмд эзлэх байр суурьгүй байх вий гэсэн айдас орчин үеийн хүнийг ямар ч зэрлэг араатан амьтнаас илүү айлгах нь тодорхой билээ. Тиймдээ ч хүн төрөлхтөн орчин үед жад эсвэл галны оронд боловсрол эсвэл мөнгөөр зэвсэглэж, махчин араатны оронд ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэх болж.

Цэцэрлэгт байхаасаа эхлэн дуу шүлэг цээжилж ангийнхантайгаа өрсөлдөж эхэлнэ. Том болсон хойноо өөрийгөө илэрхийлэх чадвар маань эрс өснө гэсэн ухаалаг тооцоог тэр бяцхан тархинууд бодож олох нь юу л бол. Харин ухамсраас илүү хүчтэй инстинкт буюу зөн совин нь хүүхдүүдийг хооронд нь битүү өрсөлдөөнд татан оруулж эхэлдэг гэвэл илүү зөв болох болов уу.

Бага анги, дунд анги, ахлах анги тэр чигээрээ сайн дүнгийн төлөөх, багшдаа тоогдохын төлөөх өрсөлдөөн. Энэ бүхний эцэст их, дээд сургуульд орох эрхийн төлөө “конкурсдэнэ”. Орлоготой, хангалуун амьдрах боломжийг олж авах нь эцсийн зорилго биз ээ. Байгалиас заяасан сайхан амьдрах гэсэн зөн совин дэлхийн хүн бүрт бий. Тодруулбал, бага ангид элсэн орж буй сингапур жаал, монгол жаал хоёрт сайхан амьдрах хүсэл тэгш заяагдсан. Мэдээж сайхан гэдэг үг тухайн соёлоос хамаарч өөр өөр утгыг олддог.

Сайхан амьдрах гэж яг юуг хэлэх вэ гэвэл соёл, философи, шашны эцэс төгсгөлгүй маргаан өрнөх нь лавтай. Харин эдийн засагчид зарим нэг хэмжих нэгжийг бодож олсон байдаг. Жишээ нь баян, хүчирхэг орнуудын иргэд эрүүл байж урт наслах, чөлөөт цагаа зугаатай өнгөрөөх, өөрийгөө боловсруулах, хөгжүүлэх, өөрөөр хэлбэл орчин үеийн нийгэмд “хүн шиг амьдрах” боломжоор илүү байгааг ажигласан байна. Ингээд Дотоодын нийт бүтээгдэхүүн, түүний нэг хүнд ногдох хэмжээ гэх зэргээр улс орнуудыг хооронд нь хэмжих болж. Энэхүү статистикийн хуурай тооноос тухайн улсын иргэнийг хэр “аз жаргалтай” амьдрах боломжтой вэ гэдгийг таамаглах боломжтой.

Тэгвэл өсөж том болсон хойноо өнөөдрийн сингапур болон монгол жаалууд хэр сайхан амьдрах боломжтой вэ? Сингапурын эдийн засаг 180 орчим тэрбум ам.доллараар хэмжигдэж байгаа нь манай улсынхаас даруй 30 дахин их үзүүлэлт юм. Нэг сингапур хүнд 36 мянган ам.долларын ДНБ ногдож байхад, монгол хүнийх хоёр мянган ам.доллар байх жишээтэй. Эндээс үзэхэд сингапурчууд илүү хангалуун амьдрах орчноо бүрдүүлсэн буюу цэвэр статистикийн үүднээс авч үзвэл тэд биднээс илүү их баялгийг эзэмшиж байна.

Сингапурчуудаас “таны амьдралын чанар хэр сайн бэ” гэж асуувал тэд 10 онооноос найман оноог өгчээ. Харин монголчууд ердөө хоёр оноо өгсөн байгааг Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлангаас харж болно. Төрөөс хувийн хэвшлээ хэр дэмжиж байна вэ гэсэн асуултад сингапурчууд мөн л сэтгэл хангалуун байдгаа илэрхийлсэн бол монголчуудын хувьд төрдөө итгэх итгэл сул, бодлого дэмжлэгд нь сэтгэл дундуур явдгаа нуугаагүй байв.

Ямартай ч Сингапурын төр иргэдээ боловсролтой болгох,

хувийн хэвшилдээ өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлдэж өгөх зэрэгт үлгэр жишээ байгаа нь үнэн. Энгийн жишээ татъя. Монголын төрөөс боловсролд зарцуулж буй зардал нь эдийн засагтай нь харьцуулахад чамгүй өндөр. Боловсролын салбарт зарцуулсан нийт зардлыг нь ДНБ-д харьцуулж үзвэл манайх долоон хувь буюу зэгсэн өндөрт тооцогдоно. Харин Сингапурынх ердөө гурван хувь. Өнгөц харахад монголчууд боловсролдоо их анхаардаг гэмээр боловч нухацтай авч үзвэл өөр дүр зураг тодорч байх юм. Төрөөс боловсролд зарцуулж буй нийт зардлыг хүнд нь хувааж үзвэл, Сингапурт 1200 орчим ам.доллар ногдсон бол Монголд ердөө 132 ам.доллар хүрэх жишээтэй. Гэтэл уул уурхайгаар баян Катар энэ тоо бүр 2400 ам.доллар байх нь тэр. Эдийн засгийн төрөлжилт, аж үйлдвэр, үйлчилгээ гэх зэрэг уул уурхайн бус салбарын үсрэнгүй хөгжлөөр дэлхийд тэргүүлж буй катарчуудын нууцын нэг энэ юм. Ингээд бодохоор, боловсролоор дамжуулж хүндээ хөрөнгө оруулах тал дээр монголчууд бид үнэндээ дэлхийн адаг болж явна гэсэн дүгнэлтийг түвэггүй хийж болж байна. “Дээд баян эрдэм ном, Дунд баян үр хүүхэд, Адгийн баян авдар сав, алт мөнгө, адуу мал” хэмээн сургаж ирсэн монголчууд бид шинэ цаг үед, зөвхөн хамтаараа шийдэх ёстой нэг асуудал бол яахын аргагүй боловсрол, мэргэжлийн ур чадвар билээ.

Аз жаргалтай, өрсөлдөх чадвартай нийгмийг боловсрол л авчирна. Боловсролтой хүн өөрийгөө танин мэдэх арга замаа олж, улмаар тасралтгүй ухаажиж, орчиндоо зөв дасаж эсвэл өөрчлөлт хийж чаддаг. Өөрийгөө танин мэдсэн хүн цаг сайн хэмнэдэг, бусадтай ажил хэрэг, бүр гэр бүл, хайр сэтгэл, нөхөрлөлийн харилцаанд орохдоо ч илүү бүтээлч, хүнлэг байж чаддаг. Өөрийгөө танин мэдээгүй хүн түр зуурын сонирхол, өнгөц өнгөнд хууртаж хамгийн үнэ цэнэтэй зүйл болох цаг хугацааг хоосон алдаж буйгаа мэддэггүй.

Бид өөрсдийгөө хэрхэн танин мэддэг билээ? Мэдээж бусадтай харьцуулж. Хүмүүс намайг юу гэж хэлэх бол? Тэд миний талаар юу бодож байгаа бол, ер нь хамт олон маань намайг хэр үнэлдэг бол гэх асуултауд өөрийгөө танин мэдэх гэсэн хэрэгцээтэй холбоотой биз ээ. Тэгвэл улс үндэстнүүд ч мөн адил өөрсдийгөө танин мэдэх улмаар иргэнээ, эдийн засгаа хүчирхэгжүүлэх замаар өрсөлдөх чадвараа сайжруулах ▶

► болж. Жишээ нь, Европын холбооны Өрсөлдөх чадварын хороо нь Европын орнуудыг Америк, Ази тивийн улсуудтай жиших замаар өөрсдийгөө дэлхийн өнцгөөс харж тодорхойлдог. Жил бүр өөрсдийн давуу тал, сул талд түшиглэсэн хөгжлийн арга замыг хайдаг энэ байгууллагын эрхэм зорилго нь “Мэдлэгийн эдийн засгийн суурийг зөв тавих”-д оршдог. Сүүлийн жилүүдэд энэ байгууллага Европын орнуудын бага, дунд боловсролын системийн чанар Азийн орнуудаас хоцорч эхэлж байгааг хүчтэй сануулах болжээ.

Харин монголчууд бид ямар байгаа бол? Одоог хүртэл өсвөр үеийнх-

нийхээ мэдлэгийн түвшинг Олон улсын стандартаар хэмжиж, бусадтай харьцуулах боломжийг бүрдүүлээгүй л байна. Гэтэл ижил төстэй орнууд маань өөрсдөө санаачлагаараа мөнгө төлж, PISA гэх зэрэг олон улсын үнэлгээгээр сурагчдаа шалгах болж. Үүний цаана өөрсдийгөө танин мэдэх, дэлхийн хөгжлийн түвшинг давхар тандах гэсэн зорилго бий нь ойлгомжтой.

Аль ч үндэстний өрсөлдөх чадвар өөрсдийгөө танин мэдэхээс эхэлнэ. Харин танин мэдэхүй нь боловсролоос эхэлнэ. Монгол Улсын хувьд боловсролын чанар нь нийгмийн бүтээлч хэсгийнхэнд гологдсоор л. ■

Филантроп

“Өглөгийн тангараг”



Facebook-ийн үүсгэн байгуулагч Марк Цукерберг болон түүний хамтрагч Дастин Москович нар хөрөнгийнхөө талаас илүү хувийг өглөгт зарцуулахаа амлаж, нигүүлсэнгүй сэтгэлтнүүдийн клубт эргэлт буцалтгүй элсэн оржээ. Дэлхийн хамгийн баян 70 орчим хүний нэгдсэн “Өглөгийн тангараг” (The Giving Pledge) төслийг алдарт хөрөнгө оруулагч Уоррен Баффет, Билл Гейтс болон түүний гэргий Мелинда хамтран санаачилсан юм. Америкийн толгой баячуулыг хөрөнгийнхөө талаас дээш хувийг буяны ажилд зарцуулахыг уриалсан энэхүү клубт Нью-Йоркийн амбан Майкл Блүүмберг, найруулагч Жорж Лукас, зочид буудлын аварга

Баррон Хилтон болон “Microsoft”-ын үүсгэн байгуулагчдын нэг Пол Аллен зэрэг алдартан багтаж буй. Эдүгээ энэхүү клубийн хүрээг тэлж, Энэтхэг, Хятадын тэрбумтнуудыг элсүүлэх нь Баффетын гол зорилго ажээ.

“Хүнийг хайрлах” гэсэн грек үгнээс гаралтай филантроп гэх ойлголтоор буяны үйлст сэтгэлээ зориулсан хүмүүсийг хэлдэг. Энэ нь АНУ болон Европын хувьд аль эртнээс тархсан ажээ. Тухайлбал, “Standard Oil” компанийг үүсгэн байгуулагч, дэлхийн анхны долларын тэрбумтан Жон Рокфеллер цуутай филантроп байв. 1897 оноос тэрбээр буяны үйлст дурлаж, боловсрол, эрүүл мэндийн

салбарт хагас тэрбум ам.доллар зарцуулсан байдаг. Альфред Нобель, Якоб Шифф, Эндрю Карнеги, Жорж Соросоос эхлээд Майкл Жексон, Жон Леннон, Шакира ч буяны үйлсээрээ дэлхийд зартай. Улс төр, бизнес, урлаг соёлын алдартнууд “филантроп” хэмээн өөрсдийгөө нэрлүүлэхдээ улам л дуртай болж буй. Ерөөсөө ийм сонирхолтой хүн соёлт ертөнцөд олон байдаг болохоор Баффет, Гейтсийн санаачилгыг баячууд дуртай хүлээж авсанд гайхах юмгүй.

Тансаг зэрэглэлийн бараа, хувцаснаас зайгаа барьж, түргэн хоолны газруудаар үйлчлүүлдэг Уоррен Баффет нэг үе дэлхийн хамгийн баян хүний сэнтийд заларч байсан ч мөнгөө буяны ажилд зарцуулсаар байгаад байр сууриа алдсан гэдэг. Тэгвэл Америкийн болон дэлхийн “толгой баян”-ы албыг олон жил хашсан Билл Гейтс өөрийн гэр бүлийн үүсгэн байгуулсан буяны санд 30 тэрбум ам.доллар зарцуулсан болохоор л “Forbes” сэтгүүлийн жагсаалтыг тэргүүлж чадахаа байжээ. 2010 онд Баффет маань Билл болон Мелинда Гейтсийн “Gates Foundation”-д өөрийн хөрөнгийн дийлэнх хэсгийг өвлүүлэх гэрээслэл бичсэн. Чухам эндээс л “Өглөгийн тангараг” төслийн санааг тэд олжээ. Нигүүлсэнгүй сэтгэлтэй хүмүүс олон бий, яагаад тэднийг нэгтгэж болохгүй гэж?

Баффет Гейтс хоёр төслийн санаагаа маш энгийн аргаар хүмүүст хүргэсэн тухайгаа ярьдаг. Зүгээр л Америкийн хамгийн баян 400 хүний нэрсийн жагсаалттай “Forbes” сэтгүүлийн дугаарыг аваад, утас цохиж эхэлжээ. “Өөрийнхөө цэвэр ашгийн талыг буяны үйлст зарцуулах, эсвэл энэ зорилгоор хөрөнгийнхөө талыг өвлүүлэх хэрэгтэй гэж бид тэрбумтнуудыг ятгасан гэх үү дээ. Гэхдээ үүнд ямар нэгэн дарамт, шахалт байхгүй. Энэ бол хууль зүйн биш, ёс суртахууны тангараг. Бидний ярьсан хүмүүсийн тал нь санаачилгыг таатай хүлээж авсанд баяртай байгаа” хэмээн Баффет “Forbes” сэтгүүлд ярилцлага өгөхдөө тэмдэглэжээ. Түүний залгасан зарим хүн санаачилгыг эргэлзсэн байдлаар хүлээж авахад нь ирээдүйдээ үлгэр дуурайл үзүүлэхийг сануулж, Эндрю Карнеги болон Жон Рокфеллерийн сайн үйлсээр жишээ татан ятгаж байсан аж. Ялангуяа “Forbes”-ын жагсаалтад орсон залуу хүмүүст ойлгуулах нь хамгийн чухал гэдгийг Баффет тэмдэглээд, “Бид залуу хүн бүртэй ярилцаж амжих ёстой” гэжээ. Энэ нь ч амжилттай хэрэгжиж ►►

байгааг Марк Цукерберг болон Дастин Московицын шийдвэрээс харж болох биз.

“Өглөгийн тангараг” төслийн хүрээнд цугларах мөнгө ямар нэг тодорхой зүйлд биш, харин хандивлагчдын өөрсдийнх нь зөв гэж бодсон ажил үйлст зарцуулагдах юм. Байгаль орчны хамгаалал, эрүүл мэнд, боловсрол гээд юу ч байж болно. Тухайлбал, “Berkshire Hathaway” компанийн ТУЗ-ийн гишүүн, “Forbes” сэтгүүлийн үнэлснээр 1.9 тэрбум ам.долларын хөрөнгөтэй Вальтер Скотт мөнгөө шинжлэх ухаан, боловсролд зарцуулах сонирхолтой буйгаа илэрхийлжээ. “Эхний ээлжинд би залуу хүмүүст тусалмаар байна. Мэдээж би өөртэйгээ ижил хөгшчүүлд муу санаагүй л дээ. Гэхдээ залуус бол хамгийн ашигтай хөрөнгө оруулалт. Дээд боловсрол эзэмших боломжийг бий болгох замаар бид боловсролтой, бүтээлч иргэдийг төлөвшүүлж чадна” хэмээн тэрбээр тэмдэглэжээ.

“Forbes” сэтгүүлийн тооцоолсноос үзэхэд “Өглөгийн тангараг” клубийн гишүүдийн буяны үйлст зарцуулахаар амласан хөрөнгийн хэмжээ хэдийнэ 120 тэрбум ам.доллараас хальчихаад буй. Гэхдээ энэ бүх мөнгө хэрэгцээтэй хүмүүстээ шууд хүрнэ гэж дүгнэхэд бэрх аж. Сайн үйлсийн төлөө асар их мөнгө зарцуулж байгаа хүмүүс тэр хөрөнгө нь ядуусыг гэхээсээ илүү баян банкирууд, буяны сангуудыг тэжээж байгааг ойлгодоггүй гэнэ. Үнэхээр ингэж боддог хүн цөөнгүй бий ажээ.

Өнгөрсөн намар “New York Post” сонины хамт олон нэгэн шуугиан дэгдээсэн юм. Юу гэвэл U2 хамтлагийн дуучин Боногийн рекламдаад байдаг ядуурлын эсрэг сан болох ONE сайхан сэтгэлтнүүдийн халааснаасаа гаргасан мөнгөний ердөө 1.2 хувийг л өлсгөлөн хүүхдүүд болон тусламж хэрэгтэй хүмүүст зарцуулжээ. Гэтэл 98.8 хувь нь тус сангийн үйл ажиллагаа, ажилчдын цалин зэрэгт алга болсон байсан гэвэл итгэх үү? Мэдээж ONE ашгийн бус байгууллагын төлөөлөгчид өөрсдийгөө өмөөрч, “Бид сайн үйлс хийдэг” хэмээн зарласаар, сурталчилсаар байсан боловч “New York Post”-ын нийтлэлийг худлаа гэдгийг нотолсон нэг ч тоо, баримт гаргаагүй. Үүнтэй ижил жишээ мундахгүй байдаг болохоор л буяны сангуудын нэр хүнд унаж, иймэрхүү санаачилгад таагүй ханддаг хүн ч олширсон талтай. Тэдний нэг нь “Forbes” сэтгүүлийн жагсаалтыг хоёр жил дараалан тэргүүлж буй Карлос Слим юм. 74 тэрбум ам.долларын хөрөнгөтэй мексик эрагаад Баффетын

ятгалгад ороогүйгээр барамгүй “Өглөгийн тангараг”-т нэгдэхгүй гэдгээ олон нийтийн өмнө мэдэгдсэн юм бол? “Сүүлийн 50 жилийн хугацаанд сайн үйлс бүтээх чиглэлээр олон их наяд доллар урссан боловч ямар ч асуудлыг шийдвэрлэж чадсангүй. Өөрийн хөрөнгийн 40-50 хувийг үүнд зарцуулна гэдэг мөн л утгагүй, үр дүнгүй хэрэг шүү дээ. Баячууд мөнгөө нийгмийн хүнд асуудлуудыг арилгахад зарцуулахыг хүсэж байгааг ойлгож байна. Гэхдээ энэ мөнгө яг хэрэгтэй хүмүүстээ очно гэсэн баталгаа хаа байна вэ? Ядууралтай тэмцэх цорын ганц бодит арга бол ажлын байр бий болгох явдал гэж би боддог” хэмээн тэрбээр сэтгүүлчдэд тайлбарлажээ. Товчхондоо, Карлос Слим бол хүмүүст

загас өгч болохгүй, харин түүнийг яаж дэгээдэх аргыг нь зааж өгөх хэрэгтэй гэж үздэг нэгэн аж.

“Өглөгийн тангараг” санаачилгыг ийнхүү хүмүүс сайнаар ч, саараар ч хүлээж авч буй аж. Гэхдээ өөдрөгөөр харж, нэгдэж буйнигүүлсэнгүй сэтгэлтэн илүү олон байгааг Баффет тэмдэглээд, “Тиймээс яагаад буяны үйлст хөрөнгөө өгөхөөр шийдсэн тухайгаа манай цахим хуудсанд захидал бичиж үлдээхийг бид хүссэн юм. Энэ бол уншихад таатай түүхүүд юм шүү” гэжээ. Тэрбумтнуудын захидлыг Givingpledge.org цахим хуудаснаас харж болно. Үнэхээр ч өглөгийн тангараг өргөсөн хүн бүрийн түүх сэтгэл хөдлөм байсан болохоор нийтлэлийнхээ төгсгөлд зарим хүний захидлаас иш татав.

Уоррен Баффет:

-Эхнэр бид хоёр амьдралаас хүссэн бүхнээ авч чадна гэдгээ мэдэж байсан болохоор энэ бүх мөнгийг нийгэмд эргүүлж өгнө гэдэгтээ итгэсэн юм. Хүмүүсийн мөнгөөр шийдэж болох зовлонг ойлгож, туслах нь эхнэрийн маань дуртай ажил болохоор намайг сайн ойлгосон л доо.

Билл болон Мелинда Гейтс:

-Бидний хүссэн бүхэн биелэх аз завшаан тохиосонд асар их баярлаж явдаг. Энэ бэлэг агуу болохоор л түүнийг сайн үйлст зарцуулах том харуцлага байгааг мэдэрдэг. Тийм ч учраас бид өглөгийн тангараг өргөхдөө баяртай байна.

Майкл Блүүмберг, (Нью-Йоркийн амбан захирагч, “Bloomberg” компанийн үүсгэн байгуулагч):

-Та хүүхдүүдийнхээ төлөө ямар нэгэн зүйл хийж, тэдэндээ маш их хайртайгаа мэдрүүлэхийг хүсэж байна уу? Тэгвэл зүгээр л бидний хүүхдүүдийн хувьд илүү сайн сайхан дэлхийг бий болгоход тусалж чадах байгууллагуудыг дэмжихээс илүү юм үгүй.

Жон Ханцман, (Юта мужийн амбан захирагч асан, АНУ-ын БНХАУ дахь Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд):

-Би бусдад туслахын тулд л амьдарч байгаагаа бүр хүүхэд байхаасаа л мэддэг байсан.

Жорж Кэйсэр, (ВОК Санхүүгийн корпорацийн тэргүүн, бизнесмэн):

-Надад төрөлхийн болон хүмүүжлийн давуу тал байлаа. Харин эргэн тойрноо ажиглаад, тийм боломж заяагаагүй хүмүүсийг харахад энэ бүхний тэнцвэрт байдлыг бий болгохын тулд өөрийн бололцоо, хөрөнгө мөнгөө чиглүүлэх хэрэгтэй нь тодорхой болсон.

Дэвид Рокфеллер, (“Standart Oil” компанийн үүсгэн байгуулагч Жон Рокфеллерийн ач):

-Эдийн засгаасаа их ашиг олж чадсан хүмүүс түүнийгээ тодорхой замаар нийгэмдээ эргүүлж өгөх тусгай харуцлага хүлээдэг гэсэн итгэл үнэмшилдээ манай гэр бүл нэгдсэн хэвээр л байгаа.

Жефф Сколл, (“eBay”-ийн анхны ерөнхийлөгч, “Participant Media”-гийн үүсгэн байгуулагч):

-Ертөнц бол асар том хэрнээ хэцүү газар бөгөөд бид бүхнээс ирээдүй хойч үедээ илүү гэгээлэг маргаашийг бий болгохын төлөө чадах бүхнээ хийхийг шаардаж байдаг.

Тэд Тёрнер, (Хэвлэлийн магнат, CNN-ий үүсгэн байгуулагч):

-Тусламж хамгийн их хэрэгтэй байгаа хэсэгт тусламж үзүүлэх нь нэг насандаа үл барам өндөр зорилго гэж аав маань зөвлөдөг байлаа. Энэ зорилго маань дэлхийг илүү гэгээлэг болгохын төлөө эрч хүчтэй ажиллаж, өдөр бүр шамдах урам зоригийг надад өгдөг учраас аавынхаа сургаальд баярлаж явдаг. ■



Монгол Улсын Ерөнхийлөгч
Цахиагийн Элбэгдоржийн ивээл дор

Олон улсын бага хурал

“Өрсөлдөх чадвар ба компанийн нийгмийн хариуцлага”

“Хариуцлагаа ухамсарласан аж ахуйн нэгж эдийн засгийн тогтвортой хөгжлийн төлөө юу хийх ёстой вэ?”

Монгол Улс, Улаанбаатар хот, Их Тэнгэр цогцолбор
2011 оны 9 дүгээр сарын 06-07

Зохион байгуулагчид:



Холбоо барих:

Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн
Санаачлага хөтөлбөр
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо
Нэгдсэн Үндэсний гудамж 5/1, 38-байр,
3 давхарт

210236 Улаанбаатар хот,
Монгол Улс

Мэдээллийн түнш:



Утас: +976 7011 7704

Факс: +976 70117705

И-мэйл: imri@giz.de

Олон улсын бага хурал-үзэсгэлэн

**“Худалдааны логистик ба нийлүүлэлтийн сүлжээний менежмент”
“Нөөц бололцоо ба хэтийн чиг хандлага”**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингис хаан зочид буудал
2011 оны 9 дүгээр сарын 27

Зохион байгуулагчид:



Холбоо барих:

Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн
Санаачлага хөтөлбөр
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо
Нэгдсэн Үндэсний гудамж 5/1, 38-байр,
3 давхарт

210236 Улаанбаатар хот,
Монгол Улс

Мэдээллийн түнш:



Утас: +976 7011 7704

Факс: +976 70117705

И-мэйл: imri@giz.de

“Mongolian Economy” сэтгүүлийн асуулт

Та компанийн нийгмийн хариуцлагын талаар юу хэлэх вэ?

Др.Михаэль Бюрш /Германы компанийн засаглалын төвийн удирдах зөвлөлийн гишүүн/:

-Ядууралтай тэмцэх, хүний эрхийг дээдлэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт болон экологийн бусад асуудлыг шийдвэрлэх, авлигыг таслан зогсоох гэх мэт томоохон сорилтуудтай бид нүүр тулгараад байна.Өнөөдөр, маргааш бидэнд тулгарах эдийн засгийн, экологийн болон нийгмийн эдгээр сорилтыг даван туулахын тулд бидэнд Засгийн газар, компаниуд, шинжлэх ухааны болон иргэний нийгмийн байгууллагуудын шинэлэг, хариуцлагатай хүчийг нэгтгэсэн нэгдмэл хүчин чармайлт шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл төр, хувийн хэвшил хийгээд иргэний нийгмийн хооронд нийгмийн шинэ гэрээг бий болгох гарцаагүй шаардлага үүсээд байна.



Энэ ч утгаараа өмнө нь зөвхөн татвараа төлж, филантропын зорилгоор хааяа нэг хандив өгөх төдийнхөөр хязгаарлагдаж байсан компаниудын үүрэг хариуцлага өргөжиж өнөө үед нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангахад хамтран оролцож, хариуцлагаа ухамсартайгаар хүлээх болсон билээ. Компанийн нийгмийн хариуцлага буюу компанийн гишүүнчлэлийн үйл ажиллагаа нь энэрэнгүйүзэлтэй огтхон ч хамааралгүй. Учир нь нийгмийн хөгжилд хариуцлагатайгаар оролцох нь компаниудын хувийн ашиг сонирхолд ч нийцдэг. Дэлхийн Эдийн засгийн форумаас “Доройтож байгаа нийгэмд ямар ч бизнес хийх боломжгүй” гэж тунхагласан байдаг.

Компанийн нийгмийн хариуцлагын үзэлбаримтлал нь компаниудын эрх, үүргийг нийгмийн гишүүнгэдэгтгаар нь шинэчлэхээр гарч ирсэн. Энэ нь компаниудад ажлын байранд хөдөлмөрийн зохистой нөхцөлийг бий болгох, байгаль орчинд учруулж буй аливаа сөрөг нөлөөлөл, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, авлигыг үлтэвчих, хувьцаа эзэмшигчдэдээ ил тод, хариуцлагатайгаар хандах, олон нийтэд чиглэсэн хөрөнгө оруулалт болон нийгмийн сайн сайханд зориулагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох замаар нийгэмдээ хувь нэмрээ оруулахыг уриалдаг байна.

Г.Батсүх /“Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-ийн дарга/:

-“Оюу Толгой” ХХК нийгмийнхээ хариуцлагыг өндөр ухамсарлаж, олон төрлийн ажил хийж байгаагаас хэдхэн зүйлийг хэлье. Манайх Орон нутгийн харилцаа эрхэлсэн тусгай хэлтэстэй. Орон нутгийн харилцаа гэдэг бол орон нутгийн хөгжлийн түвшинг хариуцдаг. Засгийн газартай хийсэн Хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн дагуу Өмнийн говийн хөгжлийн зөвлөл гэдэг байгууллага байгуулсан. Тус Хөгжлийн зөвлөлд Засгийн газраас, Их хурлаас, олон нийтийн байгууллагуудаас төлөөлөгчид оролцсон байдаг. Зөвлөлийн таван жилийн төлөвлөгөөний дагуу бол Өмнийн говь, тэр тусмаа уурхай барьж байгаа орон нутгийг хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг бодлогын баримт бичгээ хийгээд явж байна. Үүнээс гадна “Оюу Толгой” компани нь Өмнөговь аймгийн захиргаатай бас таван жилийн хугацаатай гэрээ байгуулсан байгаа. Дээрх гэрээгээр



Даланзадгад хот болоод бусад уурхайн ойролцоох сумдад барьж байгуулах соёл, нийгмийн ач холбогдолтой барилга байшингууд, байгаль орчныг хамгаалах асуудлууд, ялангуяа хөрсний эвдрэлийг хамгаалах, орон нутгийн малчдын аж амьдралыг хэрхэн дээшлүүлэх, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг яаж дэмжин хөгжүүлэх вэ зэрэг асуудлыг иж бүрнээр тусгасан. Хамгийн сүүлчийн жишээ хэлэхэд, энэ хүрээндээ өнгөрсөн тавдугаар сард Даланзадгад хотын төвд Орон нутгийн бизнесийг дэмжих төв байгуулсан. Энэ хүрээнд Даланзадгад хотын жижигхэн компани уурхайн барилгын ажилчдын, уурхайчдын ажлын хувцас болох сарын 50-60 сая төгрөгийн үнэтэй захиалгыг авсан. Түүнээс гадна бид Монголын хамгийн олон бөгөөд ховор үүлдрийн тэмээтэй Өмнөговийн Ханбогд сумын тэмээний тоо толгойг нэмэгдүүлэх, малчин, тэмээчдэд малынхаа ашиг шимийг яаж боловсруулах талаар тусгай хөтөлбөр гарган ажиллаж буй.

Ж.Питер Морроу /ХААН банкны зөвлөх/:

-Компанийн өрсөлдөх чадвар мэдэгдэхүйц сайжирч байгаа гэж бодож байна. Монголын компаниуд банкны зээл авахаас гадна олон улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргаж, гадаадад хөрөнгө босгох боломжийг хайж байгаа тул сайжрах учиртай. Энэ бүхэнд ил тод байдал, компанийн засаглал, аудитаар орсон санхүүгийн тайлан шаардлагатай. Монголын бизнесийн зөвлөлийн ээлжит хурлын үеэр санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулсан дөрвөн компани байсан. Өнгөрсөн онд бол харин ганцхан байсан. Энэ тоо дөрөв дахин өсч, ирэх онд улам олон болно гэсэн хүлээлттэй байна. Монголд компанийн засаглал, ил тод байдал нь дандаа сайн байгаагүй ч хурдтай сайжирч буй.



Компаниуд нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах хэрэгтэйг ойлгож эхэлсэн. Энэ зорилгыг биелүүлэхийн тулд хэдэн жилийн өмнө ХААН Банк Санг үүсгэн байгуулсан. Түүгээрээ дамжуулж хүүхэд залуучууд, соёл боловсролыг дэмжсэн төрөл бүрийн үйл ажиллагааг бид хэрэгжүүлдэг. Цаашид улам олон компани энэ үйл ажиллагаанд оролцоно байх. Яагаад гэвэл монгол компаниуд ашиг сайн олж, хөрөнгийн зах зэл дээр гарч эхэлсэн. Компанийн нийгмийн хариуцлага, нийгэмд хүргэх үйл ажиллагаанд тасралтгүй хөрөнгө оруулах болно.

Д.Энхчимэг /“Петровис” ХХК-ийн ерөнхий захирал/:

-Компанийн нийгмийн хариуцлага гэдэг бол маш чухал. Ямар ч албан байгууллага нийгмийн нэг хэсэг гэдэг утгаараа нийгмийнхээ сайн сайхны төлөө ямар нэгэн үйл ажиллагаа явуулж хөрөнгө мөнгө зарцуулах ёстой. Энэ бол бидний нийгмийн өмнө хүлээсэн үүрэг мөн. Сүүлийн үед компаниуд нийгмийн хариуцлагын талаар нэлээд анхаарч өргөн хүрээнд авч үзэх болсон нь нэн сайшаалтай юм. Манай байгууллага нийгмийн өмнөхүлээсэн үүргээ ухамсарлаж багагүй арга хэмжээ аваад



байна. Тухайлбал, “Ядуурлын эсрэг хамтдаа сан” байгуулж ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэдэд тусалцаа үзүүлж байсан. Мөн Монгол Улсын ирээдүй болсон залуусыг дэмжих үүднээс оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг жил бүр амжилттай зохион байгуулж байна. Мөн “Органик Монгол” төсөл хэрэгжүүлээд байгаа. Уг хөтөлбөрийн зорилго гэвэл хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, өөрийн оронд эрүүл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бололцоог эрж хайж байна. Бидний нийгмийн сайн сайхны төлөө хийсэн багахан тус эргээд тухайн байгууллагад ашиг тусаа өгөхөөс гадна Монгол Улсын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах юм.

Л.Хүрэлбаатар /“Монос” группийн ерөнхийлөгч/:

-Нийгмийн сайн сайхны төлөө хийж байгаа бүх үйл ажиллагааг нийгмийн хариуцлага гэж ойлгодог. Эмнэлгийн тоног төхөөрөмж, эм үйлдвэрлэж, импортолдог “Монос” группийн үндсэн үйл ажиллагаа маань ч гэсэн нийгмийн сайн сайхан, хүн ардын эрүүл мэндэд чиглэсэн байдаг болохоор нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа эрхэлдэг гэж боддог. Энэхүү үндсэн үйл ажиллагаанаасаа гадна иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр багагүй ажил хийдэг. Бүх нийтийн гүйлтийг арван жил дараалан зохиож, уламжлал болгосон. Эрүүл мэнддээ анхаарал тавьдаг, гүйлтийн ач холбогдлыг мэддэг хүмүүсийн хувьд энэ нь хүсэн хүлээсэн арга хэмжээ байдаг. Мэргэжлийн тамирчин ч, өндөр настай хүн ч манай Бүх нийтийн гүйлтийг хүсэн хүлээж байдаг. Хавар бүр орон даяар витаминжуулалтын аян зарладаг.



Мөн цөлжилтийг бууруулах чиглэлээр 2000 оноос хойш бүтэн 10 жил ажилласны үр дүнд жилд 20000-30000 чацарганын суулгац авах Чацаргана үржүүлгийн станцтай боллоо. Энэ мэтчлэн нийгмийн хариуцлагын чиглэлээр олон ажил хийж байгаа.

Брэдли Гоогинс /Дэд профессор, Бостон коллежийн Менежментийн Кэрролл сургууль/:

Компанийн нийгмийн хариуцлага гэдэг нь ёс зүй буюу компанийг зөв зүйтэй удирдахын үндэс болдог. Даяарчлалын нөлөөгөөр уламжлалт нийгмийн гэрээ хувьсан өөрчлөгдөж энэ нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хоорондын хил зааг, тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүргийг өөрчилснөөр талуудын хүлээх цоо шинэ үүрэг хариуцлагуудыг бий болгосон. Нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлт, таргалалтын өвчнөөс авахуулаад байгаль, нийгэм, улс төрд гарч буй аливаа өөрчлөлт нь бизнес эрхлэхэд шинэ сорилт, шаардлагууд, үүрэг хариуцлагыг бий болгож байна. Өнгөрсөн хэдэн жилд бүхний анхаарал Мерк Фармацойтикал (эмийн хангамж, нийлүүлэлт), Чиккуита (тариаланчдын хөдөлмөрийн нөхцөл), ВР (байгаль орчны тогтвортой байдал), Кока Кола (таргалалт), Нэстл (ус) компаниуд дээр төвлөрч байсан бөгөөд эдгээр нь дээрх компаниудын одоо хүлээж буй хариуцлага болон дээр дурдсан байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд шаардагдах оролцооны хоорондын ялгааг харуулсан жишээ байсан юм.



Ийнхүү шинээр үүссэн нөхцөл байдлын дүнд компанийн нийгмийн хариуцлага нь бизнесийн гол цөм болтлоо хөгжсөн. Харин өнөөдөр компанийн нийгмийн хариуцлага гэдэг бол ямар ч компанийн өрсөлдөх давуу талын стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг болжээ. Компанийн эрсдэлийн хэтийн төлөв, гол хувьцаа эзэмшигчдэдээ нэр хүндтэй байх зэрэг

нь филантропын бодлоготой уялдаатай байхаа нэгэнт больж, харин бизнесийн гол стратегийн бүрэлдэхүүнд орох болсон байна. Тухайлбал Dow Chemical компани нийгмийн хариуцлагаа өөрийн хувьцаа эзэмшигчдийн хүлээлтийг хангах, түүнийг нь давуулан биелүүлэх гэж тодорхойлсон байдаг. Хэдийгээр компанийн нийгмийн хариуцлагын цаана эрсдэлээс зайлсхийх асуудал байнга дагаж байдаг ч тэргүүлэх компаниуд эндээс байнга шинэ боломжийг олж хардаг. Менежментийн акул Петер Друкер “Бүх нийтийг хамарсан нийгмийн ямар ч асуудлын цаана бизнесийн боломж нуугдаж байдаг” гэж хэлсэн байдаг. Үүний нэг жишээ бол “Женерал электрик” компанийн Ecomagination буюу Эко төсөөлөл гэж томъёолсон дэлхий нийтэд тулгараад буй байгаль орчны асуудлуудыг хөндөх бодлого бөгөөд уг компани үүний зэрэгцээ бизнесийн маш том боломжийг олж авсан байна. Тэдний гүйцэтгэх захирал нь үүнийгээ “Ногоон бол ногоон” гэж тайлбарлажээ.

С.Түмэнгэрэл /“Өгөөж чихэр боов” ХХК-ийн ерөнхий захирал/:

-Компанийн нийгмийн хариуцлагын хувьд ярих юм бол манайхан одооноос л энэ талаар илүү бодитой зүйл ярьж, ойлгож эхэлж байх шиг байна. Энэ нь маш сайн хэрэг. Нийгмийн хариуцлагатай байна гэдэг нь ямар ч аж ахуйн нэгж албан байгууллага татвараа үнэн зөвөөр, цаг хугацаанд нь төлөхөөс эхэлнэ. Мөн нийгэмд болж бүтэхгүй байгаа зүйлийг зөв болгохыг хэлнэ. Нийгмийн хариуцлагатай болохын тулд хандив өгч, баруун солгойгүй тараах биш. Хүмүүнлэг, ёс суртахууныг бий болгох тал дээр анхаарах шаардлагатай.



Жишээлбэл, манай компанийн хувьд татвараа цаг хугацаанд нь төлж, Утаагүй Улаанбаатар, эрүүл агаар хөдөлгөөнийг дэмждэг. Хөгжлийн бэрхшээлтэй байгууллагыг сонгож, 10 дугаар цэцэрлэгт жилийн турш өглөөний цайны нарийн боов хүргэж тусламж үзүүлдэг. Мөн дунд сургуулийн нэгээс арваннэгдүгээр ангийн хүүхдүүдийн дунд “Үндэсний үйлдвэрийн аян” зохиодог.

Ажилтнуудаа гадаад дотоодын багш нарын мэргэжлийн сургалт семинарт хамруулахаас гадна, нийгэмших, соён гэгээрүүлэх, багаар хамтарч ажиллах тал дээр анхаардаг. Талархлын өдөр гэж бий болгосон нь манай хамт олонд их таалагдаж байгаа.

Ө.Золбаяр /“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хүний нөөцийн элтийн социологч/:

-Аливаа байгууллага, компани оршин байгаа нийгэмдээ үйл ажиллагаа явуулж, зорилгоо биелүүлж, ашиг олж байгаагийн хувьд нийгмийн хариуцлагатай байх нь соёлын асуудал юм. Сүүлийн үед дэлхий дахинд энэ асуудал стандарт болох хэмжээнд хүрч, олон улсын стандартчлалын байгууллагаас ISO 26000 зөвлөмжийг боловсруулжээ. Компанийн нийгмийн хариуцлага гэдэг нь үйл ажиллагаагаа нийгэм, байгаль орчин, эдийн засгийн үүрэг хариуцлагатай тэнцвэржүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй л дээ. Энэ нь нийгэм, улс орныхоо тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмэр юм. Түүнчлэн нийгэм, байгаль орчинд хариуцлагатай хандсан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тодорхой зардлыг багасгаад зогсохгүй улс үндэстний өрсөлдөх чадварыг сайжруулна. Монголын үндэстний худалдаа аж үйлдвэрийн танхимаас шалгаруулдаг “Топ 100” компанийн жагсаалтыг манай уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 10 дахь удаагаа тэргүүлж байгаа. “Эрдэнэт үйлдвэр” нь нийгмийн хариуцлагатай компанийн хувьд манай эрхэм зорилго, стратегийн зорилт, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний нөөцийн бодлого зэрэгт нийгмийн хариуцлагын асуудал тусгалаа олсон байдаг. ■



- 21 С.Мөнхсүх: “Хувийн агаарын тээвэрлэгч аюулгүй, тогтвортой, ашигтай ажиллаж болдгийг баталсан
- 24 Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтийн үндсийн үндэс нь монгол хүний хөгжил дэвшил
- 27 Монгол: Салаа замын уулзварт
- 32 Хоёр байгууллага-нэг систем

Төр ба бизнес

Laissez Faire

2008 оны хавраас бензиний үнэ огцом өсөхөд төрийн түшээд импортлогчдод татварын хөнгөлөлт үзүүлж, татаас хүртэл өгсөн боловч ямар ч үр дүнд хүрээгүй. Тэгээд мөн оны найм, есдүгээр сард түлш, шатахууны үнэ тэнгэрт хадахад Засгийн газар 28000 тонн шатахуун нөөцөлж байсныг нэхэн саная. Гол нь тухайн үед дэлхийн зах зээл дэх түүхий нефтийн ханш унаж эхлээд байсан бөгөөд удахгүй шатахуун хямдарна гэдгийг хүн бүр мэдэж байсан юм шүү дээ. Эрх баригчид татвар төлөгчдийн мөнгөөр тоглосны тод жишээ энэ буюу.

Харин одоо монголчуудын гол хэрэглээ болох махаар жишээ татъя. Нөөцийн мах туранхай, эцэнхий, хүрэлцээ муутай, дээр нь өндөр үнэтэй гэх хэл ам ер тасардаггүй. 2008 онд бүр нөөцийн мах бэлтгэсэн зарим компани төрийн байгууллагыг хуурч хонины махыг ямааныхаар, үхрийн махыг тэмээнийхээр орлуулж нийлүүлсэн хэрэг ч мандаж байв. Юу ч биш, мах бэлтгэлийн компаниудаас гадна мэргэжлийн хяналтын байцаагчид, Нийслэлийн Захирагчийн ажлын албаны зарим ажилтан ч татвар төлөгчдийн мөнгөөр бүрдсэн нөөцийн махнаас “хумсалж” байсан нь илэрч байсан удаатай. Ер нь махны үнийг барих зорилгоор төсвөөс

жилээс жилд багагүй хэмжээний хөрөнгө гаргаж, нөөц бүрдүүлдэг нь дорвитой үр дүн авчирдаг, эсэх нь эргэлзээтэй. Гурилын үнийн тал дээр ч мөн ижил дүр зураг тодроод ирэх вий. Атрын III аян зарлаж, тариаланчдыг дэмжсэн нь улаан буудайн дотоодын нийлүүлэлтийн хэмжээг өсгөсөн нь сайн л хэрэг. Гэхдээ ганцхан жишээ татахад 2009 оны ургацын улаан буудайг ХХААХҮЯ тариаланчдаас тонныг нь 350 мянган төгрөгөөр авч, түүнийгээ хадгалж байгаад 2010 онд 250 мянган төгрөгөөр үйлдвэрлэгчдэд зарсан билээ. Хариуд нь гурилын үнээ өсгөхгүй байхыг шаардсан боловч мөн л ямар ч нэмэр болоогүйг Та санах байх. Тэгвэл 2009 онд төрийн түшээд малчдын орлогыг бууруулахгүй байх үүднээс ноолуурын экспортын татварыг цуцлах тухай тогтоол гаргасан. Үүний үр дүнд малчдын гар дээр ноолуурын үнээс очих орлого нэмэгдсэн үү гэвэл үгүй. Харин ч урд хөршийнхөн үүнийг мэдчихээд Монголын ноолуурыг хуу хамсан. Улмаар үндэсний үйлдвэрүүд түүхий эдгүй болж, зарим нь бүр урдаас өндөр үнэтэй самнасан ноолуур хүртэл худалдан авахдаа тулсан юм даг. Энэ мэт жишээг тоочоод байвал цаас ч хүрэлцэхээ байна биз. Ямартай ч ард иргэдээ дэмжих гэсэн төрийн иймэрхүү үйлдэл үргэлж бүтэлгүйтэлд хүрдэг

бөгөөд татвар төлөгчдийн мөнгийг үрэн таран хийхээс цаашгүй гэдэг нь тодорхой болсон билээ.

Төр ийм замаар зах зээлд тохойгоо хүртэл гараа дүрэх нь салбарын компаниудын өрсөлдөх эрмэлзлэлийг үгүй хийж байгаа нь хамгийн аймшигтай. Дээрээс нь иймэрхүү төрийн зохицуулалт бизнесмэнүүд хийгээд улстөрчдийн харилцааг ойртуулж, авлига, хээл хахуулийн үүр болж байгаа нь нууц биш. Хувийн компаниуд өөр хоорондоо өрсөлдөх, шинэ технологи нэвтрүүлэн зардлаа бууруулах, хэрэглэгчдэдээ чанартай бүтээгдэхүүн хүргэх тухай бодохоосоо илүүтэй төрийн иймэрхүү увайгүй үйл ажиллагаанд оролцож, төсвийн мөнгөнөөс ахиухан самарчих гэж толгойгоо ажиллуулдаг болсон гэвэл буруудахгүй. Энэ нь чөлөөт зах зээлийг амьдаар нь алж байгаа хэрэг бус уу?

Адам Смитийн “Үндэсний баялаг” номонд өөрийгөө зохицуулах системийн тулгын гурван чулуу нь эрхчөлөө, хувийн эрх ашиг, өрсөлдөөн хэмээн онцолсон байдаг. Үүнийг бид “Үл үзэгдэгч гар” ч гэж нэрлэдэг. Хувийн хэвшлийнхэн ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд өөр хоорондоо өрсөлддөг бөгөөд эцсийн бүлэгт зах зээлийн бүх оролцогч хожиж таардаг гэсэн үг л дээ. “Бусдыг хуурч мэхлэхээс нь сэргийлж, хайхрамжгүй байдлыг нь засаж байдаг зүйл бол худалдан авагчаа алдах айдас” хэмээн Смит тайлбарлажээ. Хүн бүрт хувийн ашиг сонирхол байдаг нь тодорхой. Харин аж ахуйн нэгжүүд худалдан ▶▶

▶ авагч, үйлчлүүлэгчээ бусдад алдахгүйн тулд үнээ хэрхэн зохих хэмжээнд байлгах, чанараа яаж сайжруулахаа хэнээр ч заалгахгүй сайн мэднэ. Тэгвэл улстөрчид ч бизнес эрхлэгчдийн нэгэн адил өөрийн хувийн эрх сонирхолдоо хөтлөгддөг гэж профессор Жэймс Буканан үздэг аж. Үнэхээр тийм биш юм бол яах гэж төрийн эрхэнд гарах гэж зүтгэх билээ? Гэвч зах зээл шиг өөрөө өөрийгөө зохицуулаад явах механизм улс төрд үгүй учраас “үл үзэгдэгч гар” ажиллахгүй. Адам Смит аль XVIII зуунд л үүнийг сайн мэдэж байсан бөгөөд төрийн эрх мэдлийг хүчтэй эсэргүүцэгч нэгэн байжээ. Тэрбээр улстөрчид бол ерөнхийдөө л хоёр нүүр гаргагч үрэлгэн хүмүүс гэж бичсэн байдаг.

Төр, засаг өөрийгөө туслагч, дэмжигч үүрэгтэй гэж үзэх нь тухайн салбарын компаниуд урт хугацаанд өрсөлдөх чадвараа хөгжүүлэхэд нь саад болж, улмаар эдийн засгийн тасралтгүй сайжрах боломжийг алдагдуулдаг тухай эдийн засагч Д.Жаргалсайхан ч өөрийн нийтлэлдээ тэмдэглэж байв. Ер нь төр хэзээ ч сайн менежер байгаагүй бөгөөд эдийн засагтай хутгалдах тусам бурууддаг тухай мэргэжилтнүүд сануулдаг шүү дээ. “Эрдэнэт” үйлдвэр, МИАТ, “Улаанбаатар төмөр зам”, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, III, IV цахилгаан станц гээд төрийн өмчит бүхий л томоохон байгууллагад улстөрчид нөлөөгөө тогтоож, улмаар шахааны бизнес цэцэглэдэг тухай мэдээлэл байнга чих халууцуулдаг. Түүнээс гадна төрийн мэдэлд бүхэлдээ байдаг нийгмийн даатгалын салбар маань ямаршуу байгаа билээ дээ? Өнөөдөр авч байгаа тэтгэвэртээ, төлж байгаа шимтгэлдээ сэтгэл хангалуун байдаг хүн Монголд бий юу? Үүний хажуугаар нийгмийн даатгалын төрөл бүрийн сангууд хоосорч байгаа тухай мэдээлэл дуулдана. За тэгээд улсын эмнэлгүүдээр үйлчлүүлнэ гэдэг ямаршуу там байдгийг мэдэхгүй хүн үгүй биз. Товчхондоо, төрийн удирдлага дор байгаа газар хэзээ ч хөгжиж, цэцэглэдэггүй, мөн төр хэнийг ч дэмжиж чаддаггүй, харин ч “тус болох гээд ус болдог” гэсэн ганц гаргалгаа эндээс үүдэлтэй. “Эдийн засаг дахь төрийн оролцоо хэт их байгаа манай төсөв ДНБ-ий 50 гаруй хувийг эзэлж байгаагаас харж болно. Гэтэл социалист гэгддэг Хятад оронд энэ үзүүлэлт 20 орчим хувьтай л байдаг. Манай төр өөрөө эдийн засгаа боомлоод, хувийн хэвшлийнхний хийж чадах ажлыг булаацалдаад байна гэсэн үг” хэмээн Эдийн засгийн бодлого, өрсөлдөх

чадварын судалгааны төвийн захирал Ч.Отгочулуу онцлоод, “Төр бүхний дээр байж, бүгдийг зохицуулах ёстой гэсэн сэтгэлгээг арилгах шаардлагатай. Төр өөрөө ачааллаа дийлэхээ байгаад, хээл хахууль, хүнд суртлыг дэвэргэж байна” гэж тэмдэглэсэн юм.

Манай орон зах зээлийн эдийн засагт шилжээд 20 жилийн нүүр үзэж байгаа ч энэ хугацаанд арга барилаа шинэчилж чадаагүй бололтой. Төр, засаг буруу замаар будаа тээгээд байгааг иргэд нь ч анзаарах сөхөөгүй явна. Шатахууны үнийг барих зорилгоор нефть импортлогчдоо байн байн дарамталж байхын оронд газрын тос боловсруулах үйлдвэр барих хөрөнгө оруулалтыг хэрхэн татах вэ гэдэг тал дээр ухаан бодлоо уралдуулах хэрэгтэй юм биш үү? Махны үнийг зохицуулах гээд татвар төлөгчдийн мөнгөөр тоглохоо больж, зүгээр л ченжүүдийн гараар дамжилгүй хэрэглэгчдэд хүрэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарах ёстой бус уу? Монголд эрүүл, чийрэг зах зээл

хэрэгтэйг мэргэжилтнүүд хэлж байна. Үүний тулд төр, засаг эдийн засагт гар дүрэхгүй байх ёстойг сануулж байна. XVII зууны сүүлчээр Францын сайд Жан-Батист Колбэрт хэсэг бизнесмэнээс ямар тусламж хэрэгтэй байгааг нь асуухад нэг нь “Laissez nous faire” буюу “Биднийг зүгээр л орхичих” хэмээн хариулсан гэдэг. Төр нь эдийн засгийн үйл хэрэгт хөндлөнгөөс үл оролцох тухай “Laissez faire” бодлого үүнээс үүдэлтэй бөгөөд чөлөөт худалдаа, бага татвар, аль болох бага хүнд суртал байж гэмээнэ эрүүл, чийрэг зах зээл бий болж чадах ажгуу. Төрийн үйл ажиллагаа нь шударга ёс тогтоох, хувийн өмчийн эрхийг хамгаалах, хүчирхийллээс улс орныг хамгаалах зэргээр хязгаарлагдах ёстой билээ. “Импортын, хөдөлмөрийн болон үнийн хязгаарлалтыг устгаснаар бага үнэ, ажлын өндөр хөлс, илүү сайн бүтээгдэхүүн бий болж, улмаар бүх нийтийн хөгжил цэцэглэлийн дээд түвшинд хүрэх билээ” хэмээн Адам Смит бичсэн байдаг. ■

Агаарын тээвэр

С.Мөнхсүх: “Хувийн агаарын тээвэрлэгч аюулгүй, тогтвортой, ашигтай ажиллаж болдгийг баталсан

“Изинис эйрвэйз” ХХК-ийн ерөнхий захирал С.Мөнхсүхтэй ярилцлаа.

-Дэлхийн иргэний агаарын тээврийн хөгжлийн ирээдүйн талаар ярилцлагаа эхлэх үү?

- Өнөөдөр дэлхийн иргэний агаарын тээврийн хөгжил даяаршил, дэлхийн хүн амын өсөлтийг дагаад хурдацтай хөгжиж байна. Мөн иргэний агаарын тээврийн компаниудын хувьд өрсөлдөөн улам эрчимжиж байна. Ширүүн өрсөлдөөний явцад зах зээлээс чадвар муутай компаниуд хасагдаж, иргэний агаарын тээврийн үйлчилгээг өндөр түвшинд явуулж буй компаниуд үлдэх тул энэ нь үйлчлүүлэгчдийн хувьд ашигтай. Мөн онгоцны техник технологи ч илүү сайжирч, үр ашиг бүтээмж нэмэгдсэнээр үнэ өртөг буурах ач холбогдолтой. 20 жилийн өмнө аль ч улсын хувьд хөрөнгө мөнгөтэй хүмүүс нислэгээр үйлчлүүдэг байсан бол өнөөдөр агаарын тээвэр харьцангуй хүртээмжтэй болж, ихэнх улс оронд

өдөр тутмын хэрэгцээ болсон байна.

-Тэгвэл Монголын иргэний агаарын тээврийн хөгжлийн дэлхийн хөгжилтэй харьцуулахад ямар түвшинд явж байна вэ?

-Манай улсын хувьд зах зээл хязгаарлагдмал иргэний агаарын тээврийн салбар боломжийнхоо хэрээр хөгжиж байна. Аливаа улсын нэг хүнд ногдох агаарын тээврийн зорчигчдын тоо гэж байдаг бөгөөд Монгол Улсын хувьд энэ харьцаа 0.1 байна. Дэлхийн хөгжингүй болоод хөгжиж яваа, буурай хөгжилтэй бүх л орнуудын дундаж харьцаа 0.5 буюу хоёр хүний нэг нь агаарын тээврийн хэрэгслээр дотооддоо зорчдог гэсэн статистик бий. Эндээс харахад манай улсын хувьд агаарын тээвэрээр зорчигчдын тоо тав дахин нэмэгдэж байж дэлхийн дундаж жишиг хүрэхээр байна.

1990 онд манай улсын иргэний ▶



► агаарын тээврийн салбар ид цэцэглэж байсан үе гэж хэлж болох юм. Тухайн үед орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээнд 79 онгоц ашиглагдаж, 800 мянга орчим зорчигч тээвэрлэдэг байсан гэсэн тоо баримт бий. Харин 2010 оны байдлаар орон нутгийн нислэгийн үйлчилгээнд долоон онгоц нисэж, 150 мянган зорчигч үйлчлүүлжээ. Эдийн засгийн өсөлт, агаарын тээврийн хөгжил хоёр хоорондоо нягт уялдаа холбоотой. Дотоодын нийт бүтээгдэхүүн нэг хувиар өсөхөд агаарын тээврийн урсгал хоёр хувиар өсдөг гэсэн статистик тоо байдаг. Ирэх таван жилийн хугацаанд Монголын ДНБ гурав дахин өсөх төлөвтэй байна. Энэ тоон дээр үндэслэн агаарын тээвэр энэ хугацаанд зургаа дахин нэмэгдэнэ гэж таамаглаж болохоор байна. Иргэдийн орлого нэмэгдэхийн хэрээр бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт өсөх бөгөөд зах зээлийн хуулиар эрэлт нэмэгдэхэд нийлүүлэлт дагаад өснө.

Дэд бүтэц муу хөгжсөн манай орны хувьд агаарын тээвэр хурдацтай хөгжих боломж байгаа. Ялангуяа орон нутгийн агаарын тээвэр эрчимтэй хөгжинэ гэдэг нь тодорхой юм. Олон улсын агаарын тээврийн нислэгийн хувьд манай улс өнөөдрийн байдлаар БНСУ, БНХАУ, ХБНГУ, ОХУ, Япон гэсэн

хэдхэн гарцтай байгаа. Цаашдаа нислэгийн шинэ гарцыг нэмэгдүүлэх замаар салбарын хөгжил улам хурдацтай явагдана гэдэгт итгэлтэй байна.

“Изинис” нь иргэний агаарын тээврийн салбарт хувийн хэвшлийг төлөөлж буй компани. Иргэний агаарын тээврийн салбарын хууль эрх зүйн орчин хэр байна вэ?

-Агаарын тээврийн салбар өөрөө маш том онцлогтой. Учир нь маш их хөрөнгө мөнгө шаарддаг учраас сайтар бодож төлөвлөх ёстой. Өнөөдөр энэ салбарын эрх зүйн орчинд засаж сайжруулах зүйл байгаа хэдий ч сүүлийн хэдэн жил нэлээд амжилтад хүрсэн гэж бодож байна.

Манай компанийн хувьд Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагаас дэмжигдэж манай улсын болон дэлхийн олон орны агаарын тээврийн үйл ажиллагаанд хэрэгждэг “шийтгэлгүй мэдээллийн систем”-ийн тогтолцоог мөрдөн ажилладаг. Энэхүү тогтолцоо нь үйл ажиллагаанд байж болох дутагдлыг арилгах, улмаар нислэгийн аюулгүй байдлыг хангах хамгийн үр дүнтэй аргад тооцогддог юм. Учир нь алдаа дутагдал гарсан тохиолдолд ажилтантай хариуцлага тооцож, шийтгэл оногдуулах бус харин үйл ажиллагааны процесс, тогтолцооны хаана нь ямар дутагдал байгааг илрүүлэн, нийт системийн хувьд сайжруулалт хийх зарчмыг баримталдаг. Мэдээж хэрэг үүний хажуугаар нисгэгч, онгоцны үйлчлэгч, инженер техникийн зэрэг нислэгийн удирдлагын ажилчдаа өндөр түвшинд бэлтгэх, мэдлэг боловсрол, ур чадварыг нь дээшлүүлэхэд ихээхэн анхаарч ажилладаг.

“Монголын иргэний агаарын тээврийн салбарт өрсөлдөөн ямар байна вэ?”

-Дотооддоо эрүүл өрсөлдөөн явж байгаа гэж хэлж болно. Харин МИАТ дотоодын зах зээлд зуны ид ачаалалтай үед түр хугацаанд орж ирвэл шударга, тэгш өрсөлдөөний нөхцөл алдагдана. Тухайлбал, 2-3 жилийн өмнө МИАТ орон нутгийн нислэгийн зах зээлд зуны улиралд нислэг үйлдсэн. Дотоодын иргэний агаарын тээврийн салбарт ажиллаж буй хоёр жижиг авиа компани өвөл, зунгүй бүх л ачааллыг нуруу дээрээ үүрч яваа. Бидэнд ашигтай ажиллах зуны цөөхөн хэдэн сар байдаг. Гэтэл энэ үеэр нь МИАТ-ийн том онгоцууд орж ирэх нь эрүүл бус өрсөлдөөн болно шүү дээ. Өвлийн улиралд орон нутгийн бараг бүх чиглэл алдагдалтай бөгөөд бид нислэгийн урсгалаа хэвийн хэмжээнд байлгахын тулд алдагдлаа үүрээд үйл ажиллагаагаа тогтвортой явуулахыг хичээдэг. МИАТ орон нутгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах тохиолдолд төрөөс бидэнд олон улсын нислэгийн боломж бололцоог нээлттэй болгож өгснөөр өрсөлдөөний тэгш байдлыг хангах нь чухал юм.

Яг үнэндээ хамгийн анхны мөн төрийн компани гэдэг утгаар бүхий л ашигтай саналууд МИАТ-т ирдэг. Харин бусад компанийн хувьд боломж бага байна. Гэхдээ энэ байдал цаашдаа өөрчлөгдөх байх. Манай Зам тээвэр, барилга хот багуулалтын яамнаас агаарын тээврийн зах зээлийг либеральчилж хувийн хэвшлийн тээвэрлэгчдэд олон улсын шинэ чиглэлд нислэг үйлдэх томилогоо олгохыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Олон улсын жишгээс харахад улс орнууд эхлээд төрийн компаниа дэмждэг. Альтернатив хандлагын үүднээс төрийн компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хувийн компанийг гаргаж ирэх туршлага байдаг. Ажлаа сайн хийхгүй тохиолдолд тухайн ажлыг гүйцэтгэх хувийн хэвшлийн компани байгаа шүү гэсэн санааг агуулж заавал төрийн болон хувийн хоёр компанийг байгуулдаг аж. Хоёрдугаарт, үндэсний аюулгүй байдлын үүднээс ч төрөөс нь хоёуланг нь зэрэг дэмжих хүчтэй байлгах зорилготой ажилладаг байна. Солонгосын жишээгээр аваад үзвэл ►

► “Кореан Эйр”, “Асиана Эйрлайнс”, Японд ЖАЛ, “Олл” “Ниппон Эйрвэйз” (АНА) байна. Хувийн болон төрийн компаниудыг аль альныг нь төрөөс бодлогоор ижилхэн дэмжих нь зүйтэй. Олон улсын жишгээр тухайн улсын төрийн болон хувийн авиа компаниуд хоорондоо өрсөлдөх бус харилцан хамтарч ажиллаж гадаадын зах зээлд өрсөлдөх боломжоо нэмэгдүүлдэг юм байна лээ. Монголын нөхцөлд хязгаарлагдмал зах зээлд буюу өргөн уудам нутагт цөөн зорчигчид цөөхөн онгоцоор үйлчлүүлдэг ч үйлчилгээ, стандарт бүх зүйл өндөр түвшинд байх ёстой тул харилцан биенээ дэмжээд хамтран ажиллах нь илүү үр дүнтэй.

–“Изинис” компани Монголын иргэний агаарын тээврийн салбарт шинэ өнгө аясыг бий болгож, орж ирсэн. Харин одоо ямар зорилго, үүрэгтэйгээр ирээдүйн төлөвлөгөөгөө гаргаж ажиллаж байгаа талаараа ярина уу?

–Манай компанийг анх үйл ажиллагаагаа эхлэх үед хувийн компанид итгэх итгэл сул байсан. Хувийн компани зөвхөн ашгийн төлөө ажилладаг, тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахгүй гэдэг үзэл бодол тухайн үед нийгэмд байсан. Харин бид хувийн авиа компани нь тогтвортой, ашигтай, аюулгүй ажиллаж чадна гэдгийг баталсан. Энэ бол манай компанийн хамт олны нэг том бахархал.

Бидний баримталдаг зарчим бол нислэгийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангахад оршино. Манай компани аюулгүй байдлаа хангахын тулд зарим тохиолдолд борлуулах суудлын тоогоо буюу орлогоо хязгаарладаг. Хүмүүс тантай билет дууссан гэсэн мөртлөө онгоцонд сул суудалтай явдаг гэдэг. Үнэндээ бол онгоцны жингээ хязгаарлаад аюулгүй байдлаа хангаж байгаа хэрэг. Гадаад хамтын ажиллагааны хүрээ ч өргөжин тэлж байгаа. Тухайлбал, Японы АНА болон Германы Люфтханза Техник компаниудтай удаан хугацааны гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. АНА компанийн үйлдвэрлэл хариуцсан захирлаар олон жил ажилласан япон “Изинис” компанийн үйлдвэрлэлийг хариуцаад ажиллаж байна. Одоогоор бид боловсон хүчин, техник технологи, нисгэгчдээ бэлтгэж байгаа гэж хэлж болно.

Нислэгийн аюулгүй найдвартай байдлыг хангахаас гадна үйлчлүүлэгчдийнхээ ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлэхийг зорьж ажилладаг. Нислэгийн үеийн үйлчилгээ болон хоол хүнсэнд багагүй

анхаарал тавьж байна. Тийзний үнэ тарифаа үе шатлалтайгаар тогтоосон. Ингэснээрээ хүүхэд, ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдод хөнгөлөлттэй үнээр үйлчлэх, урьдчилан захиалагчдад илүү хямд тийз авах боломжийг бий болгодог. Харин нислэгийн өдрийг тулгаж захиалга өгсөн үйлчлүүлэгчдэд бага зэрэг үнэтэй тусна.

Манай компани өнөөдөр орон нутагт хамгийн олон чиглэлд буюу 14 чиглэлд нисэж байна. Эдгээр нислэг зуны улирлаас бусад үед ашиггүй байдаг ч бид нислэгээ тасралтгүй тогтвортой үйлдэж ирлээ. Яагаад алдагдалтай чиглэлүүдэд байнгын нислэг үйлдэж байна вэ гэвэл бид ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийж байгаа юм. Алдагдалтай ч нислэгийн чиглэлүүдэд тогтмол нислэг тасралтгүй үйлдсэнээр иргэдэд “Изинис” компани үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг, алга болчихдоггүй гэсэн итгэл бий болно. Ингэснээр зах зээл цаашаа өргөжин тэлж хөгжих болно.

–“Изинис” өнөөдөр олон улсын ямар чиглэлд нисэж байгаа вэ?

–ӨМӨЗО-ны Хайлаар, ОХУ-ын Улаан-Үд рүү нисэж байна. Цаашид Хятад, ОХУ болон Казахстан улсын бусад хотууд руу нислэг нээх боломжийг судалж байна.

–Дотоодод аль чиглэлийн нислэг хамгийн их эрэлттэй байдаг вэ?

–Зуны улиралд Өмнөговь болон Хөвсгөл аймгуудыг чиглэсэн зорчигч урсгал их байдаг. Одоо манай компани Даланзадгад, Мөрөн рүү өдөрт тус бүр 2-3 удаа нислэг үйлдэж байна.

–Иргэний агаарын тээврийн салбар дахь боловсон хүчний мэдлэг чадвар хэр байна вэ?

–Ерөнхийдөө сайжирч байгаа. Гэхдээ улам сайжруулах ихээхэн хэрэгцээ шаардлага болон өргөн боломж байна. 1990-ээд оныг хүртэл төрийн бодлогоор энэ салбарын нарийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэдэг байсан. Харин 90-ээд оноос одоог хүртэл нарийн мэргэжлийн инженер, нисгэгчдийг бодлогоор дэмжиж шинэ чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх ажил хангалтгүй байсан гэж хэлж болох талтай. Харин сүүлийн жилүүдэд анхаарч эхлээд байгаа.

Манай компанийн хувьд ч энэ талд боловсон хүчнээ сургах дадлагажуулахад ихээхэн анхаарч ажилладаг. Гадаадын олон байгууллагатай харилцаж, тэднээс туршлага судалж байна. Жишээ нь, Японы АНА компаниас “Изинис” ажилтан авч ажиллуулах, мөн монгол

ажилтнуудаа АНА-гийн үндсэн ажилтнаар 1-2 жил ажиллуулах зэрэг олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Мөн Германы Люфтханза Техник компанийн инженер манай дээр томилогдон ажиллаж байгаа бөгөөд монгол инженерүүдийг сургаж дадлагажуулахад ихээхэн анхаарч байна. Энэ нь хүний нөөцийн капитал бий болгож байгаа нэг хэлбэр юм. Хуучнаараа бус дэлхийн стандартаар сэтгээ гэсэн уриаг бид баримталдаг.

–“Изинис” компани нислэгийн үнэ тарифаа хэр бодит түвшинд тогтоосон гэж үздэг бол?

–Иргэний агаарын тээврийн салбар өндөр хөгжсөн орнуудтай харьцуулахад манай нислэгийн тариф өндөр. Хүн ам олон орнуудын хувьд агаарын тээврийн зорчигч урсгал их тул том онгоцоор нислэг үйлдсэнээр нэг суудалд онгодох зардал доогуур байдаг бөгөөд энэ нь хямд зардлаар үйлчлэх боломжийг олгодог. Харин манайд эсрэгээрээ. Зорчигч цөөхөн, жижиг онгоцоор хол зайд нисдэг, техник технологийн ихэнхийг гаднаас оруулж ирдэг. Үүний зэрэгцээ, Монголд онгоцны түлшний үнэ өндөр бөгөөд дэлхийд хамгийн өндөр үнэтэй түлш хэрэглэдэг гэж тооцогддог. Энэ бүх шалтгаан нислэгийн тийзний үнэд нөлөөлдөг. Гэвч бусад орны жижиг онгоцтой авиакомпаниудтай харьцуулбал үнэ тариф ойролцоо түвшинд байгаа.

–Парк шинэчлэлийн хувьд ямар арга хэмжээ авч байгаа вэ?

–Одоогийн байдлаар манай компани таван онгоцтойгоор үйл ажиллагаа явуулж байна. Зургаа дахь онгоцоо худалдан авах гэрээгээ хийчихсэн байгаа бөгөөд энэ оны есдүгээр сард Монголд ирнэ. Зургаан онгоцны хоёр нь 93 хүний суудалтай, тийрэлтэт хөдөлгүүртэй, 4000 км-ийн зайд буулт хийлгүйгээр алс нисэх боломжтой Авро Ар-Жэй 85 маягийн агаарын хөлгүүд юм. Бусад дөрөв нь 34 хүний суудалтай сэнст тийрэлтэт хөдөлгүүртэй Сааб 340Б онгоцууд. Ирэх жил тав дахь Сааб хөлгөө оруулж ирэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Манай компанийн бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаагаа тэлэх ажлын төлөвлөгөөнд олон улсын томилгоо маш чухал үүрэгтэй. Тиймээс төрөөс бодлогоор дэмжих тохиолдолд том онгоц оруулж ирэн хамтарч ажиллахад бэлэн байна.

–Танай компани 93 хүний суудалтай шинэ онгоцоо хүлээж аваад удаагүй байгаа. Шинэхэн онгоц аль чиглэлд нисэж байгаа вэ? ►►

Ховд, Улаангом хотууд болон Өмнөговь аймгийн Цогтцэций сумын чиглэлд нисэж байна. Үйлчлүүлэгчдийн хувьд сэтгэл хангалуун байгаа нь гурван зүйлээр харагдаж байна. Нэгдүгээрт, тийрэлтэт хөдөлгүүртэй өндөр хурдтай нисэх боломжтой онгоц тулцаг хэмнэнэ. Жижиг онгоцоор дээрх чиглэлд гурван цаг гаруй нисдэг бол том онгоцоор нэг цаг зарцуулж байна. Хоёрдугаарт, онгоцны бүхээгийн багтаамж сайтай тул тав тухтай аялах нөхцлийг бүрдүүлж байна. Гуравдугаарт, хоолны чанар болон нислэгийн үйлчилгээний хувьд таалагдаж байна гэсэн дүгнэлт хийгээд байна.

–“Изинис” компанийн ойрын болон ирээдүйн зорилгыг сонирхье?

–Ойрын ирээдүйд техник технологи, хүний нөөц, материаллаг баазаа сайтар хангах бэлтгэл ажлыг маш эрчимтэй хийж байна. Техник үйлчилгээний төв барьж байна. Багаа бүрэлдүүлж байна. Инженер техникийн мэргэжилтэй таван залуусыг Германы Люфтханза техникийн инженерийн сургуульд явуулахаар ажиллаж байна. Ажилчдынхаа мэдлэг, ур чадварыг

нэмэгдүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт хийж байна.

Салбарын хувьд ирээдүйд орон нутаг болон олон улсын нислэгийн чиглэл болон нислэгийн тоо давтамж улам нэмэгдэж Монголдоо төдийгүй гадаадын улс орнууд руу зорчиход агаарын тээврийн үйлчилгээ улам хялбар, хүртээмжтэй төдийгүй өргөн сонголттой болно гэдэгт итгэлтэй байна. Энэ үед Ховд аймгийн Булган суманд амьдардаг иргэн тухайн газраасаа Франц руу нисэх тасалбарыг захиалан авч, зорьсон газартаа олон нислэг дамжилгүй түргэн шуурхай, ая тухтай зорчин хүрэх боломж бүрдэх болно. Мөн үйлчлүүлэгч дэлхийн аль ч өнцгөөс Монгол Улсын хүссэн газартаа онгоцоор хүрэх боломжийг бий болгох юмсан гэсэн мөрөөдөл байдаг.

Ирээдүйд бид дэлхийн хэмжээнд өөрийн гэсэн нэр хүндтэй болж, нислэгийн ажиллагааны олон улсын стандартыг хангасан тээвэрлэгч болох зорилгыг өмнөө тавин ажиллаж байна. Мөн тийзний үнийг илүү хүртээмжтэй болгох нь бидний нэн тэргүүний зорилт юм. Өртгийг хямдруулахын тулд системийн бүтэц, нисэж байгаа хүний

нийт тоо их чухал. Дээрээс нь төр дэмжээд хөрөнгө оруулах хэрэгтэй. Иргэний агаарын тээвэрт оруулсан нэг долларын хөрөнгө оруулалт эдийн засагт буцаад найман доллар болдог гэсэн олон улсын статистик тоо байдаг. Мөн иргэний агаарын тээврийн салбарт бий болгосон нэг ажлын байр шинээр зургаан ажлын байр бий болгодог. Эндээс харахад иргэний агаарын тээврийн салбар эдийн засагт маш чухал ач холбогдолтой гэдэг нь тодорхой харагдаж байна.

–“Изинис” компанийг удирдаж яваа залуугийн талаар манай уншигчид сонирхох нь мэдээж. Та өөрийгөө танилцуулна уу?

–Миний бие 12 жил АНУ-д сурч, ажиллаж амьдарч байгаад 2009 онд гэр бүлийнхээ хамт эх орондоо ирсэн. Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлийн мэргэжилтэй. “Изинис” компанийн гүйцэтгэх захирлын ажлыг аваад нэг жил болж байна. Надад итгэл үзүүлж, ийм өндөр хариуцлагатай албанд томилсонд талархаж явдаг. Мөн ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг өндөр мэдлэг боловсрол, чадавхтай хамт олноороо бахархаж байна. ■

Хөгжил

Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтийн үндсийн үндэс нь монгол хүний хөгжил дэвшил

Б.Оюунчимэг /Санхүү эдийн засгийн дээд сургуулийн багш, доктор (Ph.D), профессор/



Улс орноо хөгжүүлэх, эдийн засгаа өсгөх талаар бид ихийг хүсдэг, чамгүй ч ярьдаг. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийнхэн “Монгол Улсын хөгжлийн гарц” гэсэн ярилцлага зохион байгуулж, бусад нэвтрүүлэг хийж байдаг ч улс орноо хөгжүүлэх, эдийн засгаа өөд татах үндсийн үндэс нь чухам юу болох талаар энд өгүүлэх зүйлийг төдийлэн хөнддөггүй.

Улсаа хөгжүүлэх, эдийн засгаа өсгөх гарц бол технологийн дэвшил гэж үздэг. XX зуунд, XXI зуун гарсаар ч хөгжил дэвшилд шийдвэрлэх нөлөөтэй шинэ технологи, шинэ шийдлүүдийн зэрэгцээгээр өргөн хэрэглээний зүйлс, тухайлбал гялгар уут, компьютер, интернэт, гар утас гээд олон зүйл бий болсон.

Ер нь технологийн хэрэглээ өргөжиж байвал эдийн засаг өсөж байна хэмээн тооцсон хэвээр байгаа. Эдийн засгийг өсгөх чухал хүчин зүйл гэж бидний үздэг нөгөө технологийн

дэвшлүүд нь байгалийг бохирдуулж, унаган төрхийг нь алдагдуулж, түүний өөрийгөө цэвэрлэх бүтэц, тэнцвэрт тогтолцоо (экосистем)-г нь туйлдуулж, хүмүүсийн эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж байна. Хэрэгцээ шаардлагаа хангахаар зохион бүтээсэн, шүтээн болсон технологийн дэвшлийн үр дүн болох олон зүйл дэлхийг хамгийн ихээр сүйтгэж, хүмүүсийг хохироож байгааг судлаачид тэмдэглэх боллоо.

Харвардын их сургуулийн судлаач, физикч Алекс Виспер-Гроосын хийсэн тооцоогоор “Google”-ээс хоёр мэдээлэл хайх хугацаанд компьютерээс данх ус буцалгах хэмжээний нүүрс төрөгчийн хий ялгардаг байна. Дэлхийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн явцад ялгардаг хүлэмжийн хий агаарын үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын ялгаруулдаг хорт хийнээс хавьгүй их байдаг гэсэн мэдээлэл ч байдаг аж.

Монголчуудын толгой дараалж дор хаяж нэгийг, олонх нь хоёр гурваар нь хэрэглэж, биеэсээ огт салгахгүй, өвөртөлж унтах нь холгүй байдаг гар утас үйлдвэрлэх үед, бүр хаяж гэсэн хойно ч байгаль орчныг жирийн үеэс нь хоёр дахин их бохирдуулдаг гэнэ. Ихэнх гар утсыг “колтан” хэмээх металл ашиглан үйлдвэрлэдэг бөгөөд эл металл хөрсийг хамгийн их бохирдуулдаг халгаатай эд болохыг тогтоогоод байна. Зах зээлд борлуулж байгаа бүх зай хорт бодис агуулдаг. Зүй бусаар хаясан зай хөрс, агаарыг бохирдуулдгаас гадна тэсэрч дэлбэрвэл хорт хийнд нь хүн амиа алдах ч аюултай аж.

Эрдэс баялгаа олборлох замаар ашиг олж, эдийн засгаа өсгөх хүсэл улс орнуудад байсаар ирсэн ч бүгд баяжин хөлжиж, хөгжин дэвшиж чадаагүй байдаг. Тэдгээрийн нэг нь Болив улс. Энэ улс уул уурхайн томоохон олборлолт хийсэн ч нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй тул эдийн засгаа өсгөж чадаагүй байна. Боливчууд нь Бразил, АНУ, Японд газрын тосоо түүхийгээр нь өгөөд, эдгээр улсаас нефтийн бүтээгдэхүүн өндөр үнээр худалдаж авдаг аж. Ихэнх буурай орон байгалийн баялгаа нээн илрүүлж, гадаадад гаргаж эхэлмэгц дийлэнх иргэд нь улам ядуурдаг болохыг эдийн засагчид хэдийнэ ажигласан байгаа юм. Байгалийн баялгаа олборлож, гадаадад гаргасны дараа дотоодын үйлдвэрлэл буурч, зарим нь дампуурч, ажиллах хүсэлгүй хүн олширсноос ажилгүйдэл ихэсдэг практик ч байна.

БОАЖЯ, Дэлхийн Банк, Нидерландын Вант Улсын Засгийн газраас хамтран гурав дахь жилдээ хэрэгжүүлж буй “Байгаль орчны шинэчлэл Немо-2” төслийн хүрээнд Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Хэнтий аймгийн нутагт ашигт малтмалын хайгуул олборлолтоос үүдэн сүйдэж, эвдэрч орхигдсон 1309.6 га хэмжээтэй 420 нэгж газар байгааг илрүүлэн тогтоожээ. Байгальд халгүй, ногоон, хариуцлагатай эдийн засгийн өсөлт бидэнд хэрэгтэй байгааг дээрх ажлын үр дүн тодорхой харуулж байна.

Эдийн засгийг тэтгэдэг зүйл бол банкны эрүүл тогтолцоо гэж үздэг. Банкгүй улс орон гэж байдаггүй. Банкгүйгээр ямар ч орны эдийн засаг өсөхгүй, улс нь ч хөгжихгүй. Банк, түүний тогтолцоог тухайн улс орны бодит эдийн засгийн тусгал гэж ч тооцдог. Улс орны эдийн засгийн өнгө төрх, байр байдлыг төдийгүй ямаршуу иргэдтэй болохыг үнэн мөнөөр нь харуулдаг зүйл бол банкны үйл ажиллагаа. Чухам банкных нь үйл ажиллагаанаас л эдийн засгийн үйл ажиллагаа хаанаа нь доголдож, ямар алдаа гажуудал гарч байгааг олж харж болдог аж. Зээл олгох ёсгүй хүнд олгодог, авах ёсгүй хүн авдаг, авсан зээлээ хугацаанд нь эргүүлж төлдөггүй, бүр огт төлөхгүй “чанаргүй” хэмээх зээл болгодог, төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй арилжааны банкууд харилцагчийн адгаламжийг алга болгох гэх мэт банкны үйл ажиллагааны дутагдал манайд цөөнгүй байх тул банкныг эдийн засгийг тэтгэгч гэж үзэхэд хэцүү байна. Дэлхийн банкнаас гаргасан II улирлын тайланд Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний үнэ эрс өссөнөөс төсвийн зардал хэт нэмэгдсэн, нийт хүн амын 13 хувь нь ажилгүй учир орлогын эх үүсвэргүй, халамж хүртэгчдийн тоо ихсэж, халамжийн хэмжээ өссөөр байна гэж дүгнэжээ.

Монголын эдийн засаг эрүүл бус байна гэж үздэг хүн цөөнгүй, бүр ямар өвчтэй болохыг нь тодорхойлсон байх юм. “Голланд” хэмээх өвчин манай эдийн засагт байдаг аж. Энэ өвчин уул уурхайн салбарыг нэрвээд зогсохгүй төр, засгийн үйл ажиллагаа нүүдлийн малажахуйд халдварласан гэнэ. Манай гавьяат эдийн засагч Ц.Даваадорж “Голлоанд өвчин”-ий монгол загварыг боловсруулж, “байгалийн баялгийг илрүүлж экспортолно, эх орны үндэсний үйлдвэрүүд дампуурч, ажилгүйдэл өснө, ажиллах дур хүсэлгүй болж ажиллах чадваргүй хүмүүс олширно”

гэж тодорхойлжээ.

Эдийн засгийн өсөлтийг тодорхойлох хэмжүүр, үзүүлэлтүүдийг өөрийн нөхцөл байдалд тохируулалгүй, гаднын улс орнуудын юмыг тэр чигт нь авч хэрэглэдэг нь эдийн засгийн бодит хөгжилд сөргөөр нөлөөлсөөр... Монгол Улсыг хөгжүүлэх, эдийн засгийг өсгөх гарцууд маань ийм л байгаа нь бид улс орноо хөгжүүлэх, эдийн засгаа өсгөхийн хувьд буруу замаар будаа тээж буйг илтгэн харуулж байгаа бус уу.

Бид улс орны эдийн засгийн өсөлтийг “эдийн засгийн хөгжил” гэж ойлгосоор ирсэн ч ер хөгжил гэж юу болох, юугаа илүүтэй хөгжүүлэх, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтийн үндсийн үндэс нь чухам юу болох талаар нухацтай ойлгох шаардлагатай байна.

“Хөгжил” гэдгийг зогсонги байдаггүй, хөдөлгөөнт шинжтэй, энгийн доод шатнаас нарийн дээд шатанд шилжих шилжилт, тоо хийгээд чанарын дэвшилт өөрчлөлт хосолсон зүй тогтолтой үйл явц гэж ойлгож болох юм. Улс орны хөгжлийн хувьд хамгийн гол үзүүлэлт нь эдийн засгийн өсөлт биш болохыг тэргүүний дэвшилт хүмүүс ойлгож, ухаарч байна. Америкийн нэрт гүн ухаантан Ральф Уолдо Эмерсон “Улс орны хөгжлийн үзүүлэлт нь хуримтлуулсан материаллаг баялаг, арвин ургац, том хотууд бус харин хүмүүжүүлсэн хүн” гэсэн үгэндээ алив улс орны хөгжлийн хэмжүүрийн талаар өгүүлсэн нь бий.

Хөгжил нь эдийн засгийн өсөлтөөс өргөн цар хүрээтэй төдийгүй хамгийн гол нь мөн чанарын тухай ойлголт. Өсөлт алив өөрчлөлтийн тооны талыг, ил шинжийг нь харуулдаг бол хөгжил мөн чанарыг илэрхийлдэг. Тухайлбал хүн амын тооны өсөлтийг хүн амын өсөлт, ДНБ-ий тоо хэмжээний өсөлтийг эдийн засгийн өсөлт гэж нэрлэдэг бол хүнд гарсан эерэг өөрчлөлт, дотоод, чанарын ахиц дэвшлийг түүний хөгжил гэдэг.

Улс орны хөгжлийг хүн ардынх нь хөгжил дэвшлээр тодорхойлох ёстой гэдэг үзэл хандлагын хүчийг нэмж, хэрэглээнд өргөнөөр оруулах шаардлагатай байгаа юм. Нийгмийн харилцааны явцад, түүний үйлчлэлээр гарваль шинж чанарт тулгуурлан хүнд бий болж, бүрэлддэг дэвших хандлагатай өөрчлөлтийг хүний хөгжил гэнэ гэж манай нэгэн судлаач тодорхойлжээ. Бидний зорьж буй нийгмийн хөгжлийн цөм нь хүн төвтэй хөгжлийн үйл явц юм. Үр бүтээлтэй ▶

ажилладаг, бусадтай хэвийн харилцдаг, бусдад жинхэнэ ёсоор анхаарал тавьж халамжилдаг хүмүүс л улс орноо хөгжүүлнэ.

Өнөөгийнхэн ихэвчлэн гадаад хөгжил, гадаад эдийн засагт анхаарлаа илүүтэй хандуулж байна. “Эдийн засаг хэрэгтэй ч үүнээс илүү чухал нь бидний өвөг дээдсээсээ уламжилж ирсэн оюуны өндөр соёл, сэтгэлийн амар амгаланг бий болгодог зүйл юм. Гадаад хөгжил биеийн жаргал эдлүүлж чадах боловч сэтгэлийн амар амгаланг бий болгож чадахгүй. Тиймээс гадаад эдийн засаг, дотоод сэтгэл хоёрыг адил тэнцүү хөгжүүлж чадвал маш чухал. Үүнд анхаарлаа хандуулах замаар улс орноо хөгжүүлээсэй” хэмээн XIV Далай лам Д.Данзанжамц өгүүлсэн нь бий. Хэчнээн сайхан гадаад хэрэгцээт эд зүйлс байвч дотоод сэтгэлд амар амгалан үгүй бол тайван оршин амьдарч, ажиллаж хөдөлмөрлөж эс чадна. Эдийн засаг, гадаад материаллагийг өсгөснөөр биеийн амгаланг эдэлж болох ч цөөнгүй сөрөг үр дагавар дагуулна гэдгийг мартаж болохгүй. Эдийн засгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх нь биеэр эдлэх жаргалыг л нэмэгдүүлэх гэсэн эдийн засгийн шинжтэй арга хэмжээ гэж үзэж болох.

Эдийн засаг нь хүний амьдралын нэг тал, хэрэгцээгээ хангах үйл ажиллагаа. Эдийн засгийг дан ганц эд зүйлсийг үйлдвэрлэх, хуваарилах, хэрэглэх төдийгөөр ойлгож хандах нь учир дутагдалтай. Эдийн засаг нь эд материалын төдийгүй, оюуны үйлдвэрлэл юм.

Хүмүүс эдийн засгийн субъект, эдийн засгийн үйл ажиллагаа явуулагч, үйлдвэрлэл эрхлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гол хэрэглэгч, эдийн засгийн амьдралыг бүхэлд нь хөтлөгч юм. Бид эдийн засгийн амьдралынхаа явцад бие биеэ хүртэн мэдрэх, ойлголцох, зохицох, нөлөөлөх, хамтран ажиллах үүрэгтэй. Эдгээр үүргийг хэрхэн биелүүлж байгаагаас эдийн засгийн үйл ажиллагаандаа амжилт гаргах, эдийн засгаа өсгөх нь хамаардаг.

Хүнийг хөрөнгө чинээ, бие хаа, гадаад төрхөөр нь үнэлдэг болсон нь нийгэм хөөрхийлөлтэй байдалд орсны шинж, капиталист маягийн эдийн соёл Монголд хүч түрэн ирж байгаагийн илрэл. Барууны өндөр хөгжилтэй орны техник, технологид суралцахын зэрэгцээгээр өөрсдийн уламжлалт соёлыг хүндэтгэн дээдэлж, энэ хоёрыг хослуулан хөгжүүлэх нь зохистой болов уу. Энэ талаар “хүн

төрөлхтний соёл иргэншил Дорноос эх авч, Өрнөдөд дэлгэрч, Дорно, Өрнө хоёр ойртон ойртсоор хоёр соёл иргэншил нэгдэн нийлж, Өрнийг өөртөө багтаасан Дорно дахины соёл болох замаар синтезлэгдэж, нэгдмэл соёл болж өндөрлөх түгээмэл зүй тогтолтой” хэмээн нэрт гүн ухаантан Н.Хавх бичжээ.

Улс орны хөгжил эд баялгаас бус, харин иргэнээс нь шууд шалтгаална. Монголчууд хүнээ өөрчилж байж л хөгжил дэвшлийн тухай ярих ёстой. Улс орны эдийн засаг өсөхийн хэрээр хүн ардынх нь амьдрал дээшилж байх учиртай, эдийн засгийн үйл ажиллагаа нь иргэддээ, тэдний амьжиргааг дээшлүүлэхэд чиглэх ёстой атал олонхийн амьдрал дээрдэх биш, харин өдрөөс өдөрт дордож байгаа талаарх мэдээллийг бид үргэлж авсаар.

Хөгжлийн гадагшаа харсан, зөвхөн эд зүйлсийг үйлдвэрлэх, борлуулах, хэрэглэхийг чухалчилсан, байгалийн баялгийг шамдан олборлох бодлогыг хөгжлийн дотогш хандсан бодлого болох өөрсдөө бүхнийг үйлдвэрлэх, оюуны баялгийг бүтээх, улс эх орныхоо, нийгмийн төлөө сэтгэлтэй хүмүүсийг төрүүлэх бодлогоор солих, үгүй ядаж энэ хоёр бодлогыг хослуулах шаардлагатай байгаа юм.

Эдийн засгийг хүмүүнлэгээр хөгжүүлэх, шударга нийгэм байгуулах, зах зээлийн нийгмийн хуулиар замнах шаардлагагүй гэж үздэг “хүмүүнлэг эдийн засгийн” хэмээх чиглэлийг баримтлагчдын тоо сүүлийн жилүүдэд өсөж, эдийн засгийн үйл ажиллагааны бүхий л чиглэлд төрийн төрөл бүрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай тэмдэглэгцгээж ч байна.

Зах зээлийн эдийн засаг нь баяжихын цорын ганц эх үүсвэр, тансаг амьдрах боломж гэж томъёолдог “чөлөөт зах зээлийн” хэмээх чиглэлийг баримтлагчдын ам, ажил хоёр тохирохгүй болж. Сүүлийн жилүүдэд дэлхий баян тансаг болж байгаа ч тэгш бусаар хөгжиж, өөрөөр хэлбэл хөгжлийн ялгаа ихсэж, ядуу зүдүү хүний тоо олширсоор. Төрийн зохицуулалтыг бууруулснаар эдийн засгийн амьдралын олон асуудлыг шийдвэрлэж чадахаа болиод байгаа. Хөрөнгө баялаг цөөн хүний гарт очиж, олон улс орны ДНБ тэдний хөрөнгийн хаана нь ч хүрдэггүй, дэлхийн нийт хөрөнгийг хүн амын хоёрхон хувь эзэмшдэг, хамгийн баян гурван хүний хөрөнгө ядуу 48 орны ДНБ-ээс давж байна гэсэн тоо баримт “зах зээлийн” хэмээх эдийн засгийн нүүр царайг

харуулж байна.

Улс орны хөгжил, ололт амжилт, эдийн засгийн өсөлтийг дотоодын нийт бүтээгдэхүүнээр хэмжих нь шаардлага хангахаа больж байгааг олон улсын эдийн засагчид эрчимтэй ярих болсон, түүний оронд “хамарсан өсөлт” (Inclusive growth) гэдэг шинэ хэмжүүрийг хэрэглэх саналыг япончууд гаргаж, Хятад улс хамарсан өсөлтийг хөгжлийнхөө гол хэмжүүр болгох тухай Ерөнхийлөгч нь 2010 оны аравдугаар сард Бээжинд болсон Ази, Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагааны (АРЕС) орнуудын Хүний нөөц хариуцсан сайд нарын уулзалт дээр мэдэгдсэн. Хамарсан өсөлт гэдэг нь эдийн засгийн өсөлтийн үр шимийг нийгмийн бүх давхаргын хүмүүст, ядуу доройг нь орхилгүйгээр нэгбүрчлэн хүртээх, улмаар эдийн засгийн өсөлтийг нийгмийн (хүний) хөгжил дэвшилтэй тэнцвэртэй уялдуулан холбох, хэмжих явдал аж.

Улс хөгжлийг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас илүүтэйгээр хүний хүчин зүйлсийн нөлөөллийг чухалчилдаг дэлхий дахины нийтлэг үзэл баримтлалд анхаарал хандуулах хэрэгтэй байна. Манай орны хүн амын дээд, доод давхаргынхны орлого ихээхэн зөрөөтэй, баян ядуугийн ялгаа их байгааг хэн хүнгүй мэднэ. Үүний шалтгаан нь байгалийн баялаг бүх ард түмний өмч атал цөөн хүн түүнээс хүртдэг, эдийн засгийн өсөлт нийгмийн бүх давхаргыг хамарч чадахгүй, хөгжлийн өгөөж хүн бүрт хүрэхгүй байгаа явдал.

Хөгжил нь буурч доройтох биш харин урагш дэвших жамтай хөдөлгөөн бол хөгжлийг хэрэгжүүлэгч нь хүн тул монгол хүн ахиж дэвшиж л байвал Монгол Улс хөгжинэ. Энэ бол бидний туйлбартай баримтлууштай хөгжлийн бодлого. Нийгмийн хөгжил ийм учир шалтгаантай. Эрүүл зөв сэтгэж, үндэсний соёлоороо боловсорч, ёс суртахууныг дээдэлж, амьдралыг идэх уух, эдэлж хэрэглэх зүйлээр л хэмжихгүй, хүн ардынхаа бодит амьдралыг мэдэрдэг, түүнд харшлах арга замаар ашиг хонжоо олох гэдэггүй хүмүүс л Монгол орныг хөгжүүлнэ. Ядуу зүдүү байхгүйн тулд монгол ёс заншлаа, уламжлалаа, хүний мөн чанараа алдаж болохгүй, бид. Улс орноо хөгжүүлэх, эдийн засгаа өсгөх үндэс нь иргэдээ хөгжүүлж дэвшүүлэх, боловсруулах, ёс суртахуунлаг болгох явдал. Монгол хүний хөгжил нь Монгол Улсын дэвшил, ололт амжилтын эх сурвалж, гол зорилго, хүрэх өндөрлөг юм. ■

Тэд бидний тухай

Монгол: Салаа замын уулзварт

Wall Street Journal"-ын тусгай сурвалжлагч Маурэн Орд (Maureen Orth) Монголоор аялж, "The Luxury Frontier" хэмээх сонирхолтой нийтлэл бичсэнийг уншигчдадаа хөрвүүлэн хүргэж байна. Энэхүү нийтлэлийн гарчгийг үгчилбэл "Тансаг зэрэглэлийн зааг" болох боловч монгол уншигчдадаа утга, агуулгын хувьд арай дөхөм байлгах үүднээс дураараа өөрчилсөндөө хүлцэл өчье.

Хэтэрхий том газар нутаг болон гадаадын зохицуулалт саад хийж байсан орны үүдийг баялаг тогшин сэрээхэд юу болдог вэ? Нэг буландаа тансаг "Louis Vuitton"-ыг байрлуулж, зам дороо дэлхийн хамгийн том алт, зэсийн нөөцийг агуулах Монголын нүүдэлчин нийгэмд чинээлэг байдлын үндэс хэдийнэ соёлжээ.

Өөрийн морин дээр гялалзах догшин аварга Монголын уудам тэнгэр лүү 131 фийт өндөрт цойлно. 1206 онд Их Монгол Улсыг зарлан тунхагласнаасаа 800 жилийн дараа Чингис хаан 250 тонн гангаар амилан дахин мордсон нь энэ ээ. Нийслэл Улаанбаатараас гараад цөөн тооны засмал замын нэгээр давхиж ирэхэд ашигт малтмалаар баян, тусгаар тогтносон шинэ Монголын энэхүү хөшөө

нь хүчирхэг хөршүүд болох Хятад, Оросын зүг гаргаж буй том "дунд хуруу" шиг сэтгэгдэл төрүүлнэ. Дэлхийн түүхэн дэх хамгийн том, хүчирхэг гүрнийг бий болгож байсан Чингис хааны бахдам түүх Хятадын 200 жилийн дарангуйлал, Оросын дагуул болсон 70 жилийн явцад бүдгэрч, олны анхаарлыг татахаа больсон бол энэ оны долдугаар сард Монголын эрүүл ардчиллын 21 жилийн ойн баяр тохиож байгаа юм. Өнөөдөр 80 төрлийн ашигт малтмалын нөөц, тэр дундаа нүүрс, зэс, алт, ураныг байж боломгүй их хэмжээгээр хэвлийдээ тээсэн Монголын нутагт газрын тосны хайгуул хүртэл эрчимтэй явагдаж байна. Техасыг хоёр нийлүүлсний дайтай хэрнээ сийрэг хүн амтай энэ орон толгой эргэм шилжилтийн үедээ иржээ. Эдүгээгийн өөр ямар ч үндэстэн Монгол шиг салаа зам, түүхэн сонголтын өмнө нүүр тулж байгаагүй биз. Энэ улсын ирээдүй Нигертэй ижил байх уу, Чилитэй төстэй байх уу? Венесуэльтэй юу, Австралитай юу?

"Монгол бол үнэхээр боломжоор дүүрэн орон" хэмээн ING хөрөнгө оруулалтын банкны Монгол дахь салбарын тэргүүн Ховард Ламберт (Howard Lambert) онцлов. "Энд бүхнийг шинээр хийж болно. Санхүүгийн дэд бүтэц хөгжөөгүй нь үнэн, гэхдээ Та түүний барилгын нэг хэсэг болж чадна. Лондоны албаны өрөөндөө зүгээр шахам сууж байхын оронд жолоогоо эргүүлээд л энд машин бүтээж болно. Өдөр бүр би шинэ барилга харж байна. Хөгжил хурдсаж, замгүй орны хүмүүс

спорт машин авч байхыг ажиглаж сууна. Гэхдээ нийгмийн ялгаа улам л гүнзгийрч байна даа" гэв.

Нэгэн цагт Лениний хүрэл хөшөө ноёрхож байсан Сүхбаатарын талбайгаас өөр юу ч Монголын өнөөгийн хөл толгойгүй байдлыг илэрхийлж чадахгүй буюу. Эдүгээ энд 2009 оны аравдугаар сард үүдээ нээсэн "Louis Vuitton"-ы гялцал дэлгүүр байраа эзэлж, VIP зэрэглэлийн үйлчлүүлэгчдэдээ оргилуун дарс, тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүн санал болгох аж. Гэвч энэхүү дэлгүүрээс хэдхэн зуун ярдын зайд тэрс үзэлтнүүд гэрээ нүүлгэж ирэн суулт хийж байх агаад гадныхныг өөгшүүлж, өөрсдийнх нь төлөө хангалттай ихийг хийхгүй байна гэх шүүмжлэлийг Засгийн газар руугаа хайр найргүй чулуудна. "Бидэнд ажил хэрэгтэй байна. Ядуус ч гэсэн амьжиргаагаа дээшлүүлэх эрхтэй" хэмээн 52 настай И.Багануур надад хэлээд, "Төр, засгийн эрхмүүд зөвхөн өөрсдөдөө зориулж бодлого боловсруулаад, ард иргэдийнхээ төлөө юу ч хийхгүй байна" гэв.

"Louis Vuitton"-ы тансаг дэлгүүрийг "Burberry", "Zegna", "Emporio Armani" болон "Hugo Boss" хуваалцан байрлана. "Burberry" мөн эдүгээ баригдаж буй Шангри Ла зочид буудалд дараагийн дэлгүүрээ нээх гэж төлөвлөж байгаа бол "Ferragamo" болон "Dunhill" ч тэнд талбай авчих санаатай байгаа гэнэ. Байдал ийм атал Төв Азийн хамгийн хүчтэй ардчиллыг бий болгосноороо бахархдаг Монгол орны нийслэл гудамжны хаяг гэх юмгүй байх бөгөөд дөнгөж саяхнаас л зип-код нэвтрүүлж эхэлжээ. "Монголчууд илүү амжилттай байх тусам илүү их сорилтын өмнө тулгарч байгаа нь хувь заяаны егөөдөл юм уу даа" хэмээн АНУ-аас Монголд суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Жонатан Аддлтон онцлов.

Тансаг зэрэглэлийн дэлгүүрүүд яагаад Монголд ирээд байгаа юм бол оо? Энэ орон ердөө 2.8 сая хүн амтай бөгөөд тэдний бараг тал нь 500 мянган хүнд зориулагдан баригдсан Улаанбаатар хотод шавааралдан суурьшиж байгаа. Хотын оршин суугчдын 700 мянга нь ихэвчлэн үгүйрч хоосорсон малчид байх агаад эргэн тойрны уулсыг дүүргэсэн гэр хороололд амьдрахдаа өвлийн тэсгим хүйтэнд дулаан байхын тулд нүүрс, зарим нь бүр лааз зэргийг шатааж, хотын агаарыг бохирдуулна. Малын тоо нь хүнээсээ 16 дахин их энэхүү хуучинсаг ▶



оронд тансаг зэрэглэлийн дэлгүүрүүд яаж ашиг олоод байгааг л би ойлгохыг хүссэн юм.

Миний анхны уулзаж, ярилцлага авсан Монголын албаны хүн хиймэл зүлэг, машинаар гоёсон албаны өрөөндөө зангиагүй сууж байв. Монголын Сангийн дэд сайд, 38 настай Ч.Ганхуяг “Би баасан гаригт чөлөөтэй хувцаслаж байхаар шийдсэн юм” хэмээн тайлбарлалаа. Тэрбээр хамгийн сүүлд Давост очоод ирсэн тухайгаа тайлагнасныхаа дараа надад шинэ Монголын “Чоно эдийн засаг” гэх нэрийг сурталчилсан цахим хуудсыг нээж сонирхуулав. Улаанбаатар нь дэлхийн хамгийн бага температуртай нийслэл гэж хэлж болох агаад Монголын -40 градуст хүрдэг өвлийг зөвхөн “Чоно эдийн засаг” л эсэн мэнд туулж чадах ажээ. Тэгээд Ганхуяг монголчууд уул уурхайн хоёр том ордоо хэрхэн “янзлах” гэж байгаагаа тайлбарласан юм.

Дэлхийн хамгийн том ашиглагдаагүй зэс, алтны нөөц хэмээн тооцогддог дөрвөн тэрбум ам.долларын Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээг Монголын Засгийн газар Австралийн “Rio Tinto” болон Канадын “Ivanhoe Mines” компанитай 2009 оны аравдугаар сард хийсэн. 2012 онд үйл ажиллагаагаа эхлэх уг уурхайн барилгын ажил ид үедээ явж байгаа бөгөөд 40 сая тонн зэс, 46 сая унци алт агуулж байгаа гэх урьдчилсан тооцоо нь үнэхээр мэл гайхуулна.

Дараагийнх нь дэлхийн хамгийн том нүүрсний уурхай болох магадлалтай Тавантолгойн орд бөгөөд эдүгээ түүний гэрээг үзэглэхээр өрсөлдөж буй зургаан компани сонгон шалгаруулалтад хэн нь ялснаа сонсохыг тэсэн ядан хүлээж байгаа юм. Хоёр аварга “усны үхэр” хоёул говийн өмнөд хэсэгт буюу ашигт малтмалаар үргэлж өлсөж, цангаж байдаг “ёроолгүй” Хятадын хилтэй ойролцоо байрлах аж. Энэ хэсэгт цөөн тооны малчин байх агаад нүүрсний уурхайг ашиглалтад оруулснаар 60 мянган хүнтэй хотхон босох төлөв бий.

“Монголчууд үргэлж л эндээ байсаар ирсэн шүү дээ” хэмээн Ганхуяг тэмдэглээд, “Бүхий л баялагтайгаа, бүхий л зүрх сэтгэлтэйгээ бид Баруунтай сайн холбоотой байхыг хүсэж байлаа. Гэвч аз болоход барууныхан биднийг хэтэрхий хожуу анзаарчээ. Хэрвээ бид Чехословак байсан бол тэд эхний таван жилийн дотор л Монголыг тоноод, эцсийн дүндээ бид ашиглуулаад л үлдэх байлаа. Бид манжийн дарлалд 200 жил, ЗХУ-ын удирдлага дор 70 жил, Барууны эс ойшоосон байдалд 20 жил амьдарлаа. Эргээд болоход энэ нь бидний хувьд өөрсдийгөө боловсруулах цаг хугацаа байжээ. Бид хувьчлалын



бүхий л эв дүйг олоод сурчихлаа” гэв.

Мөнөөх зэс, алтны аварга төслийн гэрээг хийхдээ Монголын Засгийн газар 34 хувийг нь эзэмшиж, нэг ч төгрөг гаргалгүйгээр татварын өмнөх 59 хувийн орлогыг нь хамахын тулд зургаан жил дуншжээ. Гэвч энэ замд зарим нэг цохилт учирсан байна. Гэнэтийн ашгийн гэх 68 хувийн татвар авч байсан боловч дараа нь цуцалсан. Түүнчлэн 2008 онд сүүлийн сонгууль болоход улстөрчид бэлэн мөнгө тараах амлалт өгсөн ба эдүгээ Засгийн газар зэс, алтны төслөөс урьдчилгаа болгож авсан мөнгөөрөө сар бүр баян, ядуу хэмээн ялгалгүйгээр иргэн бүртээ 17 ам.доллартай дүйцэхүйц мөнгө тарааж байгаа юм. Эдүгээ энэхүү эх үүсвэр нь хомсдолд орох төлөвтэй зэрэгцээ улс орны хувьд асар их хэрэгцээтэй дэд бүтцийн хөрөнгө оруулалтад зарцуулахгүйгээр мөнгийг бэлнээр тарааж, нийгмийн халамжаас хамааралтай улс болгож байна гэх шүүмжлэл нэлээд өргөн тархжээ.

Хэдий тийм боловч өнөөдөр долоон тэрбум ам.доллараар үнэлэгдэж буй



Монголын ДНБ ирэх арван жилд жилдээ л 20 хувиар өсөх хандлагатайг Ганхуяг онцолсон юм. “Бид эдийн засгаа 3-5 жил тутамд хоёр дахин өсгөнө. Бүр Олон улсын валютын сан хүртэл үүнийг хүлээн зөвшөөрч байгаа гээд бод. Үүнээс л үүдээд тансаг зэрэглэлийн дэлгүүрүүд биднээс аятайхан үнэр аваад ирж байгаа хэрэг” хэмээн тайлбарлав.

“Louis Vuitton” Монголын зах зээлд нэвтэрсэндээ үнэхээр сэтгэл хангалуун байгаа бөгөөд хэрэгцээ нь хязгааргүй байх ч албагүй ажээ. LV-ы CEO Ийв Карселле (Yves Carcelle) “How are you?” гэхийг монголоор “Сайн явж байна уу?” хэмээн асуудгийг мэдсэн нь тусгай тэмдэг мэт санагдсан биз. “Burberry”-гийн төлөөлөгч монгол хэрэглэгчид нь нэг мянгаас жаахан л давдаг дуртай байдгаа надад хэлсэн тухай би Карселлед дуулгахад тэрбээр хүлээн зөвшөөрч “1-2 мянган хүн гэдэг л чиний хувьд хангалттай шүү дээ. Чи дундаж орлогоор бүхнийг тооцоолж болохгүй, яагаад гэвэл дундаж орлого гэдэг бол бүх зүйл биш. Чамд тансаг бараа авчих чадалтай цөөн ч болов мянган хүн байна уу гэдэг л гол асуулт юм. Хамгийн гол нь улс төрийн тогтвортой байдал хийгээд дэлгүүрээ байх ёстой газар нь байрлуулчих орчин, нөхцөл юм” хэмээн тайлбарлалаа.

Миний ажигласнаар “Louis Vuitton”-ы үйлчлүүлэгчид нь ихэвчлэн 30-40 насны бүсгүйчүүд байх агаад аль хэдийнэ цүнхийг нь аваад үүрчихсэн, харин эрчүүд эндээс голдуу бэлэг сонгодог ажээ. LV-ы хүсэл мэдээж Хятад, Орост нэвтэрснээрээ дүрэлзсэн байх л даа. “20 жилийн дотор Хятад манай хамгийн том хэрэглэгч болж чадсан. Түүгээр ч зогсохгүй бидний бизнес дэлхий даяар өргөжин тэлж байна. Өнөөгийн мэдээллийн хэрэгслүүдийн ачаар тансаг бүтээгдэхүүн болон загвар гэдэг дэлхий нийтийн универсал хэл болоод байна шүү дээ” гэв. Монгол Улс ч гэсэн дэлхийн трендийг дагаж буй ажээ. “Монголчууд телевиз үзэж, шинэ загвар харж байна. Бид Оросын “Vogue” болон “Cosmo”-г дөнгөж шинээр нь авч байгаа” хэмээн Монголын загварлаг бүсгүй болох Б.Дэлгэрмаа яриу.

Монголчуудын хувьд эд баялгаа өөрийн бие дээр илэрхийлэх нь бүр уламжлал болсон хэрэг аж. Малчид жилдээ дөрвөн ч удаа нүүдэг тухай Монголын урлагийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Ц.Ариунаа ярьж эхлээд, “Чиний бүхий л баялаг чиний хувцаслалт хийгээд гоёл чимэглэл, морь болон эмээл болоод дагаад явна” хэмээн тайлбарлав. “Соёл талаас нь авч үзвэл монголчууд өөрийгөө гайхуулах дуртай гэх үү дээ. Манайхан ▶

► өөрсдөөрөө маш их бахархдаг, энд зөвхөн би ганцаараа байна гэж боддог. Тэд онцгой, тусгай байвал зохилтой хэмээн боддог” гэж Дэлгэрмаа нэмж хэлэв.

Өнөөгийн баян малчин сансрын таваг, гэрийнхээ дээвэр дээр байрлуулсан нарны толь, мотоциклоороо танигдана. Гэвч түүний гол “нөхөр” нь үргэлж л байгаль эх байж иржээ. Ариунаагийн хэлснээр бол монголчууд эхлээд газар дэлхий, морь, ээжийнхээ талаар дуулах бөгөөд энэ бүхний дараа л хайр дурлал, найз нөхдийнхөө талаар санах нь бий. “Монголчууд хоорондоо зохицохоосоо илүүтэй байгаль дэлхийтэйгээ зохицолддог. Чи тал хээр нутагт орших гэрт амьдарч байна гээд төсөөл л дөө. Чиний хөрш юу бодож байгаа нь хамаагүй” гэсэн юм.

ЗХУ-ын ивээл дор байсныхаа гавьяагаар монголчуудын 98 хувь нь бичиг үсэг тайлагдаж, боловсролтой болсон бөгөөд эдүгээ 151 их сургуулийнх нь оюутнуудын 70 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлнэ. Гэвч ЗХУ-аас үлдсэн муу зуршил гэвэл яах аргагүй архидалт. Энэ нь ялангуяа эрчүүдийн дунд нэлээд тархсан бөгөөд 25 хувь нь архинд орсон байх жишээтэй. Би Улаанбаатараас машинаар гурван цаг яваад хүрдэг Монголын хоёр дахь том хот болох Дарханы хүүхдийн асрамжийн газарт очиж үзэхэд 40 орчим хүүхэд эцэг эх нь архинд орсноос болж тэнд очсон байв. “Чи шил архийг аяга кофеноос хямдаар буюу ойролцоогоор 75 центээр худалдаж авч болно” хэмээн АНУ-ын Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Мелони Линдберг хэлсэн юм. Хэрвээ чи зүрхний шигдээс болоод гудамжинд ухаан алдчихсан хэвтэж байвал хэн ч чам руу дөхөж очихгүй, ууж байгаад тасраад уначихсан л гэж бодно хэмээн надад анхааруулж байсан л даа. “Монголчууд өмнө нь хэзээ ч цагаан архи шиг хатуу юм хэрэглэж байгаагүй” гэж Монголын сэхээтнүүдийн нэг болох Баабар яриад, “Ер нь бол монголчууд сархадаа сүүнээс гаргаж авдаг юм” хэмээн тайлбарлав.

Баабар бол Монголын хүндэтгэл хүлээсэн хүмүүсийн нэг. Түүхч, зохиолч, нийтлэлч, нийгмийн идэвхтэн болохын тулд биохимич мэргэжлээсээ татгалзсан тэрбээр “Britannica” нэвтэрхий толийг монгол хэлнээ орчуулах төслийн ахлагч байсан. Түүнчлэн өөрийн үзэн яддаг оросуудаас болж нэгэнтээ шоронд хүртэл хоригдож байсан Баабар Монголын Засгийн газар одоог хүртэл социалист чиг хандлагаасаа салж, хагацаж чадаагүй бөгөөд улсын патерналист төвлөрсөн төлөвлөгөөт Оросын загвар одоо ч ноёлж байгаа гэж



үздэг. “Системийг хөдөлгөж буй хүмүүс одоо хэр нь коммунист, эсвэл социалист сэтгэлгээтэй байна” гэж Баабар яриад, “ЗХУ таван жил тутамд бидэнд таван тэрбум ам.доллар өгдөг байлаа. Энэ нь Монголын үйлдвэржилт, хөдөө аж ахуй болон цэргийн хүчийг хангаж байсан ч эцсийн дүндээ бүрэн хараат болгож дөнгөсөн юм” гэлээ.

Монголын Засгийн газар иргэдэдээ бэлэн мөнгө тарааж буйд Баабар бухимдаж, үүнийг ЗХУ-аас боловсрол эзэмшигчдийн сэдсэн “эдийн засгийг нялхруулах” бодлого хэмээн нэрлэнэ. “Улс улам баян болж байгаа учраас Парламентын гишүүд сонгуулийн үеэр олон амлалт өгдөг. Тэгээд хүмүүс тэрхүү бэлэн мөнгө, үнэгийг боловсрол болон үнэгүй бүхнийг амлаж буй эцэг шиг тэр улстөрчийн амлалтад цадаж эхлэх нь байгалийн баялгийн зөвхөн муу тал нь болж хувирах вий” хэмээн Баабар тайлбарлана.

Энэ бүхнийг угжих саалийн үнээ хэмээн монголчуудын хүлээж буй “Оюутолгой” компанийн CEO, 52 настай улбар үст австрали эр Камерон МакРэй Улаанбаатар дахь албаны ерөөндөө суух агаад эхний алхам болгож “Ivanhoe” болон “Rio Tinto” долоон тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж буйгаа яриад, уурхайг ашиглалтад оруулахын тулд өдөртөө л долоон сая ам.доллар зарцуулж байгаагаа учирлав. Түүний компьютер барилгын ажлыг харуулах олон тооны хөдөлгөөнт загварыг багтаах бөгөөд үлэмж төслийн далайцыг харуулахын тулд ч тэр үү, дэндүү жижигхэн Эйфелийн цамхагийг ашиглажээ. “Бид монголчуудын өмнө нь хэзээ ч барьж авч байгаагүй томоохон бүтээн байгуулалтыг хийж байна” хэмээн МакРэй онцлоод, “Гэхдээ бид инженер, техникийн ажилчид, барилгын

ажлын өндөр туршлагатай хүмүүсийн дутагдалд ороод байгаа” хэмээв. Барилгын ажлын ид үед 17 мянган хүн хэрэгтэй бөгөөд уурхай ашиглалтад ороод жилдээ л 50-55 сая тонн хүдэр боловсруулах юм байна.

Монголын Засгийн газар эдүгээ энэхүү төслөөс татвар болон хураамж зэргээр хагас тэрбум ам.доллар авсан гэнэ. Гэхдээ л монгол ажилчид бэлтгэгдээгүйн улмаас эндхийн хоёр гол ажилчны нэг нь хятад хүн байх агаад уурхай Хятадын хилээс ердөө 28 милийн зайд орших тул хэрэгцээтэй зүйлүүдийг нь ачсан 80 ачааны машин Хятадаас Оюу толгой руу өдөр бүр хөвөрнө. “Бид Монголын Засгийн газарт 5000 монгол хүнийг сургана гэж амласан” гэж МакРэй хэлээд, уурхай ашиглалтад орох үед нийт ажилчдын 90-ээс доошгүй хувь нь монголчууд байх ёстойг тайлбарласан юм.

Өмнийн говьд алслагдсан уурхайн энэхүү байршил нисэх буудлын талаар дуугүй өнгөрдөг юм аа гэхэд асар их хэмжээний эрчим хүч, ус хэрэглэж таарна. “Бид говьд эрчим хүч хүргэх, сайн чанарын авто зам тавихад анхаарна. Мөн Хятад руу эрчим хүч дамжуулах шугам татаж, тэндхийн системд нэгдэнэ” хэмээн МакРэй учирлав. Харин усны хувьд хайгуул явуулсан бөгөөд хаана ч холбогдоогүй усны томоохон эртний судал илрүүлсэн ажээ. Таван жилийн дараа Оюутолгой хаана байх вэ гэж намайг асуухад МакРэй “Бид дэлхийн хоёр дахь том зэсийн уурхай болсон байх бөгөөд хамгийн бага туршлагатай ажиллах хүчин, тэднийг дадлагажуулах хамгийн далайцтай хөтөлбөртэй сууж байна” гэлээ.

Дэлхийн II дайнаас өмнө Монгол орон Япон болон ЗХУ-ын хоорондох ►



► “жийргэвч” улсын үүрэггүйцэтгэж байсан бол түүний дараа мөн үүргээ ЗХУ болон Хятадын хооронд биелүүлсэн түүхтэй. Бээжин Монголын өмнөд хилээс ердөө 340 милийн зайд орших ба Цагаан хэрмийг монголчуудаас л хамгаалахын тулд барьсан гэдэг дээ. Нэг үе 70 мянган орос цэрэг Монголд байсан. Энэхүү эртний хорсол дайсагнал арилахад хэцүү. Тухайлбал, Транс-Монголын төмөр зам нь Хятадын биш, гагцхүү Оросын царигийн хэмжээтэй нийцэх агаад үүнээс болж Монголоос Хятад руу гарч буй галт тэрэг болгон дугуй солих залхмаар үйл ажиллагааг даван туулах ёстой. “Үндэсний аюулгүй байдал” гэх нэрийн дор үнэндээ Монголын бизнес эрхлэгчид болон улстөрчдийн дунд Тавантолгойн нүүрсийг галт тэргээр Орост хүргэх үү, эсвэл ачааны машинаар Хятад руу зөөх үү гэсэн асар том мэтгэлцээн өрнөх аж. Орост хүргэхийн тулд мэдээж хэдэн зуун милийн урттай шинэ төмөр зам босгох шаардлагатай бол ачааны машинаар ердөө 150 мил яваад л Хятадын хилд оччих юм.

“Цэргийн хүчин хөндлөнгөөс ороод ирж магадгүй гэсэн болгоомжлолоос үүдээд төмөр замыг Үндэсний аюулгүй байдалтай холбож байна” хэмээн саяхныг хүртэл Дэлхийн банкны уул уурхайн ахлах мэргэжилтэн байсан Грэм Хэнкок тэмдэглээд, “Энэхүү хүйтэн дайны зовинол одоог хүртэл Монголыг тайван байлгахгүй нь. Монголчууд оросуудыг ах нар хэмээн хүндэлж, нөхдөө гэж бодож байхад нөгөөдүүл нь 70 жилийн турш өмнө зүгт нэг асар том шар шулам байгаа шүү хэмээн сургасаар ирсэн” гэлээ. “Монголчууд үндэсний аюулгүй байдалдаа хэт их анхаараад, эдийн засгийн өгөөжөө хойш тавиад байх шиг.

Монголын эдийн засгийн хувьд аль нь сайн бэ гэдгийг эхлээд бодохын оронд шийдвэр нь геополитикийн шалтгаанд үндэслээд явчихдаг” хэмээн Хэнкок тайлбарлав.

Монгол дахь өөрчлөлт хэтэрхий хурдан явагдаж байгааг тус улсын тэргүүлэх социологич Л.Сумати тайлбарлаад, хөдөлгөөн хэт их байгаа учраас хүмүүсийг нийгмийн давхаргад хуваах ямар ч боломжгүйг учирлав. Зургаан сая малын амийг авч одсон 2009-2010 оны аймшигт зуднаас болж малчид Улаанбаатарын гэр хорооллуудад олноороо орж ирж байгаа бөгөөд ихэнх ядуус тэнд бөөгнөрч байгаа нь байдлыг улам л хүндрүүлж буй ажээ. “Улаанбаатар ядуусын армийг оршин суулгаж байна. Сонгуультай нүүр тулах үед ямар ч намын өмнө эдгээр хүнтэй хэл амаа ололцоно гэдэг бэрх даваа болох төлөвтэй” хэмээн Сумати онцлоод, “Тэд хэтэрхий тогтворгүй бөгөөд зарим талаасаа бас ууртай байгаа. Яагаад гэвэл тэд баян, ядуугийн ялгаа улам гүнзгийрч байгааг мэдрэхийн зэрэгцээ ямар ч өөр зам байхгүйг харж байгаа юм” гэв. Тэгвэл яагаад чинээлэг хүмүүсийг ангилж болохгүй байгаа юм бэ хэмээн намайг асуухад, “Манайд эрх мэдэлд хүрэх асар баян хүний бүлэглэл байдаг” хэмээн Сумати хэлэхдээ бизнес эрхлэгчид төрийн эрхэнд гарах явдлыг өгүүлсэн болов уу. “Гэвч чинээлэг хүмүүсийн дунд ч хэлбэлзэл хэтэрхий их байгаа тул баячууд ч одоо нийгмийн нэг давхарга болж чадаагүй байна” хэмээн тайлбарлав. Монгол Улсад томоохон албан тушаалтнууд хөрөнгө, орлогоо мэдүүлэх тухай чанд хатуу хууль байдаг ч өдөр тутмын 22 сонин, телевизийн 21 сувагтай Улаанбаатарын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн

хувьд хэвлэлийн эрх чөлөө гэж үгүй. Энд арын хүн, бизнесийн эрх ашиг багширчээ. Эрхлэгчийг үргэлж л эзэмшигч нь хөдөлгөдөг бөгөөд бүр нийтлэл бичүүлэхийн тулд мөнгө төлдөг хувилбар ч өргөн тархсан тухай би сонссон.

Авлигын тухай бол ярихын ч хэрэггүй. Азийн сан Суматид мөнгө төлж, улирал бүр мянган гэр бүлээс сүүлийн гурван сард эмч, багш, зохион байгуулагч болон цагдаа нарт хэдий хэмжээний хахууль өгсөн тухай нь асуулга явуулдаг аж. 2010 оны гуравдугаар сард судалгаанд оролцсон нийт гэр бүлийн 16 хувь нь хахууль өгч байснаа хүлээн зөвшөөрсөн бол мөн оны есдүгээр сард 13 хувь болтлоо буурсан боловч хахуулийн хэмжээ нь хоёр дахин нэмэгдсэн байжээ. Өөрөөр хэлбэл, авлига гэдэг Монголын Засгийн газрын хувьд ажилгүйдэл, ядуурлын дараа гуравдугаарт жагсах том асуудал болтлоо ужирсан байна. Мэдээж энэхүү судалгаа том гарууд болон төрийн эрх мэдэлтнүүдийн ихэвчлэн бэлэн мөнгөөр авдаг томоохон хэмжээний нууц авлигыг харуулж чадахгүй. “Хятадууд цүнх дүүрэн бэлэн мөнгөтэй ирдэг” хэмээн банкир Ламберт (Lambert) онцлоод, “Хятад эр нэг шил архи барьж ирээд л долоон сая ам.доллараар үнэлэгдэх чиний уурхайг ядах юмгүй авчихаж мэднэ. Монголчууд хэдийгээр хятадуудад дургүй боловч энэ тал дээр тэднийг ихэд хүндэтгэдэг юм билээ” хэмээв.

Монголын коммунизмаас гарах шилжилтийн үе одоо хүртэл өөрийгөө мэдрүүлсээр л... Кирилл үсэгтэйн зэрэгцээ нийслэлийн нэлээд хэсэг нь хуучин Москваг санагдуулна. ЗХУ нуран унасан тухай санагалзахдаа өнөөг хүртэл эмзэглэдэг хэсэг ч бий. Нэгэн үе баруунтай холбоотой байсан Оросын аппаратчикуудтай тун ч төстэй хүмүүс ч байна. Тэдний нэг нь өнөөгийн улс төр, бизнесийн хүрээний хэл аманд багагүй өртдөг Х.Баттулга юм. Өмнө нь жүдогийн аварга байсан тэрбээр эдүгээ Bentley хөлөглөж, Монголын тал нутагт Чингис хааны аварга хөшөөг босгохын тулд халааснаасаа 10 сая ам.доллар зүгээр л гаргасан нэгэн. Баттулга бол зохион бүтээгч, яагаад гэвэл хөшөөний эргэн тойрныг амралтын хүрээлэн болгож чадсанаар барахгүй Монголын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын албыг хашиж, Парламентын хүчирхэг эрхэм болж чадсан хүн. Тэрбээр спортын зүтгэлтний хувьд гадаадаар явж байсан бөгөөд бизнесээ Хятадын электрон бараа зарахаас эхэлж, компьютерийн мэргэжлээр сургууль дүүргэсэн бол эдүгээ улсаа хангадаг томоохон мах боловсруулах ►

► үйлдвэрийн эзэн сууж буй. 2004 онд түүний өөрийн хэрэгцээ ханасан болохоор улстөрд хүч сорихоор шийдэж, Парламентын гишүүн болсноо тэрбээр надад тайлбарласан.

Баттулгын өнөөгийн гол хүсэл эрмэлзлэл гэвэл Дорноговьд, Оросын хилээс 300 мил, Хятадынхаас 125 мил, мөнөөх Тавантолгойгоос 200 милийн зайд орших монголчуудын “аж үйлдвэрийн хот” гэж нэрлээд буй 10 тэрбум ам.долларын өртөгтэй Сайншандын цогцолборыг барих явдал юм. Энэ нь төмөр зам болон автозамаар нийслэлтэй, зөвхөн төмөр замаар ОХУ-тай холбогдоно. Хятад руу автомашинаар хүдэр болон түүхий нүүрс хүргэхийн оронд Сайншандад тэдгээрийг боловсруулахын зэрэгцээ газрын тосоо ч нэрэх ажээ. Үүний үр дүнд монголчууд ашигт малтмалаа нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн болгож, урьдчилан тооцоолж буйгаар 30 хувиар илүү ашиг олохын зэрэгцээ хэдэн зуун мянган ажлын байр шинээр бий болгох аж. Гэхдээ юуны түрүүнд уг хотхоныг барих ажлыг “О”-ээс нь эхлэх хэрэгтэй. Дараа нь Тавантолгойн нүүрс уурхайгаасаа ачигдаад, Владивосток боомтод хүрээ ч үгүй байхдаа Оросын төмөр замд холбогдож, нийт 3000 мил аялах юм. XIX зуунд нэгэн мундаг лам яг энд агуу метрополис хөгжих болно хэмээн зөгнөж хэлсэн болохоор л Сайншандын төсөл толгойд нь орж ирсэн тухай Баттулга надад сонирхуулсан юм.

Улаанбаатар даяар Сайншандын талаар эргэлзээтэй зүйлсийг ярьж байхыг би сонссон. Хүмүүс Баттулгыг оросуудтай ихэд дотно харилцаатай гэж хүртэл шивэр авир хийдэг юм билээ. “Төмөр замыг л атгаж чадах юм

бол манай ашигт малтмалын баялгийг атгаж чадна гэсэн гэнэн бодолдоо оросууд итгэж байгаа” хэмээн өөрийн ахтай хамт хятадуудтай бизнес хийдэг, Монголын томоохон бизнесмэн болоод татвар төлөгчдийн тоонд багтах Ж.Од яриу. Тэрбээр Сайншандын тухай бүхнийг үгүйсгэх агаад Оросуудын геополитикийн тоглолт болохыг онцолж, “Энэ нь өнөөдөр Монголд хэрэгжиж чадахгүй, хэтэрхий хожимдсон хэрэг” гэлээ. Харин Баттулга “Монголчуудын хувьд түүхий эдээ Хятадад өгөх нь ашиггүй. Энэ бол геополитик биш, энэ бол бизнес. Бид ашигт малтмалаа дэлхийн зах зээлд гаргахыг л хүсэж байгаа” хэмээн сөрж зогсох аж.

Монголын Засгийн газрын эмзэгхэн нэгдэл ирэх сонгуулиар дахин гарч ирэхийн тулд бүх талаасаа бүслэгдсэн мэт сэтгэгдэл төрүүлнэ. Инфляциас сэргийлж, баялгаа зөв хуваарилахын тулд Парламент нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль баталсан бөгөөд уул уурхайн, тэр дундаа 10 хувийг нь иргэдэдээ олгосон Тавантолгойн орлогоо ч тогтворжуулалтын санд хуримтлуулах учиртай. Тавантолгойн IPO-г Хонконг, Лондонд хийхээр Засгийн газар нь төлөвлөж буй. Үүний зэрэгцээ монголчууд Хөгжлийн банк гэгчийг ч байгуулж амжсан. Дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ байнга хэлбэлзэж байдаг тул тооцоо хийж, урт хугацааны өсөлтөө тогтворжуулж чадахгүйгээ тэд мэдэж байгаа. Гадаад хэргийн сайд Г.Занданшатартай ярилцах үед тэрбээр улс орны хувьд яаралтай хэрэгтэй байгаа дэд бүтэц, тэр дундаа автозам болон төмөр зам, эрчим хүч, хот байгуулалт, жижиг, дунд үйлдвэрлэл болон хүнсний үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтын асар их боломж байгааг тэмдэглэсэн юм.

Гэвч бодит амьдрал дээр бүх зүйл хамаагүй хэцүү байх ажээ. Тухайлбал, дэлхийн хамгийн чанартай ноолууртай энэ орны үйлдвэрлэгчид нь хаалгаа барьж мэдэхээр байгаагаар учирлана. Засгийн газар нь түүхий ноолуурын экспортод татвар ногдуулдаггүй учраас хятадууд монголчуудын гар дээрээс хамаг ноолуурыг нь өндөр үнээр цохиж авч байх зуур үндэсний үйлдвэрлэгчид нь татварт дарамтлуулж гүйцдэг ажээ. “Гоёо” компанийн Худалдааны захирал Д.Эрдэнэ-Очирын хэлж буйгаар төр, засаг нь малчдын төлөө тэднийг золиосолдог аж. “Ноолуур хилээр гаргахад ямар ч татвар, хураамж байдаггүй болохоор хятадууд зах зээлийг атгаж байна. Тэд Засгийн газарт мөнгө төлөх ёстой боловч улстөрчид юу ч авах бодолгүй байгаа. Гэтэл үндэсний компаниуд орлогын албан татвар, НӨАТ зэрэг татвар төлөх ёстой... Хэрвээ

Монголын парламентад сонгогдохыг хүсвэл малчдыг биш, үйлдвэрлэгчдийг хуурч байж гарч ирнэ” хэмээн тэрбээр тайлбарлаад, хятадуудыг ноолуураа ноос, торго, хөвөн зэрэгтэй хольдог тухай шүүмжлэв. “Тэд бүгдийг нь хольчихоод ямар ч хамаагүй нэр өгчихдөг. Бид удахгүй мөхлөө” гэв.

Мэдээж Монгол орон олон улсын хөрөнгө оруулалтын тойргийн нэгэн цагаахан, халуухан цэг болсон нь эргэлзээгүй. Нэгэн орой би GE-ийн бизнесээ 130 дахь оронд буюу Монголд нээж буй хүндэтгэлийн хүлээн авалтад оролцсон юм. Эднийх худалдаагаа шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангалттай тоноглогдоогүй хэрнээ ачаалал ихтэй Монголын эмнэлгүүдэд MRI машин нийлүүлэхээс эхлэх юм. Харин “Caterpillar” энд аль хэдийнэ 100 сая ам.долларын бизнес эргэлдүүлж байгаа. “Монгол бол яг л бялуу хийж байгаатай ижил” хэмээн тус компанийн бизнес зөвлөх Жэксон Кох (Jackson Cox) тэмдэглээд, “Бүх орц нь ширээн дээр байгаа. Орчин үеийн цэцэглэх эдийн засгийг бүтээхэд хэрэгтэй бүх зүйл энд байна. Ганцхан дутаж байгаа юм нь улс төрийн хүчтэй, алсыг харсан шийдвэр гаргаж чадах удирдлага. Эхлээд 25 жилийн дараа Монгол орон ямар байхыг хүсэж байна вэ гэдгээ урьдчилан хараад, боловсрол, дэд бүтэц болон эрүүл мэндийн салбараа тийш нь чиглүүлэн төлөвлөх хэрэгтэй” гэсэн юм.

Монгол орны газар нутгийн зөвхөн 25 хувьд л геологийн хайгуул хийсэн боловч байгаль хамгаалагчид ой, усаа устаж үгүй болох аюултай хэмээн зүй ёсоор айж, эмээж байгаа боловч миний уулзсан хүмүүсийн ихэнх нь ямар нэгэн байдлаар эцэстээ хожиж чадна хэмээн үзэж байх шиг. Грэм Хэнкокийн хэлснээр бол эндхийн иргэдийн төлөөлөгчид маш их идэвхтэй. Компаниуд удаан хугацаанд замбараагүй байдал үүсгэхээс явж чадахгүй аж.

Байгалийн баялгаа ёроолд нь тулгасныхаа дараа Монгол орон яах вэ? гэдэг л гол асуулт юм. “20 жилийн дараа эдгээр нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг нөхөн сэргээгдэх баялаг буюу мэдлэг боловсрол болж хувирахгүй юм бол бид моментийг алдлаа гэсэн үг” хэмээн нийтлэлч Д.Жаргалсайхан яриад, “Газар дор агуулагдаж буй энэхүү баялаг газар дээр гарч ирэхдээ бидний хүсэл, эрмэлзлэлийг хангах учиртай юм” гэлээ.

“Бодлогогүй мөнгө бол сайн гэхээсээ илүү хор хөнөөлтэй” гэж Ж.Од онцлоод, Монгол орон жинхэнэ утгаараа ямар баян гэдгийг илэрхийлэх үүднээс “Бид мөсөн уулын зөвхөн оройн хэсэгт нь байна” хэмээн итгэдгээ ярьсан юм. ■



Үл хөдлөх хөрөнгө

Хоёр байгууллага-нэг систем

Монгол Улс дахь газрын мэдээллийн удирдлага болон эд хөрөнгийн эрхийн бүртгэл

БломИнфо А/С ММСС-гийн төсөл
Улаанбаатар, Монгол Улс

1. Үндэслэл

Монгол Улсын газрын харилцааны байгууллага (ГХБГЗЗГ) нь хамтрагч нөгөө тал болох үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн асуудлыг хариуцсан байгууллагаас (УБЕГ) хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулж буй юм. ГХБГЗЗГ-ын үндсэн үүрэг нь газар хувьчлалын үйл явцыг эрхлэн явуулах бол УБЕГ нь газар болон бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх болон бусад эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Тухайн байгууллагуудын харилцааны нөхцөл байдал болон Монгол Улсад тус хоёр байгууллага үйл ажиллагаа эрхлэн явуулах шалтгаан зэрэг нь энэ нийтлэлийн цар хүрэнээс хальсан хэрэг буй за. Гэхдээ үйл ажиллагааг хуваан хэрэгжүүлэх энэ бүтэц нь орчин үеийн газар зохион байгуулалтын тогтолцоот олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүн орнуудад тийм ч түгээмэл бус юм. Хэрэглэгчийн үйлчилгээг тэргүүн эгнээнд тавьж, компьютер өргөн хэрэглэж, томоохон мэдээллийн сан байгуулах боломж бүрэн бий болсон өнөө үед дээрх хоёр байгууллагын гүйцэтгэж буй үүргийг нэгэн дээвэр дор нэгтгэх эсвэл хослуулах байдлаар ажиллуулах байдал өргөн дэлгэрч байна. Үүний хүрээнд энгийн иргэд, бизнес эрхлэгчдэд газрын харилцааны асуудлаар нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, интернетийн технологи ашиглах зэргээр бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь түгээмэл болжээ. Иргэд газар хувьчлан авах, эдийн засгийн эргэлтэд оруулах нь ихэссэнээр ГХБГЗЗГ болон УБЕГ нь олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хамтын ажиллагаагаа сайжруулах үйл ажиллагааг явуулж байна. Хэдий ийм хүчин чармайлт нэлээд хэдэн жилийн өмнөөс үргэлжлэн явагдаж буй ч сүүлийн үед хийгдээд буй нэгэн шинэтгэл нь байгууллага хооронд мэдээлэл солилцох журмыг боловсруулан гаргаж буй явдал юм. Үүний үр дүнд газрын удирдлагын асуудлаар хэрэглэгчдэд шууд суурилсан үйлчилгээг хүргэж, боломжийг нээж байгаа билээ.

Энэ нийтлэлээр Монгол Улс дахь газар өмчлөл, үл хөдлөх хөрөнгийн асуудлыг хариуцан ажилладаг тус хоёр байгууллагын хооронд харилцан мэдээлэл солилцохын давуу талуудын талаар товч өгүүлэх юм. Нийтлэлийн зорилго нь энэхүү үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын иргэд, бизнес эрхлэгчид, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч нар ч ямар үр дүнг хүртэх талаар олон нийтэд мэдээлэл олгох явдал билээ.

2. Газар хувьчлал- Өнөөгийн тогтолцоо– хоёр гол үе шат

Монгол Улс нь 2003 онд иргэдэд газар хувьчлах түүхэн шийдвэрийг гаргасан билээ. Иргэд газар өмчлөх эрх бүхий тогтолцоог бий болгосноор өмчийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөний тоо ихээр нэмэгджээ. Ерөнхийдөө өнөөгийн хэрэглэж буй бүртгэлийн үйл ажиллагаа хоёр үе шаттай явагдаж байна. Үүний эхний үе шат нь газар хувьчлалтай холбоотой анхан шатны бүртгэлийг ГХБГЗЗГ дээр хийдэг бол, хоёрдугаар үе шат болох хувьчилж авсан газрыг өмчлөх эрхийг УБЕГ дээр олгож буй билээ. Доорх хэсэг дээр цаашид шинэтгэл хийхэд шаардлагатай үндэслэлийг ил тод болгохын тулд дээр дурдсан хоёр үе шат бүхий үйл явцын талаар товч дурдлаа.

2.1 ГХБГЗЗГ – Бүртгэлийн эхний үе шат

Иргэд газар хувьчлан авахыг хүссэн өргөдлөө хамаарах дүүргийн Засаг даргад хандан гаргаснаар газар хувьчлан авах үйл явц нь аймаг болон дүүргийн түвшинд эхэлдэг. Иргэдээс гаргасан өргөдлийг зохих шатны Засаг дарга дэмжин захирамж гаргаснаар Монгол Улсын иргэн газар өмчлөх эрхтэй болох юм. Засаг даргын гаргасан захирамжаар газар хувьчлахтай холбоотой эрх үүсэн улмаар тухайн газрыг ГХБГЗЗГ-т бүртгүүлэх боломжтой болох юм. Гэхдээ газар өмчлөх эрх болон өмчийн эрх нь харилцан ялгаатай эрхүүд юм.

Орон нутгийн Засаг дарга иргэдээс гарсан өргөдлийн дагуу шийдвэр гаргахад эхний эрх үүсдэг бол, шинээр газар өмчилж авсан иргэний гаргасан өргөдөлд үндэслэн УБЕГ үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхийг олгох хүртэл сүүлийн дурдсан эрх үүсээгүй л байна. Гэхдээ УБЕГ нь эд хөрөнгө эзэмших эрхийн гэрчилгээг олгохоос өмнө иргэд хувьчлан авсан газраа өмчлөх эрхийг ГХБГЗЗГ-т бүртгүүлэх шаардлагатай байдаг. Орон нутгийн Засаг дарга өмчлөх эрхийг баталгаажуулсаныг ГХБГЗЗГ-т бүртгүүлэхээр өргөдөл гаргаснаар үйл явц эхэлдэг. Иргэдийн гаргасан өргөдлийг ГХБГЗЗГ дээр гурав хүртэл сарын хугацаанд шалган бүртгэдэг бөгөөд үүний дараагаас л иргэн газар өмчлөх эрхээ УБЕГ-т бүртгүүлэн эрхийн гэрчилгээ авч болно.

2.2 УБЕГ – Бүртгэлийн хоёрдугаар үе шат

Эд хөрөнгийн шинээр үүсэж буй эрхийг бүртгүүлэхэд тухайн этгээд нь ГХБГЗЗГ-т бүртгүүлсэн талаарх баримтыг кадастрын бусад мэдээллийн хамтаар өгөх ёстой. Баримт бичгүүдийн тоонд кадастрын зураг болон ГХБГЗЗГ-т бүртгүүлсэн талаарх батлах баримт багтана.

Одоогоор энэхүү мэдээллийг УБЕГ-т дамжуулах нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхээр өргөдөл гаргагчийн өөрийн хариуцах асуудалд байгаа билээ. Тухайн этгээд нь ГХБГЗЗГ-аас баримт бичгүүдээ авч, улмаар өөрийн бөглөсөн өргөдлийн маягтын хамтаар УБЕГ-т хүргэж өгөх ёстой юм. ГХБГЗЗГ дээрээс баримт бичгүүдээ авахад иргэд бүх баримтуудаа хуулбарлан авах ёстой бөгөөд эх баримт нь тус газрын архивт хадгалагдана. Тусгайлан заасан банкинд бүртгэлийн төлбөрийг тушаасны дараагаар өргөдөл гаргагч нь УБЕГ дээр биечлэн ирж улсын бүртгэгчид баримт бичгээ өгнө. УБЕГ дээрх үйл явц харьцангуй хурдан явагддаг, ямар нэгэн асуудалгүй бол эд хөрөнгө эзэмших эрхийн гэрчилгээг 1-2 долоо хоногийн хугацаанд гарган өгдөг байна. Хэрэв өргөдөл гаргагчийн өгсөн баримт бичигт ямар нэгэн асуудал байвал өргөдөл гаргагч ГХБГЗЗГ руу эргэн очиж бичиг баримтын зөрчлөө арилгуулсаны дараа УБЕГ дээр эргэн ирэх шаардлага гардаг ажээ.

2.3 Өнөөгийн үйл явцад тулгарч буй асуудлууд

Дээр дурдсанчлан ГХБГЗЗГ болон УБЕГ-ын хоорондын харилцаа холбоо сул, мэдээлэл солилцох байдал хязгаарлагдмал байгаагаас үүдэн иргэд УБЕГ-т бүртгүүлэхийн тулд олон шат дамжлага давах шаардлагатай болдог ажээ. Үүнээс үүдэн гурван сөрөг үр дагавар үүсэж буйг доор харууллаа.

2.3.1 Цаг, зардал ихээр зарцуулах

Хамгийн анхны асуудал нь бүртгэл хийлгэхийн тулд иргэдэд тулгарч буй хүндрэл болох цаг хугацаа, зардлын асуудал билээ. Ихэнх зардлыг иргэд үүрч байгаа ч ГХБГЗЗГ болон УБЕГ нь мөн л нэмэлт ажил гүйцэтгэх шаардлагатай болж буй юм. Иргэд хамгийн багадаа хоёр удаа, ихэнхдээ гурван удаа бүртгэлийн асуудлаар тухайн байгууллагуудаар очих шаардлага гарч байна. Байгууллага хоорондын зай хол байх тохиолдолд иргэдийн халааснаас гарах зардал улам нэмэгдэх нь гарцаагүй. ГХБГЗЗГ нь шинээр эзэмших газрын эрхийг нотлохын тулд зураг гаргах болон бусад баримт бичгүүдийг олгох шаардлагатай бол УБЕГ нь эдгээрийн хуулбарыг архивлах шаардлагатай байдаг ажээ. Энэ бүхнээс үүдээд бүртгэл бүрт илүү цаг зарцуулж, илүү зардал гаргадаг байна. ▶▶

2.3.2 Алдаа гарах, хууран мэхлэх эрсдэл

Автомтажуулах боломжтой үйл ажиллагааг хүний оролцоотой гүйцэтгэснээр ямар нэгэн байдлаар хууран мэхлэх явдал газар авдаг болохыг хэн бүхэн мэднэ. Гар дамжин явж буй цаасан баримтууд элэгдэх, урагдах тэр ч байтугай хууран мэхлэх зорилгоор засвар хийх ч боломжтой.

Тиймээс цаасан хувилбараар буй мэдээллийг одоо УБЕГ-ын системд (REAL) оруулахын тулд улсын бүртгэгч гараар гүйцэтгэх шаардлагатай болж байна. Энэ шатанд өгөгдөл оруулахад алдаа гарах магадлал ихтэй бөгөөд үүнээс үүдэн гарсан хохирлыг УБЕГ хариуцах шаардлагатай болно.

2.3.3 Давхцал болон үр ашиггүй байдал

Гуравдугаарт ГХБГЗЗГ болон УБЕГ нь өөрсдийн ур чадвартай ажиллагсадын ихэнхийг УБЕГ-т хүргүүлсэн баримтуудыг шалгах зэрэг үйл ажиллагаанд ашиглаж байна. ГХБГЗЗГ дээр эх баримтуудыг үүсгэх, үүнийг УБЕГ дээр бүртгэх, хадгалахын тулд бүртгэгч нарын зүгээс ихээхэн хүчин чармайлт шаарддаг. Улмаар хувьчилж буй газрын хэмжээ нэмэгдэх, эдийн засгийн эргэлтэд орох тусам ГХБГЗЗГ болон УБЕГ-ын хооронд “аялах” баримт бичгүүдийн тоо нэмэгдэж, бүртгэх, дахин хуулбарлах зэрэг үйл ажиллагаанд илүү их хүний нөөц шаардлагатай болох нь ойлгомжтой. Энэхүү асуудал, эрсдэл нь тухайн байгууллагууд илүү үр дүнтэй, хэрэглэгчдэд суурилсан байгууллага болох эрмэлзлэлд саад болсоор буй билээ.

3.Цаашдын шинэчлэгдсэн үйл ажиллагаа

Өнөөгийн үйл ажиллагаанаас хамаараад Монгол Улсын иргэдэд тулгарч буй хүндрэлүүдийг ойлгон ГХБГЗЗГ болон УБЕГ нь хувьчлан авсан газрын бүртгэлтэй хамаарах хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хамтарсан хүчин чармайлт гаргаж байна. Энэхүү шинэтгэлийн үр дүн нь тухайн байгууллагуудад өөрсдийн мэдээллийг цахим хэлбэрээр солилцох боломжийг олгох юм. Үүний хүрээнд байгууллагууд шинээр журам гаргаж хэрэгжүүлснээр иргэд цаасан мэдээллийг хоёр байгууллагын хооронд “зөөж гүйх” шаардлага үгүй болох аж. Бүрэн хэрэгжсэн тохиолдолд энэхүү шинэ үйл явц нь бүртгэлийн үйл ажиллагааны чанарыг сайжруулж, тухайн байгууллагуудын үйл ажиллагаанд ч дэвшил гаргах юм.

Санал болгож буй шинэтгэл нь хоёр үе шат бүхий хандлагаар явагдана. Хоёр байгууллага өөрийн мэдээллийн технологийн системийг сайжруулах чиглэлээр ажиллаж буй тул ГХБГЗЗГ-аас УБЕГ-т цахим хэлбэрээр мэдээлэл дамжуулах нь хамгийн тэргүүн зорилго юм. Гэхдээ МТ-ийн шинэтгэл нь ойрын үед бүрэн хэрэгжиж дуусах боломжгүй, нөгөө талаар иргэдэд учирч буй хүндрэлүүдийг бууруулах зайлшгүй шаардлага байгаагаас үүдэн иргэд бус харин ГХБГЗЗГ нь иргэдийн газар өмчлөлтэй холбоотой мэдээллийг УБЕГ-т цахим хэлбэрээр дамжуулж байх шинэтгэлийг анхан шатандаа хийхээр төлөвлөөд байна.

3.1 Эхний үе шатны үр дүнгүүд


Шинэтгэлийн эхний үе шатны үр дүн нь юуны өмнө Монгол Улсын иргэдэд шууд хамааралтай юм. ГХБГЗЗГ болон УБЕГ нь хоорондоо мэдээлэл дамжуулах, хүлээн авах үүргийг хүлээх бөгөөд иргэдийн хувьд ГХБГЗЗГ дээрээс баримт бичгүүдээ авч, биечлэн УБЕГ-т хүргэж өгөх шаардлагагүй болох юм. Гэхдээ тухайн байгууллагууд нь ч энэхүү үе шатны үр дүнг хүртэх юм. Учир нь мэдээллийг илүү зохион байгуулалттай, найдвартай арга замаар дамжуулснаар гарч буй алдааны тоо багасаж, мэдээлэл дутуу байх, орхигдох явдлаас үүдэн гарах асуудал буурах болно. Эцэст нь дундын зуучлагч нарын оролцоог халснаар иргэд хууран мэхлэгдэх явдал үгүй болох билээ.

3.2 Хоёрдугаар үе шатны үр дүнгүүд

Дээр дурдсанчлан, ирээдүйд ГХБГЗЗГ болон УБЕГ-ын хоорондын мэдээлэл багц байдлаар цахим хэлбэрээр дамжиж байх болно. Үүнээс гарах үр шимийг үндсэндээ эдгээр байгууллагууд

хүртэх юм. Кадастрын зураг, эрхийн гэрчилгээ болон бусад баримт бичгүүд нь цахим хэлбэрт орсноор мэдээллийг бодит цагаар солилцож, баримт бичиг болгоныг олшруулах шаардлага үгүй болох ажээ. Мэдээлэл дамжуулах эсвэл мэдээллийн сандаа харилцан нэвтэрснээр хоёр байгууллага мэдээллийг шууд хүлээн авах боломжтой болно. Цахим бус байдлаар хийгдсэний улмаас үүдэн гарах алдаа үгүй болж хоёр байгууллага дээр байгаа баримт бичгүүд яг ижил болох юм. Эцэст нь үйл ажиллагааг автоматжуулснаар хоёр байгууллагын бүртгэгч нар мэдээлэл дамжуулах зэрэг ажлаас чөлөөлөгдөх болно.

Монгол Улсын иргэд ч гэсэн энэхүү хоёр дахь шатны үр дүнг хүртэх юм. Юуны өмнө зарцуулж буй зардал болон цаг хугацааг ихээр бууруулах ба хоёрдугаарт тэдний зүгээс гарч болох алдаа, зөрчил байхгүй болж цаашдаа бүртгэлд хамрагдахад хялбар, хямд, хурдан болох юм.



MCC-гийн төслийн тайлангаас авсан зураг

4. Дүгнэлт

Газар хувьчлал болон эрхийн бүртгэлийн чиглэлээр харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилгоор ГХБГЗЗГ болон УБЕГ-ын гаргаж буй энэхүү шинэ санаачилга нь талархууштай алхам билээ. Хоёр байгууллагын хоорондын мэдээлэл солилцох байдлыг сайжруулах чиглэлээр хоёр үе шат бүхий үйл ажиллагааны хүрээнд хэрэгжих энэхүү шинэтгэл нь Монгол Улсын цаашдын газрын удирдлага болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ирээдүйг улам сайжруулах билээ. Эхний үе шат нь хувьчлан авсан газрын эд хөрөнгийн эрхийг бүртгэх үйл ажиллагаанд баримт бичгүүдийг биечлэн дамжуулах явцад өөрчлөлт хийх замаар явагдах юм. Энэ нь иргэдэд тулгарч буй хүндрэлийг бууруулах, ГХБГЗЗГ болон УБЕГ-ын хамтын ажиллагааг сайжруулах боломжийг хангана. Хоёрдугаар үе шат нь тус хоёр байгууллагын харилцан мэдээлэл солилцох үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэн ГХБГЗЗГ болон УБЕГ-ын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах билээ.

Цаашид цахим систем үйл ажиллагаагаа эхлэн хоёр байгууллагын хамтын ажиллагаа сайжрах үед Монголын иргэд илүү сайн үйлчилгээ хүлээн авах, шинээр авсан газрын эрхийг бүртгүүлэхэд харьцангуй бага ачаалалтайгаар гүйцэтгэх боломжтой болно. Мөн төрийн байгууллагууд ч энэхүү жишээг даган өөрийн үйл ажиллагааг сайжруулах нь дамжиггүй. Эцэст нь Монгол улсын эдийн засагт ч мөн өөрийн эерэг нөлөөг үзүүлэн, найдвартай, үр дүнтэй эд хөрөнгийн эрхийг үүсгэн бий болгох юм. ■



1989 онд "Durst Organization" компани Нью-Йоркийн төвд АНУ-ын үндэсний өрийг тооцоолох машин суурилуулсан байна. Гэтэл 2008 онд уг машин 12-оос илүү оронтой тоо багтааж чадаагүйгээсээ болж гацаад, хэсэг хугацаанд ажиллаагүй юм. Америк улсын өрийн хэмжээ гэрлийн хурдаар нэмэгдэж байгааг инээдтэй гэмээр энэхүү явдал харуулжээ.

Зээлжих зэрэглэл

Америкийн "А" ямар үнэтэй вэ?

2011.08.05. Баасан гариг. АНУ "дэлхийн хамгийн найдвартай зээлдэгч" гэх тодотгоолоо алдав. "Standard & Poor's" агентлаг тус улсын зээлжих зэрэглэлийг хамгийн өндөр буюу "AAA" байсныг "AA" болгож бууруулснаараа америкчууд өрөө дарах тал дээр асуудал гарч мэднэ шүү гэх анхааруулгыг олон улсад өгсөн юм.

2011.08.08. "Хар даваа гариг". Америкийн голлох үзүүлэлтүүд 5.5-6.9, Азийнх долоон хувиар уруудсан нь 2008 онд хямрал эхэлснээс хойш тохиогоогүй уналт болохыг "Bloomberg" онцлов. 10 хүрэхгүй хоногийн дотор S&P 500 индекст багтдаг хувьцааны нийт үнэлгээ гурван их наяд ам.доллараар танагдсан тухай <http://www.gazeta.ru> цахим хуудсанд мэдээлжээ. Мягмар гаригийн өглөө уналтын давалгааг Азийн биржүүд үргэлжлүүлсэн бол Европын голлох индексүүд 3-5 хувиар доошиллоо. Ийнхүү "Standard & Poor's" агентлагийн шийдвэр олон улсын хөрөнгийн зах зээлийг сайн гэгч сэгсрээд авсны дараа санхүү, эдийн засгийн хямрал дахиад нүүрлэнэ гэх айдас дэлхийг нөмрөв.

Америкийн зэрэглэл буурсан нь

ямар үр дагавартай вэ? Бараг бүх улс орон гадаад валютын нөөцийнхөө дийлэнх хэсгийг ам.доллар, Америкийн Засгийн газрын бонд хэлбэрээр хадгалдаг, олон улсын гадаад гүйлгэний 85 хувийг ам.доллар эзэлдэг учраас энэ нь дэлхий нийтийн асуудал мөн. Түүнчлэн хөрөнгө оруулагчид, тэр дотроо тэтгэврийн болон бусад томоохон сангууд Америкийн Засгийн газрын өрийн бичгийг ихээр авсан байдаг болохоор сандрах нь гарцаагүй. Санхүүгийн элитүүд гэнэт америк долларт эргэлзэж эхэлбэл дэлхий тэр аяараа цохилтод орж, "Lehman Brothers" банк дампуурснаас ч аймшигтай үр дагаварт хүрнэ гэж цөөнгүй эдийн засагч үзэж буй.

Гэхдээ №1 эдийн засгийн зээлжих зэрэглэл буурч магадгүй гэсэн яриа аль эртнээс цухалзаж эхэлснийг сануулах нь зүйтэй болов уу. 14.6 их наяд ам.доллараар үнэлэгдэх ДНБ-тэй орны өрийн хэмжээ түүнтэйгээ дүйцэж эхэлснээс тэр л дээ. Олон жилийн турш төсвийн алдагдлаа зээл авах буюу Засгийн газрын бонд арилжаалах замаар барагдуулж ирсэн АНУ-ын төсөв Дэлхийн II дайнаас хойш хэдхэн л удаа, тодруулбал 1970 онд, мөн 1998-2001 оны хооронд л

ашигтай гарч үзсэн юм. Америкчууд төсвийн зарлагаа тэлж, өрийн бичгээ улам ихээр гаргахын хэрээр "AAA+" зэрэглэлтэй энэхүү үнэт цаасны эрэлт ч гэрлийн хурдаар нэмэгдэж байв. Ялангуяа 2008 оны санхүү, эдийн засгийн хямралын үед АНУ-ын Засгийн газар уналтад орсон эдийн засгаа татаж гаргахын тулд төсвийн зарлагаа үлэмж ихээр нэмэгдүүлсэн билээ.


"Standard & Poor's"-ийн хувьд зээлжих зэрэглэл тогтоогч "Fitch" болон "Moody's" агентлагаас урьтаж буюу өнгөрсөн дөрөвдүгээр сард Америкийн зээлжих зэрэглэлийн таамаглалыг эергээс сөрөг болгон бууруулсан. Энэ нь удахгүй нэг "А" үсгийг нь хасчихаж чадна гэх анхааруулга байлаа. Америкийн Засгийн газрын өрийн хэмжээ 14.28 их наяд ам.доллар хэмээн хуулиар тогтоосон дээд хязгаараасаа хэдийнэ хальсан байв. Энэ орны эрх баригчид наймдугаар сарын 2-ны дотор өрийн дээд хязгаараа нэмэгдүүлэх хуулийн төсөл батлахгүй бол албан ёсоор техникийн дампуурал зарлах ёстой болсон юм. Гэвч энэхүү бичиг баримт нь батлагдахгүй удаан сунжирснаас "Fitch" болон "Moody's" ч Америкийн зээлжих зэрэглэлийг эргэж харна шүү гэдгээ сануулсан. Уг нь америкчууд сүүлийн 70 жилийн хугацаанд бараг зуун удаа өрийн дээд хязгаараа шинэчлэн тогтоосноос үзэхэд энэ нь энгийн үзэгдэл болсон баймаар. Гэтэл энэ удаад сонгуулийн өмнөх жил таарсан болохоор улстөрчид шоу хийж ▶

байна хэмээн ажиглагчид дүгнэсэн нь бий. Тодруулбал, төсвийн алдагдлыг хэрхэн бууруулах тал дээр намуудын байр суурь зөрчилдөж байсан юм. Барак Обама болон Ардчилсан намынхан нийгмийн чинээлэг давхаргад нэмэлт татвар ногдуулах санал гаргасан бол Бүгд найрамдах намынхан нийгмийн зарим хангамжийг зогсоох хүсэлтэй байв. Ямартай ч эцсийн мөчид буюу наймдугаар сарын 1-нд хоёр нам тохиролцож, хуулийн төслөө баталж чадсан боловч энэ нь "Standard & Poor's" төлөвлөсөн шийдвэрээ гаргахад нөлөө үзүүлсэнгүй.

Алдарт хөрөнгө оруулагч Уоррен Баффет "Бидний зээлжих зэрэглэл AAA байх ёстой. Даанч манай Засгийн газрын үйл ажиллагаа энэ дүнг хүртэх гавьяагүй ажээ" хэмээн халагласан байна. "Вашингтон шууд бүсээ чангалж эхлэх нь байдлыг дордуулахаас цаашгүй. Тиймээс богино хугацаанд эдийн засгаа эрчимжүүлж, харин хэмнэлтийн бодлогоо дунд хугацаанд л эхлэх хэрэгтэй" хэмээн Америкийн нөлөө бүхий эдийн засагч Нуриэл Рубини "The Financial Times" дахь буландаа бичив. Хөрөнгийн зах зээлийн уналтыг сааруулахын тулд Холбооны нөөцийн системийн удирдлага бодлогын хүүгээ 0-0.25 хувьд дахиад хоёр жил барихаа амлалаа. Үр дүнд нь голлох индексүүд хэсэг хугацаанд сэргэж эхэлсэн ч эргээд л буурах төлөвтэй болоод ирэв.

"АНУ өмнөх шигээ лидерийн байр сууриа эзэлж чадах уу? Барак Обамагийн ямар үйлдэл хийхээс зөвхөн түүний улс төрийн ирээдүй төдийгүй улс орны ирээдүй хамаарна" хэмээн "The Washington Post"-ын тоймч Жозеф Дайон бичжээ. Үнэхээр энэ бүхэн дэлхийн санхүү, эдийн засгийн бүтцэд ямар нэгэн өөрчлөлт оруулах юм биш биз? Улс орнууд, хөрөнгө оруулагчид Америкийн Засгийн газрын өрийн бичигнээс зайгаа бариад эхэлбэл томоохон эргэлт гарах нь гарцаагүйг эдийн засагчид тэмдэглэж байна.




Япон, Их Британи, Франц болон бусад хөгжингүй орны удирдагчид "Standard & Poor's"-ийн шийдвэрээс болж АНУ-ын өрийн бичигт хандах өнцгөө өөрчлөхгүй гэдгээ мэдээлж амжсан. Харин Энэтхэгийн зүгээс "Standard & Poor's" дэлхийн зах зээлийн хувьд ноцтой шийдвэр гаргасныг онцлоод, энэ тал дээр олон талын дүн шинжилгээ хийхээ мэдэгдсэн юм. Гэхдээ дэлхийн анхаарлыг Хятадын байр суурь л үлэмж ихээр татаж буй. Америкийн хамгийн том зээлдүүлэгч



болох БНХАУ сүүлийн үед энэхүү үнэт цааснаас аажим аажмаар ангижирч буйг ажиглахад хялбар. 2010 оны аравдугаар сард тус улс 1.18 их наяд ам.долларын хэмжээтэй Америкийн Засгийн газрын өрийн бичгийг атгаж байсан бол өнгөрсөн гуравдугаар сард энэ үзүүлэлт 1.15 их наяд ам.доллар болтлоо буурсан байлаа. Харин "Standard & Poor's"-ийн шийдвэр хятадуудыг энэ үйл ажиллагаагаа илүү эрчимтэй явуулахад нөлөөлөхөөс гадна америкчуудтай хүчээр ярьж болно гэсэн бодлыг нь улам дэврээх талтай. "Төсвийн алдагдлаа багасга, хуулийн төслөө хурдан батал" хэмээн АНУ-д ил цагаан зааж, шүүмжлэхээс нэрэлхдэггүй БНХАУ-ын эрх баригчид нэг улсын мөнгө олон улсын мөнгө болчихоод байгаа учир түүнд олон улсын хяналт шалгалт шаардлагатай хэмээн үздэг. Эдүгээ Хятадын хувьд дэлхийд нөөцийн шинэ валют хэрэгтэй гэдгийг батлах сайхан боломж ч бүрдэж мэднэ. Ер нь "Fitch" болон "Moody's" АНУ-ын зээлжих зэрэглэлийг мөн бууруулаад, хятадууд Америкийн Засгийн газрын өрийн бичгийг их хэмжээгээр борлуулаад эхэлбэл байдал эвгүйдэхийг мэргэжилтнүүд тайлбарлаж байна. Гэхдээ маргааш юу болохыг хэн ч хэлж мэдэхгүй шүү дээ. Энэ талаар Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлангаас тодрууллаа.

-Дэлхийн бараг бүх улс орон гадаад валютын нөөцийнхөө дийлэнх хэсгийг ам.доллар, АНУ-ын Засгийн газрын өрийн бичиг хэлбэрээр барьдаг. Монгол Улс ямар байна вэ?

-Дэлхийн улс орнуудын нийт гадаад өрийн 50, гадаад валютын нөөцийн 61, гадаад гүйлгээний 85 хувь нь ам.доллараар байна. Хэдийгээр энэ үзүүлэлт сүүлийн 10 жилд буурч байгаа ч ам.доллар нь дэлхийн гол



нөөцийн валют хэвээр л байна. Манай улсын хувьд гадаад төлбөр тооцооны 65 хувь нь ам.доллараар хийгдэж байна. Мөн дотоодын валютын захад хамгийн идэвхтэй арилжаалагддаг валют учир Монголбанк ам.доллараар гадаад валютын улсын нөөцийг түлхүү барих зайлшгүй шаардлагатай юм л даа. Өөрөөр хэлбэл, манай гадаад худалдаанд ямар валют зонхилж байгаатай уялдуулж бид нөөцөө удирдах хэрэгтэй болдог. Олон улсын практикт гадаад нөөцийн нэлээд хэсгийг АНУ-ын өрийн бичигт хөрөнгө оруулах замаар удирддаг. Сүүлийн жилүүдэд Хятад, Япон, Солонгос нь АНУ-ын Засгийн газрын өрийн бичгийн гол хөрөнгө оруулагчид болж байна. Энэ хандлага ч цаашдаа харьцангуй тогтвортой байх төлөвтэй.

–“Standard & Poor’s” АНУ-ын зээлжих зэрэглэлийг бууруулсан нь Монгол Улсад ямар нөлөөтэй вэ?

–“Standard & Poor’s” АНУ-ын зээлжих зэрэглэлийг бууруулснаар ам.долларын ханш цаашид сулрах, АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны өгөөж өсөж, үнэ нь буурч болзошгүй байсан. Гэвч өнөөгийн

дэлхийн эдийн засгийн тогтолцоонд ам.долларыг орлуулах нөөцийн валют байхгүй байгаагаас гадна АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны зах зээлээс өөр найдвартай томоохон зах зээл ч байхгүй тул хөрөнгө оруулагчид ам.долларт, АНУ-ын Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулсан хэвээр байна. Хэдий үнэлгээ нь буурсан ч АНУ-ын Засгийн газрын үнэт цаасыг “тэг” эрсдэлтэй гэж суурь болгон тооцоолдог олон улсын практик хэвээр л үргэлжилнэ, тодруулбал энэ зээлжих эрх гэдэг үнэлгээний өөрийнх нь утга тэндээс эхэлдэг. Харин ч энэ ч утгаараа сүүлийн өдрүүдэд АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны үнэ зах зээлд өсөж байна.

Монгол Улсын гадаад төлбөр тооцоо, ханшийн бодлогыг хэрэгжүүлэхэд голлон хэрэглэгдэж байгаа валют нь ам.доллар хэвээр байгаа. Дэлхийн зах зээлд бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ ам.доллараар илэрхийлэгдэж, төлбөр тооцоо хийгддэг хандлага ойрын жилүүдэд өөрчлөгдөх магадлал тун бага байгаа тул АНУ-ын зээлжих зэрэглэл буурснаар Монгол Улсад үзүүлэх нөлөө бага юм. ■

Монголын хөрөнгийн биржээр дүүрэн хөглөрч байгааг ч шийдэх цаг ирснийг тэмдэглэж байсан. Харин энэ удаад хувьцаат компани, хөрөнгө оруулагчийг холбох гүүр болсон брокеруудын талаар дуугүй өнгөрч боломгүй нь. Монголчууд бид хоёр сая 796 мянгуулаа хувьцаа эзэмшигч болсон шилжилтийн гэмээр энэ үед брокерийн пүүсүүд борооны дараах мөөг шиг л олширч буй. Гэвч энэ салбар ямар аймшигтай бохирдсоныг үгээр илэрхийлэхийн арга алга. Шинэ оны босгон дээр сүлд модны баяраа тэмдэглэж байсан нэг брокер Санхүүгийн зохицуулах хорооны газрын даргын нүдний шилийг хугартал цохисон тохиолдол ч гарч байв. Сэлэнгэд брокерийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй ганц л компани байхад гурав, дөрвүүлээ бөөгнөрч, хүмүүсийг дансаа нээлгэ хэмээн уриалах нь энгийн үзэгдэл болж. Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвд өмнө нь данстай байснаа мэдээгүй хүмүүст 300 төгрөгөөр л тэрийг нь сэргээгээд өгчих юмыг мэдсээр байж шинээр данс нээж, 5000 төгрөгийг нь авч байсан хэрэг ч мандаж, чих халууцуулж байх жишээтэй. Ийм булхайтай, ичиж үхэхэд ч багадмаар заваан байдал хэр удаан үргэлжлэх юм бол оо? Яагаад манай брокерууд муу нэртэй, муухай данстай болчихов?

Сүхбаатарын талбайн баруун талд байрлах ягаан байшингийн танхимд өнөөдөр брокер дилерийн 49 компанийн төлөөлөгч суудлаа эзэлсэн байна. Дөрвөн өрөө байрнаас нэг их том байгаад шалихгүй энэхүү талбайд 64 брокерийн сандал, ширээг багтаах боломжтойг Монголын хөрөнгийн биржийнхэн дуулгав. Гэтэл Санхүүгийн зохицуулах хорооноос брокер дилерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан 83 байгууллага бий. Өнгөрсөн оны сүүлчээр энэ тоо 52 байсан бол 2006 онд ердөө 25 байжээ. Хар ухаанаар бодоход брокерийн пүүсүүд олон болох тусмаа хоорондоо өрсөлдөж, тэр чинээгээрээ үнэ өртгөө бууруулж, үйлчилгээгээ сайжруулмаар. Гэтэл үгүй ажээ. Дэлхийд байхгүй өндөр шимтгэл авдаг хэрнээ манай брокерийн пүүсүүд данс нээж, хувьцаа авч, зарахаас өөрийг хийх нь ховор. Та 5000 төгрөгөөр данс нээлгээд, дараа нь хувьцаа авах бол гүйлгээнийхээ 1-4.5 хувийг хураалгана. Хувьцаа худалдаж авахдаа ч, авсан үнэт цаасаа эргүүлж зарахдаа ч энэ хэмжээний шимтгэлийг ахин дахин төлөх юм. Гэтэл ханш өсдөг шигээ ▶

Бирж

Брокеруудыг битгий давраа



Лондоны хөрөнгийн биржийнхэн манай хөрөнгийн зах зээлийг сайхан болгочихно хэмээн олон хүн хүлээж буй. Гэвч бидэнд гадныхны царай харж суухаас илүүтэй гал тогоондоо шийдэх асуудал мундахгүй байгааг “Mongolian

Economy” сэтгүүл өмнөх дугаарууддаа онцолж байсан. Санхүүгийн тайлангаа гаргахгүй, хувь нийлүүлэгчдийн хурлаа товлохгүй, ногдол ашгаа тараахгүй, бүр үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь эргэлзээтэй “сайхан гар”-ууд

буурдгийг хүн бүр мэднэ. Та гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг өөрөө л хүлээх ёстой. Уг нь бусад оронд брокер дилерүүд харицагчдынхаа хүссэн мэдээллийг өгч, зөвлөх үйлчилгээ ч үзүүлдэг. Гэтэл Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 49 компанийн дунд ийм үйлчилгээ үзүүлж чаддагийг нь нэрлэе гэвэл гарын таван хуруу ч олдох биз. “Брокер дилерийн компаниуд хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах үүрэгтэй байдаг. Гэвч манай мэргэжилтнүүд хөрөнгө оруулалтын суурь шинжилгээ, дүгнэдийг хийж чадахгүй байна. Хөрөнгө оруулагчид нь ч тийм мэдээлэл шаардахгүй, итгэлцэл төдий явсаар өдий хүрлээ” гэж эрсдэлийн шинжээч Д.Ганбаяр ярьж байна. Манай хувьцаат компаниуд санхүүгийн тайлангаа ч цаг тухайд нь гаргадаггүйгээс болоод мэдээлэл хүртээмжгүй байдаг нь үнэн. Гэвч ядахдаа мэдээллээ гаргаж байгаа компаниудынх нь анализыг зохих ёсоор хийчихмээр байна шүү дээ. Энэ тал дээр брокер дилерийн компаниудын ихэнх нь хойрго хандаж байгааг хэн ч үгүйсгэхгүй болов уу.


Манай брокерийн пүүсүүдийн авч буй арилжааны шимтгэл Лондоныхоос даруй 100 дахин өндөр байгааг Монголын хөрөнгийн биржийн Хэрэг эрхлэх газрын дарга Г.Саруул хүлээн зөвшөөрсөн. Гэвч гээндээ ч бий, гоондоо ч бий гэдэг дээ. Юу гэвэл шимтгэлийн 0.5 хувийг Монголын хөрөнгийн бирж өөрөө, 0.1 хувийг Санхүүгийн зохицуулах хороо, 0.24 хувийг Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв авдаг бол үлдсэн хэсэг нь л брокер дилерийн компаниудын орлого болдог ажээ. “Хөрөнгө оруулагчдыг хэн олж ирж байгаа юм бэ? Мэдээж брокер дилерийн компаниуд. Гэтэл зүв зүгээр сууж байгаа дээрх байгууллагууд 0.84 хувийг нь хамаад авчихаж байна. Энэ хувь хэмжээг багасгах эрэлт, хэрэгцээ гарсан нь үнэн. Бид шимтгэлээ бууруулах боломжтой ч дээрх төрийн байгууллагуудаас хамаараад байгаа юм. Энэ хүсэлтээ бид 2006 оноос л тавьж байгаа боловч ямар ч хариу ирдэггүй” хэмээн Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга Т.Цогтбаяр учирлав. Мэргэжлийн ёс зүйтэй зах зээлийг бүрдүүлснээр хөрөнгийн захын дэд бүтцийн 50 хувийг барьж байгуулсантай тэнцэхийг Монголын санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг бичиж байв. “Харилцагчийн нэр дээр

байсан хувьцааг брокерууд дур мэдэн борлуулах асуудал их гарч байсан нь ёс зүйн маш том зөрчил төдийгүй хууль зөрчсөн үйлдэл юм. Үүнээс болж зах зээлийн нэр хүнд хөрөнгө оруулагчдын өмнө ихээр унасан” хэмээн тэрбээр тайлбарлажээ. Үнэхээр брокерууд хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр арилжаа хийсэн, эсвэл хувьцаат компаниудын удирдлага жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг зөрчсөн гэх хоёр гол үндэслэлээр л гомдол гардаг тухай Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын орлогч дарга С.Тулгаа ярьж байна. 1991 оноос төрийн өмчит 520 компанийг Монголын хөрөнгийн биржид бүртгэж, хувьцааг нь цэнхэр, ягаан тасалбар болгон иргэдэд үнэгүй өмчлүүлснээр олон хүн Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд данстай гэдгээ ч мэдэлгүй он жилүүдийг үдсэн билээ. Иймэрхүү учраа мэдэхгүй хүмүүсийн хувьцааг брокерууд хууль бус аргаар борлуулах, үрэн таран хийх явдал 1995-2006 онд тоймгүй ихээр гарч байсан аж. Санхүүгийн зохицуулах хороо иймэрхүү увайгүй үйлдлийг чадлынхаа хэрээр зогсоож чадсан ч эмгэгийг нь нэг мөр эмчилж дөнгөөгүй. Одоо ч хэд хэдэн брокерийн пүүсийн үйл ажиллагааг зогсоож, цагдаад өгчихөөд сууж байх жишээтэй. Үүний хажуугаар хувьцааны үнийг зохиомлоор хөдөлгөх, дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийж өөртөө ашиг олох, худлаа мэдээлэл тараах зэрэг ёс зүйгүй явдал өнөөдрийг хүртэл амь бөхтэй оршсоор байгааг учир мэдэх хүмүүс анхааруулж байгаа юм. “Хөрөнгийн зах зээл хөгжсөн бүх

оронд иймэрхүү үйлдлийг эрүүгийн хуулиндаа тусган хориглосон байдаг бөгөөд зөрчсөн тохиолдолд маш хатуу шийтгэдэг. Ёс зүйгүй үйлдэл хийсэн мэргэжлийн брокер дилер хөрөнгийн зах зээлд ажиллах эрхээ насан туршдаа хасуулдаг” хэмээн Ө.Ганзориг онцолжээ.

Харин Монголд ямар байдаг бол? Өнгөрсөн онд л гэхэд Санхүүгийн зохицуулах хороонд 321 өргөдөл ирсэн боловч буруутай гэдэг нь нотлогдсон этгээдүүдэд нийт 710 мянган төгрөгийн торгууль л ногдуулжээ. Өнөөгийн хуулиар бол ёс зүйгүй үйлдэл хийсэн брокер ердөө 20000-40000 төгрөгөөр торгуулиад өнгөрөх жишээтэй. Хууль зөрчсөн нь тогтоогдсон аж ахуйн нэгжийг дээд тал нь 250 мянган төгрөгөөр торгоно гээд бод л доо. Ер нь болсон болоогүй брокерийн пүүс олшрох, мэргэжлийн оролцогчдын ёс зүйгээ уландаа гишгих нөхцөлийг өнөөгийн хууль эрх зүйн орчин бүрдүүлээд байна гэж дүгнэвэл буруудахгүй ажээ. Брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50 сая төгрөгөөс доошгүй байна хэмээн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд заасан байдаг. Товчхондоо, 51 сая төгрөгтэй байхад л брокерийн пүүс байгуулах нөхцөл нь хуулийн дагуу бүрдэж байгаа учраас Санхүүгийн зохицуулах хорооныхон материалаа бүрдүүлээд ирсэн байгууллагуудын хүсэлтийг хүлээж авч, тусгай зөвшөөрөл өгөхөөс өөр аргагүй. Ямар сайндаа л өнгөрсөн зургадугаар сарын 30-наас брокер дилерийн компаниудын бүртгэлийг энэ он дуустал зогсоохдоо “Монголын ▶

Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын тоо болон нийтийн активын хэмжээ



Брокер, дилерийн компаниудын нийт активын хэмжээ /тэрбум төгрөг /	2007	2008	2009	2010
	7.3	13.7	13.1	19.9

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

хөрөнгийн биржид багтах аа байчихна” гэсэн шалтаг хэлж суух вэ дээ. “Millennium IT” программыг нэвтрүүлснээр брокерууд ягаан байшин дахь сандал, ширээг булаацалдах шаардлагагүй болж, интернэтээр ажлаа хийж болох учир тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг тухайн үеэс л бүртгэж эхлэх ажээ. Хагас жилийн дотор 30 орчим брокерийн пүүс шинээр тусгай зөвшөөрөл авсан байна шүү дээ.

“10-хан сая төгрөгөөр хувьцаат компани байгуулж, 51-хэн сая төгрөгөөр брокер дилерийн компани босгоод ирэх боломжтой байна. Ямар ч шалгуур, стандарт, бодлого алга. 51 сая төгрөгийн ард юуных нь хариуцлага байх вэ дээ. Баахан данс нээчихээд, хэдэн арилжаа хийчихээд алга болчихвол яах билээ. Иймэрхүү компаниуд л бусдынхаа нэр хүндэд муугаар нөлөөлөөд байна. Уг нь манай брокерийн пүүсүүд дотор гадаадын томоохон хөрөнгө оруулалтын банкуудтай хамтардаг, олон улсын жишгийн дагуу үйл ажиллагаа явуулдаг нь ч бий шүү дээ” хэмээн Т.Цогтбаяр 2003 оноос өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн муу талыг онцлов.

“Хөрөнгийн зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа брокер дилерийг зоосоор төлөөлүүлж үзвэл сүлдтэй тал нь мэргэжлийн ёс зүй, тоотой тал нь мэргэжлийн мэдлэгийг харуулдаг” хэмээн Ө.Ганзориг тайлбарласан

нь бий. Монголд бол ёс зүйн хэм хэмжээний талаар цаасан дээр бичсэн хэдэн заалт Монголын хөрөнгийн бирж төдийгүй Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд байдаг ч тэр бүхнийг мөрдөх нь байтугай уншдаг хүн ховор болохыг хаа хаанаа хүлээн зөвшөөрөх ажээ. Брокеруудын мэдлэгийн хувьд ч мариуухан дүр зураг тодрох вий. Саяхан үнэт цаасны арилжаанд орох эрх олгох шалгалт явуулахад 120 хүн хамрагдсаны 75 хувь нь л тэнцсэн байх жишээтэй. Бүр асуултуудыг нь ном болгон хэвлээд, бүтэн сар бэлдэх хугацаа өгчихөөд байхад 30 гаруй брокер тэнцээгүй байна гээд бод л доо. Хялбархаан хэдэн асуултад бүдэрсэн тэднийг харж үзээд, энэ наймдугаар сард дахин шалгалтад орох боломжоор хангаад байгаа юм. Тэгээд ч тэнцэхгүй байвал жинхэнэ утгаараа “Bye bye” болох ажээ.

Сонирхуулахад, Монголын хөрөнгийн биржийн шинэхэн удирдлага өнгөрсөн хавар олон брокерийн арилжаанд орох эрх дууссан байсныг анзаарсан байна. Үүнийгээ ч тоосон юмгүй ажлаа хийсээр л байсан юм билээ. “Энэ бүхнийг олон жилийн турш хэн ч анхааралгүй ирсэн байна. Ийм байж болдоггүй юм гэх дохиог бид өгч эхэллээ” хэмээн Г.Саруул тэмдэглээд, “Брокер гэж нэр булхай гэдэгтэй л ижил муухай сонсогддог болсон. Энэ нэрийг сайжруулах үүднээс шалгалт авч байгаа юм. Брокерууд мэдлэгтэй, ёс зүйтэй,

үлгэр жишээ байх ёстой” гээд мөнөөх шалгалтын асуултуудтай номоо надад үзүүлэв. Эргүүлж тойруулж харах нь ээ тэнд мэргэжлийн ёс зүйн талаарх асуулт тун ч ховор байгааг анзаарсан юм. Нью-Йоркт иймэрхүү шалгалтын асуултуудын 40-50 хувь нь мэргэжлийн ёс зүйтэй холбоотой байдаг бөгөөд хамгийн хэцүүд тооцогддогийг Г.Саруул тайлбарлаад, “Саяхан явуулсан аттестатчилах шалгалт бол бид тэр чиглэл рүү явж байгаа эхний алхам юм” хэмээн тайлбарлалаа. Уулын мод урттай, богинотой гэдэгчлэн брокерууд бүгд л болохоо байчихсан хүмүүс гэвэл ташаа ойлголт болно. Гэвч хамт олныхоо нэрийг гутаагаад явдаг хэсэг нөхдийг зайлуулахын тулд иймэрхүү шалгалтаас эхлээд өчнөөн юм хэрэгтэй болох нь мэдээж.

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны хувьд гишүүддээ IOSCO буюу Олон улсын үнэт цаасны хороодын байгууллагын стандартыг мөрдүүлдэг болохыг чухалчилж байгаагаа Т.Цогтбаяр яриу. Эдний шаардлагад нийцсэн кодекс буюу Ёс зүйн дүрмийг тус холбоо 2008 оны зургадугаар сард баталсан ч түүний хэрэгжилтэд хяналт тавих Ёс зүйн хороог өнгөрсөн хоёрдугаар сард л байгуулжээ. Гэвч уг Ёс зүйн хороонд хөндлөнгийн шинжээч ч байхгүйгээс үзэхэд брокеруудаа дүрэм, журмаа биелүүлж байгаа эсэхийг хянах нь юу л бол. “Уг нь хараат бус гишүүд байх ёстой. Харин бидэнд тийм хүмүүсийг цалинжуулах мөнгө алга. Тиймээс л брокер дилерийн компаниудаасаа хүн сонгохоос өөр аргагүй байсан” гэж Т.Цогтбаяр тайлбарлалаа. Тэрбээр өмнө нь Санхүүгийн зохицуулах хороонд ажиллаж байсан, эдүгээ Монголын хөрөнгийн биржид суудалтай 49 компанийн 47-г нь багтаадаг холбоог тэргүүлж буй хүнийхээ хувьд брокер дилерийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг тогтоох, арилжааны шимтгэлийг бууруулах зэрэг чухал асуудлуудад анхаарлаа хандуулсаар иржээ. Гэвч хууль эрх зүйн орчин нь өөрөө увайгүй, ёс зүйгүй үйлдлийг өөгшүүлээд байгаа өнөө үед ямар ч сайн дүрэм байгаад нэмэргүй. Ямартай ч брокер дилерийн компаниудыг шигшиж, цэвэрлэж, брокеруудын мэргэжлийн мэдлэг хийгээд ёс зүйг дээшлүүлэх нь ганц, хоёр өдрийн ажил биш аж. Энэ аянд хөтлөх замын гараа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаас эхэлнэ хэмээн хүлээж, найдах л үлджээ. ■

Санхүүгийн зохицуулах хороонд иргэдээс ирсэн өргөдөл, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010
1. Хороонд иргэдээс хандан гаргасан өргөдлийн тоо	415	670	316	341	321
2. Арилжааны хэлцлийг хүчингүй болгосон, буцаан байршуулсан	1.227	3.914.718	3.310.551	70	2.716
3. Захиргааны шийтгэл хүлээлгэсэн тоо	8	15	50	23	7
4. Торгуулийн хэмжээ /төгрөг/	480.000	2.785.000	5.060.000	3.333.000	710.000
5. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж шүүх хуралдаанд оролцсон байдал	-	2	20	19	21

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Таван толгой



Цаг үе

Тавантолгойг ойлгоход толгой хүрэхгүй нь ээ

Д.Мөнхчимэг

Засгийн газар наадмын өмнөхөн ээлжит бус хуралдаан хийж, Тавантолгойн Цанхийн баруун хэсэгт үйл ажиллагаа явуулах стратегийн хөрөнгө оруулагчийг “бий болголоо”. Ийн онцолсны учир олон улсын сонгон шалгаруулалтын хоёрдугаар шатанд тунаж үлдсэн зургаан компани, консорциумын нэг нь ч ялсангүй. Харин Хятадын “Shenhua Energy”, Америкийн “Peabody Energy”, Орос-Монголын хамтарсан консорциумын хуваан эзэмших нэгэн компани гараанаас гараагүй ч барианд ороод ирлээ. Энэхүү гэнэтийн шийдвэр Япон, БНСУ-ын Засгийн газрыг гайхшралд оруулаад зогсохгүй Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шинжээчдийг хямрааж, хэл ам дагуулав. Ерөнхийлөгчийн Эрдэс баялгийн бодлогын зөвлөл П.Цагаан “Зөөлхөн хэлбэл бүрдэл дутуу, хатуухан хэлбэл хариуцлагагүй материал ирүүлсэн учраас нэмж мэдээлэл шаардаж авч, судалж үзсэний дараа байр сууриа илэрхийлэх боломжтой” гэж тайлбарласан бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шинжээч Б.Алтан-Очир “Энэ гэрээгээр явбал бид баруун Цанхиа алдана” хэмээн шуудхан хэлжээ.

Ийнхүү баруун Цанхийг тойрсон

дуулиан намжиж амжаагүй байтал “Эрдэнэс Тавантолгой” Хятадын “Chalco”-той 250 сая ам.долларын гэрээ хийж, зүүн Цанхийн нүүрсийг урагш зөөж эхлэв. Коксжих болон эрчим хүчний нүүрсний нөөцөөрөө дэлхийд хоёрдугаарт эрбэмбэлэгдэх энэхүү орд газартай холбоотой шинэ мэдээлэл, шийдвэр болгон монголчуудын төдийгүй гаднынхны толгойг улам л ихээр гашилгах боллоо.

Баруун Цанхи

Монгол Улсын төр, засгийн тэргүүн ОХУ, БНХАУ, АНУ руу ээлж дараалан хүлгийн жолоо залж ирсний дараахан дээрх гурван их гүрний ашиг сонирхлыг Тавантолгойд багтаасан шийдвэр гарч ирэв. Тодруулбал, Цанхийн баруун хэсэгт үйл ажиллагаа явуулах стратегийн хөрөнгө оруулагч компанийн 40 хувийг БНХАУ-ын “Shenhua Energy”, 24 хувийг АНУ-ын “Peabody Energy”, үлдсэн 36 хувийг Орос-Монголын хамтарсан консорциум тус бүр 18 хувиар хамтран эзэмшихээр болжээ. Тэгээд тэднээс монголчууд нэг тэрбум ам.доллар авах юм байх.

Сонгон шалгаруулалтын хоёрдугаар шатанд “дэр нэгтгэн” орсон “Peabody Energy”, “Shenhua En-

41 Алтны үнийн өсөлт хүчээ авлаа

42 “Мянганы үйлдвэр” мянгуужингийн үлгэр болох уу?

ergy” яагаад хоёр тийш салсан, мөн тэдэнтэй хамтарч байсан Японы “Mitsui” хаашаа алга болсон нь сонирхол татна. Түүнчлэн “Оросын төмөр зам”-тай гар барилцан гараанаас гарсан Япон, БНСУ-ын компаниудын нэгдэл яагаад “жийгдчихсэн” юм бол? Энэ талаар зөвхөн монголчууд мэдэхгүй ангайж суусан юм биш ажээ. Япон, Солонгосын төр засгийн зүгээс Монгол Улсыг тендерээ ойлгомжгүй, шударга бус явуулж байгаад гомдоллож, холбогдох яам, тамгын газрууд руу тайлбар шаардсан албан бичгийг удаа дараа явуулсан тухай AFP, “Reuters” зэрэг олон улсын хэвлэл, мэдээллийн агентлаг ам уралдан бичигцгээв. Хамгийн инээдтэй нь Монголын удирдагчид тодорхой тайлбар шуудхан өгчихөж чадахгүй дэлхийн өмнө онигоогоо дэлгэлээ.

Гэтэл Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугарын ярьж буйгаар Япон, Солонгосын компаниудыг “жийсэн” юм байхгүй, ажил зохион байгуулж байсан хүмүүс холбогдох консорциумд урилга өгөхдөө зөвхөн гол үүрэгтэй газрууд руу нь явуулчихснаас үл ойлголцол үүссэн аж. “Солонгос, Японы хөрөнгө оруулагчдыг бүр хассан гэх ойлголтыг засах нь улс төр, эдийн засгийн харилцаа талаасаа чухал” хэмээн тэрбээр тайлбарлаад, “Монгол-Оросын консорциумд Монголын талаас хэн ч оролцож болно. Монгол компанийн хувьд бие даагаад дөрөв дэх консорциум болж орох, эсвэл бусадтай хамтрах эрх нь ч нээлттэй” гээд бүр ч толгой эргүүлээд явчихлаа.

Ийм учир нь ойлгогдохгүй шийдвэр гаргах байсан бол яах гэж анхнаасаа 15 компани, консорциум өрсөлдүүлж, ▶

► тэднээсээ зургааг нь шигшиж гаргаж ирсэн юм бэ? Эрчим хүчний нүүрсний экспортоор дэлхийд тэргүүлдэг Австралийн “Xstrata coal”, төмрийн хүдрийн үйлдвэрлэлээр №1 Бразилийн “Vale”, гангийн үйлдвэрлэлийн “акул” болох Люксембургийн “ArcelorMittal” яагаад гологдсон нь тодорхойгүй байна. Хамгийн гол нь 40:24:36 гэсэн тоог гаргаж ирэхдээ ямар зарчим баримталснаа Засгийн газар ард түмэндээ тайлбарлах хэрэгтэй болжээ. “Яагаад Хятадын төрийн өмч давамгайлсан компани ганцаараа 40 хувийг буюу төслийн гүйцэтгэх захирлыг томилох болон бусад бүх эрх мэдлийг авсан бэ? Тэгсэн атлаа Орост 18 хувь ногдож байгаа нь хоёр хөршөө адил тэгш тавьж, дээр нь гуравдагч хөршийн бодлого явуулна гэсэн манай улсын гадаад бодлогын гол шугамтай аль зэрэг нийцэх вэ?” хэмээн эдийн засагч Д.Жаргалсайхан бичжээ.

Зүүн Цанхи

“Эрдэнэс Тавантолгой” компани “бор зүрхээрээ” хариуцаж, борлуулалтаа өөрөө хийнэ хэмээн амлаж байсан Цанхийн зүүн хэсэгт захиалгаар олборлолт явуулахын тулд БНЭУ-ын “Mesco Steel”, ХБНГУ-ын “BBM Operta”, Австралийн “Masmanon” гэсэн гурван компани өрсөлдсөн. Гэтэл Монголын зүгээс энэхүү сонгон шалгаруулалтын дүнг мөн л зарлаагүйгээр барамгүй өөрсдөө нүүрсээ олборлоод, Хятад руу зөөж эхэлснийг юу гэж ойлгох вэ? Монголчууд өөрсдөө чадна гэдгийг үгүйсгэх гэсэнгүй, чадахын дээдээр чадна. Тэгвэл аль эртнээс ийм зорилго тавиад ажиллах нь яасан юм бол? Олон улсын сонгон шалгаруулалт тоглоом юм уу? Үүний өмнө Монголын хөрөнгийн биржийн менежментийн багийг сонгохдоо мөн л тендерээ цуцалж, бөөн шуугиан дэгдээсэн. Эргэж буцсан инээдтэй байдлаараа дэлхийн өмнө шившгээ дэлгэх нь манай Засгийн газрын “стратегийн” болчихсон бололтой.

За тэр ч яах вэ. Хамгийн гол нь Цанхийн зүүн хэсгийн нүүрсний борлуулалтыг монголчууд өөрсдөө хийхгүй юм байна гэдгээ мэдээд олон хүн санаагаар унах биз. Мөн л урд хөршийн “Chalco” (“Cinalco”-гийн охин компани) энэ амин чухал асуудлыг хариуцахаар тусгасан 250 сая ам.долларын гэрээг “Эрдэнэс Тавантолгой” дур мэдээд хийчихсэн байгаа юм. Тэгээд БНСУ болон Японы компаниудыг гомдоохгүйн тулд нүүрснийхээ 30 хувийг тэдэнд борлуулах тухай санамж бичиг мөн

үзэглэжээ.

Дээрх гэрээг байгуулснаас нэг их удалгүй хүнд даацын 40 машинаас бүрдсэн анхны цуваа зүүн Цанхийн дөрвөн мянган тонн нүүрсийг ачаар Гашуунсухайтын боомтыг чиглэн хөдөлсөн. Бас болоогүй, эхний машины орой дээр алтан соёмбо залчихсан байгаа юм аа. Тэгээд Эрдэнэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт тэргүүтэй албаны хүмүүс бөөн баяр болоод байсныг ердөө ойлгосонгүй. Энэ нь тийм сайхан мэдээ гэж үү?

Яагаад борлуулалтаа өөрөө хариуцна гэж байсан “Эрдэнэс Тавантолгой” энэ ажлаа хятадуудад даалгачихав? “Нэгэнт хүнээс урьдчилгаа мөнгө авч байгаа юм бол тэдний өмнө ямар нэгэн нэмэгдэл үүрэг хүлээх ёстой биз дээ” хэмээн Д.Сугар тайлбарласан байх юм. Тодруулбал, монголчууд 250 сая ам.доллараа төлж барагдуулах хүртлээ нүүрсээ зөвхөн “Chalco” компанид 100 хувь өгнө. Тэгээд хятадууд манай нүүрсний 20-30 хувийг Япон, Солонгост хүргэх юм. Энэ жилийн хувьд Цанхийн зүүн хэсгийн тонн нүүрсийг 70 ам.доллараар борлуулж байгаа нь зах зээлийн ханшаас доогуур үзүүлэлт гэдэг нь ойлгомжтой. “Ойролцоогоор 5-6 жилийн дараа Монголын Засгийн газар өөрийнхөө нөөцийг өөрөө мэдэж борлуулдаг болно” гэж Д.Сугар ярьсан бол “ЭрдэнэсМГЛ” компанийн гүйцэтгэх захирал Л.Энэбишийн хэлснээр Цанхийн зүүн хэсгээс энэ ондоо 1.3 сая тонн нүүрс экспортолж, 2015 он гэхэд уг үзүүлэлтийг 15 саяд хүргэх аж. Бид энэ их нүүрсээ хятадуудад хямд үнээр өгөх юм биш биз?

Цанхийн баруун хэсэгт урд хөршийн компанид үнэмлэхүй хувь өгөөд зогсохгүй үлдсэн зүүн хэсгийнхээ борлуулалтыг мөн л хятадуудад даатгаж байгаа нь ямар учиртай юм бэ? Нүүрсний хэрэглээ төдийгүй үйлдвэрлэлээрээ БНХАУ дэлхийд тэргүүлдэг нь үнэн. Тэр тусмаа бид энэ орны нөлөөг бага байлгах ёстой бус уу? Тавантолгойн нүүрсний гол худалдан авагч энэ ордод гол байр суурийг эзлэх нь ямар үр дагавартай вэ? Хятадууд өөр хоорондоо Монголын нүүрсний үнийг наймаалцаж, борлуулна гэсэн үг бус уу? Ийм байхад монголчууд дэлхийн зах зээлийн ханшийн талаар нэг хэсэгтээ мартсан нь дээр ажээ.

Мөнгө цагаан, нүд улаан

Тавантолгойн энэ бүх толгой эргүүлсэн байдлыг ойлгомжтой тайлбарлаж өгөхийг монгол хүн бүр Засгийн газраасаа шаардах цаг иржээ.

Энд ямар бодлого яваад байгааг “Эрдэнэс тавантолгой”-н хувьцааг эзэмшиж буй хоёр сая 796 мянган иргэн мэдэх эрхтэй.

“Монголын тал өөрийн байр суурин дээр хатуу зогсож чадсанаар хөрөнгө оруулагчид манайд 500 сая ам.долларыг буцалтгүйгээр шууд олгож, дахин нэмж 500 сая ам.долларыг урьдчилгаа болгон өгнө” хэмээн Засгийн газар мэдэгдсэн. Үгүй, энэ бол Монголын талын байр суурь биш. Харин сонгуулийн амлалтаа биелүүлэх гэсэн хэсэг бүлэг хүний ашиг сонирхол давамгайлж явааг үгүйсгэх аргагүй. Ер нь хэлэлцээр зөвхөн монголчуудын талд ашигтай болно гэж хүлээж суух нь тэнэг хэрэг. Нэгэнт л Тавантолгойг ашиглахын тулд хөрөнгө мөнгөө зарцуулах талууд тус бүрдээ өөрийн сонирхол, ашиг хонжоог хайх нь ойлгомжтой. Энэ сонирхлынхоо төлөө бүтэн тэрбум ам.доллар цацаж байгаагаас нь харахад тэд Цанхийн баруун хэсгийг бүрмэсөн өөрийн болгох юм биш байгаа гэсэн хар төрж буйг нуух юун. “Зүүн, баруун Цанхи төрийн мэдэлд 100 хувь байгаа. Бид зөвхөн баруун Цанхийг ашиглах компанийг яаж эзэмших вэ гэдэг хувь хэмжээг л яриад байгаа юм” гэж Д.Сугар тайлбарлажээ. Тэгвэл Оюутолгойн ордыг ашиглаж буй “Оюутолгой” ХХК-ийн 34 хувийг авах гэж монголчууд бөөн юм болоогүй бил үү?

За тэгээд мөнөөх угтуулан тавих нөхцөл, нүүрс тээвэрлэх төмөр зам, транзит тээврийн үнэ, боомтын шийдэл зэргийн тухай тодорхой мэдээлэл байхгүйгээс гадна ямар технологи ашиглах нь ч одоог хүртэл ойлгомжгүй байна. “Урагшаа болон зүүн тийшээ явах төмөр замын асуудлаар талууд нааштай тохиролцоонд хүрсэн, мөн 600 мегаваттын цахилгаан станц барихаар болсны зэрэгцээ нүүрснээс шингэн түлш гаргах, кокс үйлдвэрлэх зэрэг нэмүү өртөг бий болгодог үйлдвэр барихаар шийдсэн” гэсэн бүдэг бадаг гурван өгүүлбэрээс өөр юу ч бидэнд дуулгасангүй. ТЭЗҮ байтугай төсөлд хэдий хэмжээний хөрөнгө оруулах нь ч тодорхойгүй байна шүү дээ.

Түүнчлэн Монгол Улсад төлөх бүх татвар, хураамжаас гадна “Эрдэнэс Тавантолгой” компанид тээврийн зардлыг хассан борлуулалтын орлогоос таван хувьтай тэнцэх төлбөрийг мөн өгөхөөр тохиролцсон хэмээн Засгийн газрын хэвлэлийн мэдээнд онцолсон байв. Гэтэл тээвэрлэлтийн зардал ямар байх тооцоо нь хаана байгаа юм бэ? ОХУ бидэнд дамжин өнгөрөх ►

▶ тээврийн хөнгөлөлт үзүүлнэ гэсэн яриа хэлэлцээр явагдаж байсан ч 18-хан хувь дээр дэнжигнэсэн тэдний ашиг сонирхол хаашаа эргэхийг хэн хэлж чадах вэ?

Цанхийн баруун хэсгээс тэрбум ам.доллар, зүүн хэсгээс нь 250 сая ам.доллар урьдчилгаа болгон авлаа хэмээн ам уралдан баясахаас өөрийг засгийн эрх баригчид ярихгүй байна. Үүнээс үүдээд энэ бүх гэрээ хэлэлцээр зөвхөн мөнгөн дээр тогтож байна хэмээн дүгнэхээс өөр арга алга. 3.2 их наяд ам.долларын гадаад валютын нөөцтэй хятадууд зангарагатай загалгүй яах вэ. Тэр хэрээрээ Тавантолгойд нөлөөгөө бататгасан юм биш байгаа? “Засгийн газар, хөрөнгө оруулагчийг сонгохдоо зөвхөн урьдчилгаа төлбөрт хэтэрхий хөтлөгдөх вий. Урьдчилгаа мөнгө авна гэдэг бол нэг л асуудал. Цаана нь дэд бүтэц, нөгөө угтуулан тавих нөхцөл гээд том асуудлууд байгаа шүү” хэмээн Ерөнхийлөгч хүртэл

сануулж байсан. Улс төрийн намуудын сонгуулийн амлалт болох Хүний хөгжлийн сангийн 330 тэрбум төгрөгийг шинээр байгуулагдсан, дөнгөж хөлд орж буй “Эрдэнэс тавантолгой”-гоор гаргуулахаар шахаж буйг тус компанийн ТУЗ-ийн гишүүн Ж.Батзандан ярьж байв. Урьдчилгаа мөнгөний тухай бодсоор хэлэлцээрийн ширээний ард суух нь аюултайг Дэлхийн банкны мэргэжилтнүүд ч анхааруулж байлаа.

“Мөнгө цагаан, нүд улаан” хэмээн монголчууд ярьдаг. Эдийн засаг, бизнес, геополитикийн олон сонирхлын огтлолцол болоод буй Тавантолгойн баялгаа нэг тэрбум 250 сая ам.долларын төлөө тарамдаад хаячих вий гэсэн болгоомжлол төрж буйг нуух юун. “Эрдэнэс тавантолгой”-н 536 ширхэг хувьцаа хоосон цаас биш, хожим нь монгол хүн бүрийн амьдрал, амьжиргааг дээшлүүлэх баталгаа болоосой гэж хүсэж байсан юм сан. Харин Засгийн газар иргэдийнхээ итгэлийг даах нь уу? ■

валютын зах зээл дэх тодорхой бус байдал зэргээс болж уг металлын ханш 2010 онд 35 удаа түүхэн дээд амжилтаа эвдэж, нийт 26 хувиар дээшилсэн байдаг. Тэгвэл эдүгээ дэлхийн хамгийн том эдийн засаг болох Америкийн төсвийн алдагдал, өрийн хямрал хөрөнгө оруулагчдыг алт ихээр худалдаж авахад нөлөөлж буй аж. “Standard & Poor’s” агентлаг АНУ-ын зээлжих зэрэглэлийг бууруулснаас болж наймдугаар сарын 8-нд дэлхийн хөрөнгийн зах зээл уналтад орсон бол алтны үнэ эсрэгээрээ огцом өсөж, түүхэнд анх удаа 1700 ам.доллараас давж гарсан билээ.

Үүний хажуугаар Францын зээлжих зэрэглэл буурч магадгүй гэсэн хүлээлт үүссэн нь хөрөнгө оруулагчдыг улам айлгах болов. Эдийн засгийн хэмжээгээрээ Европтоо хоёрдугаарт ордог тус улсын Ерөнхийлөгч Николя Саркози төсвийн асуудлаас болж ээлжийн амралтаа эдэлж чадалгүй яаран ажилдаа орж, Засгийн газрын ээлжит бус хурал хийсэн нь дэлхийг түгшээв. Грек, Ирланд зэрэг орны өрийн хямрал Франц, Итали зэрэг томоохон эдийн засагт халдварлаад эхэлбэл Европын санхүүгийн байдал дээсэн дөрөөн дээр ирнэ гэсэн болгоомжлол зах зээлд бий болжээ. “Грек бол Итали, Франц зэрэгтэй харьцуулахад юу ч биш. Европоос болгоомжилсон хөрөнгө оруулагчид мөнгөө найдвартай газар хадгалахыг хүсэж байна. Гэтэл өнөөдөр алтнаас өөр сонголт алга” хэмээн “MF Global” компанийн ахлах стратегич Боб Хаберкорн тайлбарлажээ.

АНУ болоод Европын орнуудын төсвийн хямрал, Засгийн газрын өрийн бичгийн зах зээлд бий болсон тодорхой бус байдал хөрөнгө оруулагчдыг үнэт цаасаа их хэмжээгээр зарахад хүргэж буй. Хөрөнгийн захаас гадагшилж буй тэр мөнгө шууд шар металлын санхүүжилт болж хувирч байна. “Жижиг хөрөнгө оруулагчдын зүгээс гарч ирж буй алтны эрэлт хяналтаас гарч байна” хэмээн “Wells Fargo”-гийн шинжээч Пол Кристофер ярьжээ. “Засгийн газрын өрийн бичгийн зах зээлд асуудал үүссэн учраас хөрөнгө оруулагчдын хувьд алтнаас өөр ухаалаг гарц алга” хэмээн “Kingsview Financial” компанийн мэргэжилтэн Мэтт Земан онцлоод, энэ эрчээрээ явах юм бол наймдугаар сард унци алт 2000 ам.долларт хүрч мэднэ гэснийг <http://gold.prime-tass.ru> цахим хуудсанд мэдээлжээ.

Америк доллар, еврогийн ханшийн савлагаа, хөгжингүй орнуудын Засгийн ▶



Үнэт металл

Алтны үнийн өсөлт хүчээ авлаа


Дэлхийн зах зээл дэх алтны үнэ галзуурсан мэт өсөж байна. Наймдугаар сарын 11-нд унци алт 1795.4 ам.доллараар арилжаалагдсанаар ахиад л түүхэн дээд түвшиндээ хүрэв. Он гарсаар уг үнэт металлын ханш 25.5

хувиар өсөөд буйг “Dow Jones News-wires” мэдээллээ.

Олон улсын санхүү, эдийн засгийн байдал доройтох, тогтворгүй болох үед алтны эрэлт нэмэгддэг нь амьдралаар батлагдсан. Грекийн өрийн хямрал,


Алтны үнэ сүүлийн нэг сард (унци/ам.доллар)

VII.10-1555.5; VIII.10-1760; Өөрчлөлт: 13.1%



Мөнгөний үнэ сүүлийн нэг сард (унци/ам.доллар)

VII.10-36.36; VIII.10-39.18; Өөрчлөлт: 7.8%



Эх сурвалж: Kitco.com

газрын үнэт цаасны зах зээлд бий болсон тодорхой бус байдал дэлхийг улам л түгшээсээр. Гадаад валютын нөөцөө хэрхэн найдвартай хадгалах вэ хэмээн толгойгоо гашилгасан хөгжиж буй орнуудын Төвбанк 2010 оноос алт худалдан авах болсон билээ. ОХУ, Хятад, Тайланд, Бангладеш, Венесуэл, Филиппин зэрэг олон орон уг металлыг ихээр төвлөрүүлэх болсон нь эрэлтийг улам өсгөсөөр.

Алтны хөрөнгө оруулалтын эрэлтээс гадна үйлдвэрлэлийн бодит хэрэгцээ ч сүүлийн үед өсөж буй. Хөгжиж буй орнуудын санхүүгийн байдал сайжирсантай холбоотойгоор Энэтхэг, Хятадын иргэдийн гоёл чимэглэлийн бүтээгдэхүүний хэрэглээ огцом өсөж байгааг World Gold Council тэмдэглэж байв. Алтны нийт эрэлтийн талаас илүү хувийг гоёл чимэглэлийн үйлдвэрлэл бий болгож ирсэн билээ.

Алтны хэрэгцээ нэмэгдэж байгааг дагаад бусад үнэт металлын, тэр дундаа мөнгөний эрэлт ч ихсэж буйг шинжээчид тэмдэглэж байна. Наймдугаар сарын 11-нд унци мөнгө 39 ам.долларт хүрсэн нь хоёр сарын өмнөхөөсөө 15 орчим хувиар өссөн үзүүлэлт ажээ. Гэвч хөрөнгө оруулагчдын үнэт металлын зах зээлд үүсгэсэн хөөс хагарч мэдэхийг эдийн засагчид анхааруулж буй. Энэ оны эхний улиралд өсөлтөөрөө дэлхийг гайхуулж, сүүлийн 31 жилийн дээд цэгтээ тулаад байсан мөнгөний үнэ цэнэ хоёрдугаар улиралд навс унасан билээ. ■

Түлш, шатахуун

“Мянганы үйлдвэр” мянгуужингийн үлгэр болох уу?



Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат Тамсагаас Оргилсон газрын тосоор дээлийнхээ энгэрийг мялаасан тэр цагаас л монголчууд эх орныхоо хөрснөөс ундарч буй жаахан ч гэсэн “шингэн алт”-аа боловсруулах горьдлого сэтгэлдээ тээх болсон. Өнгөрсөн онд уг ордын улсын бүртгэлд авсан баталгаат нөөцийн хэмжээгээр манайх дэлхийн 97 орноос 39 дүгээр байрт жагссан нь горьдлогыг зорилго болгон өөрчилсөн гэлтэй. Хайгуулын ажил эрчимтэй явагдаж, үр дүн ч сайн байгаа болохоор бид удалгүй эхний

20-д багтахыг байг гэхийн аргагүй. Гэвч “Made in Mongolia” шошготой шатахуун хэрэглэх монголчуудын мөрөөдөл нэгэн мянганы босго алхсан ч бүтэшгүй мөрөөдөл хэвээр үлдэх юм биш биз?

Үйлдвэр үгүйлэх нь

ОХУ энэ оны тавдугаар сарын 1-нээс нефтийн бүтээгдэхүүний экспортоо хязгаарласнаас Монголд бензиний хомсдол нүүрлээд байхад салбарын сайд нь тахиа шарж, байдгаараа малийж зурагтаар гарсандаа баахан зэмлэл хүртэж амжсан. Ийнхүү газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь гадаадаас хангадаг, түүнийхээ 90 гаруй хувийг ганцхан хойд хөршөөсөө авдаг монголчууд бултаараа инээдмийн эмгэнэлт жүжгийн гол дүр болцгоов. Газрын хэвлийдээ “шингэн алт”-ны нөөцгүй байгаад ийм өрөвдөлтэй царай гаргаж суусан бол өөр хэрэг л дээ. Гэтэл уудам Монгол орны маань зүүн зүгт нүүрс, алт, зэс төдийгүй газрын тос багагүй хэмжээгээр агуулагдаж байгааг эхнээс нь илрүүлээд байгаа шүү дээ.

Яг нэг жилийн өмнө Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Зүүнбаян, Цагаан элсний бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд газрын тосны хайгуул, олборлолт явуулж буй “Доншен” компанийн үйл ажиллагаатай танилцсан. БНХАУ-ын хөрөнгө оруулалттай тус компанийн удирдлага цаашид 20-30 жил олборлолтын үйл ажиллагаа эрхлэх боломжтой агаад нийт 177 сая баррель түүхий тосны нөөцөөс ▶

▶ ашиглалтын баталгаат нөөц нь 40 сая хэмээн бардам өгүүлж байв. Үүний хажуугаар Эрдэс баялаг, эрчим хүчний яам Тамсагийн сав газар дахь Тосон уулын ордын баталгаат нөөцийг 119.02 сая тонн, ашиглалтын баталгаат нөөцийг 13.67 сая тонн гэж тогтоосон байдаг. “Тогтоогдсон нөөц 200 сая тонноор нэмэгдэнэ. Тэгэхээр Тамсагийн сав газраас олборлож болох нефтийн хэмжээ 23 сая тонн болох юм” хэмээн Газрын тосны газрын дарга Д.Амарсайхан өнгөрсөн сард ярьжээ. Мөн “Петро Матад” компани нөөцөө Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулчихвал албан ёсоор газрын тос олборлогч болох учиртай. Товчхондоо, Монгол Улсад өөрийн хэрэгцээгээ хангахуйц хэмжээний “шингэн алт” бий.

Үүний хажуугаар сэтгэл сэрдхийм тоонууд бас байх ажээ. Өнгөрсөн жил манай улс 864 мянган тонн нефтийн бүтээгдэхүүн импортлолсон нь 678 сая ам.доллар болсон байна. Гэтэл мөн хугацаанд бид хоёр сая 78 мянган баррель буюу дунджаар 285.5 мянган тонн түүхий нефть экспортлолсон нь 154.9 сая ам.доллар болжээ. (сурвалжлагч баррелийг тоннд шилжүүлэхдээ оросууд Urals маркийн түүхий газрын тосоо 7.28 барр/тонн хэмээн боддог аргачлалыг ашиглав. Энэ нь тухайн ордын нефтийн химийн бүтцээс шалтгаалж хэлбэлзэх учир тойм тооцоо болохыг анхаарна уу). Тоо бодъё! Өнгөрсөн жил Оросоос авсан нэг тонн нефтийн бүтээгдэхүүний ханш дунджаар 785 ам.доллар болж байгаа бол Хятад руу гаргасан түүхий нефть тонн нь ойролцоогоор 542 ам.доллараар үнэлэгджээ. Тонн тутамд 243 ам.долларын зөрүү гарч байна шүү дээ. Сүүлийн жилүүдэд манай орны нефтийн олборлолт тогтмол нэмэгдэж ирсэн бөгөөд эх орондоо дусал ч бензин үйлдвэрлэдэггүй Монгол орны экспортын гол нэрийн барааны тоонд газрын тос цохиж яваа нь сонин биш гэж үү? “Петролайн Дачин Тамсаг” компани 2010-2019 онд 93.3 сая баррель (дунджаар 12.8 сая тонн) нефть олборлох төлөвлөгөөтэй байгаа. Бид үүнийг түүхийгээр нь Хятад руу урсгасаар байх уу?

Монголбанкнаас гаргасан 2010 оны гадаад худалдааны тоймоос үзэхэд нефтийн бүтээгдэхүүн манай улсын нийт импортын 20.7 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, түлш, шатахууны үнийн хэлбэлзэл манай эдийн засагт асар ихээр нөлөөлөх чадалтай. Дэлхийн зах зээл дэх нефтийн үнэ нэг хувиар өсөхөд Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 0.1 хувиар буурна гэсэн тойм тооцоо ч байдаг. Автомашинны тоо гэрлийн хурдаар нэмэгдэж, үйлдвэрлэл эрчимжиж, барилгын ажил сэргэж, уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхэлж буйтай холбоотойгоор газрын тосны бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ талийх нь ойлгомжтой. Өнгөрсөн онд бид 864 мянган тонн нефтийн бүтээгдэхүүн импортлож хэрэглэсэн бол 2015 онд энэ хэмжээ 1.7 сая тоннд хүрнэ гэсэн тооцоог мэргэжилтнүүд гаргасан нь бий.

Маргааш...


“Сохорсон биш завшив” гэгчээр оросууд харамч зан гаргаснаас үүдэн нефть боловсруулах үйлдвэрийн талаар чихэнд чимэгтэй мэдээлэл дуулдаж эхлэх шиг. Засгийн газар “Дорнод газрын тос” гэх төрийн өмчийн оролцоотой компани байгуулах төлөвтэй. Нөгөө талаас Дархан-Уул аймагт баригдах хоёр сая тоннын хүчин чадалтай үйлдвэрийн асуудал ахиад “амилж” ирэв. Үүний хажуугаар УИХ-ын гишүүн П.Алтангэрэл, Д.Арвин, Я.Батсуурь, Н.Ганбямба нар “Газрын тосны боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” тогтоолын төслийг санаачлан Засгийн газрын хуралдаанаар оруулахад дэмжигдээд гараад ирэх жишээтэй. Энэ мэт мэдээллээс үзэхэд монголчуудын

мөрөөдөл мөдхөн биелчих юм шиг. Гэхдээ түлш, шатахуунтай холбоотой асуудал нийгмийг бухимдуулах бүрт төр, засгийн эрхмүүд худлаа үнэн яриагаар аргалаад өнгөрсөн тохиолдол нэг бус байгааг сануулах нь зүйтэй болов уу.

2008 оны зун бензиний үнэ тэнгэрт хадах үед манайд энэ асуудал хүчтэй босож ирсэн дээ. Германчууд нүүрснээс шингэн түлш нэрэх тухай төсөл танилцуулж олны анхаарлыг татаад л... “Монголсэкию” компанийн захирал, академич Т.Намжим төслийнхөө ТЭЗҮ-ийг боловсруулсан Японы “Тоёо инженеринг” корпорацийн дэд ерөнхийлөгч М.Казахисаг дэргэдээ зогсоочихоод, “Үйлдвэрээ 2012 онд ашиглалтад оруулна” хэмээн сэтгүүлчдэд ярьж байв. “2012 онд үндэсний брэнд-бензинээ хэрэглэнэ” гээд сонин хэвлэл, зурагтаар ч иргэдийг ёстой л хошхируулж өгсөн дөө. Гэтэл дэлхийн зах зээл дэх нефтийн үнэ буурангуут энэ бүхэн зүүд зэрэглээ мэт замхраад алга болсон. Тэгээд санхүү, эдийн засгийн хямрал цаашилж, газрын тосны үнэ сэргээд ирэхтэй зэрэгцэн өнгөрсөн аравдугаар сард УИХ-ын дарга Д.Дэмбэрэл академич Т.Намжимын яриад байдаг мөнөөх Дархан-Уулын төслийг гэнэт санасан юм шиг Японы “Тоёо Инженеринг” болон “Марубени” корпорацийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзав аа. Яг тэр үед Ерөнхий сайд С.Батболд 2014 он гэхэд Сайншандад газрын тос боловсруулах үйлдвэр барина хэмээн гадаадын хэвлэлүүдэд ам гарч явсан байгаа юм. Үүнээс хойш бараг бүтэн жил улирсан ч дорвитой ажил хийсэн нь нүдэнд үзэгдэж, гарт баригдахгүй байсаар бензиний хомсдолтой нүүр тулсан билээ. Тэгэхээр өнөөдөр УИХ, Засгийн газар нефтийн үйлдвэрт сүрхий анхаараад байгаа нь сурвалжлагчдыг аргадаж, иргэдээ тайвшруулах гэсэн ээлжит жүжиг байх вий гэсэн хар төрөөд буйг нуух юун.

Харин одоо улиг болсон асуултаа дахиад нэг тавья. Газрын тос боловсруулах үйлдвэр хэзээ ашиглалтад орох вэ? Уг нь 2012 он хүртэлх Засгийн газрын мөрийн хөтөлбөрт нефтийн үйлдвэртэй болох талаар тусгасан байдаг. Тэр ч дашийн шог болсон нь ойлгомжтой. Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны дэд дарга Л.Зоригтын ярьснаар бол ирэх оноос 100-300 мянган тоннын хүчин чадалтай газрын тос боловсруулах хэд хэдэн жижиг үйлдвэр байгуулж, туршиж эхлэх юм билээ. Харин Газрын тосны газрын дарга Д.Амарсайханы тайлбарласнаар зүүн аймгийг хангах жижиг үйлдвэрийг барих суурь тавьснаас 1.5 жилийн дараа л эцсийн бүтээгдэхүүн гарах боломжтой юм байна. Харин өнөөдөр тэр суурь нь ч алга. “Монголын маргааш дуусахгүй ээ” гэж... ▶

Боловсруулаагүй нефтийн экспорт (мянган баррель)



Эх сурвалж: ЭБЭХЯ

► Том-жигж, төртэй-төргүй

Үйлдвэр хэзээ ашиглалтад орох вэ гэдгээс дутахааргүй чухал асуулт бас бий. Яг ямар үйлдвэр хаана барих гээд байгаа юм бэ? Дорнод аймгийн Чойбалсан хотод газрын тос боловсруулах “Дорнод газрын тос” төрийн өмчийн оролцоотой компани байгуулах нь зүйтэй гэж Засгийн газар өнгөрсөн долдугаар сарын 6-нд болсон хуралдааныхаа үеэр үзэвч, компанийн хувийг эзэмших аж ахуйн нэгжийг зохих журмын дагуу сонгон шалгаруулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугар нарт даалгасан. Гэтэл эндээс бөөн хэл ам үүсээд байгаа юм. Д.Сугарын хэлснээр “Дорнод газрын тос” компани нь зүүн бүсийн гурван аймгийг шатахуунаар хангах юм гэсэн. Гэтэл 120 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулах гээд явж байгаа “Хэт” компани Дорнод аймгийн Булган суманд үйлдвэр байгуулах газраа авчихсан, ТЭЗҮ-ээ гаргачихсан, мөнөөх зүүн бүсийн гурван аймгийг нь бензинээр хангана гээд явж байгаа юм. “Бид үйлдвэрээ 24 сарын дотор ашиглалтад оруулах бөгөөд 50 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Тусгай зөвшөөрөл л өгчихвөл бүхнийг бүтээж чадна” хэмээн тус компанийн дэд захирал Б.Хүдэр-Ян учирлана. Гэтэл Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт түүнд тусгай зөвшөөрөл өгөх янзгүй.

“Өдрийн сонин”-ы өнгөрсөн зургадугаар сард зохион байгуулсан “Монголд нефть боловсруулах боломж бий юу” сэдэвт хэлэлцүүлгийг товчоноор “П.Алтангэрэл VS Д.Зоригт” гээд гарчиглачихад болмоор санагдсан. УИХ-ын гишүүн П.Алтангэрэл болохоор “Хэт” компанид тусгай зөвшөөрлийг нь өгчих, төрийн өмчийн оролцоотой компани байх шаардлагагүй гэсэн байр суурьтай байлаа. Харин Д.Зоригт сайд тэр оролцвол үйлдвэрээ байгуулахын тулд авах зээлийн хүү буурна, түүхий эдээ хөнгөлөлттэй үнээр авна гээд л Б.Хүдэр-Яныг “найрч” байгаа бололтой. Цаагуураа “Заавал төрийн өмчийн оролцоотой компани байгуулна. Тусгай зөвшөөрөл горьдсоны хэрэггүй. Хүсээд байгаа юм бол тендерт оролцоорой” хэмээн занасан шинжтэй. Энэ салбар стратегийн ач холбогдолтой учраас төр орохоос өөр аргагүй гээд л Д.Зоригт сайд тайлбарлаж гарав. Сүүлдээ хэлэлцүүлэг нь хэрүүлийн шинжтэй болоод, П.Алтангэрэл “Зах зээлийн жамаараа явж байгаа зүйлийг төр дампууруулдаг, хувийн хэвшлийнхэн чадна гээд байхад тусгай зөвшөөрлийг

нь өгөхгүй байгаагийн цаана огт өөр ашиг сонирхол байгаа” хэмээн бухимдав. Дараа нь тэрбээр “Төртэй хамтрахгүй гэхээр эрх мэдэлтнүүд нь хөдөлдөггүй муухай зүй тогтол бий болоод байна. Тиймээс ажил нь урагшилдаггүй” хэмээн гомдоллосон байх юм.

Гэхдээ “Хэт” компани тусгай зөвшөөрлөө аваад, санхүүжилтээ олоод үйлдвэрээ байгууллаа гэхэд түүхий эдээ хаанаас авах вэ? Мэдээж Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Тамсагийн сав газраас гарч буй нефтийн Монголын талд ногдох хувийг худалдаж авч таарна. Үүний тулд Засгийн газартай гэрээ хийх ёстой. Товчхондоо, Б.Хүдэр-Яны хувьд төр, засгийн эрхмүүдийг нэг бус удаа царайчлах хэрэг гарах юм.

Нөгөө талаас Д.Зоригт сайд хувийн хэвшлийнхнээс болгоомжлох нь аргагүй. Хашир хүн гэж хаширсан хүнийг хэлнэ гэдэг дээ. 2000 оноос хойш салбарын яаманд газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах талаар тавьсан 17 төсөл, санал байдаг тухай дээр дурдсан. Нэг үе бүтэх, бүтэхгүй олон компанид тусгай зөвшөөрөл өгснөөс эмх замбараагүй байдалгаарсан нь бий. Тухайлбал, 2004 онд Хятадын “Уран шаглаа” компани Зүүнбаянд стандартын шаардлага хангахгүй тоног төхөөрөмж ашиглан үйлдвэрлэл явуулж байсныг 2005 онд зогсоожээ. Төсөл нь тодорхой биш “Түгэх”, “Адэсэм”, “Азаа төвхөн”, МИС зэрэг компани газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байсныг бас цуцалсан. Түүнчлэн ОХУ-ын “Востокнефтьгаз” компани Рашаант өртөөний ойролцоо жилдээ хоёр сая тонн газрын тос боловсруулах үйлдвэр барина гэж 2006 оны зургадугаар сард тусгай зөвшөөрөл авчихаад бултчихсан. Хятадын “Монпетро-Уаншида” компани Багахангай дүүрэгт жилдээ нэг сая тонн нефть боловсруулах үйлдвэр барих тусгай зөвшөөрлөө 2007 онд авч байсан ч ажил хэрэг болгоогүй. Тэр байтугай газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлөө барьцаалан зээл авах, бусдад худалдах зэргээр ашиглах оролдлого ч гарч байсныг мэргэжилтнүүд илрүүлсэн байдаг.

Үүний хажуугаар чихэнд цэцэг ургуулсан туйлын сайхан төслүүд сонсогдсон ч яагаад ч юм бэ таг чиг. Тухайлбал, Чойр хотод жилдээ хоёр сая тонн газрын тос боловсруулах үйлдвэрийг өөрийн хөрөнгөөр байгуулаад, манай Засгийн газарт 34 хувийг нь эзэмшүүлэх санал БНСУ-ын “ENFMOC” компани гаргасан байдаг. Австрийн хөрөнгө оруулалттай дээрхийн ижил төсөл ч байдаг гэж

ярьдаг юм билээ. Эдгээрийн дундаас арай ч алга болчихдоггүй, үе үе гарч ирдэг нь мөнөөх Т.Намжимийн Дархан-Уул аймаг дахь үйлдвэр.

Өнгөрсөн зургадугаар сард ч гэсэн Японы олон улсын хамтын ажиллагааны банкны дэд ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчид ирж, Сангийн сайд, УИХ-ын дарга, Төрийн өмчийн хорооны дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргатай уулзаад, “Дархан-Уул аймаг дахь төсөл нь хоёр улсын харилцааны бэлгэ тэмдэг болно. Та нар төр, хувийн хэвшлийн оролцоотой компани хурдан байгуулчих. Бид санхүүжүүлэхэд бэлэн” гээд л, гар хуруугаа барилцаад явсан гэсэн. Гэхдээ энд ч бас “но” бий. Аль 2007 оны долдугаар сард тусгай зөвшөөрлөө авсан “Монголсэкио” компанийн төсөл яагаад бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна вэ? 600 сая ам.долларын уг төслийг Японы тал санхүүжүүлэх ч манай Засгийн газраас зээлийн баталгаа нэхээд байгаа юм. Гэтэл Сангийн яам “Өнөөгийн хуулийн орчинд ийм их хэмжээний мөнгөнд баталгаа гаргах боломжгүй” гэчихсэн байдаг. За яах вэ, Засгийн газар баталгаа гаргаад, Дархан-Уул аймагт үйлдвэр бослоо гэхэд түүхий эдээ хэрхэн базаах вэ гэдэг бас л том асуудал. Т.Намжимийн тайлбарласнаар ОХУ, Казахстанас түүхий нефть худалдаж аваад, түүнийгээ боловсруулаад Монголын хэрэгцээг хангана гэж байгаа. Тэгвэл мөнөөх бүсчилсэн байдлаар байгуулах хэд хэдэн жижиг үйлдвэр яах бол? Монгол шиг жижиг зах зээлийн хувьд энэ нь тохиромжтой шийдэл мөн үү? гээд олон асуулт хөвөрнө. Юу ч биш, Кувейтээс түүхий нефть авч, Тяньжинд боловсруулаад эх орондоо авчирна гэх мэтийн учрыг нь олоход тун бэрх төлөвлөгөө ч дуулддаг шүү дээ.

2015 оноос Монголд жилдээ нэг сая тонноос дээш хэмжээний газрын тос олборлоно гэсэн таамаглал гарсан. “Шингэн алт”-аа түүхийгээр нь Хятадад гаргачихаад, өөрсдөө өндөр үнэтэй, чанар муутай түлш, шатахуун худалдаж авахын тулд Оросыг царай алдсаар суух юм биш биз? Газрын тосны олборлолт эрчимжих нь тодорхой болсон өнөө үед төр, засгийн хүрээнд энэ салбарт баримтлах нэгдсэн бодлого үгүйлэгдэж байх шиг. Манай сайд дарга нар хэрэлдээд суух биш, хуруугаа хөдөлгөх цаг болсон нь мэдээж. Гэхдээ тал тал тийш хошуурч байгаад насны өрөнд орчих вий. Эх орондоо үйлдвэрлэсэн бензин хэрэглэнэ гэсэн монголчуудын нэгэн мянган дамжсан мөрөөдлийг мянгуужингийн үлгэр болгочихгүй л байгаасай. ■



Аян замын тэмдэглэл

Хүндлэм бишрэм Отгонтэнгэр уул

Д.Бэхээ

Тэртээх хөх уулсын дундаас нэгэн Цаст хайрхан уул бусдаас өндөрт дүнхийн харагдах. Цэлмэг тэнгэрт ямар ч үүл алга. Нарны туяа цагаан уулын оройд гялбаалан тусах нь уулыг улам сүрлэг үзэсгэлэнтэй харагдуулах аж. Миний хувьд зурагнаас л харж бишрэн хүндэлдэг тэнгэрлэг тэрхүү уулын бэлд очихоор зорьж яваа минь энэ. Бид Завхан аймгийн Отгон сумаар дайраад нэлээд бартаа саадтай замаар явсаар Отгонтэнгэр хайрханы бэлд үдэш очиход өглөөн нарнаас цэлмэгхэн байсан тэнгэрт үүл хурж, удалгүй бороо орж ширүүссэнээр хайрхан тэр чигээрээ үүлэн дунд умбав. Хангайн оргил цэгийн дэргэд ирснийг мэдрүүлэх мэт хүйтэрч, бороо орохтой зэрэгцэн манайхан ч майханаа барьж, дулаан хувцасаа давхарлан өмслөө. Гадаа лав -2-3 хэмтэй байгаа байх аа. Харин нутгийн саахалт айлын

хүүхдүүд бараг нүцгэн шахам гэрээсээ орж гарч харагдана. Тэд Цаст уулын энгэрт төрж, өссөн болохоор баргийн хүйтнийг ажрахаа байсан биз дээ.

Маргааш өглөө нь ургахын улаан наран байгаль дэлхийг гэрэлтүүлэн мандахад сэрлээ. Бөх унтжээ. Урд орой нь майхныг маань аваад хаячих шахам аашилж байсан цаг агаар нам гүм. Ямар ч үүлгүй цэлмэгхэн хөх тэнгэр, өглөөн нарны туяагаа цацруулж, Отгонтэнгэр хайрханы оройн цас цагааранхан харагдах. Монголын ард түмний буян заяаг ивээлдээ аван дүнхийх Цаст цагаан уулыг “оригоор” харах нь юутай гайхалтай вэ. Хүндлэм, бишрэм, хайрлам сэтгэл төрнө. Байгаль дэлхийтэйгээ ойр өссөн монгол хүн бүрийн сэтгэлийг соронзон мэт татах энэ л эгэлгүй уул нутгийнхны ярьдгаар үнэхээрийн амьдум болов уу. Өнгөрсөн зургадугаар сард болсон Отгонтэнгэр

уулын Төрийн тахилгын үеэр Монголын бурхан шашинтны холбооны тэргүүн хамба Д.Чойжамц “Биднийг уулын бэл доороос ирж явахад Отгонтэнгэр уул яг л амьд юм шиг санагдсан. Үүлээр биеэ нуугаад бороо зүсрээд Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүлээж авч байгааг нь харахад яг л амьд юм шиг. Ямар гайхамшигтай юм бэ. Бид л сэтгэл зүрхнээсээ тахиж чадвал энэ уул ус гэдэг чинь эзэнтэй юм байна гэдэг бодол төрж байлаа” гэжээ.

Бид ийнхүү хээрийн амт шингэсэн өглөөний цайны дээжээ ууландаа өргөөд Отгонтэнгэр дархан цаазат газрын хаалгаар орж, Хайрханы бэлд босгосон Очирваань бурханд мөргөөд цааш Отгонтэнгэрийн овоо руу чиглэлээ. Энэхүү газраар аялахад монгол хүмүүс 300, гадаад хүмүүс 3000 төгрөг төлдөг. Тус газрын байгаль хамгаалагч Ш.Батмэнд Цагаан уулын орчимд хог тарьж болохгүй, хогоо уутанд хийгээд аваад явах ёстой, идээ будааны дээжээ өргөхдөө цаастай чихрийг цааснаас нь гаргаж тавиарай, Бадархундага нууранд өргөл барьцаа хадганд боохгүй шүү. Хадгаа доорх Очирваань бурханд тавих хэрэгтэй. Мөн бие засаж болохгүй” гэдгийг хатуу анхааруулав. Ийн цааш явсаар Цаст цагаан уулд нэлээд ойртож, ▶



Очирваань бурхан

“Мэлхий хад” нэртэй газрын орчимд машинаа тавиад хоёр км орчим өгсүүр бас шалбааг намаг, чулуу ихтэй газраар явж овоонд хүрэв. Өнгөрсөн зургадугаар сард Отгонтэнгэр уулыг тахих Төрийн тахилга хэдийнэ болоод өнгөрсөн ч бид өөрсдийнхөө хэмжээнд сүсэгт уулыг тахисан юм. Манай гэр бүлийн найз лам С.Отгонбүрэн маань арц хүжээ гаргаж тавиад, ууланд хүндлэл үзүүлэн уулын лус савдгийг тахисан номнууд уншлаа. Манайхан ч идээ будаагаа өргөж, гэр бүл, ах дүү, хамаатан садан, найз нөхөд болон ажил төрлөө даатгаж, эрүүл энх, амжилт бүтээлийн ерөөлийг сүүн цацлын хамт өргөв. Үүний дараа Цагаан уулын яг урд хормойд байх Бадархундага нуур руу эрчүүд маань өргөл барьцаа аваад явлаа. Нууранд хүрэхэд мөн л тийм ч амар бус замаар талдаа нэг цаг гаруй алхдаг гэнэ. Нутгийнхны заншлаар эмэгтэйчүүд нуурыг зүглэдэггүй бөгөөд эрчүүд нь нууранд очиж, өргөл барьцаа өргөж хүндэтгэл үзүүлдэг юм байна. Зарим тохиолдолд эмэгтэй хүмүүс нууранд оччихсон явж байдаг гэнэ. Ёс заншил бол ёс заншил. Отгонтэнгэр дархан цаазат газрын хамгаалагчаар 18 жил ажилласан Ш.Батмэндийн эхнэр Бадархундага нуур руу нэг алхаж ч үзээгүй гэсэн шүү.

Бадархундага нуур бол хөлгүй их усан мандал аж. Монголчууд эртнээс тус нууранд хамгийн үнэтэй цайтай мөнгөн ембүү, мөнгөн аяга гэх мэт зүйлсийг өргөсөөр иржээ. Харин өнөө жилээс байгаль орчныг хамгаалах асуудлын хүрээнд нууранд хадаг өргөхийг хориглосон байна. Мөнгөн аяганы оронд мөнгөө цулаар нь өргөх нь байгаль орчинд илүү хүндлэлтэй тусгах тухайд ч ярих болжээ.

Эрчүүд маань хоёр цаг гаруйн дараа эргэж ирснээр Цагаан ууланд хүндлэл үзүүлэх бидний ажиллагаа дуусч, ургах нарнаар гарсан манай аяллын багийнхан үд орчимд майхан дээрээ эргэж ирсэн билээ.

Отгонтэнгэр уул руу явах замд жуулчны бааз бий. Тус бааз өмнөх

жилүүдэд бүр дархан цаазат газрын бүс дотор байрлаж байсан бөгөөд ирж очсон хүмүүсийн архидалтын газар болж хувирсан учраас холбогдох байгууллагаас жуулчны баазыг дархан цаазат бүсээс нэлээд хол буулгасан байна. Ер нь Цагаан ууланд хүндлэл үзүүлэхээр очсон хүмүүс, цагаан хоол идэж, сайн сайхан бүхнийг бодож, сайн үйл хийвэл, Отгонтэнгэр хайрхан буян хишгээ харамгүй хайрладаг гэнэ. Энэхүү том газрын хамгаалагчаар нэг л хүн ажилладаг. Ганц хүнд хэтэрхий ахадсан ажлыг Ш.Батмэнд чадах ядахаараа хийж, хайрхан уулаа хамгаалсаар яваа. Шөнө дунд буугаа үүрээд хулгайчидтай тэмцэх нь энүүхэнд. Дархан цаазат газрын ан амьтныг агнаж, нүгэл үйлдэгсэд бишгүй байдаг байна.



Очирваань бурхан

Ингээд Хайрхан уулынхаа бэлд нутаглаж, өглөө бүр цайны дээжээ өргөж, тус бүс нутгийг хамгаалсаар ирсэн Отгонтэнгэр дархан цаазат газрын байгаль хамгаалагч Ш.Батмэндийн эхнэр О.Даваатай цөөн хором хөөрөлдсөн юм.

-Отгонтэнгэр уулын энэ жилийн Төрийн тахилга ямар болов? Нутгийнхан манай уул тэр хүнийг хүлээж авсан, аваагүй гэж ярих юм. Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчийг хүлээж авсан уу?

-Цагаан уул маань хүссэн бүхэнд зулайгаа харуулаад байдаггүй юм ш дээ. Зарим хүнийг ирэхээр тэнгэрт бүртгэх ч үүлгүй байснаа л гэнэт үүлээр оройгоо нууцихдаг юм. Зарим хүнд болохоор гэнэт үүлээ хөөгөөд л зулайгаа харуулна. Энэ жилийн Төрийн тахилга сайхан болсон. Цагаан уул Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчийг хүлээж авлаа гэж нутгийнхан ярьж байна. Тахилгын үеэр бороо хуртай, үүлтэй байсан ч холоос ирсэн хүмүүст буурал тэргүүтнээ харуулаад сүсэг бишрэл дагуулсан. Зохион байгуулалт ч сайтай, хог новш бага тарьсан тахилга болсон. Энэ жилийн тахилгад 1800 гаруй машин

7000 гаруй хүн ирсэн гэсэн. Тэгвэл 2007 оны Төрийн тахилгаар дээрх тоог хэд дахин нугалсан хүн, машин ирснээс их хэцүү болж билээ. Хүн, машины зуд болсноос ч тэр үү өнгөрсөн жилийг хүртэл манай нутагт байнгын зуд, ган гачиг болж, улаан шуурга тавьж, олон ч айл малгүй болсон доо. Харин өнгөрсөн жил манай аймгаас төрсөн Жалханз хутагт Ч.Эрдэнэчулуун нутагтаа ирж, уулыг тахиснаар бороо орж, ган гачиг тайлагдаад иргэдийн магнай тэнийж сайхан жилүүд тохиож байна. 2007 оны тахилгаар энэ хөндий дүүрэн хог новшоор дүүрч, байгаль дэлхийг тахих бус бараг л сүйтгэж хаяад явсан. Тэгээд манай нөхөр Улаанбаатар хотоос ирсэн албаны хүмүүст хэлж ярьсаар өнөө жилийн Төрийн тахилгыг байгаль орчныг хамгаалах талаас бодож зохион байгуулсан байх аа.

-Хүн их ирдэг үү?

-Ууландаа мөргөхөөр зөвхөн завханчууд бус УИХ-ын гишүүд, сайд дарга нар, бизнесмэнүүд бусад аймгийн иргэд гээд л хүмүүсийн хөл зундаа ер тасардаггүй. Жуулчид ч их ирдэг. Зарим жуулчин зураг авах гээд долоо хононо. Манай уул ер оройгоо харуулахгүй шүү дээ. Тэгээд жуулчид хүлээж ядаад явангуут нь тэнгэр цэлмэчихдэг, их сонин ш дээ. Гэхдээ жуулчид их сайн хүмүүс. Хог тарьдаггүй, харин ч монголчуудын тарьсан хогийг түүгээд байгаль орчныг цэвэрлээд явдаг юм.

Отгонтэнгэр уулын тухай

Хойд мөсөн далай, Атлант, Энэтхэгийн далайнуудыг 200 сая жилийн, Гималайн нурууг 30-аад сая жилийн өмнө үүсэн бий болсон гэж үздэг бол Хангайн нурууны ноён оргил, Отгонтэнгэр “Богд Очирваань” нь дэлхий анх галав юүлсэн усан далайгаар бүрхэгдсэн үед буюу гурван тэрбум жилийн өмнө усан доороос цухайснаар Монголд анх эх газар үүссэн гэдэг. Ертөнцийн эх газрын анхдагч ч гэж үздэг билээ. Халх Монголыг даасан бурхныг Очирваань



Отгонтэнгэр уулын овоо

► хэмээнэ. Отгонтэнгэр хэмээх нэр нь түрэг, монгол хэлний дундынх гэгдэх “Отхан” буюу “Галын хаан, голомт сахигч”, монгол хэлний эртний үгийн санд “Этүгэн” буюу “Анхны эх газар” хэмээсэн унаган монгол үг ажээ. Монголчууд энэ уулыг эртнээс тахиж, “Сүмбэр уул”, “Очирваань хайрхан”, “Цаст цагаан уул”, “Отгонтэнгэр”, “Этүгэн уул” хэмээн нэрлэж, цай идээний дээжийг өргөж ирсэн түүхтэй. Монголчуудын хувьд хүрээлэн буй нутаг ус, байгалийн нөхцөл нь ихээхэн үүрэгтэй байсны дээр байгалийн хүчин зүйл, хүний хувь тавилан хоёрын харилцан шүтэлцээг далдын холбоогоор тайлбарлан, тахиж шүтсээр иржээ. Монголын түүхэн сурвалжуудад тэмдэглэснээр одоогоос 230 гаруй жилийн тэртээ буюу 1779 онд Богд-Очирваань хайрханыг тахиснаас хойш жил бүрийн зуны дэлгэр цагт тахиж байхыг зарлигдсан байдаг юм билээ.

Хангайн нурууны ноён оргил мөнх цаст Отгонтэнгэр уул нь Завхан аймгийн Алдархаан, Отгон сумдын нутагт 4031 м өндөрт оршино. Отгонтэнгэрийг тойрсон 108 төрлийн халуун, хүйтэн рашаан, 108 булаг шанд, нуур, цөөрөмтэй. Мөн 108 гол горхи эх авч, эргэн тойрондоо Их, Бага Богд Мандалт Даян, Их мянган, Хатан бэйл, Дуут нуур, өвөр Бадархундага, Мөнгөт цохио, Гэрэлт ам зэрэг байгалийн үзэмжит сайхан тогтоц бүрдсэн. Зуны цагт 2000 метрээс доош бороо, 2000 метрээс дээш цас ялгаран буудаг. Энэ уулын эх бие орчноор мөнх ногоон арц, вансэмбэрүү, ванжингарав, юмдүүжин, чихэр өвс, цэнхэр, шар дэгд, согоон сүмэн, алтан гагнуур, зэрэг 400-гаад эмийн ургамалтай. Урд өврийн Бадархундага нуур 1000 орчим метрийн өндөрт байрладаг. Отгонтэнгэр уулын ам жалга бүрээс олон зуун гол ундрэн урсах бөгөөд хамгийн том нь уулын ар талаас Идэрийн гол эх авч, хойд мөсөн далайн ай савд, өвөр талаас Завхан, Буянт голууд эх авч, Их нууруудын хотгорын ай савд усаа нийлүүлэн цутгадаг. Уулын орчим бүхэлдээ эртний сөнөсөн галт уулын үлдэгдэл болон асар өндөр, эгц, цавчим хад байц бүхий гүдгэр, хотгор, хавцал, мөсөн голын ул мөр элбэг тохиолдох бөгөөд байгалийн өвөрмөц нэн сонин тогтоцтой.

Монгол түмний сүр сүсгийн дээд энэ их оргилд буга согоо, ирвэс, шилүүс, хойлог, ховор шувуу, ан амьтад нутагшин байдаг. Богд Очирваань уулын мөнх ногоон арц, халуун, хүйтэн рашаан хэдийнэ алдаршсан билээ. ■

Ишлэл

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн Отгонтэнгэр уулын Төрийн тахилгын үеэр хэлсэн үгнээс

...Монгол түмний эртнээс үйлдэж ирсэн уулын тэнгэр тахиж ёслол нь манай ард түмний орчлон ертөнцийн гүнзгий, далд чанадын зүй тогтол, жам ёсыг танин барьж, ухааран ойлгож, улмаар түүнд аж амьдрал, ахуй нөхцөлөө зохицуулж ирсэн гүн ухаан, ёс жудаг, заншил бэлгэдлийн цогц үйлдэл билээ. Эрдэнэт хүмүүний сэтгэл ухаанаар хандаж чадвал эцэг тэнгэр, эх дэлхий ээл ивээлээ хайрлана, эс тэгвэл ширвэж шийтгэнэ. Хүн байгалийн хүйн холбоо, шүтэн барилдлагын оньс аньс нь энэ билээ. Өнө эртнээс үүнийг ухааран ойлгосон өвөг дээдэс минь эцэг тэнгэрээ сүслэж, эх байгалиа хамгаалж, мянга мянган жилээр орчлон ертөнц, орон дэлхийтэйгээ зохицон аж төрсөөр өнөөг хүрч иржээ. Энэ бол хүн байгалийн харилцааны гүн утгыг таниулсан аугаа ухаан бөгөөд хүн төрөлхтөний оюун сэтгэлгээнд оруулсан монгол түмний бахархам хувь нэмэр болой. Эдүгээгийн хэлээр бол биет бус соёлын өв бөгөөд бид бүхэн цаашид эзэмшиж, эзэн болж явах ёстой. Монголоор овоглосон оюуны өв соёл байх учиртай.

Түүнчлэн тахилгын ёслолтой холбогдуулан хүүхэд залуучуудад үндэсний соёл, түүх уламжлал, ёс заншил, нутаг усны тахилгат хайрхан, уул овооны талаар мэдлэг олгох, байгаль хамгаалал, экологийн боловсролыг сурталчлан дэлгэрүүлэх ажлыг орон нутагтаа өргөнөөр зохион байгуулах нь зүйтэй...

Монголын бурхан шашинтны холбооны тэргүүн хамба гавж, Д.Чойжамцын хэлсэн үгнээс

...“Сүсэгтэн олон маань энэ сайхан уулаа тахихдаа бие сэтгэл хэл гурвын үйлийг хамгийн түрүүнд сахих ёстой. Шинэ сайхан монгол дээлтэй хүмүүс олон харагдаж байна. Энэ бол биеийн үйл мөн юм. Энэ сайхан газарт муу муухай зүйл ярихгүй, дандаа билэг дэмбэрэлтэй зөөлөн сайхан зүйл ярьж эвсэг найрсаг сэтгэлдээ сайхан бүхнийг бодож байх ёстой. Энэ сайхан газартаа ирсэн та бүхэн өөрийнхөө болон хамаатан садангийнхаа өмнөөс мөргөл залбирлаа сайн үйлдэх ёстой хамгийн түрүүнд урт удаан наслахыг хүсэх хэрэгтэй дараа нь өвчингүй байхыг тэгээд барцадгүй мэнд суухыг хамгийн сүүлд эд хөрөнгөтэй байлгахыг хүсдэг юм шүү. Архигүй тахилга бол их сайхан үйл юм. Мөн тахилгын хоёр өдөр цагаан хоолтон байна гэдэг бол бас их сайхан сэтгэл, үйл юм.

Сэргээгдэх эрчим хүч

Нар дэлхий хоёр

Д.Зоригт

Өнөөдөр дэлхийн хөгжлийг хөдөлгөгч хамгийн томоохон хүчин зүйлийн нэг бол яах аргагүй эрчим хүч билээ. Эрчим хүч өдгөө хүн бүрийн идэх хоол, унтах нойр шиг өдөр тутмын зайлшгүй хэрэглээ болсон. Энэ утгаараа гаднын олон орон эрчим хүчний салбараа тэр дундаа байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчийг түлхүү дэмжиж, хурдтай хөгжүүлж байна. Манай сэтгүүл энэ удаа дэлхий нийтийн хошуурч байгаа сэргээгдэх эрчим хүчний нэг болох нарны тухай бичиж байна.

Дэлхий нийт байгальд ээлтэй эрчим хүчийг хэрхэн гаргаж авах талаар толгойгоо гашиглаж байсан цаг саяхан. Харин өнөөдөр олон улс сэргээгдэх, байгалийн гаралтай эрчим

хүчийг хэдийнэ ашиглаж эхлээд байна. Олон улсын эрчим хүчний агентлагаас гаргасан судалгаагаар 2050 он гэхэд дэлхийн эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 50-иас доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан гаргах гэнэ. Үүний багагүй хувийг нарны дулааны станцыг ашиглан үйлдвэрлэнэ гэж үзэж буй.

Дэлхийн хэмжээнд одоогоор нарны эрчим хүчний хэрэгцээний 80 хувийг Герман, Чех, Итали, Япон, Америк гэсэн таван улс хангадаг байна. 2010 оны байдлаар гаргасан судалгаагаар нарны эрчим хүч ашигладаг дэлхийн шилдэг 10 орноор доорх улсууд шалгарчээ.

Харин сүүлийн хэдэн жилд БНХАУ ►



энэ салбарт хүчээ зузаатгаж байна. Хятад улс нарны эрчим хүчээр дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй гаднын орнуудад экспортлох боломжтой. Судлаачдын үзэж байгаагаар ирэх таван жилд Хятад нарны эрчим хүчний томоохон өрсөлдөгч болох магадлал өндөр харагдаж байгаа аж. 2015 он гэхэд манай урд хөрш АНУ-г энэ төрлийн эрчим хүчний салбарт гүйцэж магадгүй гэсэн таамгийг салбарын шинжээчид дэвшүүлсэн. БНХАУ сэргээгдэх эрчим хүчний салбараа идэвхтэй дэмжиж байгаа нь үр дүнгээ өгч, энэ нь тэднийг дэлхийн хэмжээнд уг салбарт өрсөлдөхүйц чадвартай болгож байгаа гэж судлаачид дүгнэжээ.

Монгол Улс ч мөн адил нарны эрчим хүчийг ашиглаж эхлээд байгаа билээ. Төр, засгаас авч хэрэгжүүлж буй бодлогын хувьд “100 000 нарны гэрэл” хөтөлбөрийг хэрэгжүүлээд дуусах шатандаа явж байна. Өнөөдрийн байдлаар манай 100 мянга гаруй малчин өрх нарны эрчим хүч ашиглан цахилгаантай болсон. “100 000 нарны гэрэл” төслийн хэрэгжилтийн хүрээг ЭБЭХЯ-ны сайд Д.Зоригт хоёр том үе шаттайгаар дүгнэн үзжээ. Үүнд “2000-2008 он. Энэ үед эрчим хүчний салбарт өөрчлөлт шинэчлэлт хийж, улс орныг цахилгаанжуулах төрийн бодлого хэрэгжиж, малчин айл өрхүүд бага оврын нарны эрчим хүчний эх үүсвэрүүдээр хангагдсан цахилгаанжуулалтын үе байсан”.

“2008-2011 оны үе. Энэ онуудад эрчим хүчний системийн найдваржилтыг хангах зорилгын үүднээс тоног төхөөрөмж технологийн өргөтгөл шинэчлэлийг хэрэгжүүлсэн үе” гэж тус тус авч үзжээ. 2004 оноос хойш хэрэгжиж эхлээд байгаа уг төсөл нь 2011-2012 оны хооронд 20 мянган нарны эрчим хүчний үүсгүүрийг хэрэглэгчдэд хүргэснээр бүрэн хэрэгжиж дуусах гэнэ. Энэ жилийн хувьд төсөлд хамрагдаагүй малчид 285 мянган төгрөгийн үнээр өндөр хүчин чадалтай нарны цахилгаан үүсгүүр худалдан авах боломжтой. Уг нарны цахилгаан үүсгүүрийг дэлхийд тухайн салбартаа хүчтэй өрсөлдөгчдийн нэг БНХАУ-ын “Wu xi Sentech power” компаниас оруулан ирж байгаа бөгөөд энэ цахилгаан үүсгүүр нь нэг жилийн баталгаатай борлуулагдаж буй аж.

Манай орны хувьд хөгжингүй орнуудаас нарнаас эрчим хүч гаргаж авах тал дээр хоцрогдолтой байгаа ч “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв”-ийн (СЭХҮТ) ерөнхий инженер А.Эрдэнэбаатарын хэлснээр хэлжиж буй орны хувьд боломжийн түвшинд байдаг гэнэ. Ахуйн жижиг хэрэглээний түвшинд манай орон 170 мянган малчин өрхийн 140 гаруй мянга нь нарны гэрлийн цахилгаан үүсгүүр ашиглаж байна. Арай томхон 0.5-10 кВт-ын нарны цахилгаан үүсгүүрийг Монгол орны газар нутгийг үндсэнд нь хамарсан үүрэн холбооны оператор компаниудын тэжээл, холбооны

салбарууд, цэргийн анги, застав, телевизийн дахин дамжуулах станцууд, баг, сум суурин газруудын цахилгаанд өргөн ашигладаг. Үүнээс дээш хүчин чадалтай станцуудыг алслагдсан сумдын цахилгаан хангамжийг шийдвэрлэхэд ашигладаг байна.

Одоогоор манай улсад найман нарны цахилгаан станц үйл ажиллагаа явуулдаг. Нарнаас цахилгаан эрчим хүч гаргаж авах тал дээр манай улс тийм ч хангалттай биш ч багагүй арга хэмжээ аваад байгаа аж. Харин нарнаас дулаан гаргаж авах талд маш бага анхаарч байна. А.Эрдэнэбаатар хэлэхдээ “Энэ чиглэлээр манай орон бараг анхаардаггүй. Үнэндээ нарны нөөцийг олон хувилбараар дулааны эх үүсвэрт ашиглаж болно. Тухайлбал, нарны халуун ус, нарны хатаагуур, нарны тогоо гэх мэтээр олон хэрэглээ байна. Тэгвэл ахуйн дулаан хангамжид нарны эрчим хүчийг яаж ашиглах вэ. Энэ бол ойрын жилүүдэд Монгол оронд хамгийн их хөгжих ёстой чиглэл байх болно” гэсэн юм.

Өнөөдөр төрөөс ямар ч төлөвлөлтгүй суурьшсан гэр хороололд иймэрхүү арга хэмжээ авахад ихээхэн хүндрэл учрах нь дамжиггүй. Энэ асуудлыг шийдвэрлэх хамгийн хялбар аргын нэг бол нарны энергис дулаан гаргаж авах юм. Нарнаас маш энгийн, авсаархан, ашиглахад хялбар төхөөрөмжөөр дулаан гаргаж авах боломжтой бөгөөд томоохон давуу талуудтай. Жишээ нь: харьцангуй хямд, цаг уурын ямар ч нөхцөлд найдвартай ажиллаж болдог

-Түлшний зардал байхгүй

-Дуу чимээ багатай, хэрэглэхэд авсаархан

-Бие даасан байдаг. Маш олон хэрэглэгч тодорхой сүлжээнээс хараат бус байдлаар дулааныг гаргаж авах боломжтой болно.

-Байгаль экологид хор хөнөөлгүй зэрэг нарны эрчим хүчний техник технологи нь давуу талыг бий болгодог. Сэргээгдэх эрчим хүчний салбарт томоохон байр суурь эзэлдэг нарыг ашигласнаар манай орны хувьд тулгамдаад байгаа олон асуудлаа шийдэж чадна.

Хүн амын өсөлт, бүтээн байгуулалтын эрчим хүчний нэмэлт хэрэгцээ, уул уурхайн эрчим хүчний хангамжийн асуудлуудыг яаралтай шийдвэрлэх зэрэг эрчим хүч тойрсон цөөнгүй асуудал тулгамдаад байна. Бид дотоодынхоо эрчим хүчний хэрэгцээг хангаж чадахгүй хойд хөршөөсөө импортоор эрчим хүч оруулж ирэхэд хүрдэг. Хэдийгээр шинэ эх үүсвэр байгуулах тухай яригдаж байгаа ч манайх эрчим хүчний ноцтой дутагдалд орж болзошгүй. Хэрвээ бид эрчим хүчнийхээ тодорхой хувийг хот, хөдөө гэлтгүй нарнаас авдаг болчихвол үр дүнгээ өгөх нь дамжиггүй. Ийм үед сэргээгдэх эрчим хүчний талаар төрийн түшээд маань гойд анхаарч үзээсэй. Цаана чинь дэлхий нийт сэргээгдэх эрчим хүчний салбарын зүг хошуурч байна. ■





Банкир

“Манай банкууд эрсдэлээ зөв удирдах аргыг номноос бус, жинхэнэ амьдралаараа туулсан”

И.Отгонжаргал

Монгол Улсыг гадна дотнынхон үсрэнгүй хөгжлийн гараан дээр байна гэж тодорхойлдог болсон. Тиймээс улс орны хөгжилд түлхэц өгөх гол хүчин зүйлсийн нэг болох банк санхүү, хөрөнгийн зах зээлийн асуудлаар “Хас” банкны гүйцэтгэх захирал Д.Бат-Очиртой ярилцаж санаа бодлыг нь сонирхлоо.

-Уул уурхайгаас орж ирэх их мөнгөнд Монголын банк санхүүгийн салбар бэлэн байгаа юу?

-Уул уурхайн хөгжил тойрсон асуудлууд ялангуяа сүүлийн гурван жилд хүчтэй яригдаж байна. Манай Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжээд 20 жилийн нүүр үзэж байна. Хүнээр бодвол дөнгөж 20 настай залуу л гэсэн үг. 20 настай залууд юу юу ч байхгүй л байдаг. Санхүүгийн зуучлалыг илүү мэргэжлийн түвшинд хийж байгаа нь өнөөдрийн байдлаар арилжааны банкууд л байна. Уул уурхайн хөгжлийг дагаад иргэдийн орлого ч нэмэгдэнэ. Тэр орлого санхүүгийн зуучлалаар дамжаад тодорхой хэсэг нь хэрэглээнд, тодорхой хэсэг нь хөрөнгө оруулалтад орж байхгүй бол буцаад эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх мөнгөний урсгал яваад ирлээ шүү дээ. Тэр утгаараа хариуцлага маш өндөр байгаа.

Банкууд үүнд бэлэн байна уу гэдэг дээр хүссэн хэмжээнд бэлэн байж чадахгүй байгаа гэж хэлнэ. Орж ирж байгаа мөнгөний урсгал,

банкуудын өөрсдийн үүрэг, шаардлага, хариуцлагатай байдал, Монгол Улсын өөрийн орчин бэлэн биш байна. Эдгээр нь шийдэж болохгүй бэрхшээл бол биш гэж үзэж байгаа. Монголын арилжааны банкууд 1998 оноос хойш 2-3 дампуурлыг үзчихлээ. Олон нийт ч банкны талаар юуг нь анхаарах вэ? юу нь чухал, юу нь чухал биш вэ? гэдгийг мэддэг болсон. Хөрөнгө оруулагчид ч гэсэн банк гэдэг зүгээр мөнгө хүүлдэг, амархан бизнес биш юм байна гэдгийг ухамсарлаад эхэлсэн. Цаашдаа мэдээж эдийн засаг жижиг зээл дээр босох боломж байхгүй. Дунд зээл дээр нь бид ДНБ давхар оронтой тоогоор өснө гэж ярьж байгаа бол одоо байгаа 100 том аж ахуй нэгж ч тэрхүү өсөлтийг үйлдвэрлэж дийлэхгүй гэж бодож байгаа. Тэгэхээр дахиад 200, 300 дунд аж ахуйн нэгж бий болж байж энэ их орж ирж байгаа хөрөнгө оруулалтыг шингээнэ. Уул уурхайг дагасан үйлчилгээний салбарууд өргөжиж ёстой. Тэдгээр хүмүүс рүү “Хас” банк үйл ажиллагаагаа түлхүү чиглүүлье гэсэн бодлоготой байгаа л даа.

-Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилтэй холбоотой нэг хэсэг хүн арилжааны банкны хөгжил, хөрөнгийн зах зээлийн хөгжил тусдаа явах ёстой гэж үзэж байхад нөгөө хэсэг нь хамтдаа л хөгжих ёстой гэж зүтгэж байна. Таны хувьд мэргэжлийн хүний нүдээр харахад аль нь зөв вэ?

- 52 Бид ажилгүйчүүдийн эгнээнээс гарч чадсан!
- 55 Гадаадад гайхагдсан монгол чадвар
- 56 Хонгилын үзүүрт сүүмэлзэх бүдэг гэрэл
- 58 Та ямар ном уншиж байна вэ?
- 59 Бизнес эрхэлж буй хүний хувьд хамгийн чухал 20 асуулт
- 60 Стресс гэж юу вэ?

-Аль аль нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд оролцох ёстой. Гэхдээ тус тусынх нь хийдэг зүйл маш сайн тусгаарлагдсан байх хэрэгтэй. Арилжааны банк санхүүгийн зуучлалыг илүү консерватив байдлаар хийдэг. Хөрөнгийн бирж гэдэг арай өөр эрсдэлийн мэдрэмжтэй, өөр эрсдэл хүлээхэд бэлэн байгаа мөнгөний урсгалыг зуучилдаг зах зээл л дээ.

-Сүүлийн үед брокер диллерийн үйл ажиллагаа эрхлэх компанийн тоо эрс нэмэгдэж байгаа. Гэхдээ брокерийн үйлчилгээ эрхлэгчид ёс зүйн доголдолтой байгааг Та юу гэж үзэж байна вэ?

-Хүнд хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх гэж байгаа бол өөрсдөө ёс зүйтэй байх ёстой л доо. Хөрөнгөө оруулсан л бол би өөрөө хариуцлага хүлээнэ гэдэг асуудал манайд харамсалтай нь байхгүй. Биржийг тойроод ажилладаг хөрөнгө оруулалтын сан, брокерийн пүүсийн үүрэг хариуцлага нь тодорхой, тэгээд мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан байж гэмээнэ хөрөнгийн зах зээл хөгжинө. Монголын газрын хэвлийд асар их баялаг байна. Тэнд хөрөнгө оруулж ирэхийн тулд зуучлал хэрэгтэй. Зуучлал гэдэг дундаас нь нэг хувь, 0.5 хувь авна. Дээр нь хөрөнгө оруулаадегөөж авна. Манайд брокерийн үйл ажиллагааны эрх зүйн орчин нь хатуу биш болохоор асуудалтай байна л даа. Уг нь бол асар сайхан зах зээл байгаа. Тэр болгонд банкаар дамжаад санхүүжилт авах гэхээр банк хүссэн хүсээгүй консерватив байх ёстой. Тэр утгаараа банк нэлээд найдвартай юманд зээл өгөхөөс өөр аргагүй болдог. Тэгэхээр хүмүүс банк хүнд сурталтай гэж бухимдах нь бий. Тиймээс Хөрөнгө оруулалтын сангууд байх ёстой. Жишээ авъя л даа. Энд нэг хүн 100 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд алдахад ардаа алдсантайгаа ▶

► адил хэмжээний мөнгөтэй хүн байх юм. Холбогдох санхүүгийн зуучлалын байгууллагууд өөрсдийн түвшинд үнэлгээ хийгээд Та ийм эрсдэл хүлээж байгаа шүү, ийм эрсдэл хүлээж авах уу? “тийм”, зурлаа. Тэгээд банкаар дамжихгүй, хөрөнгө оруулалтын сан, брокерийн пүүс, хөрөнгө оруулалтын компаниудаар дамжуулаад хөрөнгөө босгоод авна. Үүнийг манай зарим банк хийх гэж байгаа л даа. Хийсэн тохиолдолд хадгаламж төвлөрүүлээд зуучилдаг үйл ажиллагаанаасаа тусдаа л явах ёстой.

-Та нэг толгойтой байж болно, харин үйл ажиллагаа нь тусдаа байх ёстой гэж үзэж байна уу?

-Тийм ээ, хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагааг толгой компанийн дор хийж болох авч “Хас” банк дотроо тийм эрсдэлтэй хөрөнгө оруулалтын зуучлалыг хийж болохгүй.

-Хөрөнгө оруулалтын банк, бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ эрхэлдэг компани зэрэг санхүүгийн шинэ байгууллага Монголд бий болох боломж нөхцөл нь хэр байгаа вэ?

-Хөрөнгө оруулалтын банк Монголд асар хэрэгцээтэй. Яагаад гэвэл олон сайхан санаатай залуучууд байгаа тухай та бид хоёр дээр ярилаа ш дээ. Банкин дээр очихоор тэдний сайхан санааг санхүүжүүлж чаддаггүй. Хэдийгээр би хувь хүнийхээ хувьд тэр сайхан санааг дэмжиж байсан ч банк гэдэг байгууллагын хийх ёстой чиглэл нь тэр биш гэдэг утгаараа. Банк юу санхүүжүүлдэг вэ? Шинэ сайн төслүүдийг юу санхүүжүүлдэг вэ гэхээр дараагийн санхүүгийн зуучлагчийн хэрэгцээ гараад байгаа юм л даа. Тэр утгаараа хөрөнгө оруулалтын банкны хэрэгцээ их байгаа.

Менежментийн зөвлөгөө өгөх үйлчилгээ манайд хэдийгээр шаардлагатай байгаа ч тийм чадвартай хүн одоогоор байхгүй байна. Монголд орчин нь шал өөр учраас гаднын зөвлөхүүд энд ирээд үр дүнтэй зөвлөж чаддаггүй. Монголчууд тэдэнд ам сайтай биш байдаг. Өндөр цалин авч байгаад, юу ч хийлгүй явчихлаа гээд. Тэр гаднын зөвлөхийн буруу биш, харин манайд тэдний үйлчилгээг хүлээн авах түвшин тэр хэмжээнд байхгүй. Зохицуулалтын орчин нь байхгүй байдаг.

-Та банкны үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах хэрэгтэй байна гэж ярьсан. “Хас” банкны хувьд ойрын хугацаанд ямар ажил хийхийг зорьж байна вэ?

-Цаашдаа бид үйл ажиллагаагаа нэлээд өргөжүүлэх зорилт тавьсан байгаа. Өргөжихийн тулд хамгийн түрүүнд юу хийх ёстой байдаг вэ гэхээр чадавхиа бүрдүүлэх ёстой. Тэр

дотроо эрсдэлийн удирдлага дээрээ нэлээд анхаарал тавьж байгаа. Нөгөө талаар салбарын тоогоо нэмэгдүлээд, Монголын тархан суурьшсан иргэдэд үйлчилгээ үзүүлэх гэж зорих юм уу?, эсвэл тэртээ тэргүй хүн бүр гар утастай, интернэтэд холбогдож байна, тэр сувгаар нь банкны үйлчилгээг иргэдэд хүргэх нөхцөлөөр хангах уу? гэдэг бодож үзэх асуудал болчихоод байна. Манай банкны хувьд хоёр дахь замаар явахыг зорино. Банк санхүүгийн үйлчилгээ цаашид мэдээллийн технологи дээр суурилж хүрэхээс өөр аргагүй байгаа. Тэр чиглэлд бид илүү эрчимтэй ажиллана даа. 400 салбарыг удирдаад санхүүгийн үйлчилгээг хүргэнэ гэж оролдвол эрсдэлтэй алхам. Нэгэнт хүн бүрийг төгс сайн хүн болгож чадахгүйгээс цааш ямар нэгэн алдаа гаргаж л таарна. Тэгээд ч яваандаа Монгол Улс маань хөгжөөд хүмүүс мэдлэгт тулгуурласан орлогыг чухалчлах болов уу. Дэлхийн хаана ч очоод ажилласан чадахаар чадавхитай болчихвол хөдөлмөрийн үнэ цэнэ харьцангуй өндөр болно. Гэхдээ монгол хүн бүр боловсролтой болчихвол теллерийн түвшинд ажил хийх хүн олдохгүй байлгүй/инээв/.

-Салбар нээхээс татгалзаж, банк санхүүгийн үйлчилгээг мэдээллийн технологи ашиглаж хүргэх тухай Та ярьж байна. Гэтэл өнөөдөр манай малчид доод тал нь хоёр гар утас хэрэглэж байгаа ч дуудлага ирэхээр авдаг, буцаагаад залгадаг, зарим залуу малчид нь мессеж уншиж, бичихээс хэтрэхгүй. Өөрөөр хэлбэл, монголчуудын олонх нь банкны үйлчилгээг авах хэмжээнд хүртлээ гар утсаа эзэмшиж чадаагүй байгаа шүү дээ.

-Бэрхшээл тулгарна л даа. Утсаа ашиглаж чаддаг байсан ч гэсэн утсаар мөнгөө өгч, авалцана гэж юу байсан юм бэ? гээд итгэлцлийн асуудал юуны өмнө тавигдана. Үнэтэй цайтай юмаа өгчихөөд оронд нь утасны мессеж хүлээж авахаар малчид битгий хэл, хүнд сонин санагдана /инээв/. Аяндаа нийтээрээ хэрэглээд эхлэхээр хүмүүс хэрэглэхээс өөр аргагүй болдог зүйлүүд бий л дээ. Компьютер худалдаж авахаар хүссэн хүсээгүй хэрэглээний программ хэрэгтэй болдогтой адилхан.

Сүлжээгээ хийгээд эхлэхийн сацуу бүх нийтийн санхүүгийн боловсролыг сайжруулах талын ажлыг зэрэгцүүлээд л явах хэрэгтэй. “Энэ бол найдвартай санхүүгийн суваг шүү, энд эрсдэл байхгүй” гэдгийг таниулах ажлыг зөвхөн арилжааны банкуудаас гадна Монголбанк, бусад санхүүгийн салбарт санаа зовох хүн бүрийн оролцоо хэрэгтэй. Хэрэглэгчдийг боломжийн түвшинд очихыг хүлээгээд хэрэггүй,

юмаа хийгээд л явж байх хэрэгтэй.

-Хөгжилд өрсөлдөх чадвар чухал. Монголын банк санхүүгийн салбарын өрсөлдөх чадвар өнөөдөр ямар түвшинд байгаа гэж Та бодож байна вэ?

-Манай банк санхүүгийн салбарын өрсөлдөх чадвар харин ч харьцангуй хурдацтай явж байгаа гэж боддог. Яагаад гэвэл нүүрс ухаад зарна гэдэг шиг тодорхой зүйл биш. Хүнд үйлчлээд, үйлчилгээнийхээ орлогоор амьдардаг. Нэг талаас хадгаламж татах гэж том ажил болно. Дараа нь зээл гаргах гэж энэ хүн яах бол ийх бол гэж бөөн юм бодно. Энэ талаас нэлээд өндөр хүү өгч байж хадгаламж татна, нөгөө талд зээл хүсэгч бага хүү төлнө гэж зүтгэнэ. Тэр хоёрын зөрүүгээр явдаг. Нэлээд хэцүү орчинд үйл ажиллагаа явуулдаг болохоороо 10, 20 жил үйл ажиллагаа явуулсан манай арилжааны банкуудын хувьд орчинтойгоо зохицож сурч байгаа гэж хэлж болно. Тэгээд ч банкууд л мэдээлэл холбооны технологийг түрүүлж ашиглаж байна. Бид хүсэхгүй байлаа ч Төвбанк болон зохицуулах газруудаас үүнийг хий, хийхгүй бол үйл ажиллагаагаа хаа гэдэг хүртэл түвшинд шаардлагууд тавигдаад ирж байна шүү дээ. Нэгдүгээрт, сайн болохоос аргагүй гадаад хүчин зүйл байна. Хоёрдугаарт, манай банкуудын явсан түүх нь эрсдэлээ зөв удирдах аргыг номноос бус ёстой жинхэнэ амьдралаараа туулж өнгөрүүлсэн гэж хэлж болно.

-Гадаадад орнуудад арилжааны банкууд барьцаа хөрөнгө гэхээсээ илүүтэй сайхан төслийг нь илүүд үзэх нь байдаг гэсэн. Үүнийг манайд нэвтрүүлэхэд хэцүү юу?

-Тэр бол бүрэн боломжтой. Нэвтрэхээс ч өөр аргагүй. Тэгж л сурахгүй бол арилжааны банк эрхлэнэ гэж явахын ч хэрэг байхгүй л дээ. Тэгэхгүй бол эсвэл үл хөдлөх хөрөнгийн компани, эсвэл барьцаалан зээлдүүлэх газар ажиллуулаад явсан нь дээр байлгүй. Арилжааны банк бол илүү амьдрах чадвартай бизнесээс мөнгө олно. Дампуурчих юм бол барьцаа хөрөнгийг нь аваад зарчих юм даа гэсэн байдлаар суугаад байх юм бол байгаа газраа эргэлдэж байгаад удалгүй алга болно. Тэр утгаараа бид хичээгээд л байгаа. Гэхдээ манай банкны систем бүрэлдэж байгаа түүх маань бас нэлээд хүнд замаар явчихсан. Зээлдэгчдийн зүгээс ч банкны ажилтнууд, банкны удирдлагын зүгээс ч тохиолдож болох муу үлгэр жишээ бүхнийг үзээд, харчихсан.

-Монголын банкуудыг өөрийн хөрөнгөөр өсөж томрох боломжгүй гэдэг. Тэгвэл томрох боломж нь юу байх вэ?

-Өөрийн хөрөнгө гэдэг бол хувь ►

хүний л хөрөнгө шүү дээ. Тэгэхээр Монголд уул уурхайг биш юмаа гэхэд уул уурхайг дагасан 10 том аж ахуйн нэгжид нэлээд ахиу зээл олгочих дайны хөрөнгийг бүрдүүлэх хувь хүн байна уу, үгүй юу гэдэг өөрөө асуудал л даа. Ихэнх нь орлогоосоо илүүчлээд хадгаламж хийж байгаа хүмүүс байгаа ш дээ. Тийм болохоор дотоодоосоо хангалттай өөрийн хөрөнгийг бий болгоод банкуудыг томруулна гэхэд нэлээд хугацаа шаардана. Тэгэхээр дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтаас гадна IPO гэж ярьдаг нийтэд хувьцаагаа гаргаж зарах ажил байж болно. Дотоодын болон гадаадын зах зээл дээр IPO хийж байж хангалттай өөрийн хөрөнгийн хүрэлцээ бий болж, тэр хэмжээгээрээ банкууд том төслүүдэд удаан хугацаагаар санхүүжилт олгох боломжтой болно л доо.

“Хас” банкинд IPO хийх төлөвлөгөө байна уу?

-Бид төлөвлөснөөрөө томроод ирэх юм бол хийнэ. Одоо банкны актив 600-гаад орчим тэрбум төгрөг байна. Нэг их наядад хүрэхэд тун ойрхон байгаа. Үүнийг 4-5 дахин өсгөө гэж бодох юм бол IPO хийж л таарна. Хөрөнгийн зах зээл дээр хувьцаагаа арилжих нь томрох зүй ёсны зам.

Дэлхийн хэмжээний ХХК гэж би сонсоогүй /инээв/. Тэгэхээр бид хэр амжилттай явна, манай эдийн засгийн орчин аль хэр тааламжтай байна тэр тусмаа IPO гаргахаас аргагүй болох байх гэж бодож байна.

-Монголд компанийн засаглал гэдэг үгнээс цаашгүй байна л даа. Таний банкны хувьд үүнийг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

-Засаглалыг бид юу гэж ойлгодог вэ гэхээр шийдвэрүүд хэн нэгэн хүнээс хэт хамааралтай гарах ёсгүй гэж үздэг. Тийм орчин нөхцөл бизнесийн байгууллагад бүрдсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх засаглал нь бүх юмыг мэдээд шийдээд байх ёсгүй. Аливаа шийдвэр олон өнцгөөс шүүгдэж байж гардаг тийм орчныг бүрдүүлэх нь чухал л даа. Түүнийг бүрдүүлэхийн тулд Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн үүрэг асар өндөр. Манайд хуучин Компанийн тухай хуульд тусгасан байдаг болохоор бэлгэдлийн чанартай ТУЗ байгуулчихдаг. Гэтэл бодит утгаараа ТУЗ гүйцэтгэх захиралд ажил олгогч шүү дээ. Гүйцэтгэх захирал нэгдүгээр хүн, бусад нь бэлгэдлийнх гэдэг байдлаар хандаж болохгүй.

-Та банкир хүний хувьд Монгол Улсынхаа хөгжлийн ирээдүйг хэрхэн харж байна вэ. Хөгжих боломжтой хэрнээ хөгжихгүй байгаа нь юутай холбоотой санагддаг вэ?

-Хөгжихгүй байгаа гол шалтгаан хуучин юмандаа хэт баригдаад ч юм уу

байна л даа. Хүний амьдралын мөчлөг 12 жил байдаг ш дээ. Тэгэхээр 12 жил дотроо янз янзын хүмүүс солигдоод, хуучны туршлага дээр үндэслэж шийдвэр гаргадаг биш, ирээдүйд юу хэрэгтэй байна вэ гэдэг бодит байдалд үндэслэж шийдвэр гаргадаг үе гарч ирэх ёстой байх. Тэгж байж зоригтой шийдвэр гаргана. Мэдээж алдана. Гэхдээ буруу саналгүй гаргасан алдаа, муу юм бодож хийсэн алдаа хоёрын үр дагавар өөр шүү дээ. Ойрын 12 жилд манай хөгжил очих цэгтээ нэлээд дөхсөн байх болов уу гэж бодож байна.

Нөгөө талаар Монгол Улс цөөхөн хүн амтай. Хуучин цөөхөн хүн амыг сул тал гэж үздэг байсан бол одоо давуу тал болчихлоо. Яагаад гэвэл ихэнх баялаг мэдлэгт суурилж бүтээгддэг болсон. Техник технологи хөгжөөд олон хүн ажиллуулаад байх ч хэрэггүй болчихлоо. Хөдөлмөр түлхүү зарцуулдаг эдийн засгаас мэдлэг зарцуулдаг эдийн засаг руу дэлхий нийт шилжиж байна. Манай Монгол Улс цөөн хүнийхээ боловсролд анхаараад, дэлхийн ажилтан болгох хэрэгтэй. Миний хувьд монгол хүний хөдөлмөрийн зах зээл дэлхий байх ёстой л гэж боддог.

“Хас” банкны шинэхэн гүйцэтгэх захирал Бат-Очирыг хүмүүс ажил, мэргэжлийн туршлага талаас нь сонирхох нь мэдээж. Та өөрийнхөө түүхийг тэр талаас нь товчхон сонирхуулахгүй юу?

-Миний хувьд “Хас” банктай үүсэн байгуулагдахаас нь холбоотой хүн л дээ. Анх төслөөр үйл ажиллагаагаа эхлэх үеэс л ажилласан. Өв хөрөнгө өвлөж аваагүй, энд тэнд лиценз зарж баяжаагүй мэргэжлийн менежер хүн /инээв/.

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг 1998 онд эдийн засагч мэргэжлээр төгссөн. Сургуулиа төгссөн даруйдаа Монголын хөрөнгийн биржид ажилд орсон. Тэр үедээ “НҮБ-аас хэрэгжүүлэх төсөлд монгол ажилтан сонгон шалгаруулна” гэсэн зарын дагуу шалгуулахаар очсон. Ганц би ч биш манай Хөрөнгийн биржийн дөрөв, таван залуу хамт очиж, шалгуулсан л даа. Тэнд одоогийн Сангийн яамны дэд сайд Ч. Ганхуяг надаас долоо хоногийн өмнө сонгогдоод орчихсон байсан. Тэгээд уг төслийн Техник туслалцааны баг гэж сургалт явуулдаг, зөвлөгөө өгдөг нэгжид нь сургагч-нябо гэдгээр ажлаа эхэлсэн. Дараа нь санхүүгийн зөвлөх, санхүү эрхэлсэн захирал гээд ер нь хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлага талаа түлхүү хариуцаж байсан. Тэгээд 2006 онд Fulbright-ийн тэтгэлгээр АНУ-д Бизнесийн удирдлагын магистрт яваад, Олон улсын санхүүч гэдгээр мэргэшиж

төгссөн. 2008-2009 оныг хүртэл банкны эрсдэл, хөрөнгө олох, бүртгэл талыг хариуцаж байгаад мөн оноос борлуулалт, бизнесийн үйлчилгээ тал руугаа орсон л доо. Тэгээд 2010 оны нэгдүгээр сард одоогийн Сангийн дэд сайд Ч.Ганхуяг “Надад төрийн хариуцлагатай албанд ажиллах санал ирж байгаа. Би ч гэсэн банкны ажлыг арав гаруй жил хийчихлээ. Өөр сорилт үзэж, даван туулмаар байна” гэдэг хүсэлтээ танилцуулаад, түүнийг нь манай ТУЗ зөвшөөрсөн. Тэгээд “Хас” банкны М.Болд захирал Ганхуягийн оронд “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл”-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд очоод, би 2011 оны нэгдүгээр сарын 1-нээс энэ ажлыг хийж байна даа.

-Монголын шинэ залуу топ менежерүүдийн төлөөллийн хувьд Та бизнесээ дөнгөж эхлээд байгаа, эсвэл шинэ санаатай яваа залуучуудад зөвлөгөө өгөхгүй юу?

-Битгий шантраарай л гэж хэлэх байна. Яагаад гэвэл манайх хөгжөөгүй улс. Хөгжсөн улсад гоё санааг дэмждэг сангууд ч юм уу, хөрөнгө оруулалт нь байж байдаг. Монголд тэр бол байхгүй. Сайн дээд боловсрол эзэмшье гэхэд ч гадаадад бол болно. Манайд бол нэлээд урт удаан зам туулж байж гадагшаа гарна. Тэглээ гээд бууж өгөөд, нам сууж болохгүй. Зүтгээд яваад байвал амьдрал бараан байгаа талаар бодох ч завгүй, урагшлаад л байна.

-Залуу хүний хувьд өөрийн ажил мэргэжлийн туршлагаасаа нэмж зөвлөхгүй юу?

-Гол нь багаараа зөв ажиллаж сурах. Тэгээд мэдээж оролцоотой шийдвэр гаргаж байх ёстой. Өөрөө бүхнийг мэддэг юм шиг явна гэвэл гүйцэтгэх захирлын хувьд тийм боломж нь ч байхгүй. Гүйцэтгэх захирал гэдэг бол байгууллага зөв чиглэлд явж байна уу гэдэг том зургийг харж, хянах ёстой албан тушаал. Хэчнээн мэддэг чаддаг байсан ч гэсэн мэргэжлийн түвшний ажлыг хүнд зааж явж байтал чинь маш сайн хөлөг онгоц хадан хясаа мөргөчих магадлалтай. Хүн бүр өөр өөрийн ажлыг хийж байх ёстой. Мэргэжлийн түвшний шийдвэрийг би гаргаад утгагүй. Би чиглэлээ өгөөд, хүмүүс маань боловсруулаад, тэд шийдвэрээ гаргана. Тэгж түвшин түвшний хүмүүст ажлаа хийх боломжийг нь олгож байж зөв явна уу гэхээс “миний хэлснээр хий” гээд газар дээр бууж чаддаггүй хүн чинь газар дээр хэрэгжих шийдвэрийг гаргах гээд дайраад байвал байгууллагад эмгэнэлтэй л дээ.

-За цаг зав гаргаж, манай сэтгүүлд ярилцлага өгсөн танд талархлаа.

-“Mongolian Economy” сэтгүүлийг цаашдаа орон даяар тархсан, мэргэжлийн гэж үнэлэгдсэн сэтгүүл байгаарай гэж ерөөе. ■

Бид ажилгүйчүүдийн эгнээнээс гарч чадсан!

Зүүн урд зүгээс нар уулын цаанаас мандаж алтан цацрагаараа хорвоо дэлхийг гийгүүлэн шинэ өглөөтэй золгодог. Харин хүний амьдралын өглөө бүхэн өөр. Өчигдөр болсон зүйл, өнөөдрийн хэрэг явдал маргааш дахин давтагдахгүйгээр уялдаа холбоотойгоор өгсөж, уруудаж байдаг болохоор амьдрал гэдэг сонин. Энэ л амьдралын эгшиглэнт симфони дунд хүмүүс өөр өөрийн гэсэн хэмнэлээр аж төрөн сууна. Өглөө эртлэн босож, ажилдаа яаравчлан явах нэг хэсэг байхад, яаж өөртөө тохирох ажилтай болох вэ? гэж хэдэн сар, жилээр ч гансрах нөгөө хэсэг ч бий. Ажил хийж амьдрах сайхан.

“Mongolian Economy” сэтгүүл “Амьдрал” нэртэй шинэ булан нээж байна. Энэхүү буланд “Надад ажил олдохгүй байна” гэж дэмий суух биш, өөрөө хичээвэл ажилгүйчүүдийн эгнээнээс гарч, сайхан амьдарч болдгийг харуулсан болно.

Аливаа улс орны хувьд ажилгүйдлийн түвшин нэлээд бэрхшээлтэй асуудал байдаг. Монгол Улсыг ч энэ асуудал тойроогүй. Манай улсын хэмжээнд хөдөлмөрийн насны нэг сая 860 гаруй мянган хүн байдгаас, 2010 онд нийт 113 мянга гаруй ажилгүй иргэн байдаг гэсэн тоо Үндэсний статистикийн хорооноос гаргасан тайланд дурайсаар.

Засгийн газраас 2011 оныг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил хэмээн зарласан. Хэр үр дүнтэй байх юм бол доо. Өмнө нь Засгийн газраас нэрэмжит жил зарлаад үр дүн багатай өнгөрдөг шиг битгий л байгаасай гэж олон нийт хүсэж буй нь мэдээж. Эрүүл мэндийг дэмжих жил гэдгээс илүү чухал олон олон өрхийн амьдралд нөлөө үзүүлэхүйц найдлага тээсэн сэдэв учраас ийн олон нийт бодитой үр дүн харахыг хүлээж байгаа биз ээ. Зарим хүн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийг энэ жил биш дараа жилээс зарлах байсан юм.

Тэгвэл үр дүн гарна гэдэгт илүү найдаж болохоор байлаа. Сонгуулийн өмнөх жил нэрэмжит жил зарлах нь үр дүн гарна гэдэг итгэлийг сааруулж байгаа юм даа” хэмээн учирлах нь ч байна. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамныхны дээрх нэрэмжит жилийн хүрээнд хийх ажлын гол төлөвлөгөөг нь сонирхоход олон албархуу үг хэллэгтэй ажил хийх жагсаалт гаргажээ. Тоймтой нь гэвэл Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах аж. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2011 оны дөрөвдүгээр сараас 30 хувиар нэмж, 140400 төгрөг болгон шинэчлэн тогтоосон нь албаныхны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд хийж буй томоохон шинэлэг ажилд орох нь мэдээж. Түүнчлэн барилга, уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт эрэлт ихтэй 18 мэргэжлээр 3300 залууг сургаж, эхний 951 төгсөгчийн 80 хувийг ажлын байранд зуучилсан тухай НХХЯ-

Г.Ганболд /Хувиараа хөдөлмөр эрхлэгч/:

“Ажилгүй байх нь архидахын үндэс болдог. Ажил хийж байгаа нөхцөлд хүн юун архи хайгаад явж байх манатай тэр талаар бодох ч завгүй байдаг” хэмээн Г.Ганболд өгүүлнэ. “Ноос угаах үйлдвэрт” 10 гаруй жил ажилласан холбоочин мэргэжилтэй тэрбээр сүүлийн 14-15 жил “Нарантуул” захад гэрийн зуух, пийшин хийж амьдарч байгаа аж. Ганболд гуай бүтээгдэхүүнээ Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Таван буудалд байрлах гэртээ хийдэг бөгөөд нэг пийшинг 70.000-90.000 төгрөгөөр, харин зуухаа 35.000 төгрөгөөр борлуулдаг байна. Пийшинг 2-3 хүн хийдэг бөгөөд сардаа 300.000-400.000 төгрөгийн орлого олох боломжтой бизнес аж.





► Т.Дунжаа /“Үлэмж чанар” гар хивсэн эдлэлийн сургалтын багш/:

Т.Дунжаа өдгөө 70 настай, хүүхдүүд нь эрийн цээнд хүрч амьдралаа авч явах чадалтай болсон ч тэтгэврийнхээ мөнгийг хараад, ажилгүй суухыг хүсээгүй. Өөрийн сурсан мэдсэнээ хойч үедээ өвлүүлэхээр “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих Сонгино хайрхан төв”-тэй хамтарч “Үлэмж чанар” гар хивсэн эдлэлийн сургалт явуулдаг байна.

“Би бүтэн 20 гаруй жил хоёр ажил хийсэн. Давхар ажил хийнэ гэдэг тийм ч амар даваа биш байсан. Гэхдээ ажил хийлээ гээд хэвтэрт ортлоо өвдсөн удаагүй. Харин ч өдгөө 70 нас хүрэх гээд эрүүл саруул ажиллаж явна. Хүний биеийг олж төрнө гэдэг дээдийн төрөл тийм учраас өөртөө итгэлтэй сайхан амьдрах хэрэгтэй. Түүнийхээ төлөө тэмц. Хорвоо гэдэг чинь бэрхшээлийн цаана бэлэг угтдаг юм шүү дээ” хэмээн Т.Дунжаа гуай хуучилна. Хар залууд нь хайрт хань нь өвчинд нэрвэгдэн хэвтэрт орж, түүний хэцүү амьдрал эхэлжээ. Тэрбээр “Ганц хүний цалин хэвтрийн өвчтэй нөхрөө эмчлүүлэх, дэрсхэн өсөж байгаа дөрвөн хүүгээ хүнээс дутаахгүй мөр бүтэн, гэдэс цагталан амьдруулахад даанч хүрэлцдэггүй байсан. Социализмын үед би Хөнгөн үйлдвэрийн техник мэргэжлийн сургуульд захирлын албатай байсан. Захирлын цалин тухайн үедээ хамгийн өндөрт тооцогддог байсан хэдий ч миний хүнд амьдралд хүрэлцдэггүй байсан юм. Тэгээд л үндсэн ажлынхаа хажуугаар мэргэжлийнхээ дагуу гар хивс хийж, нэмэгдэл орлого олох болсон доо. Тэр үед ажил эхлэхээс өмнө 05:00-07:00 цаг хүртэл хивс нэхэж, ажил тарснаас хойш шөнийн 01:00 цаг хүртэл ажилладаг байсан. Дөрвөн хүүгээ цэцэрлэг, сургуульд нь аваачиж өгчихөөд ажилдаа явдаг, өдөр нь нөхрөө эргэдэг байсан. Нэг жилийн дотор 15 килограмм жин хасагдаж нүд халтирмаар болж билээ. Гэхдээ хүн зовлон даадаг гэж үнэн үг шүү” гэв. ►►



▶ **С.Эрдэнэчимэг /Оёдолчин/:**

Өнгө өнгөөр алаглах торгон дээл дунд С.Эрдэнэчимэг зогсоно. Тэрбээр ажлынхаа байран дээр байгаа нь энэ. “Нарантуул” захын 39-р лангууны түрээслэгч. Гурван жил эрхэлсэн ажилгүй, хөдөө мал маллаж байгаад, гурван хүүхдээ гайгүй сургуульд оруулах юмсан гэсэн мөрөөдөл өвөртлөн 1997 онд гэр бүлээрээ хот руу шилжиж иржээ. Энэ эмэгтэй хөдөлмөрч учраас их хотын ажилгүйчүүдийн эгнээнд удаан байсангүй. Дээл хийж зарах ажлаа анх “Дэнжийн 1000”-ын захаас эхэлжээ. Түүний дээлний бизнес удалгүй цэцэглэж,

одоогоор 5-6 оёдолчинтой хамтарч өрхийн бизнес явуулж байна. Охин, хүү хоёр нь дээлний шилбэ хадаж, дотор эсгэхээс авахуулаад “Нарантуул” захад бараагаа борлуулахад нь хүртэл тусалдаг гэнэ. Дээлнийх нь үнийг сонирхоход, хийсэн материал даавуунаасаа шалтгаалж 40.000- 150.000 төгрөгийн үнэтэй. Жирийтэл өлгөсөн бараанд нь төрөл бүрийн торго, ноолууран даавуугаар хийсэн хүүхэд, том хүний дээл, хантааз, хүрэм зэрэг байна.

С.Эрдэнэчимэг “Сайн ажиллавал гадаад олдог цалинг эх орондоо олох боломжтой. Ялангуяа залуу охидууд үндэсний хувцсаа оёж сурах хэрэгтэй байна. Ажилгүй байгаа охидыг бид нар сургаад авч болно. Тэгвэл оёдлынх нь хөлсийг хийснээр нь өгөөд, аль аль талдаа ашигтай. Гадаад явж зовж байхаар нутагтаа ажил хийх нь хамаагүй дээр шүү дээ. Бид үнэнч хөдөлмөрөөрөө сэтгэл хангалуун амьдарч байна. Ер нь болохгүй юм гэж алга” гэж ярилаа. Үндэсний хувцас оёдог хүмүүсийн тоо цөөрч байгаа өнөө үед түүний залуу боловсон хүчин, ажилчдыг сургаад өгье гэсэн санал тун сайхан санагдлаа.

Архангай аймгийн Хайрхан суманд төрсөн тэрбээр Дархан хотын Политехникийн сургуулийн цахилгаанчны ангийг 1987 онд төгсчээ. Сургуулиа төгсөөд мэргэжлээрээ сумынхаа Эрчим хүчний харъяа Дизель станцад ажиллаж байтал 1990-ээд онд улс орон зах зээлд шилжиж, орон тооны цомхтголд орсон аж.

3.Цэнджав /“Ноён нуруу Оргил” ХХК-ийн захирал/:

Өдгөө 50 гаруй настай 3.Цэнджав гуай 20-иод жилийн өмнө ган зуданд малынхаа хотыг харлуулж, Улаанбаатарт шилжин ирж, ажилгүй, ядуусын эгнээнд шилжжээ. Эднийх 2000-2008 он хүртэл өлсөж даарахын зовлонг бишгүйдээ амссан байна. Цэнджав гуай зургаан ам бүлтэй айлын өрхийн тэргүүний хувьд дээрх хугацаанд зүгээр суугаагүй ч эднийх хоёр гурван өдрөөр өлсгөлөн хонох үе зөндөө байсан тухайгаа ярьж байна. “Ямар сайндаа өвөл хашааныхаа банзнаас түлж байх вэ дээ. Эхнэр бид хоёр тогтвор суурьшилтай, боломжийн цалинтай ажил хайж гутлынхаа улыг эргэтэл явсан боловч олдоогүй. Амьдрал мөн ч хэцүү байсан даа” хэмээн шүүрс алдан өгүүлсэн юм.

Харин тэдний амьдралыг өөрчлөх бизнесийн санааг гурван жилийн өмнө том хүү Ц.Мөнхбаатар нь гаргасан байна. Хятадын хөрөнгө оруулалттай тавилгын үйлдвэрт бага цалинтай ажилладаг байсан хүү нь тавилгын бизнес хийх тухайгаа аавдаа ярьжээ. Тухайн үед өдрийн хоолоо арай гэж л залгуулж байсан өрхийн тэргүүний хувьд том хүүгийнх нь алт шиг санаа мөрөөдөл мэт санагдаж. Гэтэл мөрөөдөл нь биелжээ. 3.Цэнджавын цаасан дээр буусан мөрөөдөл төдий төлөвлөгөөг нь “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв”-өөс итгэл хүлээлгэн дэмжиж 18 сая төгрөгийн зээл олгоод зогсохгүй арилжааны банкнаас дахин 100 сая төгрөг хүртэлх зээл авах боломжийг гаргаж өгчээ. Энэ л үеэс “Ноён нуруу Оргил” ХХК-ийн тавилга хийх гэр бүлийн бизнес нь амжилт дагуулж, өдгөө гэр бүлээ тэжээгээд зогсохгүй арав гаруй

хүнийг ажил амьдралтай нь залгуулж байна. Өнөөдөр тэд уг үйлдвэрээ өргөжүүлж улам олон ажлын байр бий болгож, ашиг олж болох нэг бүс шинэ бизнесийн санаатай явна. 100 сая төгрөг хүртэлх зээл авах эрхээ ашиглах гэтэл тэдэнд барьцаа хөрөнгө байхгүй учир энэ боломжоо өнөөдрийг хүртэл ашиглаж чадахгүй байгаа аж. Тэрбээр “Хэрвээ бидэнд итгэлийн зээл ахиу хэмжээгээр өгөх юм бол бизнесээ өргөжүүлэх боломж бий. Тиймээс төр, засаг бүтээлч юм хийж байгаа хүмүүсээ дэмжээд өгөөсэй” гэж хүснэ.

Эднийх гал тогооны тавилга үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрүүд дотроо нэлээд дээгүүр орох ч оргил ачааллын үедээ эцэг эхээсээ уламжилж ирсэн бурханаа хүртэл Барьцаалан зээлдүүлэх газар тавьж материалын мөнгөө олддог байна. ■



Технологи

Гадаадад гайхагдсан монгол чадвар



Дэлхийн өндөр хөгжилтэй зарим оронд Монголын авъяаслаг залуус хөгжлийнх нь түлхүүрийг атгалцаж явна гэж хэлж болно. Энэ удаа манай сэтгүүл эдгээр залуусын төлөөлөл болох БНСУ-аас эх орондоо ирээд удаагүй байгаа нэгэн залуугийн тухай өгүүлэв. Б. Хашбаатар БНСУ-ын “Хуа шин жон милл” компанид 3D программ дээр ажиллаж захиалагч компаниудын тавьсан шаардлагын дагуу бүтээгдэхүүний анхны загварыг хийдэг байжээ. 3D гэдэг нь одоо манайхны хэрэглэж байгаа AutoCAD гэдэг барилга, зам, гүүр гэх зүйлсийн загвар гаргадаг программын хамгийн сүүлийн үеийн нийлэг хувилбар юм. Одоогийн байдлаар энэ программыг дэлхийн хөгжингүй орнууд болох Америк, Герман, Шведарь, Япон, БНСУ зэрэг орон хэрэглэдэг ажээ. 3D технологиор үзэг, ундааны сав, гар утасны эх бие, таны хэрэглэж байгаа компьютер, унаж яваа машины загвар гээд ер нь төмөр, хуванцар, хайлшаар хийж болох бүх л зүйлсийн эх хувилбарыг хамгийн алдаа багатайгаар программчлаад тухайн бүтээгдэхүүний анхны загварыг гаргах хүртэлх бүхий л ажиллагааг хийдэг юм байна. Харин дараа нь захиалагч гаргасан загварыг аль нэг үйлдвэрт аваачин олшруулаад л болоо. БНСУ-д одоогоор 3D программыг ашигладаг хоёр томоохон үйлдвэр байдаг бөгөөд бидний хэзээний танил болсон “Sony”, “Samsung”, “Toyota”, “Apple”- гээд олон компаниуд захиалга өгдөг ажээ. Харин уг үйлдвэрт тухайн программ дээр ажилладаг үндсэн хоёр ажилтан байдаг нь хоёулаа монгол хүн гэвэл итгэх үү? Тэдний нэг нь Б.Хашбаатар юм. Үүнийг сонсоод бахархах сэтгэл төрснөө нуух юун. Түүний хэлснээр гадаадад яг

энэ программ дээр ажилладаг дөрвөн монгол хүн байдаг гэнэ. Нэг нь түүнтэй хамт БНСУ-д, нөгөө хоёр нь Америкт ажилладаг юм байна.

2008 оны олимпын үеэр БНХАУ 3D программ дээр ажиллах хүчийг бэлтгэх зорилгоор Б.Хашбаатарын Солонгос дахь гарын шавь нараас нь урилгаар аваачиж хичээл заалгажээ. БНСУ-ын томоохон техникийн дээд сургуулиудыг төгссөн оюутнууд дээрх программ дээр ажиллахын тулд 1-2 жил тухайн компани, үйлдвэрт дадлага хийсний дараа тодорхой чадвартай болдог бөгөөд тэдний цөөнгүй оюутан манай хоёр залуугийн шавь болж ажиллах ур чадвар эзэмших нь бий.

Гаднын орнууд зах зээлийн томоохон өрсөлдөөний талбарт хүч үзэж байгаа болохоор маш бага зүйлийг өрсөлдөгч талдаа зааж өгдөг. Тухайлбал БНХАУ-д энэ программын талаарх ойлголтыг солонгосчууд өгөхдөө хэдхэн дадлагын оюутнууд явуулах жишээтэй. Манай урд хөрш 3D программыг анхлан суралцагч болоод ч тэрүү зарим бүтээгдэхүүн нь чанарын шаардлага хангадаггүй байна. Хамгийн энгийн жишээ гэхэд зарим ундааны савны ёроолд гар урах нь холгүй зүйл тэмтрэгдэх нь бий. Аль эсвэл хуванцар эдлэлийн гадна тал бохир байх тохиолдол байдаг даа. Энэ нь 3D программыг дутуу эзэмшсэний гай ажээ. Өндөр зэрэглэлийн захиалагч компаниуд энэ төрлийн алдааг хүлээн зөвшөөрөхгүй. Харин манайд энэ программ бүрэн хэмжээнд орж ирээгүй учраас монголчууд, Хятадад өгсөн үнэ хямд, чанар муу захиалгаа хэл үггүй хүлээж авахаас аргагүй. Хэрвээ чанартай бүтээгдэхүүн хийлгэх юм бол энэ нь харьцангуй өндөр үнэтэй гарна. Энэ төрлийн жижиг, дунд үйлдвэр байгуулчихвал манайд ихээхэн ач тустай. Хамгийн наад зах нь хогны савнаас эхлээд, үзэг бал, ундааны сав, гээд бүх л зүйлийг урд хөршөөсөө захиалан авах зэрэггүй болно гэсэн үг. Дээрээс нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй. УИХ-ын гишүүд маань сонгуулийн үеэр Хятад эсвэл хаа байсан Солонгосыг зорьж өөрсдийнхөө нэртэй үзэг, цаг зэргийг хийлгэдэг. Хэрвээ эх орондоо ийм үйлдвэртэй болчихвол амар юм сан. Ер нь дэлхийн хөгжингүй орнууд энэ төрлийн салбараа ихээхэн анхаарч эдийн засгаа хүчтэй дэмжиж

байна. Байгалийн баялаг гэхээсээ илүү дэлхий нийт оюуны баялгаа дэмжээд түүгээрээ ашиг олоод хөгжөөд байгааг анзаарч хардаг л байлтай.

Б.Хашбаатарыг “Хуа шин жон милл” компанид яаж орсон тухай нь сонирхоход тэрбээр анх Монголоос “Олон улсын зуслангуудын холбоо”-ноос зохиосон залуучуудын чуулга уулзалтад оролцох гэж БНСУ-ыг зорьсон гэнэ. Тухайн үед тэндээ хууль бусаар үлдсэн гэдгээ нуусангүй. Эхний нэг жил пицца зөөхөөс эхлээд аяга таваг угаах хүртэл олон ажил хийж байгаад энэ ажлаа олжээ. Уг компанид анх туслах ажилтнаар орсон байна. Тэрбээр яван явсаар одоогийн түвшинд хүртлээ өсөн дэвжжээ. Хүн л болсон хойно алдаа мадаггүй ажиллана гэдэг хэцүү. Б.Хашбаатар нэг удаа нэлээд томоохон захиалга дээр ажиллаж байгаад алдаа гаргаж үйлдвэрийнхээ гол тоног төхөөрөмжийг эвдчихэж. Тэрбээр их өрөнд орохоо мэдээд зугтах талаар бодоод амжжээ. Гэтэл байдал эергээр эргэж үйлдвэрийн захиргаа нь сануулга өгөөд “Сайн ажилтан учраас харж үзье, дахин ийм алдаа битгий гаргаарай” хэмээн уучилсан байна. Тэр өдрөөс хойш Б.Хашбаатар бүтэн долоон жил нэг ч алдаа гаргалгүй ажиллажээ. Эндээс харахад, түүний хэр сайн ажилтан болох нь тодорхой байна. Тэрбээр Солонгост ажиллаж байхдаа сард хоёр сая гаруй төгрөгийн цалин авдаг бөгөөд байгууллагаас нь хоол, унаа, байрны мөнгийг нь гаргаж өгдөг байж. Хэдийгээр Солонгост хангамж сайн байдаг ч гэсэн сурсан мэдсэнээ эх орондоо зориулах хүсэл эрмэлзлэлдээ хөтлөгдөн Монголдоо ирсэн нь энэ. Гэтэл гаднынханд үнэ цэнэтэй м олон хүүгээ эх орон нь тоохгүй байгаа нь харамсалтай. Тэрбээр “Миний сурч мэдсэн дэлхий нийтийн жишигт нийцсэн мэргэжил эх оронд минь үнэгүйдэж байна ш дээ. Буцаад Солонгост очиж л ажилладаг байх даа” хэмээн гунигтайгаар өгүүлнэ. Энэ мэт чадварлаг боловсон хүчнээ Монгол Улс гаднынханд алдсаар байх гэж үү?

Б.Хашбаатар эх орондоо томоохон зорилго өвөртлөн иржээ. Сурсан мэргэжлээрээ цаг алдалгүй эх орондоо ажиллах төлөвлөгөөтэй байж. Гэтэл манайд энэ программын сүүдэр нь ч алга байгаа нь түүнийг ихээхэн бухимдуулжээ. Харин манайх дэлхий нийтийн хэрэглээнээс хэдийнэ “шахагдаад” байгаа AutoCAD программын хуучин хувилбарыг нь хэрэглэж байна. Б.Хашбаатар сурсан мэдсэнээ эх орондоо ажил хэрэг болгочих санаатай цөөнгүй байгууллагад хандсан хэдий ч энэ

► программын талаарх мэдлэг туйлын дутмаг байгаа нь ажиглагджээ. Том дарга нар нь ч сайн мэдэхгүй байна гэсэн юм. Мөн энэ төрлийн жижиг, дунд үйлдвэр байгуулах тал дээр санаа дэвшүүлсэн боловч ойшоох хүн олдоогүй гэнэ. Бас “Хэнд ямар арга замаар хандах ёстой гэдгээ сайн мэдэхгүй болохоор хэцүү байна л даа” хэмээн учирласан юм. Сүүлийн үед манайхан дээр доргүй инновацын талаар ярих болсон. Шинэ бизнес санаа, мэдлэг чадвартай боловсон хүчин, эрэлт хэрэгцээ хаана байна гэж хайдаг, шаарддаг болжээ. Тэгвэл таны хайж байгаа тэр бүх шаардлага чинь нэг дор байна.

Эх орон, ижий, аав, эхнэр, хүүхдийнхээ дэргэд элэг бүтэн ажиллаж, амьдрах хүсэлтэй залуус олон байгаа. Сайд, дарга нар хэлэхдээ эх орноо гэсэн хүн алга байна буцаад ир гэдэг. Эх орноо гэсэн монгол хүн олон байна. Харин иргэдээ харж үзэх эх орон, төр алга байгаа нь харагдаж байх шиг. Гаднын орнууд боловсон хүчнээ бэлтгээд, ажлын байрыг нь би болгож өгөөд, хангалттай хэмжээний цалин

хөлсөөр нь хангадаг. Харин манайд эсрэгээрээ байх юм. Монголын залуус оюуны болоод бие махбодийн хөдөлмөрөө гаднынханд ашиглуулж байгаа нь хэтэрхий харамсалтай санагдана. Ёстой нөгөө “Бурхан төрсөн газраа үнэгүй” гэдэг шиг монгол хүн Монголдоо үнэлэгдэхгүй байна. Энэ байдлаараа байх аваас Монгол Улс гэрлийн хурдаар хөгжиж буй гаднын орнуудын хойноос яст мэлхийн хурдаар мөлхсөөр л . . .

Хэрвээ томоохон байгууллага, аж ахуйн нэгж ЗД программын талаар сонирохвол ашигтай санагдана. Тэр тусмаа төрөөс бодлогоор дэмжих л зүйл байлтай. Ажлын байр бий болгоно гээд л байдаг хэрхэн бий болгох нь одоо ч тодорхой бус байна. Эх орны минь хөгжил доогуур байна гэж дээгүүр суудалтай томчууд үргэлж ярьдаг. Бид хөгжлийн шинэ гарц оллоо гэдэг. Гэтэл тодорхой үр дүн харагдахгүй л байна. Харин зөв боловсон хүчнээ, зөв салбараа, зөв арга замаар дэмжээд өгвөл Монгол Улс үйлдвэрлэгч орон болоход ойрхон байна. ■

PPP түншлэл

Хонгилын үзүүрт сүүмэлзэх бүдэг гэрэл

Х.Хулан

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа /PPP/ гэдэг ойлголт сүүлийн үед манайд моодонд ороод буй. Гэхдээ үүний хэрэгжилтийн талаар манайд чамгүй яриад байгаа хэдий ч өнөөдрийн байдлаар англи үсгийн товчлолыг нь нүдэндээ дасгаснаас нэг их хэтрээгүй байна гэж хэлж болох. Олон нийт PPP-ийг сайн ойлгож амжаагүй байтал түүнийг дагаад төр, хувийн хэвшлийн хэлэлцэл /PPD/, төрийн зарим чи гүүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх хэлбэр буюу “Аутсорсинг” гэж яригдах болсон. Уншигчдадаа эдгээрийн талаар ойлголт өгөх үүднээс дараах мэдээллийг бэлтгэлээ.

Ирээдүйн зөгнөл

20...оны есдүгээр сарын 1-ний өглөө Доржийн гэр бүлийнхний хувьд өөрчлөлт шинэчлэлт дүүрэн эхэллээ. Эхнэр нь шинээр хаалгаа нээж буй “Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв”-д оёдлын багшаар ажиллах болж. Охин Болор нь будаг, шохойны үнэр нь арилаагүй “Ертөнц” сургуулийн нэгдүгээр ангид, дүү Молор нь тус сургуулийн залгаа орших цэцэрлэгт бүртгүүлсэн аж. Эхнэр хүүхдээ албанд нь хүргэж өгсөн Дорж хадам аав Дамдин, хадам ээж Долгорыг Сонгино Хайрхан дүүрэгт шинэин барьж, ашиглалтад оруулсан “Нийслэлийн ахмадын сувилал”-ын газарт хэд хоног сувилуулж тордуулахаар давхилаа. Хүргэнээ ямар ч бартаагүй толийсон засмалаар хурдлах зуур Долгор эмээ хүргэнээсээ суув. “Энэ чинь яасан сайхан яваад л баймаар зам бэ. Бодвол төр, засгаас л янзлуулсан байдаг байх даа” гэж шогшров. Хариуд нь өвгөн Дамдин нь “Үгүй дээ хөгшөөн, дан ганц төр биш ээ. Одоо чинь цаг үе өөрчлөгдөж, урьд өмнө нь үзэгдэж дуулдаагүй юм шинээр их гарч ирж байна. Зурагтаар төр, хувийн хэвшил хамтарч төсөл хэрэгжүүлж байгаа талаар ярьж байхыг чи дуулаагүй юм уу?” гэв. Ингээд хадам, хүргэн хоёр Долгор эмээд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа /PPP/-ны тухай тайлбарлаж өгөв. “Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, “Ертөнц” сургууль, түүний хажуугийн цэцэрлэг, Ахмадын

сувилалын газар, зам засварын ажлыг хувийн компаниуд төрөө солгох тусгай зөвшөөрлийн дагуу хийж гүйцэтгэсэн тухай. Дорж “Сониноос гэвэл, манай “Шинэ стандарт” төрийн бус байгууллага ч гэсэн төртэй хамтарч ажиллах гэрээ хийж амжсан.Төрийн зарим үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа нь нөгөөл төр, хувийн хэвшлийн чинь хамтын ажиллагааны нэг хэлбэр нь байхгүй юу” хэмээн сонирхуулав.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэл гэж юу вэ?

Дээрх жишээ нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэрэгжилт нэлээд жигдэрсэн, ойрын ирээдүйг зөгнөсөн дүр зураг юм. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь харин өнөөдрийн байдлаар, манайд талууд харилцан ойлголцох, хэлэлцэн зөвшилцөх улмаар хамтын ажиллагааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болуох шатандаа явж байна. Концессын тухай хуулийг өнгөрсөн онд, “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги”-ийг энэ онд батлан гаргасан нь дээрх хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх эрх зүйн орчны үндэс суурийг бүрдүүлсэн байна. Энэхүү стратеги нь Монгол Улсад бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг харилцан ашигтайгаар хөгжүүлэх, ажлын байр, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх зорилготой аж.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэл гэж яг юуг хэлэх вэ? Энэ нь нэг ойлголт уу, эсвэл салангид авч үзэх зүйл үү гэдэг тал дээр олон хүмүүс төөрөлдсөөр байна. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа гэдэг нь хувийн хэвшлийг дунд болон урт хугацааны хөгжлийн баримт бичиг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулахыг хэлэх аж. Харин Төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг нь нийгмийн болон дэд бүтцийн салбарын үйлчилгээг шаардлагатай мэдлэг ►

чадвар, хөрөнгө оруулалт, техник технологи ашиглан хувийн хэвшлийг гүйцэтгүүлж, учирч болзошгүй санхүүгийн, технологийн, үйл ажиллагааны гэх мэт эрсдэлийг хоёр тал гэрээнд заасан нөхцөлийн дагуу хүлээхийг хэлнэ. Энгийнээр хэлбэл, түншлэл нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа дотроо багтдаг, хэрэгжилт тал дээр нь түлхүү авч үзэх нэг хэлбэр гэсэн үг. Англи хэл дээрх нэр томъёо нь гурван „ли” үсэг буюу публик прайват партнершип (public private partnership) юм. Аливаа түншлэл эхлүүлэхээс өмнө төр болон хувийн хэвшил хамтын ажиллагааны гэрээ байгуулна.

Төрийн зүгээс авах гэж байгаа үйлчилгээндээ төлбөр төлөх эсхүл хувийн хэвшилд хэрэглэгчээс ашиглалтын хураамж хураах эрхийг нь олгоно. Хэрэгжилтийг харин төр өөрөө хянах үүрэгтэй. Хувийн хэвшил хувийнхаа хөрөнгөөр үйлчилгээг тогтоосон стандартын дагуу үзүүлнэ. Гэрээт төрийн байгууллага, хувийн компани хоёрын хувьд олон салбарт хамтран ажиллах боломжтой. Ийм хамтын ажиллагаа өрнүүлж буй салбаруудаас дурдвал, хотын хөгжил, зам тээврийн үйлчилгээ, хог хаягдлыг зайлуулах, ус болон халаалт хангамжийн төслүүд, сургууль, цэцэрлэг, эмчилгээний төв барьж байгуулах, байгууламжийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийг хариуцах гээд олон төрлийн үйлчилгээг хамтарч хэрэгжүүлэх боломжтой. Жишээ нь: Америкийн хотуудын захиргаа нь 65 нийгмийн чиглэлийн үйлчилгээний 23-ыг нь хувийн хэвшилтэй хамтардаг гэсэн баримт байна.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаар “Хас” банкны гүйцэтгэх дэд захирал Л.Төр-Одоос лавлахад, “Манайх энэ ойлголтыг зөвхөн төр, хувийн хэвшил гэж явцуу хүрээнд хязгаарлачихаад байгаа. Англи хэлэнд прайват /private/ буюу хувийн гэдэг ухагдахуунд төрийн бус бүхий л этгээд оролцохыг хэлнэ. Тэр нь хувь хүн, ажахуйн нэгж, компани, корпораци, төрийн бус байгууллага байж болно. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг би Төр, түмний түншлэл гэж томъёолоод байгаа” гэж тайлбарлав. Ийнхүү “Түмэн” гэсэн томъёололд хувийн хэвшил, иргэн, төрийн бус байгууллага гээд бүгд багтах тул төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь хэр өргөн хүрээтэй ойлголт болох нь харагдаж буй. Өөрөөр хэлбэл, энэхүү харилцааг зөвхөн хоёр субъектын хооронд мэт ойлгож болохгүй нь.

Аливаа улс орны эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь эргэлзээгүй хувийн хэвшил мөн. Манай оронд өнгөрсөн оны байдлаар 68 мянган хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 40 мянган аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мэдээлэл бий. Эдгээр нь Монголын дотоодын нийт бүтээгдэхүүний 64,4-71,9 хувийг бүрдүүлэхээс гадна ажиллах хүчний 70 гаруй хувь буюу 800 мянган хүн хувийн хэвшилд ажиллаж байгаагаас харахад, улс оронд ажлын байр бий болгож, ажилгүйдлийн түвшинг бууруулахад ихээхэн үүрэггүй цэтгэж байна.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарим хэлбэрүүдээс:

Төр аливаа шийдвэрийг гаргахдаа иргэний нийгмийн байгууллага болон хувийн хэвшлийн үзэл бодлыг харгалзаж, мэдээлэл солилцож байх нь зүйтэй гэсэн хандлага 1990-ээд онд бий болсон. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг үндсэн гурван чиглэлээр хэрэгжүүлдэг байна. Нэгдүгээрт, төр, хувийн хэвшлийн түншлэл /PPP- Public Private Partnership/. Хоёрдугаарт төр, хувийн хэвшлийн хэлэлцэл /PPD- Public Private Dialogue /. Гуравдугаарт төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх хэлбэр / Outsourcing/.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хүмүүс олонтаа сонсож, тодорхой хэмжээний ойлголттой болсон. Харин төр, хувийн хэвшлийн хэлэлцэл гэж чухам юуг хэлэх вэ? Энэ тухай Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр”-ийн Эдийн засгийн бодлогын хэсгийн ахлагч Д.Ерөөгөөс зарим зүйлийг сонирхлоо. “Төр, хувийн хэвшлийн хэлэлцэл нь /PPD/ төрийн зүгээс хөгжлийн бодлого боловсруулах үйл явцад хувийн хэвшлийг оролцуулах, тэдний санаа бодлыг оролцооны аргад тулгуурлан тусгахад чиглэгдсэн арга хэрэгсэл юм. Манай хөтөлбөрийн зүгээс энэхүү арга хэрэгслийг хөтөлбөр хэрэгжиж байгаа Дархан-Уул, Завхан, Орхон аймгуудад болон Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд танилцуулан бүс, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, бүс нутагт бичил жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд саад болж буй асуудлыг илрүүлэх, тэдгээрийг шийдвэрлэх боломжийн талаар санал боловсруулах төр хувийн хэвшил олон нийтийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан тодорхой саналуудыг хобогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Засгийн газрын “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги” батлагдан гарсанаар төр хувийн хэвшлийн хэлэлцэлийг бодитойгоор хөгжүүлэх эрх зүйн орчин бий болсон боловч энэ талаарх ойлголт сул, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлбэрүүдийн талаар нэгдмэл ойлголттой болгож хөгжүүлэх хэрэгцээ шаардлага төрийн болон хувийн хэвшлийнхний аль алинд нь байсаар байгаа юм. Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбоо, Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр хамтарч Монгол Улсын Засгийн газрын 2011 оны хоёрдугаар сарын 9-ний өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги”-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.6 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, түүнийг хэрхэн шийдвэрлэх арга зам, механизмыг бий болгох зорилгоор “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь” сэдэвт бүсчилсэн форумыг Төв, Хангай, Баруун, Зүүн бүсүүдэд байгуулсан бөгөөд ирэх есдүгээр сард үндэсний хэмжээний форум хийхээр төлөвлөж байгаа” гэв.

Хамтын ажиллагааны гуравдугаар чиглэл “Аутсорсинг” буюу төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх хэлбэр нь Баруун Европ, Хойд Америкийн орнуудад XX зуунаас эхэлж бий болсон түүхтэй. Ялангуяа Дэлхийн II дайны дараа болон 1970-аад онд энэ хэлбэр эрчимтэй өрнөж, 1990-ээд оны улс төрийн тогтолцооны өөрчлөлтийн үр дүнд хуучин социалист орнуудад энэхүү ойлголт гарч иржээ. Төрийн бус байгууллагууд болон ашгийн бус байгууллагууд зарим төрлийн хяналт хийж, эрх олгох, нийгмийн суурь үйлчилгээ үзүүлж, стандарт бий болгож нэвтрүүлэх боломжтой болсон гэж ойлгож болно.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь, хувийн хэвшлийг нийгмийн үйлчилгээний салбарт татан оруулах гол механизм юм. Товчоор хэлэхэд, дэд бүтцийн хөгжил төдийгүй нийгмийн суурь үйлчилгээг ард иргэдэд хэрхэн үзүүлэхтэй холбоотой хувийн хэвшлийг оролцуулж байгаа явдал юм.

Монгол Улсад төр, хувийн хэвшлийн төсөл хэрэгжүүлж байсан туршлага одоогоор байхгүй ч алхам алхмаар хонгилын үзүүрт асах гэрлийн зүг урагшилсаар... ■

Бизнесийн завсарлага


Та ямар ном уншиж байна вэ?

Н.Энхжаргал

/Асимон Брокерс ХХК-ийн захирал/:

-У.Чан Ким, Рене Моборн нарын бичсэн “Blue ocean strategy” номыг уншиж байна. Энэ номны гол хэлэх санаа нь бизнес эрхлэх гэж байгаа хүн зориг тэвчээр гаргаж, “blue ocean” буюу хүйтэн, эрсдэл өндөртэй хөх тэнгис руу шумбах нь урт хугацаанд “red ocean” буюу ургамал амьтан ихтэй, таатай сайхан “улаан” тэнгист амьдрахаас илүү их үр ашиг авчирна гэдгийг судалгааны үндсэн дээр гаргаж ирсэнийг харуулсан юм. Загас бүр ургамал ихтэй, дулаан улаан тэнгист дуртай байдаг бол хөх тэнгист зөвхөн хамгийн хүчтэй нь л тэсэж үлддэг. Хөх тэнгист тэсээд үлдсэн загас улаан тэнгисийн ямар ч том мундаг

загаснаас хүчтэй. Улаан тэнгист ерөнхийдөө хэн ч хоолоо олоод идэх боломжтой бол хөх тэнгист зөвхөн онцгой стратеги ашигласан, цоо шинэ зүйл нэвтрүүлсэн загас л амьд үлдэнэ. Энэхүү номыг бизнесийн удирдлагын сайн ном гэж дүгнэсэн байдаг. Бусад компаниудаас түрүүлж шинэ бүтээгдэхүүн зах зээл дээр гаргасан, эсвэл дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлсэн (жишээ нь IT салбарт), нарийн мэргэжлээр дагнан үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ашгаас ерөнхийдөө өндөр байдаг гэдгийг судалгаанд оролцсон компаниудын үзүүлэлт дээр тулгуурлан гаргасан байна. Бизнес эрхлэгч бүх залуучууд, ялангуяа компани шинээр байгуулж байгаа, ямар чиглэлийн бизнес эрхлэх вэ гэдэг талаар бодож тунгааж байгаа залууст уншихыг зөвлөж байна.




Йоханнес фон Франц

/Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол дахь суурин төлөөлөгчийн орлогч дарга/:

-Жэймс Палмерийн “Цуст цагаан барон” номыг уншиж байгаа. Энэ ном нь Улаан армид бут цохигдохоос өмнө Монголын ихэнх нутаг дэвсгэрийг 1920-1921 онд эзэлж, Монголын сүүлчийн хаанд тооцогдож байсан барон Унгерн-Штернбергийн түүхийн тухай юм. Түүнгүйгээр Хятадууд Монголд үлдэж, харин Оросууд Монголыг хэзээ ч Монголыг эзлэхгүй байсан. Монголын түүхийн хуудсын харьцангуй шинэ үеийг харуулсан нь нэн

сонирхолтой боловч бароны цуст, хэрцгий ноёрхол нь бие зарсхийм.

Анхныхаа номыг бичсэн Жэймс Палмерийн зохиолыг Фабер энд Фабер (Faber and Faber) хэвлэлийн газар Лондонд 2009 онд хэвлэн нийтэлжээ. Палмерсын номын гол баатар болох өөрийгөө Чингисийн угсаа хэмээн нэрлэсэн барон Унгерн нь хэдийгээр Герман угсааны хүн боловч 1920 оны үед Монголын ихэнх хэсгийг Хятадуудаас чөлөөлсөн ба өөрийн цуст аллага, хэрцгий догшин зангаараа түүхэнд Хаант Оросын төлөөх галзуу загалмайтны адилаар зүйрлэгдсэн байдаг.




Л.Төр-Од

/“Хас” банкны гүйцэтгэх дэд захирал/:

Тэрбээр Милфорд Бэйтманы “Бичил санхүү яагаад амжилт олдоггүй вэ?” гэдэг номыг уншиж байгаа аж. Энэхүү номонд бичил санхүү, түүний нийгэм эдийн засгийн үр нөлөөний асуудлыг анх удаа иж бүрэн байдлаар болон шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийж үнэлгээ дүгнэлт өгчээ. Магадгүй зарим уншигчид Милфордын бичсэн зүйлтэй санал нийлэхгүй байх, гэхдээ бичил санхүүгийн салбарт ажилладаг хэн бүхэн энэхүү номыг заавал унших ёстой гэнэ. Өөрөөр хэлбэл, хөгжлийн тусламжийн асуудлыг олон талт өнцгөөс харж, түүний эерэг болон сөрөг үр дагаварыг нарийвчлан шинжлэн судлахад оршиж байна. 1970 оноос үүсэж хөгжсөн Бичил санхүү нь хөгжиж буй болон шилжилтийн эдийн

засагтай улс орнуудад ядуурлыг бууруулахад хэрэгжүүлдэг төр, засгийн бодлогын нэг гол хэрэглүүр болсон байна. Үүнийг рок попын одод, алдартай кино жүжигчид, нэр цуутай улс төрчид болон хөгжлийн эдийн засагчид бүгд сайшаан, хөхүүлэн дэмжиж ирсэн билээ. Харин Милфорд Бэйтман энэхүү номоор бичил санхүүг эцсийн амжилтанд хүрдэггүй болохыг харуулахыг зорьсон юм. Тэрбээр Энэтхэг, Камбож, Боливи, Серб, Уганда, Мексик зэрэг олон улс орны жишээг дурьдаж, бичил санхүү нь тогтвортой эдийн засаг болон нийгмийн хөгжилд саад тотгор болж ядуурлыг тууштай бууруулахад гол хаалт болж буйг яруу тодоор илтгэжээ. Саяхан болж өнгөрсөн Дэлхийн санхүүгийн хямралын үр нөлөөнөөс хөгжиж буй болон шилжилтийн улс орнууд түргэн гарахад бичил санхүүгийн үүрэг роль, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг эргэцүүлэн харж өөрчлөхийг санал болгосон байна. ■



Бизнес эрхэлж буй хүний хувьд хамгийн чухал 20 асуулт

Үргэлжлэл. Түрүүч нь №005 дугаарт

11. Бараагаа хэрхэн борлуулах вэ?



“Dell” өөрийн компьютеруудаа шууд зардаг бол “General Motors” болон “Coca-Cola” албан ёсны борлуулах цэгүүдэд найддаг. “Ralph Lauren” мэтийн хувцас үйлдвэрлэдэг компани бараагаа зах зээлд хүргэх дотоод болон гадаад шугамын аль алийг нь хэрэглэж байхад “Apple” брэндийн дэлгүүрүүдээ нээхийг илүүд үзнэ. Ямар ч арга барилыг сонгосон бай танай бизнесийн ерөнхий стратегитай нийцэж байх хэрэгтэйг санаж яваарай.

12. Тэгвэл бараагаа хэрхэн хүртээлтэй болгох вэ?



Хүн бүрт өөрийн компанийн талаар ярьж, сурталчлахын хажуугаар хоосорчихгүй байх нь амаргүй даваа шүү. 1990-ээд оны дунд үед “America Online” өөрийн программ хангамжийн туршилтын хувилбарын тухай сурталчлахын тулд асар их хөрөнгө хаяснаасаа болж энэхүү зарлагаа нягтлан бодох бүртгэлийн нарийн аргаар нуух хэрэгтэй болсон юм. Үр дүнд нь балансан дээрх орлого нь ч сая саяараа алга болсныг ойлгож байгаа биз дээ?

13. Зах зээлд шинэ тоглогч нэвтрэх нь ямар заналтай вэ?

Хэрвээ танай салбарт мөнгө олох боломж их байвал өрсөлдөгч гарч ирэх нь яриан байхгүй. “Microsoft” компани “Netscape”-ийг будаа болгосон шиг шууд утгаараа өрсөлдөгч төрдөггүй юм аа гэхэд шинэ технологи бизнесийг тань орвонгоор нь эргүүлж дөнгөнө шүү. Дижитал зураг гарч ирснээр “Kodak” юу боллоо доо. Тиймээс иймэрхүү зүйл гаргахгүйн тулд эртнээс нүхээ



малтаж, шинэ тоглогчдод саад хийж өг: бараа, бүтээгдэхүүнээ патентжуулж, түрээсийн урт хугацааны гэрээ хий. Түүнчлэн хэрэглэгчийн баазаа бүрдүүлж, инноваци нэвтрүүлэх тал дээр анхаар.

14. Оюуны өмчөө хэрхэн хамгаалах вэ?

Өмнөх хэсэгт ялимгүй нэмэлт оруулчихъя. Та зөвхөн нарны эрчим хүчээр цагт 240 км хурдлах чадвартай автомашин зохион бүтээлээ гэж бодъё л доо. Хэдхэн сарын дараа сэргэлэн таван өрсөлдөгч тань энэхүү загварын учрыг олоод, улам сайжруулаад өөрсдийн хувилбараа зах зээлд гаргачих вий. Загвараа олон нийтэд танилцуулахынхаа өмнө түр хугацааны патент заавал аваарай. Энэ нь



загварынхаа хэсэг бүрийг нарийвчлан боловсруулах бүтэн жилийн хугацаанд

таны шинэ санааг хамгаалах болно.

15. Эхлэлийн үед ямар хөрөнгө хэрэгтэй вэ?


Ихэнх шинэ санаа болон бизнес



хөрөнгийн хомсдолоос болж нурдгийг танд хөрөнгө оруулагчид болон жижиг дунд бизнесийн ямар ч зөвлөх хэлээд өгнө. Бизнес эхлэх үед яг хэдий хэмжээний мөнгө хэрэгтэйг яаж тооцоолох тухай тогтсон дүрэм байхгүй л дээ. Гэхдээ “Эхний ээлжинд хэрэгтэй гэж бодсон хөрөнгийн хэмжээгээ хоёр дахин үржүүлж тооцоол” хэмээн шүдний эмч нарын программ хангамжийн “Curve Dental” компанийн захирал Жим Пэк зөвлөснийг хүргэе.

16. Та бизнесээ яаж санхүүжүүлэх вэ?

Мэдээж олон сонголт бий л дээ:



Баян хамаатан, зээлийн карт (осолтой), венчур хөрөнгө оруулагч (хэрвээ таны санаа жинтэй болон нухацтай бол), банкны зээл (олж авахад тань амжилт хүсье), за тэгээд хамгийн өртөг ихтэй арга болох хувьцаа гаргах явдал. Ерөнхийдөө болж л өгвөл бизнесээ сайжруулаарай. Зөвхөн танд орж ирэх мөнгөний урсгал, өрөө төлөх зарлагаа л сайтар тохируулж, тооцоолох хэрэгтэй. Үгүй бол зүрх шимшрэм үр дүнд хүрч мэднэ шүү. ▶

17. Эхний хэдэн жилийн ард гарахын тулд яг хэд хэрэгтэй вэ?


Ахин дахин хэлье, мөнгөө хянаж бай. Аж ахуй эрхлэгчдийн ихэнх нь ирээдүйн санхүүгийн өсөлтийн таамаглалаараа онгирдог боловч тэрхүү сайхан цаг ирэхээс өмнө халаас нь хоосрох тал бий. 2000 онд дампуурсан доткомуудыг санаж байгаа биз дээ? Тиймээс “Aeron”-ы сандал,



“Мас”-ын зөөврийн компьютер зэргийг түр хойш тавиад, орлогоо бодитоор нэмэгдэх хүртэл “бүсээ чангалж” байсан нь дээр.

18. Санхүүгийн таамаглал тань ямаршуу байна?

Очих цэгээ тодорхойлоогүй бол хөдөлж чадахгүй нь тодорхой. Санхүүгийн таамаглал гаргахад хоёр чухал шат бий. Нэгдүгээрт, үйл ажиллагааны зардлаа нөхөх. Энэ



нь таны бизнес тодорхой хугацаанд зарцуулж байгаагаасаа ихийг олоод эхлэхийг хэлнэ. Хоёрдугаарт, хөрөнгө оруулалтаа нөхөх, энэ нь мэдээж та ашгүй нэг юм анх зарцуулсан бүхнээ олж авах явдал (гэхдээ инфляцийг бодохоо мартуузай). Санхүүгийн таамаглал ул суурьтай, үндэслэлтэй байх ёстой. Хэрвээ хэтэрхий өөдрөг санхүүгийн зураг зурчихвал ямар ч туршлагатай хөрөнгө оруулагч холуур өнгөрнө гэж мэдээрэй. Харин таны мөнгө дуусчихна...

19. Туслахуудаа хэрхэн аз жаргалтай байлгах вэ?



Саймон Көүэллгүй “American Idol” гэж ямар юм байх вэ? Бид ч удахгүй харна л даа, гэхдээ олон хүн “Энэ шоу өмнөх шигээ биш байна аа” л гэж бодох нь эргэлзээгүй. Хэрвээ та чадварлаг, авьяастай туслах олж чадсан аэтан бол түүнийгээ тогтоохыг хичээгээрэй. Цалин бол тэгшитгэлийн ердөө нэг хэсэг нь юм шүү.

20. Таны эцсийн зорилго юу вэ?



Эхний тааралдсан мөнгөтэй хүндээ л бизнесээ өгчих бодолтой байна уу? “MySpace”-ийн эзэмшигчид тэгсэн, харин “Facebook” бол үгүй шүү. Янз бүрийн зорилго төрөл бүрийн стратеги шаарддаг юм. Тиймээс та юу зорьж, эрмэлзэж байгаагаа үргэлж санаж яваарай. ■

“Forbes” сэтгүүлээс орчуулав

Эрүүл мэндийн булан

Стресс гэж юу вэ?

Д.Даваадалай (Их эмч)

Өнөө үеийн амьдрал, Монголын нийгмийн орчин, замын түгжрэлээс шалтгаалан та бид алхам бүртээ стресстэж буй. Стресс зарим талаараа тийм ч муу зүйл биш бөгөөд тодорхой хэмжээнд амжилтын хөшүүрэг ч болох талтай. Гэхдээ та байнга стрессийн байдалтай явсныхаа хариуг биеэрээ, тодорхой хэлбэл эрүүл мэндээрээ төлөх хэрэгтэй болдог. Хэрэв та өөрийгөө байнгын цочирдсон, тогтворгүй, яарч сандарсан байдалтай байгааг анзаарвал мэдрэлийн системээ тайвшруулж, хэвийн хэмжээнд оруулах цаг болжээ. Стресст орсон байж болзошгүй гэдгээ ойлгож, түүний талаар судалж, хэрхэн зөв арга хэмжээ авахыг олж мэдсэнээр та түүний хорт нөлөөнөөс өөрийгөө хамгаалж чадна.

Стрессийн үед хүний биед ямар урвал явагддаг вэ?

Стресс гэдэг нь ямар нэг гаднын нөлөөний эсрэг үзүүлэх хүний биеийн хэвийн үйлдэл юм. Бодит, эсвэл хийсвэр аюулын тухай мэдээлэл хүлээж авсан үед таны мэдрэлийн систем стресс гормон, тэр дундаа адреналин, кортизол ялгаруулах болно. Эдгээр гормон нь хүний биеийг ямар нэг яаралтай үйлдэлд бэлддэг. Зүрх хурдан цохилж, булчингууд чангарч, даралт ихэсч, амьсгалын тоо олширч, бүх мэдрэмж илүү хурц болно. Энэ нь хүч болон тэсвэрийг нэмэгдүүлж, эсрэг үйлдэл хийх хурдыг өсгөж, анхаарал нягтралыг ихэсгэсэнээр тулгарч буй аюулаас зугтах, эсвэл

туулж өнгөрөхөд бэлэн болох юм. Өөрөөр хэлбэл, стресс гэдэг хүний биеийг хамгаалах гол үүрэгтэй бөгөөд хэвийн үедээ сэргэг, анхааралтай, хүч чадалтай байхад тусалж, амь дүйсэн үед нэмэлт хүч чадлыг бий болгодог. Тухайлбал, тормозоо огцом гишгэж, болзошгүй авто ослыг тойрон гарахад тусална. Мөн стресс таны өдөр тутмын амьдралд тулгардаг бэрхшээлүүдийг даван туулах чадварыг нэмэгдүүлнэ. Чухал уулзалтад оролцох, илтгэл тавих үед таныг анхааралтай байлгах, эсвэл улсын шалгалт өгч буй оюутныг хөл дээр нь тогтоож байдаг гол зүйл нь стресс юм. Зурагт үзэж сууснаас хичээлээ уншсан нь дээр гэдэг бодлыг хүртэл стресс бий болгоно.

Гэвч энэ бүхнийг үл харгалзан ▶▶

► хэт их стресст орох үед эрүүл мэнд, оюун ухаан, ааш занд сөргөөр нөлөөлж эхэлнэ. Ингэснээр ажлын бүтээл буурч, харьцаа муудаж, амьдралын чанар доройтох тал бий. Тиймээс та өөрийн стрессийн түвшинг тодорхойлж, түүнийг удирдаж чаддаг байх нь хамгийн чухал. Харамсалтай нь таныг анзаарахаас өмнө стресс хэдийнэ толгой давсан байх нь элбэг бөгөөд хүмүүсийн ярьдгаар “стресст орсон” гэх байдалд хүргэдэг билээ.

Стресст орсон шинж тэмдгүүд:

Оюун ухааны түвшинд ой тогтоолт муудах, бодол санааны төвлөрөл доройтох, шийдвэр гаргаж чадахгүй болох, бүх зүйлийг болохгүй бүтэхгүйгээр харах, байнгын санаа зовинох; Сэтгэл санааны түвшинд ганцаардах, дарамт шахалтад буй мэт сэтгэгдэл төрөх, гутранги үзэлтэй болох; Бие махбодийн түвшинд гэдэс гүйлгэх, дотор муухай оргих, бие өвдөж янгинах, цээжээр өвдөх, зүрх дэлсэх, сексийн сонирхол буурах, хэт их эсвэл хэт бага идэж, унтах, хөлөрч даарах; Ааш зангийн хувьд бусдаас өөрийгөө тусгаарлах, тайвшрал олохын тулд архи, тамхи зэргийг хэрэглэх.

Гэвч эдгээр өөрчлөлт сэтгэл санааны бусад эмгэгийн үед илэрч болох учир эмчид хандаж, энэ бүхэн стресстэй холбоотой илэрч байгаа эсэхийг тогтооход туслалцаа авах хэрэгтэй. Таны хувьд яг хэдий хэмжээний стресс их вэ гэдгийг хэлэхэд хэцүү бөгөөд хүн бүрт өөр өөр түвшин бий. Зарим хүн маш их буюу удаан хугацааны стресстэй байдлыг тэсвэрлэдэг бол нөгөө хэсэг нь багахаан стрессийг ч даван туулах чадваргүй байдаг. Энэ нь гэр бүл, сэтгэл санааны байдал, амьдралыг харах өнцөг бөгөөд удамшлаас шууд хамааралтай. Стресст бараг автдаггүй бөгөөд түүний эсрэг зогсож чаддаг хүмүүсийн ихэнх нь өөдрөг буюу оптимист үзэлтэй байдаг аж. Тэд тулгарсан бэрхшээлийг хүлээн авах, түүний эсрэг зогсож шийдвэрлэхийг өөрийн үүрэг, амьдралын нэгээхэн хэсэг гэж үздэг.

Сэтгэл судлаач Конни Лиллас (Connie Lillas) хүмүүсийн стресст хариу өгөх арга, түвшинг тэдний машин барих үйлдэлтэй харьцуулсан нь нэлээд сонирхолтой судалгаа болжээ.

Хүчтэй хаазлах – ууртай болон сандарсан хариу үйлдэл. Хэт их сэтгэлийн хөдлөлд автаж, тогтвортой сууж чадахаа больсон хүмүүс байв.

Хүчтэй тормозлох – дотогшоо болон сулбагар хариу үйлдэл. Маш бага сэтгэлийн хөдлөлтэй, орчноосоо хол хөндийрсөн хүмүүс байв.

Хоёулан дээр нь хүчтэй гишгэх – шахалтад орж юу ч хийж чадахаа байх хариу үйлдэл. Дотроо тахир дутуу болсон мэт боловч гадна төрх нь маш их сандарсан хүмүүс байв.



Стрессийн шалтгаан буюу стрессор

Стрессор болгон зөвхөн сөрөг зүйл байдаг гэж ойлговол өрөөсгөл болно. Та бидний амьдралд тохиолдох аз жаргалтай мөчүүд хүртэл стрессор байж болох юм. Тухайлбал, их дээд сургуульд орох, хайр дурлалтайгаа учирч, гэр бүл, үр хүүхэдтэй болох, байр болон машин хүүтэй зээлээр авах, шинэ бизнес эхэлж, хамтрагчтай болох гэх мэт нь заримдаа стрессор болох тал бий. Түүнчлэн стрессор нь зөвхөн гаднын хүчин зүйл байдаггүй.

Түгээмэл гадаад хүчин зүйлүүд: хэт их ачаалалтай ажил, хувийн амьдрал, харилцааны тогтворгүй байдал, амьдралд гарах гэнэтийн том өөрчлөлтүүд.

Түгээмэл дотоод хүчин зүйлүүд: өөртөө итгэлгүй байх, боломжгүй зүйлийг хүсэмжлэх, хэт их төгс байдалд эрмэлзэх, гутранги байдал буюу пессимизм.

Хүний бие сэтгэл санааны болон бие махбодийн заналхийллийг ялгахгүй бөгөөд хэт завгүй ажил, хэрүүл маргаан, замын түгжрэл, өр зээл гэх мэт стрессоруудаар биеэ ачаалсан үед таны бие амьдрал-үхлийн тэмцэл дээр буй мэт хариу үйлдэл үзүүлэх болно. Хэрэв та хэт их хариуцлага дор амьдардаг бол стрессоруудын эсрэг хариу үйлдэл тань байнга асаалттай байх магадлалтай. Удаан хугацаанд ийм байдалд явах нь эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болно. Тухайлбал, даралт ихсэх, дархлааны систем доройтох, зүрхний шигдээс болох, тархинд цус харвах эрсдэл нэмэгдэх, эрт хөгшрөх, таргалах эсвэл турах, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа алдагдах, нойргүйтэх, биеэр тууралт гарах мэтийн түгээмэл эмгэг илэрч болно.

Урьдчилан сэргийлэх нь:

1. Стрессийг хэрхэн зохицуулах тал дээр суралцах. Магадгүй стресс таны амьдралд их байна, хэр хэмжээнээс хэтэрлээ гэх сэтгэгдэл төрж байгаа байх. Гэхдээ та болон таны бие хэрхэн хариу үзүүлэх вэ гэдэг арга замыг ямагт олох болно гэдэгт итгээрэй. Ажлын хэт их ачааллаа багасгаж, асуудлыг цаг тухайд нь шийдэж, хүрээлэн буй орчиндоо өөрчлөлт хийж магадгүй амьдралыг харах өнцгөө өөрчлөхийг хичээж болох юм.

2. Амралтаа зохицуулах тал дээр суралцах. Энэ нь таны амьдралын стрессийг бүрэн үгүй хийж чадахгүй ч үр дагаварт нь бага өртөх боломжийг өгөх юм. Бясалгал хийх, спортоор хичээллэх, нам гүм тайван орчныг бүрдүүлэх, сайхан дурсамжуудаа санагалзах, гэр бүлтэйгээ цагийг зугаатай өнгөрөөх зэрэг нь таны стрессийн эсрэг зогсох, мөн дарамт шахалттай үед өөрийгөө удирдаж гарахад тус болно.

3. Стрессийг хурдан хугацаанд үгүй болгох арга замд суралцах. Хүн бүр тулгарч буй стресстэй байдлыг багасгах, зогсоох өөрийн гэсэн далд чадвартай байдаг. Түүнийгээ олж нээн дасгалжуулснаар хурцдаж байгаа үед шийдлийг олж, өөрийн ухаантай хэвийн байдалд эргэн ороход тус болно.

Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчин тань стрессийн эсрэг хаалт юм. Нөхцөл байдлыг удирдах чадвар, бэрхшээлийг давах чадвар тань стресст орохоос хамгаална. Сэтгэл хөдлөл, баяр баясал, уур уцаараа удирдаж чаддаг, мөн стресст оруулж болох дотоод болон гадаад хүчин зүйлүүдийн талаар мэдлэгтэй байх нь тус болно. Эцэст нь, стресст орохоосоо өмнө урьдчилан сэргийлэх нь архагшсаных нь дараа өөрийгөө татаж гаргахаас хамаагүй хялбар бөгөөд та өөрийгөө болон хайртай хүмүүсээ хамгаалах ганц арга юм. ■